



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРГЭМ ШИНЖЛЭГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

# ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

- Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь (Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?)
- Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахтай холбогдсон хоригийн тухай
- Боловсролын харилцаан дахь хүүхдийн эрийн асуудал
- Төрийн байгууллагаас иргэнд учруулсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт: Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан байдал
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа
- Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд
- Үнэт цаасны зах зээлийн хуулийн хэрэгжилтийн зарим асуудал
- Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүндийг хамгаалах иргэний эрх зүйн зохицуулалт
- Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал
- Орчин тойрондоо аюултай зүйлс, аюултай үйл ажиллагаанаас учруулсан гэм хорыг арилгах, түүний эрх зүйн зохицуулалтын асуудал
- ХБНГУ-ын захиргааны шүүхийн Үндсэн хуулийн болон энгийн хуулийн эрх зүйн үндсүүд
- Хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан иргэнд учирсан хохирлыг арилгуулах талаархи Польш улсын эрх зүйн зохицуулалт
- Бэлгийн мөмчлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин
- Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын асуудал
- Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны сайд Намсрай
- Хууль зүйн англи нэр томъёо

## Сэтгүүлийн зөвлөл

---

### Сэтгүүлийн зөвлөлийн дарга

#### С.Сүхбаатар

Хууль зүйн доктор, дэд профессор  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч

### Гишүүд:

#### Б.Амарсанаа

Хууль зүйн доктор,  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш

#### Г.Банзрагч

Хууль зүйн доктор,  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш

#### Д.Зүмбэрэллхам

Хууль зүйн доктор,  
Төрийн албаны зөвлөлийн дарга

#### Ч.Энхбаатар

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
Удирдлагын академийн Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч

#### С.Эрдэнэболд

Хууль зүйн доктор,  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч

### Дугаарыг эрхэлсэн:

#### С.Алтантуяа

Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

---

Эрхлэн гаргагч:



Хууль зүйн үндэсний хүрээлэн

Редакцийн хаяг:

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,

Сүхбаатарын талбай-7

Утас: 315736, 99083007 Факс: 315736

Вэб сайт: [www.legalinstitute.mn](http://www.legalinstitute.mn)

И-мэйл хаяг: [altantuya.s@legalinstitute.mn](mailto:altantuya.s@legalinstitute.mn)

Улсын бүртгэлийн дугаар: 279

## ЭНЭ ДУГААРТ:



### Төрийн байгуулалтын хууль тогтоомж

**Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь (Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?)**

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид.....3-14

**Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахтай холбогдсон хоригийн тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Албаны дарга, Хууль зүйн доктор, профессор Л.Батжав.....15-16

**Боловсролын харилцаан дахь хүүхдийн эрийн асуудал**

Монгол Улсын боловсролын их сургуулийн багш О.Өнөрцэцэг.....17-20

**Төрийн байгууллагаас иргэнд учруулсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт: Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан байдал**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Батчимэг.....21-24



### Шүүх эрх мэдэл

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа**

МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант Д.Хуяг.....25-26



### Прокурорын хяналт

**Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд**

Багануур дүүргийн прокурорын газрын түүхэн товчоо.....27-29



### Иргэний хууль тогтоомж

**Үнэт цаасны зах зээлийн хуулийн хэрэгжилтийн зарим асуудал**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг.....30-45

**Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүндийг хамгаалах иргэний эрх зүйн зохицуулалт**

Докторант Ш.Сүхбаатар.....46-48

**Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир.....49-52

**Орчин тойрондоо аюултай зүйлс, аюултай үйл ажиллагаанаас учруулсан гэм хорыг арилгах, түүний эрх зүйн зохицуулалтын асуудал**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Наранцацрал.....53-58



### Олон улсын эрх зүй ба харьцуулсан эрх зүй

**ХБНГУ-ын захиргааны шүүхийн Үндсэн хуулийн болон энгийн хуулийн эрх зүйн үндсүүд (II хэсэг)**

МУИС-ийн ХЗС-ийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор Г.Банзрагч...59-64

**Хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан иргэнд учирсан хохирлыг арилгуулах талаархи Польш улсын эрх зүйн зохицуулалт**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Батуяа.....65-67



### Криминологи

**Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд.....68-80

**Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын асуудал**

Цагдаагийн академийн төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч С.Гантулга.....81-85



### Хууль зүйн албаны 100 жилийн ойд

**Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны сайд Намсрай**

Үндэсний төв архивын эрдэм шинжилгээний ажилтан Т.Билэгсайхан.....86-87



### Нэр томъёо

Хууль зүйн англи нэр томъёо.....88

# CONTENT:



## State organization legislation

### Strengthening the Overview of Parliament (What Will We See Away from Product Paper and Giving Money?)

/B.Chimid, Ph.D and Professor of Law, Awarded by Titles of the Hero of Labor, Mongolian People's teacher and Merited lawyer.....3-14

### Banning on Receiving Gifts and Services as Public Servants

L.Batjav, Ph.D, Head of Division, Office of the President of Mongolia.....15-16

### Children's Right in Education

O.Unurtsetseg, Mongolian State University of Education.....17-20

### Regulations on Elimination of Harms to Citizen Caused by Public Servants and its Reflections in the Mongolian Legislation

G.Batchimeg, Researcher of Criminal law and Criminology Research sector, National Legal Institute.....21-24



## Judicial power

### Time Period in the Civil Procedure

D.Huyag, Ph.D candidate, Senior lecturer of School of Law, National University of Mongolia.....25-26



## Prosecutors supervision

### On the Occassions of the 80th anniversary of Mongolian Prosecutor's Office\*

Brief History of the Prosecutor's Office of Baganuur District.....27-29



## Civil legislation

### Some Problems of Implementing of Law on Securities Market

Research Team of National Legal Institute.....30-45

### Civil Law Regulations for Protection of Citizen and Legal Entity's Honor and Dignity

Sh.Sukhbaatar, Ph.D candidate.....46-48

### Issues on Reimbursement of Non-material Harm in Cash

D.Tamir, Researcher of Civil and Economic Law sector, National Legal Institute.....49-52

### Elimination for Damages to the Environment and its Legal Regulations

B.Narantsatsral, Researcher of Civil and Economic Law sector, National legal institute.....53-58



## International law and comparative law

### Legal Roots of Constitution and Ordinary Laws for the Administrative Court of Germany

G.Banzragch, Ph.D, Lecturer of State and Administrative Law Department, School of Law, National University of Mongolia.....59-64

### Legal Regulations for Elimination of Consequences of Illegal Arrest in Poland

Ts.Battuya, Researcher of Criminal law and Criminology Research sector, National Legal Institute/.....65-67



## Criminology

### Legal Environment for Protection of Children against Sexual Exploitation and Violence

G.Oyunbold, Researcher of Criminal law and Criminology Research sector, National Legal Institute.....68-80

### Issues on Criminal Law Regulations for Human Trafficking

S.Gantulga, LL.M, Lieutenant and Lecturer of Police Academy.....81-85



## The 100th anniversary of the Justice sector

### First Minister Namsrai of the Ministry of Court

T.Bilegsaikhan, Researcher of National Central Archive.....86-87



## Law term

Legal Terms in English.....88

\*80th anniversary of Mongolian Prosecutor's Office will be celebrated in 2010

Б.Чимид 2010 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Төрийн ордонд болсон "Парламентийн хяналт" хэлэлцүүлэгт тавьсан илтгэлээ үндэс болгов.

## Парламентийн хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь

(Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?)



Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид

*Нэг. Таамгаар биш шинжлэх ухаанаар хандахуй*

**1.1. Марз ууланд болсон явдлыг мэргэлсэн нь:** Монголын нийгмийн улс төрийн амьдрал цэц булаалддаг цөөнгүй асуудлын нэг нь парламентат ёсны тухай юм. Түүнийг "улс төр судлал", "засаг төр", "засаглал", "нийтийн захиргаа" гэхчилэн язгуур нэгтэй ч янз бүрийн талаас нь элдэв зорилгоор эргэцүүлэх болжээ. Ялангуяа 1992 оны Үндсэн хуулиар бэхжүүлсэн засаг төрийн байгуулал, төрийн удирдлага ("захиргаа")-ын хэлбэр, парламентын бүтэц, чиг үүрэг, бүрэн эрхийн зэрэг ерөнхийгөөс тодорхой руу хандсан шинжлэх ухааны танин мэдэхүйн нарийн ширийн асуудлыг эрдэм

шинжилгээний үүднээс гэхээсээ улс төрийн нам, бүлэг, улс төр-бизнесийн шунахайрал, албан тушаалын шохоорхол /амбигци/ зэрэг "явцуу сонирхлын" үүднээс мушгин гүйвүүлж муучлах нь хэрээс хэтэрч ард олныг төвөгдүүлсээр байна. Нийгэм-улс төр, хууль зүйн ихээхэн ээдрээтэй алив асуудлыг суурь судалгаагүйгээр тааварлан цуурхах нь онохоосоо алдах нь, олзноосоо гарз нь их гэдгийг бүгд мэднэ.

10 гаруй жилийн өмнө юмсан. 1993 онд байхаа. МИАТ-ийн нэгэн онгоц Улиастай нисэх замдаа сураг тасарч түргэн авахуулсан. Орчлонд зарлаж, ороц даяар сураглаж, мэдэлтэй нь нисэн, мэдэлгүй нь мөлхөн хайж, "мэргэд" нь мэддэгээ шавхаж билээ. Онц мэргэн нь "хил давчихаж" гэж, олж хардаг нь онгоц нэргүй газар буучихсан байна. Зорчигчид далавчин доор нь сууцгааж байна. Нисгэгчид нь тойроод явна гэнэ. Энэ мэтээр итгүүлж, төөрүүлж байтал эрлийн албаныхан Завханы Тосонцэнгэлийн нутаг Марз уулнаас онгоцны сэгийг олсон байдаг. "Мэргэд"-ийн нэг нь ч онож хэлсэнгүй олны шившиг болж билээ. Тааж буудахын осол иймэрхүү л дээ. Ганц онгоцны тухайд ч таамаглаж болох. Харин улс гүрнийг бүхэлд нь жолоодогч их хөлөг болсон Парламентын тухайд ийнхүү "буудах" нь зөвхөн өөртөө бус өргөн түмэнд ил далд ихээхэн хор уршигтай.

**1.2. Гурван нээлт, олдсон боломж, манай парламентын нүүр царай**

... Хор уршигтай гэхийн учир юу гэвэл Парламентат ёс нь үе үеийн судлаачдын бүтээж, олон орны улс төрийн амьдралаар шалгаруулан нотолсон шинжлэх ухааны үнэт зүйл юм. Түүнийг судалж туурвиснаар орчин цагийн төрийн байгуулалд гурван чухал нээлт гарсан! гэж эрдэмтэд нотолж байна.

**Нэгдүгээрт:** Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг ард түмний төлөөлөлтэй нэгтгэсэн нь нэгэн нээлт гэнэ. Өөрөөр хэлбэл, дарангуйлагч дангаар зарлигдан захирах ёсыг халж, ард түмний төлөөллөөр хууль тогтоох болсон.

**Хоёрдугаарт:** Төрийн эрх мэдлийг засгийн гурван салаанд хувааж хэрэгжүүлэх хяналт, тэнцэлтэй, хүнд ээлтэй тогтолцоог бий болгосон. "Засаглал хуваах" ч гэлцдэг. Гэтэл улс чинь нэг л засагтай. Түүнийг хуваадаггүй, харин эрхлэх ажил буюу чиг үүргийг нь төрийн засгийн гурван салаанд хуваарилж хэрэгжүүлдэг гэж ойлговоос зохилтой.

**Гуравдугаарт:** Парламент нь хөшин зогсож хөгжлийг саатуулагч бус, туурвин бүтээгч байхад шилжсэн. Өөрөөр хэлбэл, "парламент нь" тодорхой бүлэг этгээд төрийн толгойд хууль гаргаж орхиод таргалан суух бус, хуулиа биелүүлж түмэн олныхоо тусын тулд байнга санаачилгатай үйлчилдэг ёсонд шилжсэн нь бас нэгэн нээлт ("төслийнхөөс өдөр тутмын идэвхтэй ажлын байгууллага") болов.

**1.3. Эдгээр нээлт Монголын парламентад нэвтэрсэн үү?! Монголчууд бид ардчиллын замыг**

сонгосноор шинжлэх ухааны энэ гурван нээлтгүй эзэмших нийгэм, улс төрийн аятай боломжийг өөрсдөө цэлийтэл нээж авсан билээ. Тэр боломж нь өөрийн өвөрмөц онцлог бүхий<sup>1</sup> парламентын засгийг төрийнхөө удирдлагын хэлбэр болгон сонгож Үндсэн хуулиараа бэхжүүлсэн явдал мөн<sup>2</sup>. Иймийн учир уг хэрэг түүнийг элдвээр гоочлон нураах биш, тал бүрээс нь тордож дутууг гүйцээж дундуурыг нь дүүргэж бэхжүүлэх түүхэн үүрэг төр, түмэнд ноогджээ. Гэтэл эхэлснээ тууштай үргэлжлүүлж, үүсгэснээ өөд татаж төгөлдөржүүлэхийн оронд үтэр өшиглөн таягдаж өөр нэгээр байн байн сольж сонжих зуршилтай нүүдэлчдийн сэтгэл зүйг залгамжилж ханахгүй бололтой. Улсын Бага Хурлын үеэс парламентын үйл ажиллагаа ахиц дөхөцтэй, олны итгэл нааштай байсан гэдэг. Тийм хэдий ч түүнийг уламжлал болгон бэхжүүлсэнгүй. Өнөөгийн УИХ-ын үйл ажиллагаанд бодлого туушгүй, хариуцлага султай, үр өгөөж дүлханаар барахгүй, сонгож бүрдүүлэх нь булхайтай, ажиллах зорилго нь аминцар, өөрөөр хэлбэл нэлээд гишүүдийн хувийн сонирхол нийгмийнхээсээ дээгүүр, хууль нь хуудуутай, шалгалт нь сульдаатай байгаа. Бүхэлд нь үзвэл өнөөгийн парламент ардчилсан хувьсгалаар нээгдсэн боломжийг гүйцэд ашиглаж, дээр дурдсан нээлтийн үр шимийг бүрэн хүртэж чадаагүй, ялангуяа хоёрдахь, гуравдахь нээлт нь хэрэг дээр нэвтрээгүйгээс үе үе олны итгэлийг алдруулахад хүргэх болжээ. Үүнийг далимдуулан парламентат ёсны эсрэг чулуу шидэж, нулимах нь ихсэв.

#### 1.4. Байгаагаа тордох уу,

#### балгас болгох уу?

Өөрт байгааг үгүйсгэн өрөөл бусдынхыг дөвийлгэн магтсаар цагийг элээж хоосон хоцрох нь өнөөгийн бидний хууч "өвчин" болжээ. Ардчиллын эсрэг их бага "дайн" өдөөгчид юуны түрүүн парламентын эрхийг хязгаарлах, явдал булаах, чадвал үгүй хийхийг оролдог нь түүхээр нотлогдсон үнэн. Энэ нь угтаа ард түмний засгийн эсрэг, ямар нэг хүн, хэсэг бэлгэ этгээд, нэг намын эсрэг дунгаар дарангуйлах ёсыг тогтоох гэснээс үүдэлтэй байдаг. Тийм оролдлогын хэлбэр, арга нь ил далд, хурц, аядуу /ажиглагдамгүй/ элдэв янз байдгийг мартаж болохгүй. Парламентын ардчиллыг хумиж гүйцэтгэх эрх мэдэл-нэг хүний эрх дархыг давамгайлүүлсэн генерал Де Голлийн V дугаар БНУ гэх эргэлтийг Монголд хуулбарлахыг санаархагчид сүүлийн үед идэвхжээср байгааг дээдэс хараад дуугүй суусаар. Деголлизмыг эх орон нэгтнүүд нь тийм ч их дэмждэггүй мэдэмсэсэн. Францын эрдэмтэн М.Доверже 1958 оны Үндсэн хуульд ерөнхийлөгчийнхөө эрх мэдлийг ихээхэн нэмэгдүүлж парламентынхыг хязгаарласны үр дагаврын талаар дүгнэж бичихдээ: "Парламентын дэглэм дэх гүйцэтгэх засаглалыг хүчирхэгжүүлэх гэвээс ерөнхийлөгчийн нэр хүнд, эрх мэдлийг бус, харин ерөнхий сайдынхыг л нэмэгдүүлэх учиртай. Эс чингэвээс гүйцэтгэх засаглалыг хуваан, дотор нь байнгын өрсөлдөөнийг бий болгож, үүгээрээ засаглалыг улам бүр доройтуулдаг бөгөөд парламентат ёсны механизмдыг дутуу дулимаг ухаарснаас энэ бүхэн үүдэлтэй болой"<sup>3</sup> гэж бичсэн байна. Тэрээр цааш нь Үндсэн хуулийг хэрэгжүүлэхэд ерөнхийлөгчөөр

сонгогдсон хүний хувийн нэр хүнд онцгой өвөрмөц үүрэг гүйцэтгэдгийг умартах ёсгүйг тэмдэглээд түүнээс хамааран Францад Де Голлий ихэд өргөмжилснөөс "ардчилсан хууль ёстой зэрэгцэн Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхээс хавьгүй их эрх мэдэлтэй болгодог хувь хүний нэр төр хоёр дахь хууль ёсыг бий болгон, улмаар нэн өвөрмөц улс төрийн дэглэм үүссэн байна". V БНУ ("Франц") нь...өдгөө ерөнхийлөгчийн засаглал илүү ойр дөт гэдгийг давтан хэлбэ гэжээ.<sup>4</sup>

Монголд 1920-иод оны эхээр үүсэж, жилд 1 удаа чуулж, төрийн бодлого тодорхойлдог Улсын Хурлын эрх мэдлийг яваандаа нам авч 1930-аад оноос цуглаж чадалгүй 10 шахам жил алгуурладаг болсон байв. 1951 оноос шинээр сонгогдсон Улсын /1960 оноос Ардын/ Их Хурал жилд 1 удаа ганц хоног чуулж намын шийдвэрийг ёсчилох төдий хэлбэрийн парламент байв. 1990 оны эцсээс Байнгын гэх болсноос хойш хэсэг зурь парламентат ёс хэвийн төлөвшиж байснаа 2000 оноос Засгийн газартайгаа хутгалдав. УИХ бүрэн эрх нь парламент дахь бүлгүүдээрээ шууд дамжсан намын эрх мэдлээр (гаднаас нь харвал тийм биш мэт) солигдож гүйцэтгэх засгаа хянах нь байтугай нам, мөнгө хоёроо урдаа барьсан Засгийн газрын гишүүдийн эрхшээлд орж эхлэв. Өдгөө бүр хувийн эрх зүйн субъект (хувийн байгууллага) болсон намыг "хууль санаачилдаг" нийтийн эрх зүйн субъект болгохоор санаархаж байна." Иймэрхүү мулгуу оролдлогыг нам шүтэгчид "хар ухаан"-аар, албан тушаал горилогчид хувийн хорхойосоор (амбицаар); захиргаадалд дасаж эзнэгшсэн нэг нь "илжиг модон худрагандаа" гэгчээр дор дороо

<sup>1</sup> Улс бүрийн төрийн удирдлага /Засаглалын/ гэх болсон/-ын хэлбэр өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрхтэй байх бөгөөд яг усны дусал шиг адилхан нь энэ ертөнцөд үгүй гэх үздэг билээ. Энэ тухай "Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэлтэй асуудал". I дэвтр. УБ., 2009 он. 34-36 дахь талаас үзнэ үү.

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. Нэг, Хорин тавдугаар зүйлд үзнэ үү.

<sup>3</sup> М.Доверже. Улс төрийн байгууламж. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007 он. 369 дахь тал.

<sup>4</sup> Мөн номын 397 дахь тал.

<sup>5</sup> УИХ жилд 2 удаа ажлын бүгд 100 хоног чуулах хуультай болсоны учир "хагас байнгын" гэж тооцох учир ч бий.

<sup>6</sup> МУШН-ын боловсруулсан гэх төсөлд "Нам хууль санаачилна" гэжээ /Монгол шуудан/ сонин. 2010. №40/.

чимээгүйхэн дэмжиж суугаа гэдэгт эргэлзэх явдалгүй. Бас түүнийг онолын талаар үндэслэхийг оролдогчид ч байх бололтой.

**1.5. Парламент сул дорой байх ёстой мэтээр ярих нь ямар ч явуургүй.** Төөрөлдөж болно. Тэгэхдээ Марз ууланд унасан онгоцны хаа хэрхэн сүйрснийг ташааран тааварласан шиг "тавьж тууж" болохгүй. Харин парламентыг шинжлэх ухааны үүднээс шинжин үзэж, одоо байгаагаа<sup>3</sup> онолын үүднээс зөв тайлж, хуулийн талаар оновчтой зохицуулж, практик үйл ажиллагааны эрч хүч, үр нөлөөг мэдэгдэхүйц дээшлүүлэхийг хэн хүнгүй хичээх цаг болж. Эл шаардлага УИХ-ын бүрэлдэхүүний өмнө, түүнийг бүрдүүлдэг, хянадаг сонгогчид бидний өмнө, ялангуяа залуу үеийнхний өмнө тулгарч байна. Тийнхүү үр нөлөөг дээшлүүлэх гарцаагүй үндсэн арга замын нэг нь сайн хууль гаргахын хамт түүний биелэлтийг хангуулах гол хөшүүрэг УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийг гүйцэд тууштай хэрэгжүүлэх явдал мөн. Ийм бүрэн эрхийг УИХ-д 1992 оны Үндсэн хуулиар хуваарилан олгосон. Түүний ач холбогдол, хангах арга нь юу вэ? Юуны түрүүн үнэнч түшээ, шударга хууль, хүчтэй хяналт, үр дүнтэй гүйцэтгэл энэ дөрвөц цогцолбол УИХ төгөлдөржиж, төр төвхнөнө. Түмний дэмжлэгч ч сэргэнэ. Гишүүд үнэнч бол хууль шударга байна, хяналт хүчтэй бол шударга хууль үр дүн сайтай байна гэдэг ойлгогчтой. Гэтэл хувийн бизнес, намынхаа явцуу сонирхлыг хамгаалсан хууль гаргаж, шударга бүсэн үүд, шуналт авлигын амсргд нээх нь үзэгдсээр. Жишээлэхэд, мөнгө тарааж, бас сая саяыг амлаж сонгогдсон гишүүд маань төсвийн хууль батлахдаа орон нутгийн төсөвт хуваарилгагдвал зохио асар их

мөнгийг тойргийн нэрээр өөртөө хуваарилж аваад "хүзүү хуваан" зарцуулдаг болж. Энэ бол хууль тогтоох албан тушаалаа урвуулсан "хувийн" төдийгүй, төрийн санхүү барих Засгийн газрын эрх, үүргийг өөртөө авч парламентын хяналтаас гаргасан нийгмийн ихээхэн хор уршигтай ноцтой гажуудал юм. Үүнийг засахад нэмэлт хууль хэрэггүй, байгаагаа л зөв тайлж хэрэглэхэд хүрэлцээтэй. Сонгууль, парламент хоёроос л шударга бус явдал, авлига ингэж эхлээд байх юм бол доош ярих, хянах тэмцэхийн аргагүй болно. АНУ-ын ОУХА-ийн Европын Товчооноос боловсруулсан "Байгууллага дахь авлигыг оношлох арга зүй" (ТРЕЕ)-д тодорхойлсон зарчмуудын нэгэнд ийн дурджээ: "Олон түвшний байгууллагын тогтолцоонд дээд удирдлагын үнэнч шударга эсэх нь эргэлзээтэй бол доод шатны ажилтнуудад хариуцлагын тогтолцоо, хууль хэрэгжилтийг тулгаад хэрэггүй. Жишээлбэл, Улс төрчид өөрсдөө авлигач байхад тэдэнд үйлчилдэг албан хаагчдыг хариуцлагын тогтолцоогоор хүмүүжүүлэх гэж оролдох нь ямар ч ач холбогдолгүй юм"<sup>4</sup> гэжээ. Үүнээс үзвэл шударга бус шийдвэр гаргаж, мөнгө хувааж, тараах замаар аргацаахын цаана төр нийгэмд учрах ямар их аюул байгааг харж болно. Эл байдлаас ангижрахад ард түмний өмнөөс тавих парламентын үр дүнтэй хяналт шалгалт л хамгийн хүчтэй зэвсэг болохсон билээ.

#### **Хоёр. Парламентын хяналт шалгалтын ойлголт, үндсэн шинж**

2.1. Хяналт шалгалтыг мэдэхгүй хэн байхав гэж үү? Гэтэл парламентын хяналт шалгалт (ПХШ) гэж ямар үүрэгтэй юу

болохыг орон орны судлаачид шинжилсээр янз янзын санаа дэвшүүлсээр байгаа болохоор амаргүй л суудал байж таарна. Францын судлаачид "парламентын хяналт" гэдэг "танхимууд Засгийн газрын үйл ажиллагааны тухай мэдээлэл авч, уг үйл ажиллагаа нь улс төрийн бодлогоос ноцтой зөрсөн бол түүнийг арилгах цогц арга хэмжээ мөн" гэж үзсэн байхад Германы судлаач Засгийн газар, бусад байгууллагын үйл ажиллагааг шалгах, тодорхойлох, үнэлэлт өгөх, эзлэлт (санц) хэрэглэх... үйл явц<sup>5</sup> гэсэнчлэн олон баримт өгүүлж болно.

Гадаад орны хуульд ч ПШХ-ын тухай аль нэг талаас онцлон заасан нь цөөнгүй. Тэр дундаа парламент нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, мөрдөн шалгах эрх үүрэгтэй байхыг хуульчилсан нь ардчилсан улс орнуудын нийтлэг жишиг болно. Австри, Алжир, Андора, Бельги, Болгар, Бразил, Болив, Унгар, Венесуэл, Герман, Гүрж, Испани, Итали, Иемен, Казакстан, Латви, Литви, Лихтенштэйн, Португал, Словен, Тажикистан, Турк, Узбекистан, Франц, Хорват, Швед зэрэг нэлээд орны Үндсэн хуульд парламентаас Засгийн газар (Кабинет)-ын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт, түүний арга хэлбэрийн тухай заажээ.<sup>6</sup> Тэр бүхний дүнд "парламентын хяналт шалгалт" гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нэгэн институт ("төрөл хэсэг") үүсэн бүрэлджээ. Энэ тухайд эрх зүйн мэргэжлийн тодорхойлолт байж болох юм. Тэр нь парламентаас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль биелүүлэх үйл ажиллагааг хянан шалгаж үнэлэлт дүнгэлт өгөх үйл ажиллагааг зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр цогц гэж болно. Гэвч энэ бол хууль зүйн

<sup>3</sup> Ер нь байгын парламентгүй байх буюу түүнийг ард түмнээс таслан дарамталсан өөр бүтцийг дээр нь тохож болохгүй шүү дээ -Б.Ч

<sup>4</sup> Авлигатай тэмцэх газрын олон улсын зөвлөх Вазгер-ийн тайлангаас эшлэв

<sup>5</sup> Дам эшлэв "Парламентское право России". Авторский коллектив др. О.Н. Булгаков и другие. ЭКСМО. М. 2006. С.136-

талаас нь өгүүлж буй хэрэг тул практик үйл ажиллагааны хувьд юу юм бэ? гэдэгт ойлгомжтой хариу болж чадахгүй.

Үйл ажиллагааны хувьд ПХШ гэдгийг угтаа хяналт шалгалт гэж юу вэ? гэдгээс ургуулж авч үзэх нь зөв байх. Хяналт шалгалт гэдэг шийдвэр, үр дүн хоёрыг хооронд нь жишиж үзээд таарсныг нь бататгаж, тасалдал, гажигийг арилгах үйл ажиллагаа юм. Ер нь шийдвэр гаргах түвшний байгууллага, албан тушаалтан нар хоёр үйлдлийг заавал өөрөө хийж байх ёстой гэдэг. Өөрөөр хэлбэл бусдад найдаж, дайж болохгүй удирдлагын зайлшгүй үүрэг бол бодлогын шийдвэрийг өөрөө гаргаж, бодит биелэлтийг нь биечилэн (механик угтаар бус) тооцож байх явдал мөн. Нэгдэхийг эс гүйцэтгэвээс хөгжлийг чөдөрлөгч, хоёр дахь үүргийг эс биелүүлвээс хариуцлага сулруулагч болно.

Иймд парламент төрийн бодлогын эцсийн шийдвэр гаргадгийн учир түүнд хяналт шалгалтын үүрэг бий эсэх талаар эргэлзээ байх ёсгүйгээс гадна түүний энэ үүрэг эгэл жирийн биш гэдэг нь ойлгомжтой. Түүнийг ердийн албан газрын хяналт шиг жижигрүүлж болохгүй. Тэр бол аугаа том зүйл. Тухайлбал, төрийн эрх мэдлийн салаа хоорондын хяналт тэнцлийн зарчмыг хэрэгжүүлэх механизм, юуны өмнө гүйцэтгэх эрх мэдэлд өгөх төрийн хамгийн дээд түвшний улс төр, эрх зүйн үнэлэмж, хуулийн тасалдал, улс төрийн бодлогын гажилтыг арилгах гол арга хэрэглүүр мөн билээ.

2.2. Үзэгдлийн мөн чанарыг нээн харуулахын тулд түүний үндсэн шинжийг тодруулах нь чухал билээ. Иймийн учир ПХШ-ын үндсэн шинжийг дор цухас боловч

тэмдэглэе!

2.2.1. ПХШ бол хууль тогтоох үйл ажиллагааны салшгүй, ихээхэн хэсэг юм.

Монгол Улс хууль тогтоох үйл ажиллагааг засгийн буюу төрийн эрх мэдлийн гурван салааны нэг хэмээн ангилж Үндсэн хуульчилсан билээ. Үндсэн хуулиар энэ чиг үүргийг УИХ-ын бүрэн эрхийн хувьд "хууль батлах нэмэлт, өөрчлөлт оруулах", "хууль, УИХ-ын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах"<sup>8</sup> гэж тодруулсан бий. Гэтэл түүнийг "хууль батлах", "хууль гаргах" төдийгээр явцууруулан ойлгож бараг л "хэдэн хууль гаргах" гэдгээр нь УИХ-ын ажлын амжилтыг дүгнэдэг хэвшил тогтжээ. Эцсийн дүнд сайн хууль гаргаж түүнийхээ биелэлтийг хянан шалгаж, бодитой үр дүнд хүргэх явдал хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн агуулга билээ. Хураангуйлбал, хууль тогтоох үйл а ж и л л а г а а = х у у л ь гаргах+биелэлтийг хянаж шалгах (хоёрын нийлбэр) гэж бүдүүвчилж болно. Тэгэхээр хууль гаргаж орхиод байвал хамаг ажлынхаа тэн хагасыг умартсан хэрэг гэхээс яах вэ? Хууль олигтой хэрэгжихгүй байгаагийн нэг гол шалтгаан ч энд бий.

2.2.2. ПХШ-ын үндсэн зорилго нь бодлого-хуулийнхаа заалт үр дүн хоёрыг жишиж үзээд ажлын тасалдыг арилгаж, амьдралд нийцэхгүйг өөрчилж, ашигтай өгөөжтэйг нь бэхжүүлж хуулийн тогтвортой, хэтэч байдлыг ханган нийгмийг хуулиар жолоодоход чиглэнэ. Энэ бол түүний шууд ач холбогдол юм. Өөрөөр хэлбэл ПХШ-аар хуулийн үр нөлөөг хангана гэсэн үг. Үүнийг: Шийдвэр+үр дүн=хууль тогтоох ажлын үр өгөөж гэсэн бүдүүвчээр харуулж болно.

2.2.3. ПХШ бол төрийн хяналт шалгалтын хамгийн дээд шатных бөгөөд хянагдаж байгаа байгууллагын хувьд гаднын хяналт шалгалт мөн. Яагаад гэвэл энэ нь хууль тогтоох дээд байгууллагаас Үндсэн хуулийн дагуу ард түмний өмнөөс хийж үр дүнт нь шаардлагатай бол хууль гаргаж зохион байгуулах бүрэн эрх бүхий юм. Түүнчилэн ПХШ бол Засгийн газар, шалгагдаж буй бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хууль дунд нийцэж байгаа эсэхийг төдий бус тэр хууль, үйл ажиллагаа нь зүй зохистой эсэх, хэр зэрэг ирээдүйтэй, үр ашигтай болохыг үнэлж сул талыг нь засаж залруулдаг амьд ажил юм.

2.2.4. Парламентын хяналтын эзэн-субъект нь дэлхийн жишгээр ярьвал Монгол Улсын Их Хурал, түүний гишүүн болох нь ойлгомжтой билээ.

УИХ-ын тухай, УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулиудад "УИХ-ын хяналт шалгалт" гэсэн заалтуудаас гадна "УИХ-ын гишүүний асуулга, асуулт" гэхчилэн бие даасан хяналтын хэлбэрүүдийг тодорхойлсон байна.<sup>9</sup> Энэ нь ном зохиолд парламентын "ажиглалт, мөрдөн шалгалт"-ын сацуу "депутатын хяналт шалгалт"-ыг бие даасан субъектын хувьд нь тусгайлан авч үздэгтэй нийлж байна. Практикт парламентын бүтцийн нэгжүүд, тухайлбал Байнгын хороо, комиссын шалгалт гэж байх бөгөөд түүнийг хэрэг дээрээ парламентын өмнөөс хийдэг, түүнд илтгэж дүгнүүлдэг учир харьцангуй бие даасан мэт боловч эцсийн дүндээ ПХШ юм.

Субъектын талаас үзвэл олонхи, цөөнхийн хяналтын эрхэнд онцлон анхаарах учиртай. Ялангуяа олон намын тогтолцоот

<sup>8</sup> Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. 25.1, 25.8

<sup>9</sup> Хяналт шалгалтыг гаднын, дотоодын гэж 2 ангилдаг бөгөөд нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд хийж байгаа бол гаднын, алив тогтолцоонд дотроо хийж байгаа бол дотоодын гэдэг. Энд парламентын дотоод хяналтыг авч үзээгүй болно. - Б.Ч.

<sup>9</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хууль. 2006 он. 33 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль. 2007 он. 49, 50 дугаар зүйл



парламентын хувьд олонхи, цөөнхийн хяналт нь чуулган, хороодын хянан шалгалтыг орлохгүй бөгөөд технологийн төдий бус улс төр-эрх зүйн хяналт шалгалт болох онцлогтой. Иймд парламентын ямар нэг шалгалт судалгаанд намын бүлэг бүрээс төлөөлөл оруулсан хэсэг байгуулж ажиллуулдаг нь парламентынх, харин цөөнхөөс олонхийн үйл ажиллагаанд, түүний Засгийн газарт тавих хяналт, мөн олонхийн хяналт бол бие биедэй найр тавин нялууралгүй, шулуун шударга баймааж парламент цэвэрших хүчтэй хэрэглүүр болно. Манай УИХ-д олонхи, цөөнх "нэгэн хөнгилд орчихоод" эв нэгдэлтэй гэсэн күүрмаг дүр үзүүлэх болсныг олон түмэн шүүмжилдэг нь аргагүй.

ПХШ нь төрийн магадлан шалгах газар (Аудит) Хүний эрхийн комисс, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг хөндлөн хяналтын байгууллага, сонгогчдын оролцоо ч субъектын чухал ач холбогдолтой. Гагцхүү тэдгээрт эрх олгож, журамласан хууль дутагдаж байна.

**2.2.5. Алив хяналт шалгалт** өөрийн хамрах зүйл буюу объектоотой байна.

*Гүрээ. Байгаа онохуй. ПХШ-ын объектыг зөв сонгож тогтоох нь*

Энэ бол нэлээд ээдрээтэй будлиулдаг асуудал тул тусгайд нь өгүүлж байна.

**3.1. ПХШ-ийн объект гэж** хянуулж шалгуулж буй байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хэлнэ. Аль байгууллагын ямар үйл ажиллагаа вэ? гэдгийг олж тогтоох гэсэн үг ПХШ-ын шууд объект нь **хуулийн биелэлтийг хангах үйл ажиллагаа юм.** Үүнийг "хууль биелүүлэх"-тэй хутган ойлгож болохгүй. Үндсэн хууль ёсоор хуулийн биелэлтийг хангах ажлыг улсын хэмжээнд гүйцэтгэх эрх мэдлийн

дээд байгууллага, Ерөнхий сайд эрхлэн хариуцдаг билээ. Тэгвэл Засгийн газар, Ерөнхий сайдын үндсэн үүрэгт үйл ажиллагаа ПХШ-ын анхдагч шууд объект болж байна. Үндсэн хуульд Засгийн газар нь "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" чиг үүрэгтэй; "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна" гэж тус тус заасан бий.<sup>10</sup> Иймд бүх хяналт түүгээр дамжих бөгөөд ПХШ-ын гадна төрийн гүйцэтгэх эрх мэдлийн нэг ч байгууллага, түүний дархлагдсан албан тушаалтан байх учиргүй. Улсын аюулгүй байдал, улс төрийн "хар хайрцагны" бодлого зэрэг "үзнэ", "шалгана" гэж хэн хүнгүй "довтлох" аргагүй эмзэг нарийн зарим асуудал байдаг. Гэсэн ч УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хорооны шалгалт зэрэг катуу чанд хязгаарлал бүхий онцгой журмаар авч үзэх учир уг асуудал парламентын хяналт шалгалтаас ангид бус.

Хуулийн биелэлтийг хангах нь хуулиа барьж улс орноо удирддаг гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааны хууль зүйн үндсэн агуулга мөн. Үүнийг аливаа байгууллага, албан тушаалтан хууль биелүүлэх үүрэгтэй гэдгээс ихээхэн дээд түвшинд үнэлж ялган ойлгох хэрэгтэй билээ. Төрийн байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаандаа хуулийг ягштал биелүүлж байх үүрэг, зарчимтай бол гүйцэтгэх эрх мэдлийн бүх байгууллага, албан тушаалтан өөрөө хууль биелүүлээд зогсохгүй, харин эрхлэх нэгж, салбар, хүрээндээ хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах чиг үүрэгтэй. Иймд хууль биелүүлэх зарчим, хуулийн биелэлт (гүйцэтгэл)-ийг хангах чиг үүрэг хоёрыг ялгаж үзэх хэрэгтэй гээд байгаа юм.

Ардчилсан орнуудад Ерөнхийлөгчийг хүртэл осол цалгар явдал гаргаваас импичмент буюу сенатын өөрийн шүүхээр оруулан шалгаж хэлэлцэж, огцруулах хүртэл эзэм хүлээлгэдэг. Хүсээгүй зүйл мэт боловч хууль дээдлэх ёс ийм. Харин коммунист дэглэмийн үед эрх барих хүчин, удирдагчийг шалгах гэдэг төрийн хэрэг байсангүй. Тийм байр суурь социализмаас ардчилалд шилжсэн орны өнөөгийн хууль, парламентын практикаас хараахан бүрэн салаагүй, эргэж хургасан байдал үзэгдэж л байдаг. Зарим судлаач ОХУ-ын зарим бус нутгийн хуульд зааснаар "ОХУ-ын субъектын гүйцэтгэх дээд байгууллагын үйл ажиллагаа парламентын хяналтад хамаарахгүй" гэснийг зохисгүй хэмээн тэмдэглэжээ.<sup>11</sup> Энэ нь тухайн улсын бүрэн эрхийн асуудал өвөрмөц байдал мөн боловч хяналтаас зуртах хандлага хууль дээдлэх зарчимд харш учир хуулбарлан дуурайх нь ардчилсан ёсонд хазгай. ПХШ-ыг хууль биелүүлэх ажлыг хийж гүйцэтгээгүйн төлөө, мөн хууль зөрчсөний учир буюу үр ашиг муутай ажилласны төлөө буруутанд хариуцлага тооцохоос салгуу ойлгож хараахан таарахгүй. "Парламентын хяналт шалгалт нь институт болохын хувьд үндсэндээ гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг ажиглаж шалгаж түүнд үнэлэлт өгөх, санцци (зэм) хэрэглэх зорилгоор явуулдаг..."<sup>12</sup> гэж бичсэн буй.

**3.2. ПХШ-ын объектод төрийн** гүйцэтгэх эрх мэдлийн зэрэгцээгээр хүний эрх, үндэсний аюулгүй байдал, улс төрийн харилцаанд хууль зүйн үүрэг хариуцлага хүлээсэн улс төрийн байгууллага, албан газар, төрийн өмчийн болон түүний дийлэнх оролцоотой "үйлдвэрийн газрын"<sup>13</sup> үйл

<sup>10</sup> Монгол Улсын Үндсэн хууль 1992 он 38.2.1, 41.1

<sup>11</sup> А.Е. Михайлова. Правовое регулирование института парламентских расследований в РФ / Автореферат Кандидатской диссертации / "Омск" 2009 С.19

<sup>12</sup> Конституционное право России. ЭКСМО. М. 2005 С.136-137.

<sup>13</sup> Үйлдвэрийн газрын тухайд 2009 оны 5 дугаар сарын 27-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан Францын Үндэсний Ассамблейн

ажиллагааг ч хүртэл хамруулдаг ёсон бий.

- Улс төрийн нам, хөдөлгөөн дэх хүний эрх, Үндсэн хуульт байгуулалд харш үйл ажиллагаа;

- Улсын төсөв, мөнгө санхүүгийн хүрээнд дэх ноцтой хуйвалдаан, ашиглалт;

- Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт дэх луйвар, залилан;

- Улсын гадаад харилцаанд Монгол Улсын болон иргэдийн аюулгүй байдалд харшлах будлиантай асуудлууд;

- Шашны харгис урсгал, сектуудын гэмт үйл ажиллагаа;

- Улсын доторхи болон улс дамнасан санхүү-эдийн засгийн харилцаанд санхүү, татвар, иргэн, олон улсын гэрээний зэрэг хууль тогтоомжийн биелэлтэд холбогдох улс төр-бизнесийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг ч объект болгон авч хянан шалгах учир буй. Гэхдээ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх эрх мэдлийн хүрээний байгууллагуудын хянан шийдвэрлэх ажиллагааг парламент хянан шалгахгүйгээс гадна нэгэнт мөрдөн байцаах, шүүх ажиллагаа эхэлсэн асуудлыг зэрэгцүүлэн шалгахгүй. Нөгөө талаар ПХШ нь шүүхийн хүчин төгөлдөр болсон тогтоол, шийдвэр, магадлалтай хэргийн үйл баримт (факт), нөхцөл байдлыг эргэлзээнд оруулсан үйлдэл хийж болохгүй гэдэг зарчим бий.

Харин мөрдөн байцаалт эхэлсэн хэрэгт парламентын мөрдөн шалгалтыг явуулахад хүрвэл уул мөрдөн байцаалтыг зогсоож парламентын мөрдөх тусгай комисс гаргаж ЭБШ хууль тогтоомжийн дагуу ажиллуулдаг зарим орон буйг номонд тэмдэглэсэн байдаг. Үнэн хуудлыг үзэж мэдэх учиртай.

**Объект, субъектыг тодруулахын хамт ПХШ-ын арга хэлбэрийг ангилан үзэж, улмаар хуулиар зөв тодорхой журамлах нь чухал юм.**

#### **Дөрөв. Парламентын хяналт**

журамд заасан бий.

#### **шалгалтыг ангилахуйн ач холбогдол**

ПХШ-ын цар хэмжээ, ач холбогдлыг аль болох гүйцэд ойгдох арга зүй нь түүнийг оновчтой олон шалгуураар ангилж харуулах явдал юм. Ангилах шалгуур цөөнгүй. Үүнд:

1) **Субъект буюу хянан шалгах үүргийг хэрэгжүүлэгч байгууллагаар нь:**

1.1. **Парламент бүхэлдээ хэрэгжүүлэх хяналт шалгалт (ХШ) (асуулга, тайлан сонсох, ерөнхий шүүмж итгэл үзүүлэх эсэх тухай санал хураах г.м.)**

1.2. **УИХ-ын гишүүний ХШ (Энэ нь бүрэн бие даасан бус боловч сонгогдсон тойрог, сонгогчдын тавьсан асуудал, санаачлан буй хуулийн төсөлтэй холбоотой танилцуулга, судалгаа авах, биечлэн үзэх, асуулга, асуулт тавих гэх мэт)**

1.3. **Парламентын бүтцийн нэгж, хэсгээр хэрэгжүүлэх ХШ (Байнгын ба түр, тусгай хорооны сонсгол, шалгалт, тусгай комиссын мөрдөн шалгалт г.м.)**

1.4. **Парламентын бүтцэд ордоггүй байгууллагаар дамжуулан даалгавараар гүйцэтгүүлэх ХШ (Улсын аудит, ХЗҮК гэх мэт АНУ-д шинжлэх ухаан мэдээллийн алба, ХБНГУ-ын Бундестагийн батлан хамгаалах асуудал эрхэлсэн бүрэн эрхт төлөөлөгч, Тооцооны танхим г.м.). Энэ нь парламентын хянан шалгалтад олон түмнийг оролцуулахаас ялгаатай.**

Аливаа хяналт шалгалтдаа иргэд, мэргэжилтэн нарыг оролцуулах нь парламент, түүний байгууллагуудын эрх хэмжээний асуудал, тэдэнд тавигдах ардчилсан ёсны шаардлага мөн.

2) **ПХШ-ыг хэрэгжүүлж буй цаг үеэр нь:**

2.1 урьдчилсан (Угтуулан тавих);  
2.2 явцын (тод хязгаарлахгүй, ялангуяа хуулийн биелэлтэд);  
2.3 эцсийн хяналт шалгалт гэж ангилна.

Жишээлбэл, парламент улсын төсвийн төслийг хянан хэлэлцэхийн

түлд Засгийн газар, түүний гишүүд, хүрээ салбартаа төсвийн орлогын эх үүсвэрийг гүйцэд тооцож, нөөцийг илрүүлж чадсан эсэх, зарлагын зайлшгүй хэрэгцээг тусгаж, үр ашигтай зарцуулахад хуваарилсан эсэхийг урьдчилан /батлахаас өмнө/ шалгаж дүгнэлт хийх нь чухал. Ингэж чадвал "тодотгол" гэж нэгэнт баталсан хуулиа нуудаг ноцтой зарчмыг арилгаж чадна.

Эдгээр нь энэчилэн асуудлыг зөв шийдвэрлэх, зөрчил гажуудлыг цаг тухайд нь арилгах, үр дүнг бодитой үнэлэх, сургаж авах зэрэг тус тусын үүрэг ач холбогдолтой.

3) **ПХШ-ыг агуулга чиглэлийн хувьд:**

- хүний эрхийг сахин хамгаалах;  
- санхүүгийн;

- батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг;

- байгаль орчны хамгааллын;  
- олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн;

- төлөөлөн гаргах (хууль) эрх зүйн акт хэм хэмжээний гэхчилэн улс бүрийн хуульд заасан гоц чиглэл бий;

- утга бол хууль, гүйцэтгэгч хоёр хаа байна тэнд ПХШ хүрэлцэх ёстой бөгөөд энэ нь гагцхүү Засгийн газар түүний гишүүдээр дамжих эцсийн дүнд түүнтэй хариуцлага онцлог, эрэмбийн зарчим бий.

4) Төрийн буюу удирдлагын хэлбэр, дэглэм нь гүйцэтгэх эрх мэдэлд парламент хяналт тавих боломжоор нь:

4.1. хянан шалгах эрхгүй;

4.2. хязгаарлагдмал эрхтэй;

4.3. бодит бүрэн эрхтэй хэмээн ангилж болно. Хэмжээгүй эрхт хаант засаг, дангаар дарангуйлагч засгийн үед парламентын хяналт шалгалт байх боломжгүй. Авторитари дэглэмд ойртох тусам хязгаарлагдаж хэлбэрлэдэг ордог.

**Ардчилсан дэглэм бол парламентын хяналт шалгалт жам ёсоороо хэрэгжих зайлшгүй нөхцөл юм.** Иймд ПХШ-ыг ярихдаа тухайн орны улс төрийн ба төрийн дэглэмийг иш үндэс болгон

оношилж болно. Монголд бодитой, бүрэн дүүрэн хяналтын орчноос хязгаарлагдмал руу чиглэсэн хандлага илэрч байна. Өдгөө парламентын цөөнхийн (улс төрийн) хяналт ор нэрийн төдий болсон, мөрдөн шалгах зэрэг илүү үр дүнтэй аргаас татгалзсаар буй зэрэг нь уг хязгаарлагдмал тийшээ байгаагийн илрэл мөн.

5) ПХШ-ыг хамрах асуудлын хүрээгээр нь нийтлэг (ерөнхий), тусгай (тодорхой) гэж ангилна (Засгийн газрын үйл ажиллагааны ерөнхий хэлэлцүүлэг, сайдад асуулга тавих хоёрын ялгааг бод).

6) Ажиллагааны журмаар нь нээлттэй, хаалттай ХШ гэж бий. Ил тодын зарчмыг хэрэгжүүлэх өргөн, явцуу хоёр зам байдаг гэсэн үг.

7) ПХШ-ыг үүсгэх үндэслэлээр нь хууль зүйн, улс төрийн, байгал-техникийн шалтгаанаар гэж хуваана. Эрх зүйн зөрчилтэй асуудлыг хууль зүйн үндэслэлээр, улс төрийн шалтгаантай бол (хуйвалдааныг илрүүлэх, бодлогын зөрөөг арилгах зэргийн улс төрийн үйлдэл, явдалтай холбоотой бол) олонхи, цөөнхийн хяналт шалгалтыг хуулийн дагуу үүсгэн явуулна. Гэнэтийн аюул осолтой холбоотой бол байгал-техникийн шалтгаантай гэнэ.

8) ПХШ-ыг үүсгэх шалтаг нь нийгмийн, байгал-техникийн гэж байна. Тэр үүднээс тогтмол (төлөвлөгөөт), гэнэтийн гэж 2 хуваана. Төсвийн гүйцэтгэлийн, мөнгөний бодлогын гэх мэт жил, улиралаар тооцдог тогтмол хяналт шалгалт байдаг бол урьдчилан тооцоогүй улс төр, хууль зүйн ноцтой үр дагавар бүхий гэнэтийн осол, гамшиг, хямрал нөмөрвөл гэнэтийн хяналт шалгалт хийхэд хүрдэг. Иймд хүргэсэн үйл явдлыг шалтаг гэж үздэг. Орчин үед тэнхөнгөнийн аюул сүйрэл ПХШ-ын анхаарлыг ихэд татах болжээ. Энэ нь хийсвэр бус, бодитой байх шаардлагатай. Парламентын гишүүд, Засгийн газар, түүний гишүүний албан хариуцлагатай холбоотой томоохон осол, хүний амь нас, хөрөнгийн кохирол, түүнчилэн олны хамарсан

гамшиг тохиолдох нь бий. Тэр болгонд парламент нүд анин, чих бөглөн суух ёсгүй.

ПХШ-ыг өмнө тэмдэглэсэнчлэн аль тогтолцоонд явуулж буйгаар нь гаднын, дотоодын, үр дүнгээр нь бодитой, хуурмаг гэхчилэн өөр, өөр шалгуураар ангилж ч болно.

*Тав. ПХШ-ын үндсэн арга, хэлбэр: Зөв сонгох нь*

5.1. Парламентын хяналт шалгалтын бүрэн эрхийг ямар арга, хэлбэрээр хэрэгжүүлбэл илүү үр нөлөөтэй болгох вэ? гэдэг нь парламентат ёс, түүгээр дамжсан төрийн удирдлагын амин чухал асуудал мөн.

Юу хийхээ мэддэг ч яаж хийх нь тодорхойгүй бол хүссэн үр дүнд хүрдэггүй билээ. Арга хэлбэр хоёр агуулга, хэлбэрийн нэгдэл бөгөөд хууль зүйн хувьд материаллаг ба процесс (хэлбэр)-ийн эрх зүйн хоёр талтай юм. Арга нь ажил хэргийн агуулгыг бүрдүүлж, хэлбэр нь түүнд зохицон амилуулдаг нөхцөл нь болно. Хариц энэ хоёр зөрвөл ажлыг унтраадаг. Жишээлбэл, асуулга тавиад хэний гаргасан ямар зөрчил гажуудал байна, түүний шалтгаан үр дагавар нь юу вэ? гэдгийг илрүүлээд орхих бус, засах арга хэмжээг тодорхойлж, зэм хариуцлага тооцсон шийдвэр (хэлбэр) гаргана. Зөрчил гажуудлын эзнийг тогтоолгүй, зэмлэлгүй өнгөрөөвөл цагийн гарз болохоос цаана дутагдлыг бугшуулж, буруутныг урамшуулдаг. Асуулгыг мэдээлэл авах асуултаас ялган, агуулгыг тодорхойлж, хэлбэрийг нь тохируулах хэрэгтэй гэх мэт. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтад Засгийн газрын мэдээлэл сонсох, олонхи, цөөнхийн хяналт гэхчилэн шинэлэг арга, хэлбэр төлөвшиж буй хэдий ч уламжлалт хэлбэр нь үлбэгэрдүүхэн давтагдаж, илүү үр нөлөөтэй зарим хэлбэрээс татгалзсаар ирвэ. Өдгөө.

1) Чуулган, хуралдаанаар Засгийн газрын мэдээлэл, тайлан сонсох.

2) Засгийн газар, засгийн газрын гишүүнд асуулт тавьж хариу

мэдээлэл авах;

3) Асуулга тавьж, чуулганд хариу сонсож дүгнэлт өгөх;

4) Тодорхой асуудлаар байнгын хороо, ажлын хэсэг үзлэг шалгалт хийх;

5) Туслах болон судалгааны байгууллагаар мэдээлэл цуглуулгаж дүгнэлт хийх зэрэг үндсэн арга, хэлбэр зонхилж байна. Эдгээрийг дэлхийн улсуудын ПХШ-ын үндсэн хэлбэрүүдтэй жишин үзвэл юу харагдана вэ?

5.2. Дэлхийн томоохон орнуудын (АНУ, Англи, Франц, Герман, Орос зэрэг) судлаачдын түүвэрлэн гаргаснаар ПХШ-ын дараах арга, хэлбэр байна:

1) Төрийн гүйцэтгэх дээд байгууллага, албан тушаалтанд асуулт тавих;

2) Тэдгээрт асуулга тавьж, хариуг хэлэлцэх (интерпелляци);

3) а) Засгийн газарт ул итгэх; б) эсхүл зэмлэн буруушаах тогтоолын төсөл оруулж санал хураах;

4) Засгийн газарт итгэл хүлээлгэхээс татгалзах;

5) Засгийн газар, сайд нарын үйл ажиллагааны тухай илтгэл, тайлан хэлэлцэх;

6) Парламентын ажил хэргийн сонголт ("сонсон хэлэлцүүлэг");

7) Парламентын мөрдөн шалгалт;

8) Парламентын дэргэдэх тусгай албадын хяналтын үйл ажиллагааг чиглүүлэх.

9) Импичмент буюу парламентын (сенатын) шүүхээр дээд албан тушаалтны хэрэг хэлэлцэх /Монголд бол Үндсэн хууль зөрчсөн тухайд Цэцийн дүгнэлтийн дагуу албан тушаалтны зөрчлийг хэлэлцэж огцруулах мэт/;

10) Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын бүрэлдэхүүнийг (хянан хэлэлцэх) томилоход хянан оролцох;

11) Улсын төсвийн гүйцэтгэлийг хянан шалгах (зөвхөн нэг хэлбэр биш бие даасан хяналт гэж тооцдог).

12) Олон улсын гэрээг соёрхон батлах, нэгдэн орох, цуцлахаар

хянан үзэх зэргийг үндсэн хэлбэр хэмээн тооцсон байх аж.

Эдгээрээс манай УИХ бараг талыг нь хэрэглэдэг. Харин 36, 5, 6-ааг бараг хэрэглэдэггүй, 12-ыг хяналт шалгалтын түвшинд авч үздэггүй, 7, 9 нь огт байхгүй буюу 7-г хэрэглэхээс татгалздаг. Тийнхүү татгалздаг хэлбэр нь дэлхийн жишигт нийцсэн парламентын мөрдөн шалгалт юм. Түүний оронд "ажлын хэсэг" гаргадаг нь нэлээд хэмжээгээр оромдох байдалд хүргэсэн ажлуу.

Түүнийг УИХ, түүний байнгын хороодоос 2006-2009 онд ажлын хэсэг томилж хийсэн шалгалтын тоо баримт харуулж байна. (Хүснэгт-1)

Энэчилэн асуулга, асуулт, тайлан сонсох мэтийн гол хэлбэрүүдийг

мэдээлэл авах төдийгээр ашиглах биш, харин хууль яаж "ажиллаж" ямар үрдүнд хүрч буй, Засгийн газар түүний гишүүний үйл ажиллагаанд илэрч буй зөрчил, улс төрийн бодлого, практик хоёрын зөрөөний шалтгаан, гэм буруу, түүнийг арилгах арга замыг олж тогтоон эцсийн шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай.

5.3. Хэлбэр хичнээн янз байсанаас онц шалтгаалахгүй хамгийн гол нь тэдгээрийг яаж илүү үр нөлөө, үлдэцтэй болгох вэ? гэдэг үнэлэмжийн асуудалд анхаарал хандуулах цаг болжээ. Хянан шалгалтын үйл ажиллагаанд үр нөлөө гэдэг үнэлэмжийн шаардлага бий. Шалгалт бүр ажил

хэрэгт эерэг үл мөр үлдээсэн байх жамтай. Эл шаардлагыг дээр дурдсан болон байж болох бусад арга хэлбэрийг жинхэнэ утгаар нь хэрэглэснээр хангаж болно.

Хуульчилан баталсан төсвийн хөрөнгийг хэдэн зуун сая, тэрбумаар нь хэтрүүлсэн, албан хариуцлага алдаж хортой архи, хүнс хоол, хүйн халдвар мэтийг тарааж олон хүний амь нас, эрүүл мэнд хохироосон, хилийн чандад мөнгөөр мөрийтэй төглож эрүүгийн хэрэг үйлдэн төрийн нэр хүндийг гутаасан, хууль бус амлалт хийж ард олныг хууран мэхэлсэн, мөнгө тарааж сонгогчийн санал худалдаж авсан, хууль буруу гаргаж том хэрэгтнүүдэд ял завшуулсан, хууль буруу хэрэглэж гадаадынханд алт эрдэнээ олон арван тооноор нь үнэгүй завшуулаад эцэст нь өр зарганд орсон, лицензийн эрхийг илт хэтрүүлж, үнэлж баршгүй эрдэнийн ордуудыг тараан хувьд өмчлүүлж, хэвлийн баялаг дахь ард түмний хөрөнгө, төрийн нийтийн өмчийг дэлхийн зах зээлд дур мэдэж арилжихад хүргэсэн, эрх мэдэлтнүүд дундаас нь хувьдаа идэж завшсан, улс, орон нутгийн хэмжээнд дэг журам алдуулж, хүний болон улс орны аюулгүй байдалд занал учруулсан гэх мэт олон арван ноцтой зөрчил яригдсаар, шалгасаар үр дүн юу болов гэхээр замхардаг. Гэтэл сүүлийн үед энэ мэтээс сайд асан Отгонбаяр, тэдэсийн хөлд үргэдэв үү гэмээр

Хүснэгт-1

№	Хянан шалгагчийн нэр	Ажлын хэсгийн тоо		Дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн байдал				Зөвхөн танилцсан			Холбогдох газарт мэдэгдэн		Шалгалтын үр дүнг гаргааргүй	
		Хийсэн үзлэг шалгалтын тоо	Шалгалтын тоо	Чуулганаар хэлэлцсэн	Тогтоол гаргасан	Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн	Шийдвэр гаргасан	УИХ-ын дарга	Байнгын хорооны дарга	Намын бүлэг	Ажлын хэсэг	Холбогдох газарт мэдэгдэн	Шалгалтын үр дүнг гаргааргүй	Шалгалгүй орхисон
1	Улсын Их Хурал <sup>14</sup> (захирамжаар-31 тогтоолоор-5)	36	24	3	3	4	4	3	6	-	3	1	5	12
2	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	46	41	1	1	13	12	-	5	-	3	7	12	5
3	Эдийн засгийн байнгын хороо	36	12	-	-	5	5	2	3	-	1	2	-	24
4	Хууль зүйн байнгын хороо	18	12	-	-	10	5	-	1	-	-	2	1	6
5	Төсвийн байнгын хороо	32	26	-	-	14	14	-	8	-	-	2	1	6
6	Төрийн байгуулалтын байнгын хороо	30	17	-	-	9	9	-	5	-	1	2	1	13
7	Нийгмийн бодлогын байнгын хороо	25	19	1	1	7	3	-	4	-	-	4	6	6
8	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	28	17	-	-	4	3	-	5	-	-	1	9	11
Бүгд <sup>15</sup>		251	168	5	5	66	55	5	37	-	8	21	35	83

<sup>14</sup> Дээрх хугацаанд УИХ-ын даргын захирамжаар 31, УИХ-ын тогтоолоор 5 ажлын хэсэг байгуулжээ.

<sup>15</sup> УИХ-ын Тамгын газар, Судалгааны төвийн Код: СТ 09/416. "УИХ-ын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүд, тэдгээрийн үйл ажиллагааны талаархи статистик мэдээлэл"-ийг эх сурвалж болгон авсан болно. -Б.Ч.

доогуур зиндааны зарим албан тушаалтныг эс тооцвол хариуцлагаа тулж хүлээсэн их тушаалтан алга. Хүний мууд дурлалагтаа үүнийг хэлсэнгүй. Хууль, шударга ёсыг бодсон хэрэг. Осол цалгар юм бүхэн дээр хариуцлагаар сүрдүүлсэн сүржин үг дуулиан тарьж, дүр үзүүлэх, хурал цуглаан хийж ажил хэрэгт ямар ч нэмэргүй хоосон лоозогнож, шударга тэмцэгчийн дүр эсгэн албан тушаалаа хамгаалах төдийгээс хэтрэхгүй байгааг ард түмэн харсаар, харамссаар байна. Хоосон маргаанд хамаг цаг мөнгөө барчихаад эцэст нь хуулиудаа нэг хоёрхон өдөр, ялангуяа чуулган завсарлахын өмнөх өдөр арав, хориор нь "беендеж", баталсан нэр зүүгээд орхиод. Түүнийг хэдэн арав, заримдаа 100 гаруй хоног оор нийтлэлгүй орхиод хөдөөлцгөөж ийм тийм хууль баталж амжилт гаргах хэмээн сайрхах явдал зуршил болох нээ. Үүнийг бодит судалгаа харуулсан билээ.<sup>14</sup>

Энэ бүхэн УИХ хууль, тогтоолын биелэлтийг шат шатандаа хариуцан хангах үүрэгт тангарагтай олон мянган ажилтнаас бүрдсэн Засгийн газар, түүний бүх шатны байгууллагын үйл ажиллагааг байнга ажиглан хянаж, шалгах, өөрөөр хэлбэл бодлого, үр дүн хоёрын, хууль, гүйцэтгэл хоёрын амьг нийлүүлж зөрөөг арилган улс орноо эрсдэлгүй хөтлөх үүргээ хараахан гүйцэд биелүүлэхгүй байгаагийн илрэл биш үү? Хэрвэ мөн бол үр нөлөөний талаар онцлон анхаарах цаг болжээ.

### **Зургаа. ПХШ-ын үр нөлөөг дээшлүүлэх тухайд хэдхэн үг**

Энэ бол олон хүчин зүйлээс шалтгаалах зорилт юм. Гэлээ ч давагдашгүй хүчин зүйл бишээ!

**Парламентын хяналт шалгалтын үр нөлөөг "юу болчихвоо энэ чинь" гэмээр эрс дээшлүүлэхэд наад зах нь хоёр**

гол чиглэлээр зарчмын өөрчлөлт хийх хэрэгтэй байна.

**Нэгдүгээрт.** Одоо хэрэглэж буй ХШ-ын үндсэн хэлбэрээ агуулга, механизмын хувьд эрс нарийсгаж мэргэшингүй, тогтмол хүчин чадалтай болгох зохион байгуулалт, эрх зүйн арга хэмжээ авах нь зүйтэй. Юуны өмнө төрийн эрх мэдэл хуваарилсан Үндсэн хуулийн уг зхний заалтыг сэргээж хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хяналт тэнцлийн тогтолцоог эрүүлжүүлэх нь үзэмжийн хэрэг бус, зарчмын асуудал мөн. Эрх мэдлийн энэ хоёр тогтолцоо бүрэлдэхүүний хувьд хутгалдсан учир ялангуяа парламент "гаднын хяналт" тавих эрх, боломжоо алдаж, намаар, бас мөнгөөр дамжсан Засгийн газрын эрхшээлд оржээ. Үүний хамт Үндсэн хуульчилсан бусад (УИХ-ын ба дэгийн хууль, Засгийн газрын тухай, Төсвийн байгууламжийн болон процессын хууль, ХЭҮК, сонгуулийн хороо, аудитын зэрэг) хуулийг цогцоор нь хяналт шалгалтын бүрэн эрхээ бодитойгоор хэрэгжүүлэх механизм талаас нь эргэн харж тодруулах, уялдуулах, нэмэлт хийх шаардлага тулгарч байна. Жишээ нь, асуултаар олсон мэдээллийн мөрөөр практик арга хэмжээ авдаг, асуулгыг албан тушаалын хариуцлага тооцохтой холбодог, тайланг Засгийн газрын үйл ажиллагааг өргөн шүүмж болгон хэлэлцэх буюу парламентын "сонсон хэллцүүлэг"-ийн маягаар явуулах гэх мэт. ХЭҮК-ын юу хийснийг 2 жилд 1 удаа чуулганаар сонсох нь дээр үү? Харин хүний эрх зөрчигдөж байгааг парламентад өмнөөс шалгуулж, дүгн чүүлганд сонсож, мөрөөр нь дорвитой арга хэмжээ авдаг болгох нь илүү үр дүнтэй юу? Сайд нараас асуултын хариу сонсоно гэж хоёр гуравхан гишүүн сууж (телевизээр харахад) оромддог, ажлын хэсэг томилж гаргаад орхичихдоогоо

ялтай билээ. Бод л доо. Аливаа хяналтыг үр ашиг, хариуцлага тооцохтой холбох шаардлагыг өндөржүүлэх нь туйлын чухал.

**Хоёрдугаарт.** Өөрийн практикт түшиглэн дэлхийн улсуудын жишигийг харгалзан парламентын хяналт шалгалтын жам ёсны буюу зайлшгүй хэрэгтэй хүчтэй шинэ арга хэлбэрийг хууль зүй, ажил хэргийн жинхэнэ агуулгаар нь нэвтрүүлэн ашиглаж, хэвшүүлэх зорилт тулгамдаж байна.

ПХШ гэдэг ёслолын ажиллагаа биш. Ёс нь гажсаныг эрслэн засаж гэмтэнд хариуцлага тооцоход тохирсон нэлээд үр дүнтэй хэлбэр нь парламентын мөрдөн шалгалт юм. Түүнийг хэрэглэх, нэвтрүүлэх асуудлыг бид аль хэдийнээс санал болгож ирсэн, зарим ном товхимолд бичиж байсан<sup>15</sup> боловч анхаарч үзэхийн оронд хий хардан үгүйсгэж ажил хэрэг хохироосоор л байна. Иймд уг хэлбэрийн учир холбогдлыг энд тухайлан тэмдэглэе!

### **Долоо. Парламентын мөрдөн шалгалтын учир шалтгаан, ач холбогдол**

#### **7.1. Яагаад ойлгохыг хүсэхгүй байна вэ?**

"Мөрдөн шалгах" гэсэн нэр томъёог "хэрэг бүртгэх", "мөрдөн байцаах" гэдэг хоёр үйл ажиллагааны нийлбэр гэж эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд үздэг. Түүнийг бас Үндсэн хууль, парламентат ёсноо арай өөр агуулгаар хэрэглэдийг анзааралгүй зөвхөн ЭБША-ны талаас нь ойлгож санал зөрөлдөөд байна уу даа. Тэгвэл тэр өөр агуулга гэдэг нь юу болохыг товч дурдъя.

Агуулга, хэлбэр хоёр тохирч байх нь амьдралын диалектик. Зөргө гажвал сүйтгэл, түйтгэл авчирна. ПХШ-ын цөөнгүй хэлбэрийн дотроос мөрдөн шалгалтын агуулга нь улс

<sup>14</sup> Дээрээ авлигатай бол доош доошоо бийд эргэлзэх хэрэггүй гэж өгөөдсөн нь бий.

<sup>15</sup> Хууль зүйн үндэсийн хүрээлэн "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2007-2010 оны 1 дүгээр улирлын бүх дугаарт нийтэлсэн хуулиудын батлагдсан нийтлэгдсэн өдрөөр нь тооцон гаргахад ним үзүүлэлт гарсан.-Б.Ч

<sup>16</sup> Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. I дэвтэр. УБ. 2008 он. 93 дахь тал.

төр, хууль зүйн арга механизмыг хослуулан ашиглаж шинжин тогтоохоос илүү нааштай арга замгүй болсон ноцтой үр дагавартай, ихээхэн ээдрээтэй хэрэг явдлын учрыг олж, зангилааг тайлахад оршдог. Гэтэл түүнийг хэн нэг этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцааж тогтоох төдийд ойлгон, үгүйсгээд байна уу гэлтэй.

Шүүх эрх мэдлийн байгууллага бол хэрэг, маргааны үйл баримтыг эрх зүйн ухамсрын үүднээс үнэлж, үйлдэл явдал хууль хэрэглэн шийдвэрлэдэг. Түүнээс биш хэргийг улс төрийн хэм хэмжээ, зүй ёсны үүднээс шалгаж тогтоодоггүй. Улсын дотоодод төдийгүй гадаад орчинтой холбоотой улс төрийн "зангуутай" гэмт явдал, засаг төрд аюултай хариуцлагагүйн, байгал-техникийн осол сүйрэл улс орон, засаг төрийн үйл ажиллагааны хүрээнд үе үе үүсч гардаг. Улс гүрэн, нам, холбоо дамнасан эдийн засаг, мөнгө санхүү, улс төр бизнесийн холбогдолтой хуйвалдаан, үндэсний аюулгүй байдалд халгаатай бусармаг далд үйлдэл, хүний аюулгүй байдал, Үндсэн хуульт байгуулалд харшилсан улс төр, шашны харгис урсгал (сект)-уудын далд явуулга гээд эдийн засаг-нийгэм улс төрийн харилцаанд үе үе үүсдэг, учрыг нь олж тунгаахад түвэгтэй, "эзэн тодгүй" ноцтой үйл баримт тохисдог. Олон улсын амьдралын баримтаар үзвэл мөнгө, хөрөнгийн "урхитай" засгийн эрхийн төлөө хуйвалдаан чухамхүү парламентын хүчирхэг хяналт шалгалт шаарддаг. Төр, нийгмийн зүтгэлтнийг улс төрийн шалтгаанаар хороосон хэргийг ЭБША-ны журмаар мөрдөн тогтоох боломжтой хэдий ч алуурчны ард суугаа эздийн үүр, хуйвалдаан мэтгийг нь илрүүлэх, захиалагч гэх улс төрийн хүчнийг олж тогтоох улс

дамнасан асуудал ч гардаг. Өнгөрсөн зууны эцсээрх АНУ, Франц, Германы ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийн үед зэвсгийн наймаа, улс төрийн буулт хийх зэргээр гадаад улс орноос хууль бус хандив, харамж сэм авч, нам, сонгуулийн компаниа санхүүжүүлж байсан ("Enron" концерноос хандив авсан Бүгд найрамдахчуудын сан", Г.Колийн хэрэг" гэх мэт) том том хэрэг хуйвалдааныг чухамхүү парламентын мөрдөн шалгалтын оролцоотойгоор илрүүлсэн гэдэг.<sup>16</sup>

Монголд маань УИХ эдэрээтэй цөөнгүй хэрэг явдлыг "ажлын хэсэг" томилж танилцдаг практик тогтжээ. "Зориг агсныг хөнөөсөн хэрэг" гээд л ажлын хэсэг гарч байсныг бүгд мэднэ. Үр дүн хаана байна? Ажлын хэсэг ямар ч эрх мэдэлгүй юм чинь!! Ашигт малтмалын лиценз тарааж уурхай арилжсантай холбоотой асуудал, банк, эрүүл мэндийн хүрээнд гарсан ихээхэн гарз хохирол бүхий дуулиант асуудлуудаар цөөнгүй шалгалт хийж ирсэн байдаг. Өөрчлөгдсөн, илэрсэн, дээрдсэн юм байна уу? Үр дүн юу байгаа гэдэг ихэнхдээ бүрхэг өнгөрдөг. Банкууд дамлуурч, эмнэлгүүд "орон гэргүй" болж өвчтөнөө тэврэн тэнхээд хүрээ юу?! Тоон үзүүлэлтээр бол маш их ажил хийсэн харагдана. Хэлбэрээ олоогүй, эрх мэдэл, хүч тэнхээ султай ажлын хэсгийн шалгалт гэгчийн үр дүн нь ихэвчлэн "танилцах", "мэдэгдэх" төдий өнгөрдөг байна.

Зөвхөн УИХ-ын даргын захиралжаар гэхэд 31 удаа ажлын хэсэг томилсноос 24 нь ажиллаж, 7 буюу бараг 1/4 нь хийгдэж, дөнгөж 7-д нь шийдвэр гаргаж, 2/3 нь дүнг танилцах төдий өнгөрсөн харагдана<sup>19</sup>. Ийм маягийн хэлбэрдлээс гарахын тул шалгалтын тоог цөөлж, түвшинг дээшлүүлж, чанарыг эрхмэлэх, тэр дундаа ажлын хэсгийн оронд **мөрдөн**

шалгах аргыг эзэмших нь чухал болжээ.

## 7.2. Парламентын мөрдөн шалгалт гэж юуг хэлнэ вэ?

7.2.1. "Мөрдөн шалгахыг" парламентат ес хөгжсөн орнуудад ПХШ-ын нэгэн хэлбэр болгон хэрэглэж ирсэн байна. Энэ тухай "Олонхи оронд парламентын мөрдөн шалгах комисс (хороо) байгуулдаг... Тэдгээр нь зөвхөн төрийн байгууллагуудаас төдийгүй олон нийтийн байгууллагаас мэдээлэл, баримт бичиг шаардан авах эрхтэй" гэхчилэн бичсэн нь бий.<sup>20</sup> Түүний дотор ардчилалд шинээр болон сэргээн шилжиж буй орнуудын Үндсэн хуульд энэ асуудал илүү тодорхой тусгагдах болсон нь анхаарал татаж байна. Венесуэлийн 1999 оны Үндсэн хуулийн 222 дугаар зүйлд тус улсын "Үндэсний Ассамблей

\* Асуулга;

\* Мөрдөн шалгалт;

\* Асуулт зэрэг бусад хэлбэрээр хянан шалгах чиг үүргээ биелүүлнэ гэсэн бол Латвийн шинэ Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд Сеймийн гишүүний гуравны нэгээс цөөнгүйн шаардлагаар парламентын "мөрдөн байцаах комисс" байгуулж ажиллуулахыг заажээ. Мөн социализмын дараахь Болгарын Үндсэн хуулийн 79.1; Унгарын Үндсэн хуулийн 21.1-д мөрдөх, байцаан шалгах хороо байгуулж ажиллуулахыг заасан зэрэг жишээ байна.<sup>21</sup>

Мөн Бүгд найрамдах Турк улсын 1982 оны Үндсэн хуульд Үндэсний Их Хурал

\* Асуулт;

\* Судалгаа;

\* Ерөнхий хэлэлцүүлэг;

\* Асуулга болон Их Хурлын мөрдөн шалгах аргаар хянан

<sup>16</sup>Современный парламент. Теория. Мировой опыт. Российская практика. Под общей ред. ДЮН. О.Н.Булгакова. ЭКСМО. 2005. С.82-83

<sup>17</sup>Манаихан "Зоригийн хэрэг" гэж ярьж бичдэг нь түүх алслах тусам тэрээр нэг том хэрэгтэн байж гэх таамаг үүсгэж болох нүгэл юм даа. Уг нь "Зориг агсныг хөнөөсөн хэрэг" л дээ. –Б.Ч.

<sup>19</sup>УИХ-ын Тамгын газрын "Судалгааны төв"-ийн 2009 оны судалгааны тоо баримыг үндэс болгов.

<sup>20</sup>Конституционное право зарубежных стран. 2-е издание. Издательство. "НОРМА". М., 2005. С.316.

<sup>21</sup>Конституции государств Европы. Изд. "НОРМА". М., 2001. Том-2. С.309. Том-1. С.406. Том-2. С.543. Том-3. С.251-252.

шалгах эрх мэдлээ хэрэгжүүлнэ”<sup>22</sup> хэмээн зааж эдгээр хэлбэрийнхээ агуулгыг тодорхойлсон байна. Мөн хуулийн 100 дугаар зүйлд Үндэсний Их Хурлын мөрдөн шалгах үйл ажиллагаа, түүнийг эрхлэх хорооны тухай нэлээд нарийвчилан заасныг доор хураангуйлан дурдъя.

**7.2.2. Турк улсын Үндэсний Их Хурлын мөрдөн шалгах хороо (МШХ)-г ҮИХ-ын гишүүдийн 1/10-ээс доошгүйн хүсэлтээр улс төрийн нам, хүчний харьцааг баримтлан 15 гишүүнтэй парламентын шийдвэрээр байгуулж, дотроос нь хорооны дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, эхвлэл мэдээллийн төлөөлөгчийг сонгоно.** МШХ байгуулах хүсэлт гаргасан гишүүн бүрэлдэхүүнд нь ордоггүй. Тус хороо Ерөнхий сайд болон бусад сайдтай холбогдох гэмт үйлдлийг шалгах бөгөөд түүнд хамааралтай төрийн болон хувийн байгууллагаас мэдээлэл, нотлох баримт хүсэх, албан журмаар гаргуулах, Засгийн газрын гишүүд, холбогдох бусад этгээд, гэрч шинжээчдийг сонсох эрхтэй аж. Сайдын тайлбар (өөрийгөө өмгөөлөх үг) сонсоно. Үг хэлэхэд нь цаг хязгаарлахгүй. ЭБШХ-ийн дагуу гэрч, шинжээч байцаах, хураах, нэгжих, эрх чөлөөг хязгаарлах зэрэг хэрэгцээ гарвал шүүхэд бичгээр хандаж болно. Баримт бүрдүүлэх дэд хороо ажиллуулж болно. Мөрдөн шалгасан тайлан гаргаж асуудлыг хорооныхоо хаалттай хурлаар хэлэлцэн оролцсон гишүүдийн олонхиор шийдвэрлэнэ. Хэрэг зөрчил гаргагчийн асуудлыг Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэхээр ҮИХ-д оруулна. Нам, эвслийн бүлэг нь мөрдөн шалгахтай холбогдсон хэлэлцүүлэгт оролцохгүй. ҮИХ зөрчил гаргагчийг Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол

баримтыг 7 хоногийн дотор тус шүүхийн даргын ажлын албад илгээнэ.

Энэчилэн улс гүрнүүдэд улс төрийнх хүрээнд гадаадаас хууль бусаар санхүүжилт авах, авлигадаг зэрэг төр улсын аюулгүй байдалд ноцтой харш хэрэг явдалтай холбогдуулан явуулах парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа идэвхжиж байна. Үүнтэй холбогдон уг асуудлаар шинжлэх ухааны боловсруулалт, хуулийн зохицуулалт мэдэгдэхүйц нэмэгдэж байна.

**7.2.3. Манай хойд их хөршид “ОХУ-ын Холбооны Хурлын парламентын мөрдөн шалгалтын тухай” хууль 2005 оны 12 дугаар сарын 29-нд батлагдаж түүний дагуу гишүүн “субъектууд”-ын хууль гарчээ.** Эдгээр хуулийн тайлбар, ном зохиол олширсон байна. Эл сэдвээр эрдмийн зохиол бичсэн судлаач “Парламентын мөрдөн шалгалт нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоох байгууллагаас тогтоосон журмаар байгуулсан гусгай түр комиссоос хийж буй парламентын хяналт шалгалтын нэг хэлбэр бөгөөд комисс нь юуны өмнө иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчсөн үйл баримт, байгалийн болон техногенийн аюул сүйрлийн шалтгааныг арилгах талаар албан тушаалтны явуулж буй үйл ажиллагааны үр ашгийг шинжилнэ” гэж тодорхойлжээ.<sup>23</sup>

Оросын болон гадаад орны практик судалснаас үзвэл парламентын мөрдөн шалгалт бол парламентын олонхи, цөөнхийн аль нь ч явуулж болдог шууд, мэдээллийн, эцсийн, тодорхой хяналт шалгалт бөгөөд бодитой, хуурмаг, хууль зүйн, улс төрийн байж болно.

#### 7.2.4. Дэлхийн улсуудын

практикийг судлаачид парламентын мөрдөн шалгалт янз бүрийн улс оронд өөрийн онцлогтой боловч “гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны үр ашигтай, зүй зохистой байдал парламентын хяналт шалгалтын зүйлс болж байгаагаараа адилсана” гэж үзсэнийг хуваалцаж болно. Мөрдөн шалгах хороо, комисс байгуулах, хэрэг үүсгэх, санаачилах үндэслэл, түүний бүрэлдэхүүн бүтэц үйл ажиллагаанд мөрдөх журам улс бүрийн онцлогтой боловч үндсэн журмын хувьд 2 янз байна. Үүнд:

а) аядуу буюу сулавтар (зөвхөн өөрөө шалгаж мэдээлэл цуглуулж дүгнэлт хийж парламентад оруулдаг)

б) ЭБША-ны эрх эдэлж, мөрдөн байцаалттай бол зогсоож байгаад мөрдөн шалгаж, эсвэл мөрдөн байцаалтыг татан оруулж шалгаад, буруутныг хууль зүйн хариуцлагад шилжүүлдэг хатуу чанд дэглэмтэй ийм хоёр янз байх. Мөн шалгах зүйлсийг улс улсын хуульд нь өргөн, явцуу хоёр янзаар тодорхойлсон байдаг.

Турк улсын Үндсэн хуульд “Ерөнхий сайд болон сайд нарын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үйлдсэн гэмт хэргтэй холбогдуулан байцаан шалгах”<sup>24</sup> гэсэн байна. Парламентын мөрдөн шалгалтын тухай ОХУ-ын хуульд “Энэхүү хууль нь Оросын Холбооны Хурлын танхимуудаас нийгэм, төрд сөрөг үр дагавар бүхий үйл баримт, нөхцөл байдлыг мөрдөн шалгахад үүссэн харилцааг зохицуулна”, “Парламентын мөрдөн шалгалт нь:

1) ОХУ-ын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний ба иргэний эрх, эрх чөлөөг бүдүүлгээр буюу нийт олноор нь зөрчсөн үйл баримт;

2) Техногенийн шинжтэй онц тохиолдол үүссэний нөхцөл байдал,

3) байгаль, техногенийн

<sup>22</sup> Уг Үндсэн хуулийн 98, 99 дүгээр зүйлд “асуулт”, “судалгаа”, “ерөнхий хэлэлцүүлэг” гэж юуг хэлэх, “асуулгыг ямар бүрэлдэхүүн хэлбэр тавьж чуулганаар хэдийд яаж хэлэлцэх, Засгийн газарт итгэл хүлээлгэх санал хураах нөхцөл зэргийг заасан байна”

<sup>23</sup> Я.Е. Михайлава. Правовое регулирование института парламентских расследований в Российской Федерации // Автореферат на соискание ученой степени КЮН/ Омск 2009. С.11.

<sup>24</sup> БНТУ-ын Үндсэн хууль 98-100 дугаар зүйл

шинжтэй онцгой тохиолдлын үр дагавартай холбогдсон нөхцөл байдлыг тус тус хамаарна” гэжээ<sup>25</sup>.

Мөн хуулийн 20, 24-т зааснаар Мөрдөн шалгах Комисс (МШК) нь дээрх үүргийг хэрэгжүүлэхдээ:

- Засгийн газар, Холбооны болон түүний субъектын байгууллагууд, нутгийн удирдлагын байгууллага, албан газруудаас мөрдөн шалгалтад шаардлагатай бичиг баримтын хуулбар, мэдээлэл гаргуулан авах (Холбогдох албан тушаалтан шаардсан мэдээллийг 15 хоногт гаргаж өгнө);

- мөрдөн шалгах буй асуудлаар мэргэшлийн мэдээлэл бүхий нөхцөл байдлыг холбогдох албан тушаалтанаар тайлбарлуулах;

- сэжиглэгдэж яллагдаагийг этгээдийг урьж асууж лавлах;

- албан тушаалтан, иргэдэд комиссын бичгээр тавьсан асуултад тайлбар, хариу бичиж өгөхийг шаардах болон комиссоос мөрдөн шалгахад тус дөхөм болно гэж үзсэн мэдээллийг комиссоод илгээхийг мэдэгдэх эрхтэй юм.

Чухал шаардлагатай мэдээлэл (баримт материал) гаргаж өгөхөөс татгалзсан, комиссын асуултад өгөх хариуг оролцуулан бүрэн бус, худал мэдээлэл өгсөн, комиссын хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй албан тушаалтанд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх, буруутай зарим ажилтыг албан тушаалаас чөлөөлөхийг санал болгох эрхтэйг дээрх хуульд заажээ.

Онолын хувьд Мөрдөн шалгалт явуулах эрх нь “цөнхнийн эрх”, сөрөг хүчний эрх гэж үздэг. Түүнчилэн судлаачид: Комиссын бүрэлдэхүүнд оролцох тэгш эрхийг хангах; Мөрдөн шалгах зүйл (ажил

хэрэг)-ийг парламент хэр зэрэг нарийн тодорхойлноос түүний үр нөлөө тэр хэмжээгээр шалтгаална гэхчилэн үздэг.

Онцлон үзвээс Мөрдөн шалгах ажлыг сайтар боловсруулсан хуулиар зохицуулах нь зайлшгүй чухал бөгөөд ялангуяа түүнийг үүсгэх санаачилга гаргах, МШХ-ны бүрэлдэхүүнийг тогтоон батлах, хувийн сонирхол, улс төрийн нөлөөнөөс сэргэмжлэх зэрэгт ихэд анхаардаг бололтой.

Оросод Холбооны Хурлын танхим бүрийн гишүүдийн 1/6-ээс цөөнгүй нь ПМША явуулахыг санаачилж, 2/5-оос доошгүйн саналаар МШК байгуулах журам тогтоосон байна. Оросын Холбооны Хурлын жишээн дээр өгүүлбэл ПМШ-ыг үүсгэх үндэслэл нь түүний гишүүдийн анхааралд орсон /илт болсон/ үйл явдал, хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгчийн МШК байгуулах тухайн санал юм.

МШК мөрдөн шалгалт дууссаны дараа эцсийн үр дүнгийн илтгэл гаргана.

Түүнд:

- үйл явдлын шалтгааныг арилгах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар хэм хэмжээний акт;

- мөрдөн шалгах ажиллагаа явуулахад үндэслэл болохуйц үйл баримт (факт), нөхцөл байдалд хүргэсэн үйлдэл (эс үйлдэхүй)-ийн эзнийг албан тушаалаас нь чөлөөлөх (огцруулах) саналыг тусгана.

Парламент уг үр дүнгийн илтгэлийг сарын дотор хянан үзэж шийдвэрээ ерөнхийлөгч, Засгийн газар, прокурорт болон холбогдох

бусад байгуулагад илгээнэ. Түүнийг Засгийн газар, холбогдох бусад байгууллага хуралдаанаараа заавал авч хэлэлцээд хэрхэснийг парламентад сарын дотор харуултгэнэ

МШК-ын бүрэн эрхийн хугацаа нэг жилээс илүүгүй, мөрдөн шалгах ажлыг Төрийн Думын бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө хийж гүйцэтгэсэн байх журамтай. Өөрөөр хэлбэл: парламент тарчихаад байхад мөрдөн шалгалт явуулж болохгүй аж.

Энэ мэтээр бусдын жишиг, санал зөвлөгөө олныг өгүүлж болно. Харин тэр болгоныг гүйцэд ухаарах, манай нөхцөлд таарч тохирох эсэхийг сайтар тунгаах, үүний тулд өөрийнхтэйгээ жишиж, оноо алдаагаа дэнслэх хэрэгтэй байдаг. Сонсмогц ойлголын дүр эсгэж, хармагц харалганаар хуулбарлах гэж магтан дөвийлгөөд, өөрсдийгээ үгүйсгэн муучлахын эсрэг ямагт зогсох учиртай, бид!

Ийнхүү бусад орны жишиг жишээнээс үзвэл парламентын мөрдөн шалгалтаас жийрхэн болгоомжлох явдалгүй. Харин хүч султай оромдсон шалгалтаас арга ажиллагааны нарийн хууль барьсан мөрдөн шалгалтын арга, хэлбэрийг боловсруулж УИХ-ын хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлбэл осол сүйтэл ихтэй, онц ээдрээтэй хэрэг явдлын учгийг татаж, учрыг тайлан хужрыг тунгаан, гүйцэтгэх байгууллагын ажил үйлсэд нааштайгаар нөлөөлөх чадавын дээшлэхэд тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй. Шинэ зүйлд туйлын болгоомжтой ханд, гэхдээ ухраад байж болохгүй, урагшлах нь чухал гэхэд илүүдэх юун.





## Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахтай холбогдсон хоригийн тухай



Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Албаны дарга, Хууль зүйн доктор, профессор Л.Батжав

Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд бусдаас бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахтай холбогдсон хоригийг тусгахдаа энэ чиглэлийн асуудлаар өндөр хөгжилтэй орнуудад эрх зүйн ямар зохицуулалт байдгийг сайтар судалж, монголын онцлогт нийцүүлж боловсронгуй, тодорхой болгож хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн авч болох, болохгүй бэлэг, дурсгалын зүйл, үйлчилгээтэй холбогдсон асуудлыг гадаадын өндөр хөгжилтэй орнуудад хууль тогтоомжоор нарийн зохицуулдаг байна. Жишээ нь, АНУ-д бэлэг өгөхийг гүйх, шаардах, эсвэл зөвшөөрөгдөөгүй (хориглосон) эх сурвалжаас, эсвэл тодорхой шийдвэр гаргасныхаа төлөө юмуу нэг эх сурвалжаас олон удаа бэлэг авахыг хориглодог байна.

Төрийн албан хаагч албан тушаал эрхэлж байгаатай нь холбоотойгоор өгсөн бэлгийг өөрөө болон гуравдагч этгээдээр дамжуулан авах есгүй бөгөөд хэрвээ үүнийг зөрчсөн тохиолдолд энэ нь

хээл хахууль авсанд тооцогддог ажээ.

Зөвшөөрөгдөөгүй (хориглосон) эх сурвалж гэдэгт дараахь этгээдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа байгууллагаар тодорхой үйлдэл хийлгэхийг зорьж буй этгээд;

2. Тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа байгууллагатай хамтарч үйл ажиллагаа эрхлэхийг зорьж буй этгээд;

3. Тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа байгууллагын зохицуулж байдаг үйл ажиллагааг эрхэлдэг этгээд;

4. Тухайн төрийн албан хаагчийг албан үүргээ гүйцэтгэх, гүйцэтгэхгүй байхад нь нөлөөлөх сонирхолтой этгээд.

Бэлэг гэдэгт чухам юу хамаарахыг тодорхой зааглаж өгсөн байдаг. Бэлэг гэдэгт мөнгө, хөнгөлөлт зочлолт, зугаалга, үнэ төлбөргүй сургалт, тээврийн үйлчилгээ, хоол, байр, үзвэр, үнэт здлэл зэрэг мөнгөөр үнэлэгдэх ямар нэгэн зардлыг ойлгоно. Тэрчлэн төрийн албан хаагчийн эхнэр, нөхөр, аав, ээж, ах, эгч, дүү, бусад төрөл, төрөгсдөд тухайн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө өгсөн мөнгөөр үнэлэгдэх, дааж байгаа ямар нэгэн зардлыг мөн бэлэг гэж үздэг байна.

Харин хөнгөн зууш, ундаа, аяга кофе, баяр хүргэсэн ил захидал, тэмдэг зэрэг үнэ багатай дурсгалын зүйл, банкны хүү болон хөнгөлөлт, уралдаан тэмцээний шагнал, тэтгэвэр, тэтгэмж, хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээний дурсгалын зүйлийг бэлэг гэсэн ойлголтод хамааруулдаггүй байна.

Түүнчлэн бэлгийн болон үйлчилгээний үнийн дүнгийн дээд хязгаарыг тогтоож өгсөн байдаг. АНУ-ын төрийн захиргааны албан хаагч нь тодорхой нэг этгээдээс нэг удаа зах зээлийн ханшаар 20 доллараас илүүгүй, нэг жилд 50

доллараас илүүгүй бэлэг авч болдог ажээ. Тухайлбал, нөхөр нь Төрийн өмчийн хороонд ажилладаг бөгөөд төрийн өмчит нэг компаний захиргаа эхнэрт нь дуурь үзэх хоёр билет өгчээ. Харин билетийн үнэ 30 доллар гэж үзвэл нийт 60 доллар болно. Үүнээс хуулиар зөвшөөрсөн 20 долларыг хасвал 40 доллар илүү гарч байна. Тухайн албан хаагч 40 долларыг компаний захиргаанд төлөөд дуурийг үзэж болно, эсвэл дуурь үзэхийг татгалзаж билетийг буцааж өгөх шаардлага гарна.

АНУ-д төрийн албан хаагчид бэлэг өгсөн үйлдлийн сэдэл нь төрийн албан тушаал эрхэлж байгаатай нь холбоогүй, харин гэр бүл, садан, төрлийн болон хувийн дотно нөхөрлөлийн харилцаанд үндэслэж байвал бэлэг авахыг зөвшөөрдөг юм байна. Энд тухайн төрийн албан хаагч болон бэлэг өгөгч этгээдийн хувийн харилцааны түүх, бэлгийг зөвхөн өөрт нь өгсөн үү, эсвэл гэр бүл, бусад гишүүд, найз нөхдөд өгсөн үү гэдгийг харгалздаг. Мөн төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэсэн, эсвэл гүйцэтгээгүйтэй нь ямар ч холбоогүй, зөвхөн нийгэмд гавьяа байгуулсантай нь холбогдуулан өгч буй 200 доллараас илүүгүй бэлэн мөнгө, үнэт цааснаас бусад бэлэг, шагнал авах, түүнчлэн ийм шагнал гардуулах үеэр төрийн албан хаагч, түүний гэр бүлийнхэн юм идэж, зугаацаж болохыг хуулиар зөвшөөрдөг.

Тэхдээ энэхүү шагналыг авч болох эсэхийг тухайн байгууллагын ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьдаг албан тушаалтан бичгээр зөвшөөрсөн байх шаардлагатай. Ийм шагнал нь Нобелийн шагнал, Их сургуулийн хүндэт өргөмжлөл зэрэг болно.

Төрийн албан хаагчид хуулиар хориглосон бэлэг өгсөн тохиолдолд дараахь арга хэмжээний ал нэгийг авна. Үүнд бэлгийг нь эргүүлж өгөх,

зах зээлийн ханшаар үнийг нь төлөөд өөртөө авах, төрийн байгууллагад бүртгүүлж тушаах, эргүүлж өгөх боломжгүй, ялангуяа түргэн муудах барааг удирдах албан тушаалтан, эсвэл тухайн байгууллагын ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт гавих чиг үүрэг бүхий албан хаагчийн хяналт дор устгах буюу буяны ямар нэг байгууллагад өгөх зэргээр зохицуулдаг байна.

АНУ-д хуулиар төрийн албан хаагчид хориглосон бэлгийг хоёр хуваадаг бөгөөд тухайлбал, шууд буюу өөрөө авсан бэлэг, шууд бус бэлэг гэж ангилна. Шууд бус бэлэг гэдэг нь төрийн албан хаагчийн эхнэр, нөхөр, эцэг эх, ах эгч, хүүхдийн авсан бэлэг, хэн нэгэн этгээдээс тодорхой бэлэг авахыг хүссэн төрийн албан хаагчийн саналыг зөвшөөрч, хариуд нь үнэ бүхий зүйл авсан төрийн албан хаагч биш этгээдийн авсан бэлэг ордог аж.

Зан заншлын шинжтэй дор дурдсан бэлгийг удирдах албан тушаалтанд өгөх, түүнээс авах болон солилцохыг төрийн захиргааны албан хаагчид зөвшөөрдөг байна. Үүнд зах зээлийн ханшаар доллараас үл хэтрэх бэлэн мөнгөнөөс бусад бэлэг, цөөн албан хаагчийн хүрээнд албан газартаа идсэн хоол, зууш, гэр орондоо зочилж байгаа хүнд, гол төлөө найздаа өгч буй бэлэг, хувийн дотно байдлыг илэрхийлсэн бэлэг (цэцэг) гэх мэт орно.

Бэлэг дурсгалын зүйл, үйлчилгээ зэргийг ингэж нарийн тогтоож өгөөд төрийн захиргааны албан хаагчдад дараах зүйлийг хориглосон байдаг ажээ. Үүнд:

1) шууд болон шууд бус замаар удирдах албан тушаалтанд бэлэг өгөх ёсгүй;

2) бусад төрийн албан хаагчаас түүний удирдах албан тушаалтанд өгөхийг хүссэн бэлгийг дамжуулж өгөх эрхгүй;

3) төрийн захиргааны албан хаагч, түүнд шууд харьяалагддаг албан тушаал эрхэлдэггүй, мөн түүнтэй төрөл, садангийн болон хувийн дотно харилцаатайгаас бусад тохиолдолд удирдах албан тушаалтнаас бэлэг авах ёсгүй ажээ.

АНУ-д бэлэг, дурсгал өгөх, үйлчилгээ үзүүлэх асуудлыг ийнхүү маш тодорхой хуульчилж өгсөн нь төрийн албан хаагчийг нэгдүгээрт, авлигад өртлөө, хээл хахууль авлаа гэх элдэв хэл амнаас, хоёрдугаарт, үнэн худал нь мэдэгдэхгүй хэвлэл, мэдээллийн янз бүрийн гүтгэлэг, шуугиан дуулианаас хамгаалах чухал арга хэмжээ гэж үзэж байна.

Энэ бүхнээс улбаалан Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэхтэй шууд буюу шууд бусаар холбоотойгоор бэлэг болон үйлчилгээг шууд буюу шууд бусаар авахыг хориглох шаардлагатай. Бэлэг болон үйлчилгээ гэдэгт тухайн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхтэй шууд буюу шууд бусаар холбоотойгоор өөрт нь, эсвэл түүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнд үнэ төлбөргүйгээр буюу хөнгөлттэй үнээр шилжүүлсэн эд хөрөнгө буюу үзүүлсэн үйлчилгээг хамруулан ойлговол зохино гэдгийг ч хуульд тусгах хэрэгтэй. Гэхдээ төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн

хүний бусад этгээдээс хүлээн авах бэлэг буюу үйлчилгээний үнийн дүнгийн дээд хэмжээг хуульд тодорхой зааж өгөх нь маш чухал ач холбогдолтой. Хэн нэгний өгсөн буюу үзүүлсэн бэлэг, дурсгалын зүйл буюу үйлчилгээний үнэ нь түүнээс хэтэрсэн тохиолдолд төрийн албан хаагч энэ тухай байгууллагын удирдлага буюу ерөнхий менежерт бичгээр мэдэгдэж, улмаар уг мэдэгдлийг тухайн хүний Хөрөнгө, орлогын мэдүүлэгт хавсаргахыг, мөн тухайн бэлэг, дурсгалын зүйлийг цаашид хэрхэн зохицуулахыг хуульд тусгавал зохино.

Манайх шиг бие биедээ бэлэг өгөх дуртай, авсан юмуу өгсөн бэлгээрээ гайхуулах дуртай хүмүүст хуулийн ийм нарийн, тодорхой зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна. Юуг бэлэг дурсгал, үйлчилгээнд тооцож байх, тэдгээрийн үнийн дээд хэмжээ нь хэдэн төгрөг байх, мөн юуг бэлэг, дурсгал, үйлчилгээ авсан гэдэгт тооцохгүй байх зэргийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд зайлшгүй тусгах хэрэгтэй. Энд хамгийн их анхаарал хандуулж, зөв зохицуулалт хийх ёстой зүйл бол хуульд заасан дээд хязгаараас үнэ нь давсан бэлэг, дурсгалын зүйлийг яаж шийдвэрлэх (үнийг нэмж төлөөд авах, улсад тушаах, эзэнд нь эргүүлж өгөх г.м)-ийг, бэлэг нэрээр үл хөдлөх (орон сууцны байр, зуслангийн байшин), хөдлөх хөрөнгө (машин, хурдан морь г.м)-ийг нэг нэгэндээ шилжүүлдэг явдлыг хэрхэн зохицуулахыг тус тус хуульчилж өгвөл зохино.



## Боловсролын харилцаан дахь хүүхдийн эрхийн асуудал



Монгол Улсын боловсролын их сургуулийн багш О.Өнөрцэг

Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын бүрдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага дунд, дээд боловсролоос бүрдэнэ. Албан боловсролын тогтолцоо нь сургуулийн өмнөх боловсрол (цэцэрлэг), дунд боловсролын сургууль (бага, бүрэн бус болон бүрэн дунд) –аас бүрэлддэг. Бага, бүрэн бус болон бүрэн боловсролыг ерөнхийдөө нэгэн сургуулийн хүрээнд олгодог.

2006-2007 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсрол олгох 742 байгууллагад 94.7 мянган хүүхэд, ерөнхий боловсролын төрийн 590, хувийн 116 сургуульд 542.5 мянган хүүхэд, нийт 41 мэргэжлийн боловсролын байгууллагуудад 24766 суралцагч, төрийн 48, хувийн 116 их, дээд сургууль, коллежид 142.4 мянган оюутан залуус суралцаж байгаа<sup>1</sup> тухай албан ёсны тоо баримт гаржээ.

1990 онд Монгол Улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжсэн үеэс эхлэн хамгийн гол зорилгын нэг нь боловсролын салбарыг шинэчлэх, нийгмийн хөгжлийн загварт нийцүүлэн өөрчлөх явдал байв. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн хууль эрх зүйн баримт бичгийг тухайлбал,

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай хууль, Бага, Дунд болон Дээд боловсролын тухай хуулиудыг 1995 онд Улсын Их Хурлаас батлан гаргажээ. Тэдгээр хууль эрх зүйн баримт бичиг нь боловсролын удирдлагын хүрээнд ардчилсан, нээлттэй, ил тод байх, улсын сургуулиудын удирдлага, санхүүжилтэд төвлөрлийг сааруулах, сургуулийн менежментийг аймаг, орон нутгийн удирдлагад шилжүүлэх, их дээд сургууль, коллежүүдийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх болон хувийн боловсролын байгууллага байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг зарчмыг баримталж байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого нь боловсрол бол нийгмийн тэргүүлэх салбар бөгөөд эрчимтэй хөгжиж буй эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухаан, технологийн дэвшлийн чухал эх сурвалж байна хэмээн зааж өгсөн.

Монгол Улсын Боловсролын тухай хууль (2002) –д заахдаа “Монгол хүн бүр үндэс угсаа, хэл, арьс, нас хүйс, нийгэм эдийн засгийн байдал, эрүүл мэнд, ажлын байр, шашин шүтлэг болон хувийн зан чанараас үл шалтгаалан өөрийн төрөлх хэлээрээ боловсрол эзэмших эрхтэй (5.1.4-р зүйл), хүн бүр суурь боловсрол эзэмших эрхтэй, (6.3-р зүйл) бөгөөд Монгол

Улсын Үндсэн хуульд заасанчлан үнэ төлбөргүй суурь боловсрол эзэмшинэ (6.2-р зүйл) гэсэн байна.

Мөн одоогийн боловсролын хууль тогтоомжоор бага болон бүрэн бус дунд боловсролыг хүн бүр эзэмших бөгөөд бүрэн дунд боловсрол эзэмшихэд мөн үнэ төлбөргүй байна хэмээн заасан.

Монгол Улсад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яам (БСШУЯ) байна. БСШУЯ-ны чиг үүрэг нь улсын хэмжээнд боловсрол, шинжлэх ухаан, соёлын үйл ажиллагааг дэмжин, түгээн дэлгэрүүлэхэд оршино хэмээн хуульд зааж өгчээ. Мөн аймаг бүрийн засаг захиргаа, удирдлагын нэгжид аймгийн Боловсрол, соёлын газар байх бөгөөд тухайн орон нутгийн түвшинд боловсролын үйлчилгээг хариуцдаг. Эдгээр газрууд нь албан болон албан бус боловсролд холбогдох төрийн удирдлага болон менежментийг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг.

Манай оронд орчин үеийн боловсролын байгууллага бүрэлдэн тогтсон 70 гаруй жилийн хугацаанд ард иргэдэд боловсрол олгох талаар багагүй амжилт олсон билээ. Тухайлбал, 1921-1940 онд бүх нийтийг бичиг үсэгт сургах, 1941 оноос бага боловсролтой болгох, 1961 оноос бүрэн бус дунд боловсролтой болгох зорилтуудыг дэвшүүлэн 1989 оны байдлаар 16-49 насны нийт хүн амын 78.8 хувь нь бүрэн бус дунд буюу түүнээс дээш шатны боловсролтой, 12.7 хувь нь IY-VIII ангийн боловсролтой, 6.9 хувь нь бага ангийн боловсролтой, 1.6 хувь нь бичиг үсгийн боловсролтой болсон байна.<sup>2</sup>

Ялангуяа хүн амын дийлэнх хувь

<sup>1</sup> БСШУЯ, Боловсролын салбарын 2006-2007 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл, УБ, 2007 он

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газар, «Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр» УБ, 1995 он.

(44 хувь нь 0-15 насны хүүхэд, 29 хувь нь 16-30 насны залуучууд)-ийг хүүхэд залуучууд эзлэж байгаа тул боловсролын салбарыг хөгжүүлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаар анхаарал тавиж ажиллах шаардлагатайг нотолж байна. Монгол Улсын хүн амын 30 орчим хувийг бүрдүүлж буй хүүхэд, өсвөр үеийнхэн ямар нэгэн сургууль, боловсролын байгууллагад хамрагдан суралцаж буй тул хүүхдийн эрхийн тухай мэдлэг, ойлголт түгээх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг ажлыг ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежийн одоогийн тогтолцоонд түшиглэн зохион байгуулах, хэрэгжүүлэх ихээхэн нөөц бололцоо байна.

Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд хүний эрхийн олон улсын 40 гаруй гэрээ конвенцид нэгдэн орсон буюу соёрхон баталсан билээ. Мөн тус улсын Засгийн газраас олон улсын гэрээний эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, НҮБ-ын Хүний эрхийн хороо болон бусад төрөлжсөн байгууллагад 10 гаруй удаа өөрийн орны тайланг хэлэлцүүлж, зохих санал зөвлөмжийг хүлээн авсан байна. Мөн УИХ-аас Монгол Улсын «Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль»-ийг 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр баталж, хүний эрхийн үндэсний байгууллагуудын статусыг тодорхойлдог Парисын Зарчмын дагуу бие даасан байгууллагыг байгуулсан, улмаар 2003 оны 10 дугаар сарын 23-ны өдөр «Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр»

баталсан билээ. Ийнхүү Монгол Улс нь хүний эрхийн үзэл баримтлал, олон улсын хэм хэмжээ, стандартыг үндэсний хууль, эрх зүйн баримт бичгүүдэд тунхаглан мөн олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орох замаар баталгаажуулсан байна.

Гэвч хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах байдал төдийлөн хангалтгүй хэвээр байна. 2001 онд Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжийн дагуу НҮБ-ын Ерөнхий ассамблей 56138-р тогтоолын дагуу зөвлөх Пауло Сержио Линхейро нарын дэлхийн хэмжээний хүүхдийн эсрэг хүчирхийллийн дүр зургийг тодорхойлох судалгаагаар<sup>3</sup> хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь тухайн орны соёл, үндэстэн, ястны бүлэг, гэр бүлийн байдалаас үл хаммааран дэлхийн бүх оронд түгээмэл илэрч байгааг тогтоожээ. Ихэнх хүн хүүхэд эрхээ эдэлж, эрүүл саруул насанд хүрэгч болохын тулд хүчирхийлээс хамгаалагдсан байх ёстой гэдгийг мэддэг ч, ихэнх улс оронд хүчирхийлэл нь ёс заншил, ердийн үзэгдэл болон хүлээн зөвшөөрөгддөг байна. Энэхүү судалгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь 5 төрлийн газар тохиолддог болохыг илрүүлсэн бөгөөд түүний нэг нь сургууль, боловсрол олгох бусад орчин болж байгааг илрүүлсэн байна.<sup>4</sup>

Монголд, 2005 онд Английн хүүхдийн ивээх сан, Зохиостой хөгжил Жэндэр төвийн судлаачид хүүхдийн бие махбодыг, сэтгэл санааны эсрэг шийтгэлийг<sup>5</sup> тодруулах судалгааг хийжээ. Уг судалгаа нь сургууль, цэцэрлэг,

хорих анги, асрамж халамжийн төв гэсэн 4 салбарт хүүхэд бие махбод, сэтгэл санааны шийтгэлд хэр зэрэг өртөж байгааг болон шийтгэж, шийтгэхгүйгээр хүмүүжүүлэх бусад аргын талаархи хүүхэд, насанд хүрэгчдийн ойлголт, үзэл бодлыг судалсан байна. Уг судалгаанд зураг зурах, биеийн зураг, хандлагыг тандах, ярилцлагын аргуудыг ашиглан 595 хүүхдийг хамруулсан ба тэдгээр хүүхдүүдээс зөвхөн 12 нь л ямар нэгэн шийтгэлээр шийтгүүлж байгаагүй<sup>6</sup> гэж хариулсан нь хүүхдийн бие махбодыг, сэтгэл санааны эсрэг шийтгэл хэр зэрэг өндөр түвшинд байгааг харуулах юм. Мөн судалгаанд хамрагдсан 10-11, 14-15 насны хүүхдүүдийн 53,2 хувь нь сургуульд шийтгэл байнга тохиолддог хэмээн хариулсан нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх ёстой сургууль<sup>7</sup> нь эсрэгээр хүчирхийллийн орчин болж байгаа нь онцгойлон анхаарал татаж байна. Түүнчлэн хөдөөд судалгаанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 45,3 хувь нь зодуулдаг, 57 хувь нь хэл амаар доромжлуулдаг байна. Сургуулийн орчинд хүүхдийн эсрэг шийтгэлийг үзүүлж буй гол буруутнууд нь багш сурдан, хүмүүжүүлэгчид хийгээд үе тэнгийнхэн байсан нь харамсалтай.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шийтгүүлсэн шалтгаан (хувьар)<sup>8</sup>

2007 онд БСШУЯ, НҮБХС, МУБИС, ХЗҮК-ийн хамтарсан судалгаагаар судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн насны хүүхдүүдийн 80 хувь, сургуулийн бага

<sup>3</sup> UNICEF (2006) НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын “Хүүхдийн Эсрэг Хүчирхийллийн судалгаа”. 3 дахь тал.

<sup>4</sup> Мөн тэнд.


<sup>5</sup> Бие махбодын шийтгэл: хүүхдийг гараар болон ямар нэгэн зүйлээр (саваа, бус, оосор, гутал, бороохой г.м.) цохих, алгадах; өшиглөх, сэгсчих, түлэх, чимхэх, үснээс нь зулгаах; гэрийн хорионд оруулах, тусгаарлан хорих; гэрийн ажил хүчээр хийлгүүлэх, дэглэх, залхаах, хүүхдийг тав тухгүй буюу доромжилсон хэлбэр байдалд хүчээр байлгах, хүүхдээр биеийн хүчинд дасгалуудыг албадан хийлгэх; хүүхдийг түлэх, шархдуулах, г.м. Сэтгэл санааны шийтгэл: хэл амаар доромжлох, шоглох, ялгагарлах, үл хайхрах г.м. АХИС.

<sup>6</sup> АХИС, ЗХЖТ (2005) Хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны эсрэг шийтгэл: хүүхэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагын орчинд, хүүхдийн үзэл бодол. 2 дахь тал.

<sup>7</sup> UNICEF (2006) НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын “Хүүхдийн Эсрэг Хүчирхийллийн судалгаа”. 3 дахь тал.

<sup>8</sup> АХИС, ЗХЖТ (2005) Хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны эсрэг шийтгэл: хүүхэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагын орчинд, хүүхдийн үзэл бодол. 7 дахь тал.

Зураг-1



ангийн сурагчдын 77.5 хувь, 6-11-р ангийн сурагчдын 98.6 хувь нь сургууль цэцэрлэгийн орчинд ямар нэгэн дарамт, хүчирхийлэлд өртсөн болохыг илрүүлжээ (Хүснэгт 1 харна уу). Уг судалгаагаар хэний гаргасан ямар дарамт хүчирхийлэлд өртсөн болохыг тодруулахад нэгд үе тэнгийнхэн, хоёрт ахлах ангийн сурагчид, гуравт багш нарын зүгээс байв.

Хүснэгт-1

Цэцэрлэгийн ахлах бүлгийн, сургуулийн сурагчдын хүчирхийлэлд өртөж буй байдал, хувиар			
№	Хүүхдүүдийн бүлэг	Бүхий л орчинд	Сургууль, цэцэрлэгийн орчинд
1	Цэцэрлэгийн насны хүүхдүүд	90.0	80.0
2	Сургуулийн бага ангийн сурагчид	91.2	77.5
3	6-11-р ангийн сурагчид		98.6 <sup>a</sup>

Эх сурвалж: БСШУЯ (2007). Зураг зуруулах, асуулгын аргаар цуглуулсан мэдээллээс

Энэхүү судалгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн шинжтэй гэж дөрвөн төрлөөр ялган эдгээр төрөл нь сургууль, цэцэрлэгийн орчинд хэр тохиолдож байгааг тодруулсан юм. Хүчирхийллийн төрөл хэлбэрүүдээс сэтгэл санааны болон бие махбодийн эсрэг хүчирхийллийн шинжтэй үйлдлүүдэд хүүхдүүд илүүтэй өртдөг байна. Эдгээр үйлдлүүдийн гол буруутан нь нэгд, үе тэнгийнхэн, хоёрт, багш нар, мөн сургуулийн удирдах ажилтан, жижүүр, үйлчлэгч зэрэг сургуулийн бусад ажилтан нь хүүхдийн эсрэг

суралцагчдын бие махбодид халдах, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал” суурь судалгааг хийсэн бөгөөд уг судалгаанаас судалгаанд хамрагдсан 4-11-р ангийн сурагчдын 63 хувь нь сургуулийн орчинд багшийн зүгээс ямар нэгэн ялгаварлалд өртөж байсан хэмээн хариулжээ (АХИС, 2009:35). суралцагчдын бие махбодид халдах,

хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхалтын байдал” суурь судалгааг хийсэн бөгөөд уг судалгаанаас судалгаанд хамрагдсан 4-11-р ангийн сурагчдын 63 хувь нь сургуулийн орчинд багшийн зүгээс ямар нэгэн ялгаварлалд өртөж байсан хэмээн хариулжээ (АХИС, 2009:35).

Судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэж буй шалтгааныг тодруулсан юм. Үүнд:  
- Насанд хүрэгчдийн хүүхдийг хүмүүжүүлэхийн тулд түүнд хүч хэрэглэх, дарамт үзүүлж болно хэмээн үзэх уламжлалт итгэл үнэмшил;

хүчирхийлэл, дарамтыг тодорхой хэмжээгээр үйлддэг байна.  
АХИС-аас 2009 онд “Ерөнхий боловсролын сургуульд

- Хөвгүүдийн дунд хүчтэй, бярттай, сайн зодолддог байх гэсэн эрхэмлэл;

- Багш, сурган хүмүүжүүлэгчдийн сургалтын уламжлалт арга барил;

- Сургууль, цэцэрлэгийн материаллаг орчин;  
- Сургууль, багш нарын ажлыг үнэлж буй байдал нь хүчирхийллийг арилгахад саад тотгор учруулж байна.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах ажил хангалтгүй байгаагийн хамгийн гол учир шалтгаан нь нийгэм эдийн засгийн хүчин чадал, хууль эрх зүйн орчин бүрэлдээгүй зэрэг болно. Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын тухай илтгэлд «Монгол Улс хүний эрхийн холбогдолтой олон улсын гэрээ, конвенциудийг соёрхон баталсан хэдий ч эдгээр эрхийг бүрэн хэмжээгээр нь хэрэгжүүлэх засгийн газрын чадавхийг хөрөнгө хомс, чадавхи муутай хуулийн болон шүүхийн тогтолцооны сул талууд хязгаарлаж байна. Зохистой, сайн засаглалыг хэрэгжүүлэхэд саад тотгор учруулж байгаа зэрэг хүчин зүйлд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал, иргэний

нийгмийн хоорондын мэдээлэл солилцоо хязгаарлагдмал, төрийн албаны чиг үүргийн давхардмал болон тодорхой бус байдал, засаглалын доод түвшинд олон нийтийн төлөөлөл болон тайлагнал дутмаг байгаа зэрэг орж байна.» хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын Засгийн газар «Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц»-ийн 44 дүгээр зүйлээр хүлээсэн үүргийн дагуу тус конвенцийн хэрэгжилтийн талаар хоёрдугаар тайлангаа НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд хүргүүлж, улмаар 2005 оны 5 дугаар сарын 26-нд хэлэлцүүлсэн байна.

<sup>a</sup> 6-11-р ангийн хүүхдүүдээс сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн хүчирхийлэлд өртөж буй байдлыг нийт 39 үзүүлэлтээр тооцсон бөгөөд уг 39 үзүүлэлтэд бүгдэд нь огт тохиолдож байгаагүй хэмээн харуулсан тохиолдлуудыг хүчирхийлэлд үл өртөгч гэж үзлээ. Мөн бусад орчин дахь хүчирхийллийг асуулгаас тодорхойлох боломжгүй анхаарна уу.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39-р чуулганы хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2 дахь илтгэлийг хэлэлцээд Монгол Улсад холбогдуулан дараах санал зөвлөмжийг өгсөн байна.<sup>10</sup> Үүнд:

51. Боловсролын стандартыг сайжруулах, 1995 онд шинэчлэн батлагдсан Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх замаар боловсрол эзэмших боломжийг хангах талаар хийж буй хүчин чармайлтыг талархахын зэрэгцээ боловсрол эзэмших, сургуульд сурах нь зарим хүүхдэд ялангуяа хөдөөгийн хүүхдэд бэрхшээлтэй байсаар байгаад санаа зовж байна. Бага сургуулийн насны олон хүүхэд сургуульд сурахгүй байгаа, сургуульд хамрагдалтын түвшин бүс нутгийн болон жендерийн ихээхэн ялгаатай байгаа, бичиг үсэг үл мэдэх явдал хөдөөд өсч байгаа нь санаа зовоох зүйл мөн;

52. Хөдөөгийн малчин өрхийн эрэгтэй хүүхдүүд сургууль завсардаж, хүүхдийн хөдөлмөрт татагдан орох эрсдэл ихээхэн өндөр байгаад харамсаж буйгаа дахин илэрхийлж байна. Сургууль дээр хураадаг элдэв хураамж нь олон гэр бүлд санхүүгийн бэрхшээл учруулж,

улмаар хүүхдийн боловсрол эзэмших тэгш эрхээ эдлэхэд нь тээр болж байна. Цаашилбал, хүүхдүүд сургууль дээрээ хүчирхийлэлд өртөх, сургуулийн хүчин чадал хүрэлцэхгүй байх, ном, сурах бичгийн чанар муу байгаад Хороо сэтгэл зовж байна. Сургуулийн дотуур байрыг засварлах, шинээр барих талар оролцогч улсын хийж буй ажлыг сайшаахын зэрэгцээ байрны нөхцөл муу, хүүхдэд үйлчлэх хүчин чадал хязгаарлагдмал байсаар байгаад санаа зовж байна.

Ийнхүү НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжид сургуулийн хүртээмж, дотуур байрны нөхцөл, хангамж муу байгаад шүүмжлэлтэй хандаж, сургуулийн хэрэглэгдэхүүнийг сайжруулах, ялангуяа шинээр сургууль барих, дулааны, цахилгааны эх үүсвэр, дотуур байрны нөхцөлийг сайжруулах талаар зөвлөсөн байна.<sup>11</sup> Улмаар уг зөвлөмжид сургалтын чанарт шүүмжлэлтэй хандсан бөгөөд багш нарыг давтан сургах замаар сургалтын арга зүйг сайжруулах, сурах бичгийн чанарыг дээшлүүлэх асуудлуудыг тусгасан байна.

Ийнхүү НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны санал зөвлөмжөөс үзвэл Монгол Улс боловсролын салбарт ихээхэн ололт амжилтанд хүрсэн боловч шийдвэрлэх зохих асуудлууд байсаар байгааг харуулж байна. Гэтэл манай улсын хувьд уг асуудлыг хариуцсан тогтолцоо, үйл ажиллагааны туршлага болон хөрөнгө санхүүгийн байдлаас хамаараад зохих бэрхшээлүүд тохиолдсоор байна.

Энэ асуудлаар дэлхий нийт мөн анхаарлаа хандуулж байгаа бөгөөд “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” хэмээх уриан доох олон улсын түвшний томоохон бодлого хөтөлбөр хэрэгжиж байгаа. Үүний нэгэн жишээ нь Монгол Улсын БСШУЯ-наас санаачлан хэрэгжүүлж байгаа “Хүүхдэд ээлтэй сургууль” төслийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд сургуулиудын үйл ажиллагааг хэр хүүхдэд ээлтэй байгаагаар үнэлэн дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байна. Ийнхүү хүүхдэд ээлтэй орчныг төлөвшүүлэх, хүүхдийн эрхийг хангах хамгаалахад багш нарын үүрэг, оролцоо хамгийн чухал байдаг.



<sup>10</sup> НҮБ, Хүүхдийн эрхийн хороо, Санал зөвлөмж 2005 он, 20 дахь тал.

<sup>11</sup> 52, 53 (g) заалт, Зөвлөмж, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо, CRC/C/15/Add.264, 14 дэх тал, 2005 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр.

## Төрийн байгууллагаас иргэнд учруулсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт: Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан байдал



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Л.Батчимэг

Монгол Улс 1992 онд ардчилал, эрх зүйт ёсонд суурилсан хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Үндсэн хуулиа батлаад 20 орчим жил болж байна. Гэвч 1992 оны Үндсэн хуулиар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хуульчилж хохирсон иргэнээ хамгаалсан зохицуулалт буй боловч бусад холбогдох хууль тогтоомжид энэ эрхийг хууль тогтоогчид нарийвчилсан хэм хэмжээгээр зохицуулж өгөөгүй орхигдуулсан. Хэдийгээр нарийвчилсан зохицуулалт байхгүй хэдий ч шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, албан тушаалтны үндэслэлгүйгээр хуулийн хариуцлагад татсан, ял сонсгосон, баривчилсан, цагдан хорьсны улмаас учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлсэн шүүхийн шийдвэр (б) гарсан байгаа нь энэ төрлийн хохирлыг шийдвэрлэж байгааг харуулж байгаа нь дэвшилт юм. Одоо үйлчилж

байгаа болон өмнө үйлчилж байсан хууль тогтоомжуудад хууль бусаар цагдан хоригдсон, баривчлагдсан, цагдан хоригдсоны улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалт байгаа эсэх, энэ хохирлыг хэрхэн яаж шийдвэрлэж байсан эсэхийг судлахыг зорилоо.

А. Үндсэн хуулийн зохицуулалт

• БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн 83 дугаар зүйлд төрийн албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанд иргэд өргөдөл, гомдол гаргах эрхтэй, түүнийг нь зохих журмын дагуу шийдвэрлэх үүрэгтэй болохыг заасан бол БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд хууль бус ажиллагаанаас гадна чирэгдэл, хүнд суртал гаргасан албан тушаалтны үйл ажиллагаанд иргэн өргөдөл, гомдол гаргах эрхтэй ба энэхүү өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан нэн даруй шалгах шийдвэрлэх үүрэгтэй болохыг заажээ.

1940, 1960 оны Үндсэн хуульд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаанд иргэн өргөдөл, гомдол гаргах эрхтэй болохыг хуульчилсан боловч тэдгээрийн хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах, иргэн уг хохирлоо нэхэмжлэх эрхийг бусад хуульд тодорхой тусгаагүй тул иргэний тэрхүү гомдлоо эрх нь илүү тунхагийн шинжтэй байжээ.

• Харин Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй", 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний

эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" хэмээн Үндсэн хуулиар бусдын хууль бусаар учруулсан хохирол буюу хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хил ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг тунхаглаж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан нь чухал бөгөөд дэвшилттэй зохицуулалт болжээ. Үндсэн хуулийн энэхүү заалтаар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг эдийн болон эдийн бус гэж хязгаарлаагүй бөгөөд энэ нь хохирсон этгээдэд өөрт учирсан эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хамгаалсан дэвшилттэй зохицуулалт болсон юм. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх зорилгоор 2002 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэчлэн баталж мөрдсөн бөгөөд уг хуулиар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас иргэнд учирсан эдийн бус хохирлыг арилгах асуудлыг хуульчилжээ.

Б. Нарийвчилсан хуулийн зохицуулалт

Эрүүгийн байцаан шийтгэх хууль УИХ-аас 2002 онд батлан мөрдүүлсэн ЭБШхуулийн<sup>1</sup> 44 дүгээр бүлэгт "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах" тухай зохицуулсан бөгөөд мөн хуулийн 388 дугаар зүйлд "... иргэн хэрэг бүртгэгч,

<sup>1</sup> 2002 оны 1 дүгээрсарын 10-ны өдөр батлагдсан

мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан ..., сэтгэл санааны үр дагавраа арилгуулах ... эрхтэй" гэж заасан ба мөн хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-т зааснаар:

- Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө.

- Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно.

- Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах ажээ.

Өөрөөр хэлбэл, ЭБШ хуульд эдийн бус хохирол буюу сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрх болон шаардлага гаргах үндэслэлийг заасан боловч хохирлын хэмжээг тогтоох болон нөхөн төлөх журмыг Иргэний хуульд зохицуулахаар заасан байна.

#### Иргэний хууль

• 1926 онд батлан мөрдүүлсэн БНМАУ-ын Иргэний хуулиар нийгмийн халамжийн харилцаа болон зарим эдийн эрхийг голчлон зохицуулсан байх бөгөөд харин зөрчлийн улмаас үүсэх үүргийн тухай буюу бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шаардах, арилгуулах асуудлыг зохицуулаагүй байжээ.

• 1952 онд батлан мөрдүүлсэн БНМАУ-ын Иргэний хуулиар гэм хор гэсэн ойлголтыг шинээр хуульчилсан байх бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлгийн 253 дугаар зүйлд "Гэм хорыг учруулснаас үүсэн гарсан нэхэмжлэл"-ийн тухай, 17 дугаар бүлэгт "Бусдад хор хүргэснээс үүсэх үүргүүд"-ийн тухай тусгайлан авч үзсэн боловч бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас учирсан хохирлыг зөвхөн хүний бие болон

түүний хөрөнгө хэмээн явцуу хүрээнд тодорхойлжээ.

• 1963 оны БНМАУ-ын Иргэний хуулиар эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцаа (хуульд заасан бол эд хөрөнгийн бус амины бусад харилцаа)-г зохицуулахаар тусгасан, 3 дугаар зүйлд "Бусдад гэм хор хүргэх нь иргэний эрх, үүрэг үүсэх үндэслэл болох"-оор, мөн 6 дугаар зүйлд "Хүний нэр төр, алдар хүндийг камгаалах" тухай, 18 дугаар бүлэгт "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг"-ийн тухай, 319 дүгээр зүйлд "Албан байгууллагын ажилчин, албан хаагчид үүргээ гүйцэтгэж байгаад өөрийн буруугаас бусдад учруулсан гэм хорыг уул байгууллага хариуцах үүрэг"-ийн тухай тусгайлан зохицуулсан байх боловч эдгээр зохицуулалтаар "сэтгэл зүйн хохирол"-ыг авч үзээгүй байна. Өөрөөр хэлбэл, уг хуулиар эдийн бус хохирлыг "бусдын нэр төр, алдар хүндээд учирсан хохирол"-оор хязгаарлан хуульчилсан байна.

• 1994 оны Иргэний хууль нь Монгол Улсад 1992 онд батлагдсан Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан хууль боловч эдийн бус хохирлын тухайд өмнөх Иргэний хуульд байсан зохицуулалттай үндсэндээ ижил зохицуулалт тусгасан байжээ.

• 2002 оны Иргэний хуулийн<sup>2</sup> 230, 511 дүгээр зүйлд "Эдийн бус гэм хорыг арилгах" тухай заасан байх бөгөөд эдгээр зүйлд эдийн бус хохирлыг шаардах эрх, эдийн бус хохирлыг нөхөн төлөх эхлээр, гэм хорыг арилгах болон гэм хорын хэмжээг тогтооход харгалзах зүйлийг тусгасан боловч "эдийн бус гэм хор"-ыг зөвхөн "бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирол"-оор хязгаарлан тодорхойлсон байна.

Ийнхүү ЭБШ хуулийн 391 дүгээр зүйлд "Эдийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө", "Эдийн бус хохирлын

хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно" гэж заасан боловч Иргэний хуульд өөрт нь "... эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан ... тодорхойлох" журмыг нарийвчлан заагаагүй учир хохирлын хэмжээг ЭБШ хуульд заасанчлан тогтоох боломжгүй байна.

#### Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>3</sup>

ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлд "Эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцоогч этгээдээс гаргасан нэхэмжлэл нь иргэний хэрэг үүсгэх үндэслэл болно" гэж хуульчилжээ.

В.Бусад хуулийн зохицуулалт  
1. Монгол Улсын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль<sup>4</sup>

Энэ хуулийг иргэнийг эрүүгийн хариуцлагад хууль бусаар татан, мөрдөн мөшгөж хилсээр хорьж цагдсаныхаа төлөө төр хариуцлага хүлээх тухай асуудлыг ямар нэг хэмжээнд зохицуулсан анхны хууль гэж үзэж болно. Энэ хуулийг мөрдлөг болгохоос өмнө БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 нууц тогтоолоор баталсан журам үйлчилж байжээ.

Уг хуулиар иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан сэргийлэх арга хэмжээ болгон цагдан хорьсон, мөн захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ оногдуулсныг шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагаа гэж үзэж, түүний улмаас учирсан хохирлыг иргэн арилгуулах эрхтэй болохыг тогтоосон байна.

<sup>2</sup> 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

<sup>3</sup> 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

<sup>4</sup> 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдаж, 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хүчингүй болсон.



Гэвч энэхүү хуульд зааснаар хохирсон иргэн эдийн хохирол буюу аваагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж болон эд хөрөнгийн бусад хохирлыг гаргуулах боломжтой, өөрөөр хэлбэл, уг хуулиар иргэнд учирсан эдийн бус буюу сэтгэл зүйн хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх тухай зохицуулаагүй байна.

2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль<sup>5</sup>

Энэ хуулиар хилс хэрэгт шийтгүүлсэн хэлмэгдэгчид нөхөн олговор олгохоор зааж, цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд 1 000 000 төгрөгийн, бусад хэлмэгдэгчид 500 000 төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор олгохоор шийдвэрлэжээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүмүүс энэ хуулийн дагуу нөхөн олговор авч байгаа мэт боловч хэлмэгдэгчдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлын хэмжээг дээрх хуулиар тогтоосон нөхөн олговрын хэмжээтэй зүйрлэхийн аргагүй, тэгээд ч хилс хэрэгт шийтгүүлж цаазаар авахуулсан, хоригдон мөрдөгдөж, ялаа эдэлж байхдаа нас барсан, тахир дутуу болсон хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд учруулсан гэмтэл согог болон сэтгэл санааны шаналалд үнэлэмж тогтоох гэсэн оролдлого төр хийгээгүй болох нь хуулиас харагдаж байна.

Иймд энэхүү хуулийг монголын түүхийн нэгэн эмгэнэлт цаг үед хилс хэрэгт шийтгүүлж амь нас, биеийн эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч хэлмэгдсэн хүмүүс, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах гэхээсээ илүү нэгэн цагт иргэдийнхээ эсрэг хомроглон

үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө төр уучлал эрж, энэ мэт бусармаг үйл ажиллагаа түүхэнд дахин давтагдан гарахгүй байх нийгэм-улс төр, хууль зүйн дархлаа бий болгох зорилготой зохицуулалт гэж дүгнэж байна.

3. Монгол Улсын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль<sup>6</sup>

Энэ хууль нь иргэн Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актаар олгосон эд хөрөнгө, гэр бүл, орон сууц, хөдөлмөрийн болон амин хувийн бусад эрх нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон гэж үзвэл эрхээ сэргээн тогтоолгохоор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг зохицуулсан. Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актаар Монгол Улсын иргэнд олгосон эрхээ бүрэн эдлэх боломжийг хууль бусаар хязгаарласан буюу алдагдуулсан, түүнчлэн иргэнд ямар нэгэн үүрэг хууль бусаар оногдуулсан байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг иргэдийн эрхийг хохироосон хууль бус үйл ажиллагаа гэж үзнэ. Байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан материалын хохирлыг Монгол Улсын иргэний хуульд зааснаар нөхөн төлүүлнэ. Уг хуулиар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан материалын хохирлыг нөхөн төлөөр зохицуулсан байна.

4. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль<sup>7</sup>

Энэ хууль нь хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхийн шийтгэх тогтоолоор хохирлынх нь бодит хэмжээг тогтоосон хадгаламж

зээлийн хоршооны хохирогчдод хамаарна. Тогтоогдсон хохирлын 50 хувийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулна. Хуульд заасан хохирол нь сэтгэл санааны хохирол бус зөвхөн эд хөрөнгийн хохирлыг нөхөн олгохоор зохицуулсан.

5. Хохирогчдод нөхөн олговор олгох тухай хууль<sup>8</sup>

Энэ хууль нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэн, төрийн тусгай албан хаагч, хуулийн этгээдэд нөхөн олговор олгохоор зохицуулсан. Хуулинд амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлыг нөхөн олгоно гэж хуульчилсан учраас сэтгэл санааны хохирол нөхөн олговор олгоогүй байна. Ийм учраас амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлыг тооцон нөхөн олговор олгосон байна.

6. БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн тогтоол<sup>9</sup> №150

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2-т заасан үндэслэлээр холбогдолгүй болсон хүмүүсийн хохирлыг арилгах тухай

Эрүүгийн хариуцлагад татагдаж шалгагдаад, БНМАУ-ын ЭБШхуулийн дээрх үндэслэлээр холбогдолгүй болсон хүмүүст учирсан хохирлыг арилгах зорилгоор тэдний ажиллаагүй албан тушаалааны дундаж буюу албан тушаалын цалинг зохих тогтоол, баримт бичгийн үндсэн дээр ажиллаж байсан газар, байгууллагаас нь 2 сарын цалингаас хэтрэхгүй хэмжээгээр нөхөн олгож байхаар зохицуулж байсан байна. Тухайн үед төр, түүний байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон иргэний өөрт учирсан эд хөрөнгийн буюу эдийн хохирлыг төр өөрөө хариуцан хохирлыг нөхөн төлүүлдэг байжээ.

<sup>1</sup>1998 оны 1 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан

<sup>2</sup>Энэ хуулийг 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталж, 2002 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүчингүй болгосон

<sup>3</sup>Энэ хууль 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан

<sup>4</sup>Энэ хууль 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан

<sup>5</sup>Энэ тогтоол 1974 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 107 дугаар тогтоолоор

## Дүгнэлт

Хэдийгээр иргэн өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй байгаа боловч сэтгэл санааны хохиролд юу орох, хэрхэн яаж тооцож хохирлыг барагдуулах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Ийм учраас сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлсэн шүүхийн шийдвэрийг судлахад хохирсон этгээд-нэхэмжлэгчийн сэтгэл зүйн хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох эсвэл нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх мэтээр шийдвэрлэдэг ажээ.<sup>10</sup> Гэтэл шүүхийн шийдвэр гарсны дараа хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял

шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулсан 2 шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа байдаг. “Төр хариуцан арилгана” гэж заасан байгаа нь дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гэхээр ямар төрийн байгууллага хариуцан арилгах нь тодорхойгүй байгаа учраас иргэд хаанаас нөхөн төлбөрөө авахаа мэддэггүй.

ЭБШХ, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид эдийн шинжтэй буюу эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг илүүтэй зохицуулж, хохирсон амь нас, эрүүл мэндэд учирсан гэмтэл согог, хүний сэтгэл зүйд учруулсан шаналал зовиур зэргийг үнэлэх асуудлыг орхигдуулж, учирсан дээрх хохирлын хэмжээг тодорхойлоход


чиглэсэн зохицуулалт үндсэндээ байхгүй байна.

Иймээс хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсанаас сэтгэл зүйд учирсан хохирлыг тодорхойлох, нөхөн төлбөр төлөх замаар учирсан хохирлыг арилгаж зөрчигдсөн эрхийг сэргээхэд зориуд анхаарал хандуулж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад нэн чухал байна. Өнөөдөр хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүй байгаа нь иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд төр хайнга хандаж байгаагийн илрэл бөгөөд хүний эрхийн эрх зүйн баталгааг хэлбэрээс агуулгад шилжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.



<sup>10</sup> ХЗҮХ-ийн “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох” судалгааны тайлангаас.

## Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа



**МУИС-ийн ХЭС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант Д.Хуяг**

Шүүхэд хандсан хэргийн оролцогчдын эрх, ашиг сонирхолыг түргэн шуурхай хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх нь шүүн таслах ажиллагааны үр нөлөөг тодорхойлогч чухал хүчин зүйлийн нэг. Шүүн таслах ажиллагааны зорилт нь иргэний хэргийг хуулиар тогтоосон цаг хугацаанд нь зөв шийдвэрлэх явдал юм. Эрх зүй дэх хугацаа гэдэг бол хууль тогтоомжоор ямар нэгэн эрх зүйн үр дагавартай холбосон тодорхой цаг хугацааны мөчлөг буюу агшинг хэлнэ. Судлаач Ж.Наранцацрал "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа"-ны хугацаа гэдэгт иргэний хэрэг хянан шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад ажиллагааг гүйцэтгэхэд чиглэгдсэн хуульд заасан, эсвэл шүүхээс тогтоосон орон зайн агшинг (цаг үе) хэлнэ" гэжээ.

Хэрэг шийдвэрлэх ажиллагааны хугацааны тухай сэдвээр Ж.Наранцацрал "Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, түүний

зохицуулалтын зарим асуудал", А.Доржготов "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацааны зохицуулалт", П.Баттогтох "Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацааны эрх зүйн зохицуулалт", Р.Мухийт "Захирааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааны зарим асуудал", А.Чимэдцогзол, Ц.Одончимэг нар "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа" зэрэг өгүүлэл, гарын авлага гаргасан байна.

ИХШХША-ны хугацааг дараах байдлаар ангилна.

- Хуулиар тогтоосон хугацаа;
- Шүүхээс тогтоосон хугацаа.

1. Хуулиар тогтоосон хугацаа гэдэг нь үрдачилан ИХШХШ тухай хуулиар тогтоож өгсөн, хэргийн оролцогчдын хүсэл зоригоос үл хамаардаг хугацаа юм. Жишээ нь: ИХШХШ тухай

- 66 дугаар зүйл "Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана."

- 119 дүгээр зүйл "Шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг энэ хуулийн 118 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна."

- 163 дугаар зүйл "Анхан шатны шүүх давж заалдах гомдолд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хариуцагч, гуравдагч этгээдээс гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ."

- Мөн 166.2, 170, 173.2, 174 дугаар зүйл гэх мэт.

2. Судлаач Ж.Наранцацрал "Шүүхээс тогтоосон хугацаа гэдэгт шүүгч хэрэг хянан шийдвэрлэх

ерөнхий хугацааны дотор өөрийн үзэмж, санаачлагаар тогтоож аливаа асуудлыг шийдвэрлэж байгаа хугацааг хамааруулна" гэж тодорхойлсон боловч шүүхийн практикт шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацааны дотор биш уг хугацаанаас хэтрүүлж хугацааг тогтоох явдал гардаг. Жишээ нь, анхан шатны шүүхээр шийдэх гэж байгаа хэрэг иргэний хэрэг үүсгэснээс хойш 67 дахь хоногт шүүх хуралдаан нь хийхээр товлогдсон боловч зохигчид гэрээс мэдүүлэг авахуулах, бичмэл нотлох баримтыг авч шинжлэн судлах гэдэг шалтгаанаар шүүх хуралдааныг 10 хоногоор хойшлуулах тохиолдол гарч болно. Иймд шүүхээс тогтоосон хугацаа гэдэгт шүүгч өөрийн иргэний, санаачлагаар зүй зохистойгоор тогтоож аливаа асуудлыг шийдвэрлэж байгаа хугацааг ойлгоно гэж тодорхойлж болох юм. Мөн энд шүүх хуралдааныг цагаар, хоногоор хойшлуулах, өөр шүүхээр даалгавар гүйцэтгүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх гэх мэт хугацаа хамаарна.

ИХШХША-ны хугацааг дагаж мөрдөх субъектийн байдлаас хамааруулж дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Зөвхөн шүүхээс баримтлах хугацаа;
- Хэргийн оролцогчдын баримтлах хугацаа;
- Бусад оролцогчдын баримтлах хугацаа

1. 2002 онд батлагдсан ИХШХШ тухай хуульд шүүхээс баримтлах хугацааг мөн хуулийн 71 дүгээр зүйл (хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа), 72 дугаар зүйл (нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах), 96.2, 173.2 дахь хэсэг гэх мэт зүнд заасан

2. Хэргийн оролцогчдын баримтлах хугацаа нь мөн хуулийн

<sup>1</sup> Хойшид ИХШХША гэж товчлов

72.2 дугаар зүйл. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй. 73.1 дүгээр зүйл. Үндсэн нэхэмжлэлтэй хамт шийдвэрлүүлэхийн тулд хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Мөн хуулийн 167.5, 170.1, 176-1, 180.1 зүйлүүдэд заасан.

3. Бусад оролцогчдын баримтлах хугацаанд мөн хуулийн 46.1 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээд шүүхээс шаардсан бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг шүүхээс заасан хугацаанд гаргаж өгнө. Хэрэв иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гаргаж өгөх боломжгүй бол энэ тухайгаа шаардсан шүүхэд мэдэгдэнэ гэх мэт зүйл заалт байна.

ИХШХШ тухай хуулийн 71.1 дүгээр зүйлд Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүх хэргийг шийдвэрлэхээр заасан. Энэ нь ИХШХШ тухай хуулиас өөр хуульд хэрэг шийдвэрлэх ажиллагааны хугацааг тогтооно гэсэн ойлголт юм. Тухайлбал, Дампуурлын тухай Монгол Улсын хуулийн 5.2 дугаар зүйлд нэхэмжлэл, хүсэлт нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж шүүгч үзвэл түүнийг хүлээн авсанаас хойш 5 хоногийн дотор дампуурлын хэрэг үүсгэх тухай захирамж гаргах, мөн хуулийн 5.3-т дампуурлын хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор шүүх нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж, 30 хоногийн дотор хариуцагчийн төлбөрийн чадвартай болох эсэхийг тогтооно гэж тус тус заасан байна.

Зарим судлаач анхан шатны шүүх шийдвэрийнхээ тогтоох хэсгийн агуулгыг танилцуулан сонсгомогц уг шийдвэр хүчин төгөлдөр болно гэж

үздэг ба энэ нь ИХШХШ-ны хугацааг алдаатай тодорхойлж байгаа ойлголт юм. Учир нь шүүхийн практикт “Шийдвэр хүчинтэй болох”, “Шийдвэр хүчин төгөлдөр болох” гэсэн хоёр өөр ойлголт байдаг ба энэ нь хэрэг шийдвэрлэх ажиллагааны өөр өөр цаг хугацааг илэрхийлсэн, шүүх ба зохигчийн хувьд өөр өөр дагавар үүсгэдэг ойлголт юм. Анхан ба давж заалдах шатны шүүх шийдвэр, магадлалнаа тогтоох хэсгийн агуулгыг танилцуулан сонсгомогц уг шийдвэр, магадлал хүчинтэй болно. Шийдвэр, магадлал хүчинтэй болсоноор анхан болон давж заалдах шатны шүүх шийдвэрээ өөрчлөх, уншиж танилцуулсанаас өөр байдлаар шийдвэр, магадлал гаргах, шийдвэрлээгүй асуудлыг шийдвэр, магадлалд тусгах, хянан шийдвэрлэсэн асуудлыг тусгахгүй орхигдуулах эрхгүй. Хүчинтэй болсон шийдвэр, магадлалыг уншиж танилцуулсан агуулгаар нь бичгийн хэлбэрт оруулж зохигчдод хүргэнэ. ИХШХШ тухай хуулийн 120.1 дүгээр зүйлд зааснаар анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсоноор:

а. “Түүнийг иргэн хуулийн этгээд заавал биелүүлнэ”;

б. Давж заалдах болон хяналтын гомдол гаргах эрхгүй;

в. Мөн зүйлийн 120.4 дүгээр зүйлд зааснаар дахин тухайн асуудлаар шүүхийн шийдвэр гаргахгүй;

д. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтогдсон үйл баримтыг дахин нотлох шаардлагагүй бөгөөд тэдгээрийн талаар маргаж болохгүй;

е. Шүүхийн шийдвэрийг сайн дураар болон албадлагын журмаар биелүүлэх эрх үүснэ.

ИХШХШ-ны хугацааны зохицуулалттай холбогдуулан ИХШХШ тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

Үүнд:

1. Уг хуулийн 167.6 дугаар зүйлд зааснаар зохигч давж заалдах хугацааг хүндэтгэх шалтгаанаар хэтрүүлсэн ба уг хугацааг сэргээлгэх

хүсэлтийг шүүхэд гаргасан тохиолдолд уг хүсэлтийг шүүгч шийдвэрлэх хугацааг заах.

2. Хуулийн 170 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шүүгчийн захирамж, шийтгэвэр, шүүхийн тогтоолыг шүүх ямар хугацааны дотор бичгийн хэлбэрт оруулан гаргах ба тэдгээрийг зохигчдод хэд хоногийн дотор гардуулж өгөхийг заах;

3. Хариуцагч нэхэмжлэлийг гардан авсаны дараа сөрөг нэхэмжлэл гаргах хугацааг хоногоор тогтоох;

4. ИХШХШ-ны хугацаа тоолох, тодорхойлох, тасалдах, үргэлжлүүлэн тоолох, шинээр тоолох журмыг ИХШХШ тухай хуульд тодорхой бүлэг болгон тусгах;

5. ИХШХШ тухай хуулийн 45.2, 50.1, 50.2, 105.1, 184.3, 185.1.2 дугаар зүйлүүдэд заасан “даруй”, “нэн даруй” гэх хугацааг тодорхой болгох;

6. Зарим төрлийн иргэний хэргийг хэргийг хэрэг шийдвэрлэх ерөнхий хугацаа буюу мөн хуулийн 71.1 дүгээр зүйлд заасан 60 хоногийн дотор биш тусгай буюу богиногосон хугацаанд 14-30 хоногт шийдэх тухай заах. Тухайлбал, гэр бүлийн маргаан, онцгой ажиллагаагаар шийдэх хэрэг, ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас хуучин ажилдаа эгүүлэн тогтоолгох, нөхөн олговор гаргуулах хэрэг гэх мэт;

7. Хэргийн зохигчид хяналтын журмаар Дээд шүүхийн ерөнхий шүүгчид хэргийг хянуулах тухай гомдол гаргасан тохиолдолд Ерөнхий шүүгч дүгнэлт бичих, нийт шүүгчдийн хурлаар хэлэлцүүлэх хугацааг тодорхой болгох;

8. Хэрэг аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах, Дээд шүүхэд хяналтын шатаар хянагдсан тохиолдолд уг хэргийг анхан шатны шүүхэд буцаан илгээх хугацааг тусгах;

9. Шийдвэр, магадлал, тогтоолд шүүх хэргийг хүлээн авсан хугацааг заавал бичих тухай заах;

10. Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимийн хурлын тогтоолыг зохигчдод гардуулах хугацааг заах.



*Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд\**

## Багануур дүүргийн Прокурорын газар



### Прокурорын байгууллагын үүсэл, хөгжил

Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 1930 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Улсын Прокурорын газрыг анх Шүүх явдлын яаманд харъяалуулан байгуулж, дагаж мөрдөх эрх үүргийн дүрмийг баталж, прокурорын байгууллагад улсын нэрийн өмнөөс хуулийн биелэлтэнд хяналт тавих үүргийг хүлээлгэсэн. 1940 онд Шинэ Үндсэн хуулиар прокурорын байгууллагын үндсэн үүрэг, зорилт, зохион байгуулалтын зарчмыг тодорхойлж өгсөн. Прокурорын байгууллагын үйл ажиллагааг нийгмийн хөгжлийн шинэ шатанд гаргахад 1960 оны Үндсэн хууль онцгой байр суурь эзэлдэг юм. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулиар Прокурорын байгууллагыг засаглал хуваарилах онолоор Шүүх эрх мэдлийн хүрээнд хамааруулж, прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно

гэж заасан.

2002 оны 9 дүгээр сард Улсын Их Хурлаас Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталсан. Прокурорын байгууллага нь МУ-ын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг оролцогч байгууллага юм. Мөн Улсын Ерөнхий прокурорын дэргэд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас үйлдсэн гэмт хэргийг харъяалан шалгах чиг үүрэг бүхий Мөрдөн байцаах албыг шинээр байгуулж, прокурорын байгууллагын харьяанд эрүүгийн хэргийн төв болон салбар архивуудыг ажиллуулах болсон. Улсын ерөнхий прокурорын газар 21 аймаг, нийслэл, тээврийн прокурорын газар, 8 сум дундын болон 8 дүүргийн газруудаас бүрддэг ба системийн хэмжээнд нийт 39 нэгж үйл ажиллагаа явуулж байна.

### Багануур дүүргийн Прокурорын газрын түүхэн замнал

Багануур дүүрэг нь Улаанбаатар хотоос зүүн тийш 130 км-т Хэрлэн голын сав Нүүрэнтийн хөндийд 62.020 га нутаг дэвсгэрийг эзэлж оршдог бөгөөд тус дүүрэг 26 мянган хүн амтай.

БНМАУ-ын (хуучин нэрээр) Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1978 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 202 дугаар зарлигаар Улаанбаатар хотын харьяанд Багануур хороог байгуулжээ.

Улмаар БНМАУ-ын Ардын Их хурлын тэргүүлэгчдийн 1980 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар зарлигаар Улаанбаатар хотын Багануур хороог өргөтгөн район болгон байгуулж, мөн зарлигаар районы прокурорын газрыг байгуулан районы прокурор, ерөнхий хяналт эрхэлсэн туслах прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажил эрхэлсэн туслах прокурор, мөрдөн байцаагч, нарийн бичгийн дарга зэрэг 5 орон тоотойгоор анх прокурорын газар байгуулагджээ.

Багануур районы анхны прокуророор С.Чулуунбаатар, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажил эрхэлсэн туслах прокуророор Х.Равзан, мөрдөн байцаагчаар Н.Шүрэнцэцэг, нарийн бичгийн даргаар Г.Дагвадорж нар ажиллаж байжээ.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж засаг захиргааны нэгжийн хуваарьт өөрчлөлт орсноор Багануур район нь Багануур дүүрэг болон өөрчлөгджээ.

Район болон дүүргийн прокуророор С.Чулуунбаатар, Х.Алтанзүрх, Д.Цэндэсэм, Д.Пүрэвдорж нар ажиллаж байжээ.

Тус прокурорын газарт дүүргийн прокуророор ажиллаж байсан

Д.Цэндцэсэм, Д.Пүрэвдорж нар нь төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнагдсан байна.

#### Манай хамт олон

2010 оны байдлаар Багануур дүүргийн прокурорын газар нь Улсын Ерөнхий прокурорын газраас батлагдсан бүтэц, орон тоогоор нийт 7 прокурор, 9 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Одоо тус дүүргийн прокурор Б.Пүрэвжав, орлогч прокурор Т.Мөнхбаяр, хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих туслах прокурор М.Чинбат, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих туслах прокурор Б.Ууганбаатар, шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан хяналтын прокурор Ж.Бүрэнжаргал, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан хяналтын прокурор Д.Дашцэрмаа, Р.Очирсүрэн, прокурорын туслах ажилтнаар Б.Буяндэлгэр, Ж.Бат-Эрдэнэ нарийн бичгийн дарга, нягтлан бодогч Ө.Пүрэвдорж, бичээч Л.Ганчимэг, үйлчлэгч Б.Булганцэцэг, жижүүр Э.Мөнхөө, Л.Пүрэвсүрэн, С.Лхагвасүрэн жолооч Б.Ариунбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх прокурор, ажилтнууд нь прокурорын байгууллагад 2-20 дахь жилдээ ажиллаж байгаа залуу болон дунд үеийн боловсон хүчин юм.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт жилд гарч байгаа 350-400 гэмт хэрэг, 1200 гаруй захиргааны зөрчлийн материал, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 600 гаруй материал, иргэд, байгууллага, албан тушаалтнаас прокурорын байгууллагад ирүүлсэн 150 гаруй хүсэлт, гомдол, мэдээллийг манай прокурорууд анхан шийдвэрлэж байна. Түүнчлэн анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд 150 гаруй оролцож, улсын яллагчийн болон прокурорын дүнгэлт гаргаж байна.

Прокурорууд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг жилд дунджаар 40 удаа шалгаж

хяналт шалгалтаараа 120 гаруй зөрчил, дутагдал илрүүлэн арилгуулж байна.

Түүнчлэн хяналт шалгалтын явцад эрүүгийн хэрэгт 110 даалгавар, зөрчил, дутагдлыг арилгуулахаар 30 шаардлага, 20 мэдэгдлийг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад бичиж байна.

Тус дүүрэг дэх чанга дэглэмтэй хорих ангид 500 гаруй хоригдол ял эдэлж байгаа бөгөөд хорих ангийн үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу, хяналт шалгалтыг тогтмол явуулж байна. Жилд 50 гаруй ялтны ялыг хугацаанаас өмнө тэнсэн суллах, 100 гаруй ялтны ял эдлэх дэглэмийг өөрчлөх тухай саналтай хувийн хэрэг, материалыг хянаж шүүхээр шийдвэрлүүлж байна.

Сүүлийн 3 жилд манай прокурор, ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллаж бүтээлч ажил, үйлсийг өрнүүлж байна. Үүний нэг тод жишээ нь прокурор, ажилтны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор хамт олноороо гар нийлэн зуслангийн хашаа, байшин барьж ашигдалтанд оруулсан бөгөөд байгууллагын туслах аж ахуйг бий болгох зорилгоор 10 гаруй бог мал худалдан авч прокурор, ажилтны нийгмийн асуудлыг сайжруулах ажлын эхлэлийг тавилаа.

Манай хамт олны дунд эвсэг, хамтач, зарчимч, бүтээлч харилцаа бүрэлдэн тогтсон бөгөөд бидний дундаас "прокурорын тэргүүний ажилтан цол тэмдэг", "прокурорын хүндэт тэмдэг"-ээр 3, Улсын Ерөнхий прокурорын өргөмжлөл, мөнгөн шагналаар 5 прокурор, ажилтан тус тус шагнагдлаа. Үүний зэрэгцээ дүүргийн прокурорын газар нь дүүргүүдийн прокурорын газрын хэмжээнд 2009 оны ажлаараа 2 дугаар байрт шалгарлаа. Энэ бүхэн нь манай хамт олны ажил үйлсийн амжилт бөгөөд цаашид бид бүхэн Улсын Ерөнхий прокурорын газраас хяналтын ажлын чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг ханган биелүүлж Прокурорын байгууллагын түүхт 80 жилийн ойг

угтсан их ажилд амжилт бүтээл гарган идэвх зүтгэлтэйгээр ажиллах урам зориг дүүрэн байна.

#### Эрүүгийн нөхцөл байдлын талаар

Нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг 2009 оны бүтэн жилээр тус дүүргийн Прокурорын газраас судалж дүгнэлт хийхэд доорхи тоо баримтууд гарч байна.

2009 онд иргэд байгууллага, албан тушаалтнаас гэмт хэрэг болон эрх зүйн зөрчлийн шинжтэй 936 гомдол, мэдээллийг цагдаа, прокурорын байгууллагад ирүүлжээ. Үүний 40 хувьд нь буюу 318 гомдол, мэдээлэлд Прокурор эрүүгийн хэргийн дугаар олгож хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Эрүүгийн хэргийг өмнөх онтой харьцуулахад 18 хэрэг буюу 5.3 хувиар буурсан байна. Нийт гэмт хэргийг ангилж үзвэл хууд, онц хүнд гэмт хэрэг 36, хүндэвтэр гэмт хэрэг 112, хөнгөн гэмт хэрэг 168 гарчээ.

Нийт хөнгөн гэмт хэргээс 78 хэрэг буюу 45.8 хувийг хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацааг түргэвчлэсэн байна.

Гарсан гэмт хэргийн дунд хүнд, онц хүнд гэмт хэргийн тоо 11 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ онд хүнийг санаатай алах гэмт хэрэг 2 удаа гарсан нь өмнөх оноос 5-аар цөөрсөн байна.

Гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл бусдын амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 100, хулгайн гэмт хэрэг 85, дээрэмдэх булаах гэмт хэрэг 10, танхайрах гэмт хэрэг 46, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8, бусад төрлийн гэмт хэрэг 67 байна. Хулгайлах гэмт хэрэг урд онохоос 6-аар буурсан бол танхайрах гэмт хэрэг 15-аар өссөн байна. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 19-өөр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас нийт 5 хүн

амь насаа алдаж, 98 хүн биедээ хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл авч иргэд, байгуулагад нийт 508 сая төгрөгний хохирол учирчээ. Эдгээр тоонууд нь урд оноос буурсан байна.

Гэмт хэрэгт 365 хүн холбогдсон нь урд оныхоос 80 хүнээр буурсан байна. Тэднийг нийгмийн байдлаар нь авч үзвэл ажилтай 70, ажилгүй 209, малчин 13, оюутан 10, сурагч 25 хүн байгаа нь дийлэнхийг эзэлж байна. Түүнчлэн төрийн алба хаагч 6 хүн гэмт хэрэгт холбогджээ. Насны хувьд 18 нас хүртэлх хүүхэд 25, 19-30 насны 168, 31-35 насны 54, 36 наснаас дээш настай 118 хүн байна.

Сотгуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо 137 хүрч урд оныхоос 34-өөр өсчээ. Нийт гэмт хэргийн 43 хувь нь сотгуугаар үйлдэгдсэн гэсэн дүн гарч байна.

Эрүүгийн 34 гэмт хэрэгт 50 эмэгтэй холбогдсон бол 17 гэмт хэрэгт 25 хүүхэд холбогджээ. Энэ урд оныхоос тус бүр 8-аар буурсан байна.

Прокурор эрүүгийн хэрэгт нийт 63 хүнийг сэжигтэн, яллагдагчаар цагдан хорих санал гаргаж шүүхээр шийдвэрлүүлжээ. Энэ нь өмнөх оноос 5 хүнээр буурсан байна.

Прокурор хяналт тавьсан нийт хэргээс 100 хэрэгт прокурорын яллах дүгнэлт бичиж, 12 хэргийн яллагдагчаар татсан тогтоолыг баталж, нийт 112 эрүүгийн хэргийг

шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн байна.

Прокурорууд анхан шатны болон давж заалдах шатны 165 шүүх хуралдаанд улсын яллагч, прокуророор тус тус оролцжээ. Шүүх нийт 125 хүнд ял оногдуулжээ.

Үүнд: Ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг 2 хүнд оногдуулж 15-25 жил хорих ялыг 4 хүнд, 10-15 жил хорих ялыг 6 хүнд, 5-10 жил хорих ялыг 20 хүнд, 5 жил хүртэл хорих ялыг 32 хүнд оногдуулжээ. Үүнээс гадна 39 хүнд оногдуулсан хорих ялыг тэнсэн хянан харгалзаж, 11 хүнд албадан ажил хийлгэх, 10 хүнд торгох, 8 хүнд баривчлах ял оногдуулжээ. Шүүхээс энэ онд 4 хүнийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцжээ.

Прокурорын хяналтын шатанд нийт 36.8 сая төгрөгний хохирол төлүүлжээ. Түүнчлэн прокурор иргэний шүүх хуралд оролцож төрийн эрх ашиг хөндөгдсөн гэж үзэж 6574140 төгрөгний хохирлыг шийдвэрлүүлжээ.

Прокурор захиргааны хэрэг бүртгэлт хийсэн 1011 материал хянаж илэрсэн зөрчил дутагдлыг засуулж, зөвтгүүлэхээр 14 тогтоол, 9 шаардлага бичсэн байна.

Захиргааны зөрчлийн дийлэнх хэсгийг жижгээр танхайрах, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил эзэлж байна. Жишээ нь, энэ

онд жижгээр танхайрсан зөрчил 82 удаа, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн зөрчил 308 гарсан нь урд оныхоос тус тус өсчээ.

Нийт 2247 хүн эрүүлжүүлэгдсэнээс 168 нь эмэгтэйчүүд байна.

2009 онд тус дүүрэг дэх чанга дэглэмтэй хорих ангиас 41 хүн хугацаанаас өмнө тэнсэн суллагдаж, 92 ялтны ял эдлэх дэглэмийг өөрчилсөн байна.

Гэмт хэрэг, зөрчлийн үндсэн шалтгаан нь тус дүүрэгт архидан согтуурах, ажилгүйдэлтэй холбоотой байна.

Прокурорууд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг нийт 43 удаа шалгаж хяналт шалгалтаараа 129 зөрчил, дутагдал илрүүлж арилгуулсан байна.

Түүнчлэн хяналт шалгалтын явцад эрүүгийн хэрэгт 113 даалгавар, зөрчил арилгуулахаар 28 шаардлага, 18 мэдэгдлийг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад бичсэн байна.

Цаашид тус дүүргийн нутаг дэвсгэрт эрүүгийн нөхцөл байдлыг зөөлрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төр захиргаа, хууль хяналтын байгууллагуудаас эрчимтэй явуулах шаардлагатай байна гэсэн дүгнэлт хийлээ.



Үргэлжлэл. Өмнөх хэсэг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2009 оны №3(26)-т нийтлэгдсэн.

## Үнэт цаасны зах зээлийн хуулийн хэрэгжилтийн зарим асуудал

### Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг

#### ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК БОУУ УНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЛЭЖ БҮЙ БАЙДАЛ

Судалгааны баг шүүхийн практикийг судлах ажлыг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

- Нийслэлийн шүүхийн архив, Захиргааны хэргийн шүүх, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн шүүхэд биечлэн судалгаа хийж, хавтаст хэрэгтэй танилцсан;

- Улсын дээд шүүх, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн шүүхээс ирүүлсэн шийдвэрт анализ хийсэн;

- Шүүгч, өмгөөлөгч, их, дээд сургуулийн багш нартай уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс Үнэт цаастай (120 хэрэг), Компанийн тухай хуулийн үнэт цаастай (37 хэрэг), Гэр бүлийн дундын эд хөрөнгийн ногдол хувь, үнэт цаастай холбоотой (14 хэрэг) шийдвэрлэсэн хэргийн статистик тоо авахад улсын хэмжээнд (аймаг, дүүрэг тус бүрээр) нийт 171 хэрэг бүртгэлтэй гэсэн тоо өгсөн боловч энэ нь бодит байдалтай нийцэхгүй байх тохиолдол гарсан. Тухайлбал, Дархан-Уул аймагт судалгааны багийн гишүүд очиж ажиллахад статистик тоо баримтад үнэт цаас, хувьцаатай холбоотой шийдвэрлэсэн хэрэг байхгүй гэж ирүүлсэн боловч тус аймгийн шүүхийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичиг нартай уулзалт, ярилцлага хийх явцад нэг хэрэг шийдвэрлэсэн байсан.

Статистик тоон мэдээлэлд Гэр бүлийн дундын эд хөрөнгийн ногдол хувь, үнэт цаастай холбоотой 14 хэрэг шийдвэрлэсэн гэсэн тоо өгсөн боловч тухайн шүүхэд очиж хавтаст

хэрэгтэй нь танилцах үед зарим хэрэг нь гэр бүлийн бусад төрлийн маргаан болох нь харагдсан. Энэ нь тухайн судалгааг гаргаж өгч буй шүүхийн ажилтан судалгааны хүрээнд холбогдох байгууллага руу явуулсан албан тооттой сайн танилцаагүй нь харагдаж байна.

Судалгааны багийн гишүүд Нийслэлийн шүүхийн архив, Захиргааны хэргийн шүүх, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн шүүхэд биечлэн сууж нийт 49 хавтаст хэрэг, Улсын дээд шүүх, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн шүүхээс ирүүлсэн 61 шийдвэр (захирамж, шийдвэр, магадлал, тогтоол)-ийг тус тус уншиж танилцлаа.

Улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэргийг 21 аймаг, 9 дүүрэгээр нэгтгэн он тус бүрээр харуулбал:

(Улсын хэмжээнд)

№	Он	Үнэт цаастай холбоотой шийдвэрлэсэн маргааны тоо
1	1993	7
2	1994	1
3	1995	5
4	1996	4
5	1997	14
6	1998	72
7	1999	8
8	2000	3
9	2001	9
10	2002	3
11	2003	13
12	2004	4
13	2005	4
14	2006	6
15	2007	15
16	2008	3
Нийт		171

Судалгааны багийн гишүүдийн Нийслэлийн шүүхийн архив, Захиргааны хэргийн шүүх, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн шүүхэд биечлэн сууж танилцсан нийт 49 хавтаст хэргийг маргааны төрлөөр нь ангилбал:

- Хувьцаа болон хувьцааны үнэ гаргуулах хэрэг -12;

- Хувьцаа өмчлөх болон эзэмших эрхтэй холбоотой -12;

- Хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах хэрэг -11;

- Хувь нийлүүлэгчдийн хуралтай холбоотой -8,

- Ногдол ашиг гаргуулах хэрэг -7;

- Хувьцаа эргүүлэн гаргуулах хэрэг -1;

- Нэмэлт хувьцаа гаргасантай холбоотой -1 хэрэг байна.

49 хавтаст хэргээс хэргийг хэрэгсэхгүй болгосон 3, зохигчид хоорондоо эвлэрсэн 3, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн 2 хэрэг байна.

Хувьцаатай холбоотой маргааныг шийдвэрлэхэд удирдлага болгосон хуулийг тоон байдлаар үзүүлбэл:

- Иргэний хууль -24;

- Нөхөрлөл, Компанийн тухай -8,

- Компанийн тухай -6;

- Үнэт цаасны тухай -4;

- Үнэт цаасны зах зээлийн тухай -2;

- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай -2;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль -1;

- Хөдөлмөрийн тухай хууль -1;

- Өмч хувьчлах тухай -1;

- Хуулийн нэр заагаагүй -3 байна.

Хувьцаатай холбоотой маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ Иргэний хуулийг голдуу удирдлага болгодог нь харагдаж байна. Мөн шүүгч нартай уулзалт, ярилцлага хийх үед ч Иргэний хуулийг голдуу хэрэглэн тухайн маргааныг шийдвэрлэдэг болохыг хэлж байсан.

Үүнтэй холбоотойгоор Иргэний хуулийн 107, 113 дугаар зүйлийн 113.4-д зааснаар зөрчигдсэн эрхийг сэргээхэд, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэхэд нарийвчилсан зохицуулалттай хуулийг барьж



шийдвэрлэхээр байгаа боловч уг асуудлаар оновчтой, тодорхой зохицуулсан хэм хэмжээ Байдгагүйгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэглэхэд хүндрэл учирдаг гэжээ.

Улсын дээд шүүх, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн шүүхээс ирүүлсэн 61 шийдвэрийн 1 нь тогтоол, 4 нь магадлал, 14 нь шийдвэр, 42 нь захирамж байна.

Тэдгээрийг багцлан авч үзвэл:

Тогтоол-1: Хан-Уул дүүргийн шүүхээр 2005 онд, Нийслэлийн шүүхээр 2005 онд, Улсын дээд шүүхээр 2006 онд шийдвэрлэсэн 15.592.000 төгрөг гаргуулахыг хүссэн хэрэг.

Анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэрт Иргэний хуулийн 467 дугаар зүйлийн 467.2, 467.2 ... дэх хэсгүүдэд заасныг баримтлан ... гаргуулахаар шийдвэрлэсэн ба давж заалдах шатны шүүхийн магадлалд 467 дугаар зүйлийг 476 дугаар зүйл хэмээн өөрчилж бусад заалтыг хэвээр үлдээснийг Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг тогтоох хэсгийг өөрчлөн шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэлийн шаардлагад хамтран ажиллахдаа хувьцаагаар хөрөнгө оруулахаар заагаагүй байхад шүүх Иргэний хуулийн үнэт цаас, түүний төрөл, хэлбэр гэсэн 467 дугаар зүйлийг баримтлан хэргийг шийдвэрлэсэн нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэхээр байна.

Магадлал-4: 3 хэрэгт хувьцааг худалдах, худалдан авах гэрээг, 1 хэрэг нь худалдах, худалдан авах гэрээ нь агуулгаараа хууль зөрчсөн тул хэцлийг хүчин төгөлдөр бусад тооцож хэргийг шийдвэрлэсэн байна.

Шийдвэр-14: Шийдвэрийг аймгаар ялгавал, Ховд аймаг 8, Сэлэнгэ аймаг 5, Дархан-Уул аймаг 1 байна. Хэргийн төрлөөр нь ангилбал, хэцлийг хүчин төгөлдөр

бусад тооцуулахтай холбоотой 8 (Сэлэнгэ, Ховд аймаг), хувьцааны өмчлөгч, эзэмшигч болохыг тогтоолгохтой холбоотой 3 (Сэлэнгэ, Дархан-Уул аймаг), ногдол ашигтай холбоотой 2 (Сэлэнгэ, Ховд аймаг), хувь нийлүүлэгчдийн хуралтай холбоотой 1 (Ховд аймаг) маргаан байна.

Захирамж-42. Үүнээс

- зохигчид хувьцааны үнэ гаргуулах нэхэмжлэлд эвлэрсэн хэрэг 1 (Сэлэнгэ аймаг);

- "А" ХХК-ийн нийт хувьцааны 30 хувь буюу 16.691 ширхэг хувьцааны эзэмшигчээр тогтоолгохыг хүссэн нэхэмжлэлийг гурван (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1,2 дахь заалтыг зөрчсөн гэх мэт) үндэслэлээр хангаж шийдвэрлэх боломжгүй хэмээн хэргийг хэрэгсэхгүй болгосон хэрэг 1 (Сэлэнгэ аймаг);

- Ногдол хувь гаргуулах болон хувьцаагаа эргүүлэн авах нэхэмжлэл гаргасан ба хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн 19 хэрэг (Сэлэнгэ, Ховд аймаг);

- Ногдол хувь гаргуулах, худалдсан хувьцааг буцаан авах, хэцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, зөвшөөрөлгүй зарсан хувьцааг гаргуулах зэрэг нэхэмжлэлээс нэхэмжлэгч татгалзсан 21 хэрэг (Сэлэнгэ, Ховд аймаг) байна.

Хэргийн шийдвэрлэхдээ хэрэглэсэн хууль зүйн үндэслэлийг товч дурдвал Иргэний хуулийн 43, 44, 48, 106, 101, 111, 467 дугаар зүйл, Нөхөрлөл, компанийн тухай, Нотариатын тухай, Компанийн тухай, зарим тохиолдолд материаллаг ямар хууль хэрэглэсэн нь тодорхой бус, харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн процессын журам агуулсан зарим зүйл, заалтыг иш татан хэрэглэжээ.

Судалгааны явцад ажиглагдсан зүйл бол нэг талаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг өдөр тутам хэрэглэгдэггүй, үнэт цаасны тухай, үнэт цаасны зах зээлийн ойлголт дутмаг, нөгөө талаар үнэт цаасны талаархи мэдээлэл хомс байсныг энд дурдах нь зүйтэй болов уу.

Шүүхийн практикт үнэт цаас харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг гэхээсээ илүүтэй Иргэний хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрэглэж байна. Энэхүү байдал нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь тухайн харилцааг зохицуулсан "гол" хууль байх шинжээ алдсан, мөн материаллаг хэм хэмжээг агуулсан гэхээсээ илүү процессын шинжтэй хэм хэмжээг тогтоосонтой холбоотой юм. Ялангуяа хууль хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн хүртээмжтэй хамгаалах талаар нарийн зохицуулалт байх шаардлагатай байна.

#### ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН ЗАРЧИМ, СТАНДАРТ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

##### 4.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт, стандарт

##### Дэлхийн худалдааны байгууллагын баримт бичиг

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) үүсгэн байгуулах хэлэлцээрт "гишүүн бүр дотоодын хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон баримт бичиг болон захиргааны журмыг ДХБ-ын хэлэлцээрүүдийн дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэх арга хэмжээг авна".<sup>3</sup> Аливаа улс ДХБ –д элсэн ороходоо багц хэлэлцээрт нэгдэх шаардлагатай байдаг ба тэдгээрийн нэг нь Үйлчилгээний худалдааны

<sup>3</sup> Тухайн компанийн нэрийг өөрчилсөн

<sup>2</sup> Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн 16 дугаар зүйлийн 4 (1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1996 оны 12 дугаар сарын 26-нд нэгдэн орсон). Төрийн мэдээллийн тусгай дугаар VII, 2007 он.

тухай ерөнхий хэлэлцээр<sup>3</sup> (General agreement on trade in services – GATS- GATC) юм. GATC-ийн 2 дугаар зүйлийн 1-д ДХБ-ын гишүүн улс болгон үйлчилгээ үзүүлэгч гадаадын компанид болон үйлчилгээнд нь Ерөнхий хэлэлцээрийн гишүүн бусад улсад үзүүлж буй дэглэмээс дутахааргүй таатай дэглэм үзүүлэх үүрэг хүлээнэ.

Тухайн хэлэлцээрийн Хавсралт 1-д санхүүгийн зах зээл дэх ажиллагааны зэрэгцээ мөн тусгай зөвшөөрөл авах дараахь үйл ажиллагааг хамааруулна:

- брокер, дилерийн үйл ажиллагаа, тусгайлан биржийн болон биржээс гадуур зах зээл дэх үйл ажиллагаа;

- актив хөрөнгөөр итгэмжилээр захирах үйл ажиллагаа;

- хамтын хөрөнгө оруулалтын бүх хэлбэрийн үйл ажиллагаа;

- хадгалагчийн үйл ажиллагаа, тэр дундаа төлбөр тооцоо эрхлэх хадгалагчийн үйл ажиллагаа;

- зах зээлийн төрөл бүрийн клирингийн үйл ажиллагаа гэх мэт.

ДХБ-ын баримт бичигт дагуу гадаадын хуулийн болон хувь этгээдийн эрх зүйн чадамжийг түүнд гадаад улсад олгогдсон лиценз болон бусад эрх тогтоосон баримтад үндэслэн хүлээн зөвшөөрөх (recognition) асуудлыг тусгасан.

Ерөнхий хэлэлцээрийн VII зүйлийн дагуу ДХБ-ын аливаа гишүүн улс түүний хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл, эсхүл бусад мэргэжлийн шалгуурыг шаардах үйлчилгээг үзүүлэх гэж буй гадаадын компани болон хувь этгээдийн гуравдагч улс (ДХБ-ын гишүүн улс) –д олгогдсон боловсрол, ажлын туршлага, тусгай зөвшөөрөл, аттестатчилалыг мөн тухайн улсын мэргэжлийн шаардлагын нийцэж буйг бүрэн, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эрхтэй байна. Энэ хүлээн зөвшөөрөх асуудлыг аливаа улс нь өөрийн улсын хуулийн болон хувь этгээдийн

үйлчилгээг тухайн улсад нэвтрүүлэх боломжийг хангах сонирхолтой ДХБ-ын гишүүн улстай хийсэн тусгай хэлэлцээр, тохиролцолд үндэслэн хэрэгжүүлж болно. Ийм хэлэлцээрийн дагуу дээрх хүлээн зөвшөөрөх асуудлыг хэрэгжүүлэхдээ гишүүн улс үндэсний зах зээлдээ хэлэлцэн тохирогч нөгөө улсын хуулийн болон хувь этгээдэд үл ялгаарлан гадуургах, үндэсний дэглэм олгох үүрэг хүлээдэг.

Мөн VII зүйлд гишүүн улс нь Ерөнхий хэлэлцээр түүний хувьд хүчин төгөлдөр болсоноос хойш 12 сарын хугацаанд багтаан Үйлчилгээ үзүүлэх асуудлаархи зөвлөл (Council for Trade in Services)-д хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөхийг хангахаар авсан арга хэмжээг болон тухайн арга хэмжээг авах үндэслэлийн талаар мэдэгдэх үүрэгтэй. 5 дугаар зүйлд аливаа гишүүн улс боломжтой бүх тохиолдолд үйлчилгээ үзүүлэх ажиллагааны талаархи дотоодын зохицуулалтад олон улсын стандарт, шалгуурыг харгалзах ёстой.

Хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад тооцвол зохих гишүүн улсын үүрэгт гадаадын компанийг үйлчилгээний зах зээлд нэвтрүүлэхэд зарим хязгаарлалт тавихыг хориглосон үүрэг ерөнхий хэлэлцээрийн 16 дугаар зүйлд заасан байна. Үүнд:

- Холбогдох үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээд болон хамтарсан үйлдвэрийн хэлбэрт хамаарах хязгаарлалтыг тавих;

- гадаадын хөрөнгийг хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд дээд хувь эзлэх хэлбэрээр оролцоог хязгаарлах, эсхүл хувь болон хамтын хөрөнгө оруулалтын хэмжээг хязгаарлах;

- тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын орон тоог бүрдүүлэх хувь этгээдийн тооны хувьд дээд болон доод хэмжээнд хязгаарлах;

- тодорхой нэг төрлийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн тоог квот тогтоох,

эсхүл монопол тогтоох, эсхүл тийм үйлчилгээ эрхлэх тодорхой бүлэг этгээдэд онцгой нөхцөл олгох бусад хэлбэрээр хязгаарлах.

**Үнэт цаасны олон улсын комиссийн баримт бичиг**

Үнэт цаасны олон улсын комисс (International organization of Securities Commissions - IOSCO) нь хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үр өгөөжтэй, нээлттэй зах зээлийг бий болгох асуудлаар сонирхлыг нэгтгэж, харилцан мэдээлэл, туршлага солилцох зорилгоор дэлхийн 109 гаруй улсыг нэгтгэсэн 170 гаруй гишүүнтэй<sup>4</sup> олон улсын байгууллага юм. Энэ байгууллагын гишүүнээр тухайн улсын үнэт цаасны комисс, эсхүл үнэт цаасны зах зээлийг зохицуулах гүйцэтгэх эрх мэдлийн бусад байгууллага байдаг. Гишүүн нь мөн бус нутгийн хорооны гишүүн байдаг. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь энэ байгууллагын гишүүн байгууллага бөгөөд Ази- Номхон далайн бүс нутгийн хороонд багтдаг.

Уг байгууллагын үндсэн барим бичгийн нэг бол "Үнэт цаасны зах зээлийн зорилго ба зарчим" юм. Энэ баримт бичиг нь үнэт цаасны зах зээлийн 30 зарчмыг агуулах бөгөөд эдгээр зарчмыг нэвтрүүлэх нь үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчдыг хамгаалах, шударга, үр дүнтэй, нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг хангах, эрсдэлийг багасгахад чиглэгдсэн эрх зүйн суурийг бэхжүүлэх практик ач холбогдолтой. Энэ баримт бичгийн Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт дараахь зорилгыг хангаж байх ёстой байна:

- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалалт;

- Зах зээлийн шударга, үр дүнтэй, ил тод байх байдлыг хангах;

- Тогтолцооны эрсдлийг бууруулах.

Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийг зохицуулах

<sup>3</sup> Төрийн мэдээллийн тусгай дугаар VIII. 2007 он 1832-1866 дахь тал.

<sup>4</sup> [http://www.iosco.org/lists/display\\_members.cfm?memID=1&orderBy=none](http://www.iosco.org/lists/display_members.cfm?memID=1&orderBy=none)

хууль тогтоомжид тусгах шалгуур болох дээрх 30 зарчмыг нийт 8 төрөлд багцлан дурдвал:

А. Зохицуулагчтай холбогдсон зарчим

1. Зохицуулагчийн хариуцлага нь тодорхой байх, бодитойгоор заагдаж байх;

2. Зохицуулагч нь эрх мэдэл, үйл ажиллагаагаа биелүүлэхийн тулд биеэ даасан байх, хариуцлага хүлээх чадвартай байх;

3. Зохицуулагч өөрт олгогдсон эрх мэдлээ хэрэгжүүлж, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах эрх мэдэл, нөөц үр чадвартай байх;

4. Зохицуулагч нь тодорхой бөгөөд тогтвортой зохицуулалтын үйл явцыг жишиг болгох;

5. Зохицуулагчийн албан хаагчид (нууц) итгэлцлийн холбогдох стандартуудыг мэргэжлийн өндөр түвшинд стандартыг мөрддөг байх;

В. Өөрийгөө зохицуулах байгууллагын зарчим

6. Зах зээлийн тохиромжтой хэмжээ болон иж бүрдлийн хэмжээнд өөрийн өрсөлддөг хүрээнд шууд хянах үүргийг хэрэгжүүлдэг өөрөө зохицуулагч байгууллагуудыг зохицуулагч нь зөв зохицтой байдлаар ашиглах;

7. Өөрөө зохицуулах байгууллагууд нь зохицуулагчийг хянаж байх субъект болох ба эрх мэдлээ хэрэгжүүлэх болон өөрт оногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ шударга ёс болон итгэлцлийн стандартыг баримтлах;

С. Үнэт цаасны зохицуулалт дахь албадлага

8. Зохицуулагч нь хяналт, шалгалт явуулах, мөрдөн байцаах, нууцаар мөрдөх эрх мэдэлтэй байх;

9. Зохицуулагч нь албадлагыг хэрэгжүүлэх;

10. Зохицуулалтын систем нь хяналт шалгалт явуулах, мөрдөн байцаах, нууцаар мөрдөх үйл ажиллагааг үр ашигтай, өгөөжтэй байдлаар ашиглах, мөн холбогдох хөтөлбөрүүдийг үр өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэх;

Д. Зохицуулалт дахь хамтран ажиллах зарчим

11. Зохицуулагч гадаад, дотоодын харилцагч нартай

нийтийн болон нийтийн бус мэдээлэлтэй адил хуваалцах эрх мэдэлтэй байх;

12. Зохицуулагчид гадаад, дотоодын харилцагчтай нийтийн болон нийтийн бус мэдээллийг хамтран хэзээ болон яаж ашиглах талаар мэдээлэл солилцох механизмыг бий болгох;

13. Зохицуулалтын систем гадаадын зохицуулагчдад өөрсдийнх нь эрх мэдэл, чиг үүргийг нь хязгаарласан талаар асуудал тавихад дэмжлэг тусалцаагаар хангах боломжийг олгох;

Е. Үнэт цаас гаргагчдын зарчим

14. Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргах үндэслэл болох санхүүгийн үр дүн, бусад мэдээллийг цаг тухайд нь бүрэн, үнэн зөв мэдээлэх;

15. Компанийн үнэт цаасны хувьцаа эзэмшигчидтэй өөр хооронд нь ялгаваргүйгээр шударга, тэгш байдлаар харьцах;

16. Нягтлан бодох болон аудитын стандарт нь олон улсын шаардлагд нийцсэн байх ба өндөр чанартай байх;

Ф. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцооны зарчим

17. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоог ажиллуулах, зах зээлд оруулах хүсэлтэй этгээдэд зориулж тавигдах шаардлагатай стандартыг зохицуулалтын систем бий болгох;

18. Зохицуулагч систем нь хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо болон үйлчлүүлэгчдийн эд хөрөнгийг хамгаалах болон тусгаарлахад шаардагдах хууль зүйн маягт, түүний бүтцийн талаархи дүрэм журмаар хангах;

19. "Е"-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо нь тодорхой нэг хөрөнгө оруулагчид хэр зохистой болох мөн тухайн зохицуулалт түүний ашиг сонирхлыг үнэлэн дүгнэхэд шаардагдах мэдээллийг хангасан байх зохицуулалтыг бий болгох;

20. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоонд нэгжийн төлбөр, үнэ болон эд хөрөнгийн үнэлгээг хийх тохиромжтой үндэс суурийг тусгахыг зохицуулалтаар бататгах;

Г. Зах зээлд зохицуулагчийн зарчим

21. Зохицуулалт нь хөрөнгийн зах зээлийн хөндлөнгийн зуучлагч оролцох наад захын стандартыг хангасан байх;

22. Зуучлагчид учирч болох аливаа эрсдлийг тусгасан анхдагч болон одоо байгаа эд хөрөнгө мөн бусад шаардлагыг тавих;

23. Үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах, эрсдлийн зохистой менежментийг бататгах болон тэдгээртэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөхгүйг дотоод журам болон үйл ажиллагааны стандартыг зах зээлийн зуучлагчид дагаж мөрдөнө;

24. Системийн эрсдлийг бууруулахад хөрөнгө оруулагчдыг хамгийн бага эрсдэлд оруулахад зуучлагчдын зах зээл шударга зарчмаар үйл ажиллагаа явуулах;

Н. Хоёрдогч зах зээлийн зарчим

25. Үнэт цаасны зах зээлийн солилцоог багтаасан арилжааны системийг бий болгох асуудал нь зохицуулалтын эрх хэмжээ, хяналтын зүйл байх;

26. Арилжааны нэгдсэн байдлыг хангах зорилгоор арилжаа солилцооны системийг зохицуулагч байнга хангаж байх бөгөөд ийнхүү хангах үйл ажиллагаа нь зах зээлийн олон янзын шаардлагыг тэнцвэрт байдалд нөлөөлөх шударга тэгш байдлын дүрэм журмаар тогтогдох;

27. Арилжааны ил тод, нээлттэй байдлыг дэмжих;

28. Зохицуулалт нь худалдаа арилжааны аливаа шударга бус практик, хууран мэхлэх үйл ажиллагааг олж ирүүлэх, түүнийг хориглоход чиглэгдэх;

29. Зохицуулалт нь зах зээлийн замбараагүйдэлд хүргэх, тохиролцооноо үл биелүүлэх, их хэмжээгээр эрсдэлд орохоос сэргийлэх зүй зохистой менежментийн баталгааг гаргахад чиглэгдэх;

30. Үнэт цаасыг шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлж тодорхой болсон систем нь зохицуулагчийн хяналтад байх бөгөөд үр өгөөжтэй, шударга, ашигтай байхаар тогтоож өгснөөр системийн аливаа эрсдлийг бууруулах

### Дэлхийн хөрөнгийн биржийн холбоо (FIBV)<sup>5</sup>

Дэлхийн хөрөнгийн биржийн холбоо нь дэлхийн үнэт цаасны зах зээлийг хамарсан хамгийн том нийгэмлэгийн нэг юм. Энэ холбоо нь өнөөдрийн байдлаар 60 орчим гишүүн биржтэй бөгөөд эдгээр хөрөнгийн бирж нь дэлхийн биржийн хэлцлийн 97 хувийг хийдэг. Эдгээр бирж нь үнэт цаасны арилжааг явуулахаас гадна бусад төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон улсын түвшинд явуулдаг. Энэ байгууллагын гишүүнээр биржээс гадна банк, компани, засгийн газрын агентлаг, төрийн бус байгууллага байж болдог онцлогтой. Энэ холбооны үндсэн зорилго нь хөрөнгийн биржийн нэгдмэл бодлого бий болгох, эрх зүйн зохицуулалтыг ижилсүүлэх, боловсронгуй болгох, стандарт бий болгох, бирж, үнэт цаасны хороо хоорондын хамтын ажиллагааг дэмжих, шинээр үүсч буй болон жижиг хөрөнгийн биржүүдэд туслалцаа, зөвлөгөө өгөхөд оршино. Холбоонд дэлхийн нэр хүнд бүхий биржүүд гишүүнчлэлтэй байдаг боловч ямар ч улсын бирж энэ холбоонд нэгдэх бодлого барин хөгжиж байдаг. Өөрөөр хэлбэл энэ холбоонд нэгдэн ороход тавигддаг шаардлага нь өнөөдөр аливаа биржийн баримтлах стандарт болжээ.

Энэ стандартад 13 багц шалгуур үзүүлэлт багтдаг. Тухайлбал,

1. Байгууллага үйл ажиллагаа: зохицуулах хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг байх; мэргэшлийн байгууллага оролцдог байх, тэдгээрт тавигдах шаардлага, хариуцлага тодорхой байх, бүтцийн өндөр зохион байгуулалттай байх, зохиц дүрэм, журам тодорхой байх, программ хангамж, мэдээллийн сүлжээний системтэй байх, санхүүгийн эх үүсвэр оновчтой байх;
2. Үнэт цаасны арилжаанд оролцдог байх: арилжаанд оролцох

тэгш байдлыг хангах, арилжаанд оролцох байгууллагын хөрөнгийн дээд хэмжээг тогтоож өгөх, арилжаанд баримтлах бусад журам, хариуцлагыг тогтоосон байх;

3. Бүртгэл ба мэдээлэл, хуулийн дагуу, түргэн, шуурхай, шударга явуулах, дотоодын болон гадаадын бүртгүүлэгчид тэгш нөхцөл олгогдож байх, хөрөнгө оруулагчдад мэдээлэл бүрэн, шуурхай хүрч байх;

4. Арилжаа: хууль тогтоомжийн хүрээнд явагдах, гэрээнд үндэслэх, мэдээлэл, тайлагналт зохиц зарчимин дагуу явагдаж байх, нэр хүнд, нууцыг баримтлан мэдээлэл нээлттэй байх, гадаадын этгээдийн оролцоог дэмжиж байх, хоёр улсын эрх зүйн зохицуулалтын давхардалгүй байх;

5. Хэлцэл: хэлцэл нь олон улсын стандарт G-30, ISSA нарт нийцэж байх;

6. Техникийн хангамж: Аливаа бирж IT системээр хангагдсан байхаас гадна нөөц программ хангамжтай, өндөр түвшний хамгаалалттай байх;

7. Эрсдэл: эрсдэл тооцох, түүнээс шуурхай гарах механизмтай байх;

8. Маргаан шийдвэрлэх: тодорхой маргаан шийдвэрлэх механизмтай байх;

9. Хяналт, шалгалт: дотоод хяналт, шалгалтын уян механизмтай байх;

10. Хөрөнгө оруулагчийг хамгаалах: хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалсан тогтолцоотой байх, хохирлыг арилгах механизмтай байх;

11. Бизнесийн удирдлага: энэ шаардлага нь IOSCO-ийн гаргасан зарчим бөгөөд OECD-ийн компанийн удирдлагын гол зарчмуудыг тооцсон байх;

12. Худалдаа: худалдаа хөрөнгө оруулагчийн эрхийг хангасан байх, тодорхой хяналт дор явагдаж байх, мэдээлэл нээлттэй байх;

13. Гадаад хөрөнгө оруулалт: үндэсний дэглэм, эсхүл нэн таатай нөхцөл үзүүлэх дэглэм олгодог байх, гадаадын үнэт цаасыг хуулиар

хязгаарласнаас бусдыг нь арилжааг байх.

### 4.2. Гадаад улсын эрх зүйн зохицуулалт

Үнэт цаасны зах зээл Англосаксон, Эх газрын гэх үндсэн хоёр загвар дээр хөгжиж иржээ. Харин сүүлийн үед зарим улс нь энэ хоёр загварын конвергенци хэлбэрээр хөгжүүлэн хэрэглэж иржээ. Энэ загваруудын тус бүрт нь авч үзвэл дараах онцлогтой байна.

#### 4.2.1. Үнэт цаасны зах зээлийн загвар

##### А. Үнэт цаасны зах зээлийн англо-саксоны загварын онцлог:

1. хөрөнгө оруулалтын эх үүсвэр - үндсэн эх үүсвэр нь хөрөнгийн бирж;

2. Хөрөнгийн биржийн хэрэгсэл - үнэт цаасны зах зээлийн үдсэн хэрэгсэл нь хувьцаа, өрийн хэрэгсэл нь хөрөнгийн зах зээлээс хамааралтай болж эхэлсэн (ДНБ-ий 60-90% нь хувьцаа, бусад тогтоогдсон бус орлогтой үнэт цаасны үнээс бүрдэнэ<sup>6</sup>);

3. Хөрөнгийн зах зээлийн оролцогч

- арилжааны банкыг үнэт цаасны зах зээлээс тусгаарлах бодлого хэрэгжиж ирсэн (1933 оны Үнэт цаасны тухай хууль (Securities Act) 1982 оны нэмэлт өөрчлөлтийн хамт);

- эх газрын загвартай улсантай харьцуулбал санхүүгийн байгууллага илүү мэргэшсэн. Энд төрөлжсөн банкны (хөрөнгө оруулалтын банк, өөрөөр хэлбэл брокер-дилерийн компани) үзэл баримтлал дэлгэрсэн;

4. өмчийн бүтэц

- хувь хөрөнгө оруулагч болон тэдгээрийг төлөөлсөн хөрөнгө оруулагчийн хамтарсан хэлбэрийн өмчийн хувь илүү;

- төрийн болон том компани, банкны өмч бага, улсын эдийн засгийн зохицуулах төрийн оролцоо бага;

- хувьцаат хөрөнгөд хяналтын багцын гүйцэтгэх үүрэг бага.

<sup>5</sup> www.fibv.com

<sup>6</sup> Пелих С.А., Рачковская О.С. Две концепции развития фондового рынка//Финансы, М., 1999, 710, С.30

хувьцаат хөрөнгийн өмчид бутархай байдал өндөр байдал ажиглагдсан;

**5. зах зээлийн нээлттэй чанар**

- нээлттэй байдал илүү, хөрөнгийн, валютын хөдөлгөөний хязгаарлалт бага, гадаадын үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, санхүүгийн зуучлагчийн хүртээмж илүү нээлттэй. Иймд пибералчлагдсан зах зээлд шударга үйл ажиллагааг болон эрсдэлийг багасгах үүднээс төрийн хяналтыг чангатгадаг байна;

**6. Үнэт цаасны зах зээл**

- Үнэт цаасны зах зээл олон нийтийн болж, илүүгээр хөрвөх чадвартай болж байгаа бөгөөд илүү олон улсын шинжтэй болсоор байна.

Дээрх загвар нь АНУ, Англи, Канад, Австрали зэрэг улсад давамгайлдаг.

**Б. Үнэт цаасны зах зээлийн эх газрын загварын онцлог:**

**1. хөрөнгө оруулалтын эх үүсвэр**

- хөрөнгө оруулалт нь хувьцаагаар биш өрийн бусад хэрэгсэлээр хэрэгждэг;

**2. Хөрөнгийн биржийн хэрэгсэл**

- зах зээлийн үндсэн хэрэгсэл нь өрийн шинжтэй (банкны зээл, облигац), хувьцааны зах зээл коёрдогч ач холбогдолтой;

**3. Хөрөнгийн зах зээлийн оролцогч:**

- хувьцаат хөрөнгөт салбарт томоохон хөрөнгө оруулагчаар банк байдаг. Үйлдвэр, бусад санхүүгийн бус компанийн хувьцаа эзэмшигчээр банк байдаг, иймд хувьцааны ихэнхи нь банкны мэдэлд, эсхүл тэдгээрийн нэгдсэн группд хамааралтай байдаг;

- улсын санхүүгийн активд арилжааны банк өндөр хувь эзэлдэг. Банк нь өөрийн сонгодог чиг үүргээсээ (депозит, төлбөр тооцоо) гадна үнэт цаасны зах зээлд мэргэжлийн байгууллагын кувитар оролцдог (зарим тохиолдолд үнэт цаасаар дагнансан тусгай

салбар нэгж, охин байгууллага байгуулдаг);

- хамтын хөрөнгө оруулалт бага үүрэг гүйцэтгэдэг;

**4. Өмчийн бүтэц**

- хувь хөрөнгө оруулагч болон тэдгээрийг төлөөлсөн хөрөнгө оруулагчийн хамтарсан хэлбэрийн өмчийн хувь бага;

- төрийн болон том компани, банкны өмч их;

- хувьцаат хөрөнгөд хяналтын багцын гүйцэтгэх үүрэг их.

Дээрх загвар нь Герман, Австри, Япон зэрэг улсад давамгайлдаг.

**В. Үнэт цаасны зах зээлийн загварыг хослуулсан конвергенци:**

Эдийн засгийн хөгжилтэй улс орнуудад дээрхи загваруудын зааг арилаг байгаа бөгөөд санхүүгийн зах зээлийн байгууллага давхцах хандлагатай байна. Тухайлбал, АНУ, ХБНГУ гэх зэрэг улсад эдгээр загварыг хослуулсан хэлбэрээр хэрэглэж байна. 90-ээд оноос ХБНГУ хувьцааны зах зээлээ өргөтгөх бодлого хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд хамтарсан компанийн санхүүжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн мэргэжлийн байгууллага болох банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах, ашиг сонирхолыг зөрчилөөс сэргийлэх, эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах зэрэг асуудалд анхаарлаа хандуулж иржээ. Мөн үнэт цаасны зах зээлийн асуудлыг зохицуулсан хууль тогтоомжоо Европын холбооны Тогтоол, Удирдамжид уялдуулсан бөгөөд англосаксоны загвараас мэдээлэл түгээх зарчим, үнийн үндэслэлгүй хэлбэлзлийг урьдчилан тооцох зэрэг бусад худалдаа арилжааг шударга явуулах зарчмыг харгалзаж шинэчилсэн байна.<sup>1</sup> АНУ-ын хөрөнгө оруулагчийг татах, АНУ-ын зах зээлд гаргах үүднээс зах зээлээ өргөжүүлэх

үүднээс Америкийн үнэт цаасны зах зээлийг эрх зүйн зохицуулалтад нийцүүлэх бодлого хийгдэж байна.

Харин Америкийн хувьд арилжааны банкны үнэт цаасны зах зээл дэх оролцоо нэмэгдэж санхүүгийн нэгдлүүдийг байгуулж үнэт цаасаар арилжиж буй фирмийг тэдгээрийн охин компани болгох хандлагатай байна. Францын хувьд 1945 оноос банкиг хөрөнгө оруулалтын хандлага арилжааны гэж хуваасан байсан бол 1984 оноос буцаагаад нийлүүлсэн байна. 1993 оны хуулиар Японы арилжааны компаниуд үнэт цаасны зах зээлд оролцох мэргэжлийн байгууллага болох охин компанийг үүсгэн байгуулах эрхтэй болсон.

Европын орнуудад санхүүгийн зах зээлээ нэгтгэх, хууль тогтоомжоо уялдуулах хандлага нэмэгдсээр байна. Мөн арилжааны банк, хөрөнгө оруулалтын банк, банк-брокер, даатгалын компани зэрэг байгууллагад ногдох санхүүгийн үйлчилгээний хуваарилалтын зааг бүдгэрч байгаа бөгөөд банкны шинэ төрөл болох санхүүгийн үйлчилгээ үзүүлэх компанийн үүсгэн байгуулж байна. Санхүүгийн интеграцилалт нь зах зээлийг хил хязгааргүй болгож байгаа бөгөөд үүнийг дагаад эрх зүйн зохицуулалтыг ижилсүүлэх шаардлагыг бий болгож зах зээлийн байгууллагуудыг ойртуулж өгсөн. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн байгууламж, зохион байгуулалтын түвшинд дараах өөрчлөлтүүд<sup>2</sup> орж байна:

1. Санхүүгийн байгууллагыг нэгтгэж хөрөнгийг төвлөрүүлэх замаар санхүүгийн байгууллагыг өргөжүүлэх хандлагатай;

2. Банкны чиг үүргийг өргөжүүлэх (банк үнэт цаасны компани, даатгалын компанийн чиг үүргийг хэрэгжүүлэх байдлаар) хандлагатай;

3. Банкны загвартай зах зээл нь зарим улсад банк бус санхүүгийн

<sup>1</sup> Мирин Я. Рынок ценных бумаг России: воздействие фундаментальных факторов, прогноз и политика развития. М.: Альпина Паблшер, 2002. с.624

<sup>2</sup> Деринг Ханс-Ульрих. Универсальный банк – банк будущего. Финансовая стратегия на рубеже века. Пер. с нем. М. Международные отношения, 1999. с. 384

байгууллагад нээлттэй болсон. Түүнээс гадна банк нь хөрөнгийн зах зээлд нэвтэрч эхэлсэн (Франц, Испани);

4. Хөрөнгийн биржүүдийн төвлөрөх процесс явагдаж байгаа. Олон улсын түвшинд нэгдэж байна;

5. Зохицуулах байгууллагын чиг үүргийг нэг байгууллагад төвлөрүүлэх хандлагатай;

6. Улсын зүгээс хувьцааны зах зээлийг онцгой анхаарч, дэмжиж хөгжүүлэх бодлого барьж байна. Учир нь хөгжсөн хувьцааны зах зээл нь улсын эдийн засгийг хөгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг болдог.

#### 4.2.2. Гадаад улсын хууль зүйн практикийн зарим асуудал

##### Зохицуулах байгууллага

Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, журам нь төрийн зүгээс тодорхойлогдож зохицуулагдаж байх ёстой. Төрийн зохицуулалтын гол зорилго нь үнэт цаасны зах зээлийн тогтвортой, найдвартай байдлыг хангах, өөрийн улсын нөхцөл байдлыг тооцон эдийн засгийн өсөлтөд зөргөз нөлөөлөх үндэсний оновчтой загварыг тодорхойлон боловсруулахад оршино.

Дэлхийн улсуудын практикт үнэт цааны зах зээлийг зохицуулах гурван гурван үндсэн загвартай:

1. засгийн газрын байгууллагын хяналтаар (Ирланд, Голланд, Португали);

2. санхүү-банкны байгууллагын хяналтаар (ХБНГУ, Бельги, Дани);

3. тусгай чиг үүргийн байгууллагаар (АНУ, Англи, Франц, Итали, Испани).

Орчин цагт дэлхийн санхүүгийн зэх зээлийн тогтолцоонд төрийн зохицуулах, хяналтын олон шатлалтай байгууллагуудын чиг үүргийг нэгтгэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд энэ илүү үр дүнтэй нь нотлогдож байна. Ийнхүү зохицуулалтыг нэгтгэхийн гол хүчин зүйлс нь санхүүгийн зах зээлийн оролцогчийн чиг үүрэг өргөжиж нэг, хоёр чиглэлээр явцуурахаа больжээ. Энэ нь ялангуяа жижиг, эдийн засаг нь хангалттай хөгжөөгүй улсад

онцгой тохиромжтой. Олон талт санхүүгийн байгууллага нь хөрөнгө оруулагч нарт багц үйлчилгээг үзүүлэх замаар хэн хэндээ ашигтай үйл ажиллагаа явуулах боломжтой. Мэдээж үүнийг дагаад зохих чиглэлийн төрийн хяналт, зохицуулалт, өөрөөр хэлбэл мега-зохицуулагч байгуулах хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Өнөөдрийн байдлаар санхүүгийн нэгдсэн зохицуулах байгууллага нь Европын хувьд Швед (1991), Дани (1998), Норвеги (1998), Исланд (1999), Люксембург (1999, гэхдээ даатгалаас бусад нь), Эстони (2001)-д банкны байгууллагад хяналт тавих, үнэт цаас, даатгалын зах зээлийг зохицуулж байгаа бол Азид 1997-1998 оны хөрөнгийн зах зээлийн хямралын дараа (1998 - Япон, БНСУ) байгуулж эхэлжээ. Казахстанд 2001 онд Үнэт цаасны үндэсний комиссийг татан буулгаж чиг үүргийг нь Төв банкнд илжүүлж, улмаар 2004 онд Санхүүгийн зах зээл дэх хяналт, зохицуулалтын агентлагийг байгуулсан байна. ОХУ-ын хувьд 2004 онд Үнэт цаасны үндэсний комиссийг татан буулгаж, Санхүүгийн зах зээлийг зохицуулах холбооны албыг байгуулжээ.

##### АНУ:

АНУ-ын үнэт цаасны зах зээлийг хянах болон зохицуулах чиг үүрэг бүхий гол байгууллага бол АНУ-ын Үнэт цаасны болон Биржийн Комисс (Securities and Exchange Commission, SEC) юм. Комиссийг эдийн засгийн хямралын үед хөрөнгө оруулагчдын хөрөнгийн биржд итгэх итгэл алдагдаж байсан байдлад хариу арга хэмжээ болгон 1934 онд Ерөнхийлөгч Делано Рузвельт (Franklin Delano Roosevelt)-ийн дэргэд байгуулсан байна. Комиссийн тэргүүлэгчээр Джозеф Кеннеди (Joseph Kennedy) болж байжээ.

##### SEC-ийн чиг үүрэг ба эрх хэмжээ:

Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах болон үнэт цаасны зах зээлийн цогц бүтэн байдлыг хангахад чиглэгдсэн үндсэн

үүрэгтэй. Комисс нь зах зээлийн үндсэн оролцогч этгээдүүд болох хөрөнгийн бирж, брокер, дилер, хөрөнгө оруулалтын талаархи зөвлөх болон хамтын сан зэргийн үйл ажиллагааг хянадаг. АНУ-ын үнэт цаасны зах зээлийг зохицуулж буй хууль тогтоомж нь бүх хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгө оруулах гэж буй объектын талаар мэдээллийн хүртээмжтэй байхыг хангахад чиглэгдсэн байдаг. Тиймээс SEC-ийн үндсэн үүргийн нэг бол компаниудын зүгээс үнэн зөв, бодитой бөгөөд цаг хугацаанд нь өөрийн явуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл гаргуулж байхыг хангах явдал юм. SEC нь жилдээ үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрсөн 400-500 байгууллага, хувь хүнд хариуцлага тооцдог байна. Эдгээр зөрчилд трейдинг инсайдер (олон нийтэд хаалттай мэдээлэлд үндэслэн үнэт цаасны арилжаанаас ашиг олох замаар итгэмжлэлийн харилцааг эвдэх); зах зээлээр тоглох (зөвхөн тодорхой хувийн ашиг сонирхолд ашигтай байдлаар зах зээлийн хөдөлгөөнийг өөрчлөх, чиглүүлэх); нягтлан бодох бүртгэлийн зөрчил (санхүүгийн тайлангаас бодит мэдээллийг хасах бөгөөд гуйвуулах); үнэт цаасны тухай болон тэдгээрийг гаргаж буй компанийн талаар мэдээллийг худал, төөрөлдүүлэх байдлаар гаргаж өгөх явдал зонхилж байна.

Дээрх тохиолдолд SEC нь торгох хэмжээг тогтоох, хууль бусаар олсон орлогыг хураах, хувь хүн болон хуулийн этгээдэд үнэт цаастай холбоотой хууль бус ажиллагааг явуулахыг хориглох зэрэг эрх хэмжээтэй.

##### SEC-ийн бүтэц

SEC-ийн удирдлага 5 гишүүдээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Сенатын санал болгосноор Ерөнхийлөгч 5 жилийн хугацаатайгаар томилно. Тэгэхдээ жил болгоны 6 дугаар сарын 5-ны өдөр зөвхөн нэг гишүүний хугацаа дуусахаар тохируулсан байдаг. SEC-ийн бие даасан байдлыг хангах үүднээс эдгээр гишүүдийн 3-аас дээш нь нэг намд харьяалагдахыг хориглодог.

Ерөнхийлөгч нь эдгээр гишүүдээс нэгийг нь Тэргүүлэгчээр томилдог. Комисс нь байнгын бөгөөд хуралдаанаараа үнэт цаасны талаар хууль тогтоомжийг авч хэлэлцэх бөгөөд хүчин төгөлдөр буй дүрэм, журамд өөрчлөлт оруулах, зах зээлийн шинэчлэлтэй холбоотойгоор шинээр гаргах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. АНУ-ын стандартаар SEC нь холбооны жижиг агентлаг бөгөөд 3100 орчим орон тоотой, дөрвөн үндсэн хэлтсээс бүрддэг:

- корпоратив (арилжааны) санхүүгийн;
- зах зээлийн зохицуулалтын;
- хөрөнгө оруулалтын менежментийн;
- хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэлтэс.

Корпоратив санхүүгийн хэлтэс (Division of Corporation Finance) нь мэдээллийг хянах үүрэгтэй. Тухайлбал, бүртгүүлэх тухай өргөдөл, жилийн болон улирлын тайлан, хувьцаа эзэмшигчдийн жилийн хурлын өмнө хувьцаа эзэмшигчдээс тараах итгэмжит саналын талаархи материал. Мөн үнэт цаасны тухай хууль болон түүний нэмэлт, өөрчлөлтөд тайлбар хийнэ. Нягтлан бодох бүртгэлийн хэлтэстэй хамт холбогдох байгууллагын үйл ажиллагааг ажиглан нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогыг нэвтрүүлдэг. Тухайлбал, Нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс (Financial Accounting Standards Board, FASB) гаргадаг олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт (Generally Accepted Accounting Principles, GAAP).

Зах зээлийн зохицуулалтын хэлтэс (Division of Market Regulation) нь зах зээлийн үр дүнтэй болон зохион байгуулалтай, шударга явагдах үйл ажиллагааны жишгийг тогтоож, дэмжиж ажилладаг. Энэ чиг үүргийг зах зээлийн томоохон оролцогч болох брокер, дилерийн пүүс, Үнэт цаасны дилерүүдийн үндэсний нийгэмлэг (National

Association of Securities Dealers, NASD), Орон нутгийн үнэт цаасны журам боловсруулах зөвлөл (Municipal Securities Rule Making Board, MSRB), мөн Depository Trust and Clearing Corporation, DTCC, National Securities Clearing Corporation, NSCC зэрэг клиринг агентлаг, үнэт цаасны талаархи мэдээллийг боловсруулан түгээдэг агент болон байгууллагын үйл ажиллагааг зохицуулах замаар хэрэгжүүлдэг. Зах зээлийн зохицуулалтын хэлтэс нь Үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг хамгаалах корпорац (Securities Investor Protection Corporation, SIPC)-ийн үйл ажиллагааг мөн хянадаг ба SIPC нь үнэт цаас даатгах болон корпорацийн гишүүн пүүсүүдийн дансанд буй үйлчлүүлэгчдийн бусад хэргэсэлийн пүүсийн дампуурлаас даатгадаг хувийн хэвшлийн, ашгийн бус байна. SIPC нь зах зээлд унах, эсхүл залилангаас үүсэх алдагдалаас даатгадаггүй.

Хөрөнгө оруулалтын менежментийн (Division of Investment Management) нь нийт 15 трлн. \$-ийн хэмжээний хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоог хянаж, зохицуулалт хийдэг байна. Мөн тухайлбал, Хөрөнгө оруулагч компани, хамтын сан, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцдаг.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэлтэс (Division of Enforcement) нь үнэт цаасны тухай хуулийн зөрчлийг шалгах ба шаардлагатай тохиолдолд авах сахилгын арга хэмжээний талаар, эсхүл асуудлыг холбооны шүүх, эсхүл захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх талаар Үнэт цаас болон Биржийн комисст зөвлөмж гаргадаг; SEC –ийн нэрийн өмнөөс зөрчил гаргагчтай асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцээр хийдэг. Дээр дурдсанаар SEC нь зөвхөн иргэний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагын эрх хэмжээтэй.

SEC нь мөн 18 удирдах газартай бөгөөд эдгээрээс хамгийн нэр хүнд бүхий нь тохирлын хяналт, шалгалтын удирдах газар (Office of Compliance Inspections and Examinations, OCIE). OCIE нь хөрөнгийн зах зээлд оролцогчдыг байнга хянаж, шалгаж байдаг. OCIE-аас явуулж буй судалгаанд үндэслэн SEC нь үнэт цаасны тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж буйг хянаж, зөрчлийг илрүүлж байдаг. SEC нь OCIE-аас өгсөн мэдээлэлд үндэслэн эмитентод олгогдсон зөвшөөрлийг дахин харах, өөрчлөх, засах шаардлагатай байгааг илэрхийлсэн мэдэгдэх захидал илгээдэг (deficiency letters). OCIE нь nocto зөрчлийн талаар Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэлтэст мэдэгдэх бөгөөд тухайн хэлтэс нь зөрчлийг арилгах арга хэмжээг авдаг.

#### Мужийн зохицуулах байгууллага

АНУ-ын муж болон үнэт цаасны өөрийн зохицуулах албатай. Эдгээр байгууллагын ажилтнууд мужийн хууль тогтоомжийн зөрчлийг шалгадаг.

1934 оны Securities Exchange Act нь үнэт цаасны нийтэд арилжаа асуудлыг зохицуулсан. Энэ хуулийн дагуу Үнэт цаасны болон биржийн комисс (U.S. Securities and Exchange Commission, SEC) байгуулагдсан бөгөөд энэ нь АНУ-ын хөрөнгийн зах зээлийн үндсэн механизм юм.

#### Англи:

Үнэт цаасны зах зээл нь өмнө нь төрийн байгууллагаар биш, харин Лондонгийн хөрөнгийн биржээр зохицуулагддаг байсан байна. 1980 оноос Их Британи нь хөрөнгийн зах зээлийн өргөн хүрээний шинэтгэлийг хийсэн. 1988 онд Санхүүгийн үйлчилгээний тухай хууль<sup>8</sup> баталж үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг системчилж өгсөн. Энэ хуулиар үнэт цаасны зах зээлийг зохицуулах Үнэт цаасны болон хөрөнгө оруулалтын зөвлөлийг байгуулжээ. Эрх зүйн байдлын хувьд хуулиар Сангийн

<sup>8</sup> <http://www.fsa.gov.uk/pubs/cpl/rp28.pdf>

ямд харьяалагдах боловч төрийн байгууллага биш, харин үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий төрийн бус байгууллага. Мөн чанарынхаа хувьд хуулиар эрх хэмжээ нь тогтоогдсон өөрөө удирдах байгууллага юм. Энэ байгууллага нь санхүүгийн зуучлагчдад тусгай зөвшөөрөл олгох эрх хэмжээтэй хэдий ч энэ чиг үүргээ бусад өөрөө удирдах байгууллагад шилжүүлсэн байна. Санхүүгийн салбарын шинэ шинэтгэлийн хүрээнд 1997 онд энэ салбар дахь бүх зохицуулах байгууллагыг Үнэт цаасны болон хөрөнгө оруулалтын зөвлөлийн үндсэн дээр нэгтгэж Санхүүгийн үйлчилгээний зөвлөл байгуулжээ. Энэ байгууллагад бусад төрийн байгууллага болон өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг шилжүүлжээ. Дарга болон удирдах зөвлөлийн гишүүдийг Сангийн сайд томилоно. Санхүүгийн үйлчилгээний зөвлөлд Английн төв банк, бусад санхүүгийн байгууллага, үнэт цаасны компани, даатгалын компани, тэтгэврийн сан, хадгаламж, клирингийн зэрэг байгууллагын хяналтын үүргийг шилжүүлжээ.<sup>10</sup> Энэ байгууллагын санхүүжилт нь хяналтанд байгаа байгууллага болох мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагын үйлчилгээний төлбөрөөс (тухайлбал, хөрөнгийн биржийн эргэлт зэрэг) болон Зөвлөлөөс үзүүлж буй бусад үйлчилгээний төлбөрөөс бүрдэнэ. Өөрөөр хэлбэл PPP зарчмын хэрэгжилт үүнээс харагдаж байна.

Санхүүгийн салбарын зохицуулах байгууллагыг нэгтгэх хандлага англиас гадна гадаад олон улсад ажиглагдаж байна. Эхний ээлжинд скандинавын орнуудад энэ процесс явагдсан бол хожим нь Япон, Солонгос, Унгар, Латви зэрэг улсад явагджээ.

#### Франц Улс:

Хөрөнгийн зах зээл дэх зохицуулалт Франциин хувьд Эдийн

засаг, сангийн яамны харьяа олон шатлал бүхий байгууллагаас бүрддэг. Энэ зохицуулалтын үндсэн, гол байгууллага нь Биржийн арилжааны комисс (1967 онд байгуулагдсан) юм. Энэ комиссийн гол үүрэгт хөрнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах, мэдээллийн нээлттэй байх стандартыг хангах, хөрөнгө оруулалттай компаниудад тусгай зөвшөөрөл олгох, инсайдерийн арилжаанд хяналт тавих, мөн түүнчлэн хөрөнгө оруулагч нараас ирсэн гомдлыг хянах зэрэг багтана.

Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй. Эдгээр гишүүд Үндэсний Ассамблей, Сенат, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Төв банк зэргээс томилсон этгээд, бусад өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

Дараагийн байгууллага нь Санхүүгийн зах зээлийн зөвлөл юм. Энэ байгууллага нь үнэт цаасны компанийн болон биржийн үйл ажиллагааг хянах, Эдийн засаг, сангийн яамнаас батлах хөрөнгийн биржийн үйл ажиллагааг зохицуулах журам, дүрмийн төслийг боловсруулах чиг үүрэгтэй. Энэхүү Зөвлөл Эдийн засаг, сангийн яамнаас томилох 16 гишүүдээс бүрдэнэ.

Францын биржүүдийн нийгэмлэг болох EURONEXT Paris (2000 он хүртэл Парижийн бирж) нь санхүүгийн төрөлжсөн байгууллага бөгөөд зах зээл дэх өдөр тутмын ажиллагааг хариуцна.

Францын санхүүгийн тогтолцоог яг энэ загварт хамаарна гэж үзэх нь хүндрэлтэй. Францын төрийн зохицуулалт, үүрэг өндөр. Францын эдийн засгийн шинэтгэлийн үр дүнд герман загвараас англиасаксон загвар луу шилжсэн гэж үзэх үндэслэлтэй.

#### ХБНГУ:

Германд хөрөнгийн зах зээлийг олон төрлийн байгууллага зохицуулдаг. 1994 онд холбооны байгууллага болох Үнэт цаасны комиссийг байгуулсан. Комисс нь

эмитентоос мэдээлэл цуглуулах зах зээлийг хянах ба хууль тогтоомж, бусад журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг. Германы Үндсэн хуулийн онцлогоос (муж-газрын асуудал онцгой байр суурь эзэлдэг) хамааран холбооны байгууллагаас гадна Мужийн статс-комиссарын газрын төлөөлөгч мөн байна. ХБНГУ-д арилжааны банк нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн мэргэжлийн байгууллага байна. Иймд үнэт цаасны зах зээлийг зохицуулах чиг үүрэгт банкны хяналт ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Банкны холбооны хяналт шалгалтын танхим нь банкны болон үнэт цаасны компаниудад хөрөнгийн босгын хэмжээг баримталж буй байдал, балансын бүтэц гэх зэрэг үйл ажиллагаанд хяналт тавина.

Сүүлийн жилүүдэд германы үнэт цаасны зах зээл америкийн адил илүү нээлттэй болж байгаа нь нэг талаасаа эргээд америкийн үнэт цаасыг татах зорилготой юм.

#### Япон:

1948 онд Үнэт цаас болон биржийн комисс байгуулагдсан ба энэ байгууллага нь америкийн загвартай төстэй юм. 1951 онд энэ байгууллагын чиг үүргийг хялбаршуулж эрх хэмжээг нь Сангийн яамд шилжүүлж яамны харьяанд зөвлөлдөх байгууллага болох Үнэт цаас болон биржийн зөвлөл байгуулжээ. Энэ байгууллага нь энэ салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмжийг боловсруулах чиг үүрэгтэй байв. Харин 1990-1991 оны хөрөнгийн биржийн хямралын дараа инсайдер мэдээллийг хууль бусаар ашигласан, үнийг үндэслэлгүйгээр хэлбэлзүүлж зөрчил гарч байсан гэх үндэслэлээр Сангийн яамны дэргэд эргээд Үнэт цаас болон биржийн комисс байгуулсан бөгөөд энэ байгууллага нь зах зээлийн төлөв байдлыг ажиглах ба хянах үрэгтэй байв.

1998 онд санхүүгийн тогтолцооны шинэтгэлээр

<sup>10</sup> <http://www.pwc.com/Extweb/industry.nsf/docid/9EC5D5DD1C5FDB085256DF6000EF523>



санхүүгийн зах зээл бүрэн либералчлагдаж хамтарсан хөрөнгийн хэрэгслээр арилжих эрхийг санхүүгийн холдингуудад олгосон. Үнэт цаасны компаниудад санхүүгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах, бүртгэх, ашиглах үйлчилгээ явуулах болон брокерын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байна. Үүний зэрэгцээ Ерөнхий сайдын дэргэд Санхүүгийн хяналтын агентлагийг байгуулсан. Энэ байгууллага нь улсын хэмжээнд бүх санхүүгийн тогтолцоог хянах байгууллага юм. Сангийн яам нь зөвхөн санхүүгийн бодлогыг тодорхойлох, валютын болон олон улсын санхүүгийн харилцааг чиглүүлэх үүрэгтэй.

#### ОХУ:

ОХУ-ын үнэт цаасны эрх зүйн зохицуулалтын үндсэн эх сурвалж нь ОХУ-ын Иргэний хууль, үүнээс гадна 1996 оны Үнэт цаасны зах зээлийн тухай холбооны хууль, 1995 оны Хувьцаат нийгэмлэгийн тухай холбооны хууль юм. Тодорхой төрлийн үнэт цаасны эргэлтийг зохицуулсан хэм хэмжээ бусад төрлийн эрх зүйн актад тусгагдсан байдаг байна. Ерөнхийлөгчийн, Засгийн газрын болон бусад холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын актаар хуулийн зохицуулалтыг тодорхой болгож өгдөг бол Санхүүгийн зах зээлийн холбооны алба эрх хэмжээнийхээ хүрээнд холбогдох зохицуулалтыг гаргадаг.

Зохицуулах төрийн байгууллага нь Санхүүгийн зах зээлийн холбооны алба байна. Энэ алба нь 2004 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 314 дүгээр "Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо ба бүтцийн тухай" Ерөнхийлөгчийн зарлигаар өмнө нь байсан Үнэт цаасны холбооны комиссын чиг үүргийг уламжлан авч байгуулагдсан байна. Уг байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагааны журам, зохион байгуулалтын асуудлыг 2004 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн Санхүүгийн зах зээлийн холбооны албаны асуудал (Вопросы

федеральной службы по финансовым рынкам) Засгийн газрын тогтоол, мөн Засгийн газрын тогтоолоор 2004 оны 6 дугаар сарын 30-ны өдөр баталсан Санхүүгийн зах зээлийн холбооны албаны журмаар зохицуулсан байна.

Энэ байгууллага нь үнэт цаасыг гаргах, эргэлтэд оруулахыг зохицуулах; улсын бүртгэлийг хэрэгжүүлэх; үнэт цаас гаргах, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон Өөрийгөө зохицуулах байгууллага, хөрөнгө оруулалтын сан гэх зэрэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн практикийг нэгтгэх, боловсронгуй болгох санал боловсруулах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах; хууль тогтоомжийн дагуу үнэт цаасны зах зээлд мэдээллийг хангах гэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлднэ.

Санхүүгийн зах зээлийн холбооны албаны дарга, түүний орлогчийг Засгийн газар томилно. Зохион байгуулалтын хувьд дараахи статусын хувьд тэгш 10 албаны бүтэцтэй:

- Санхүүгийн зах зээлд дэх зохицуулалтыг хөгжүүлэх газар;
  - Хамтын хөрөнгө оруулалтыг зохицуулах, хянах газар;
  - Санхүүгийн зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах газар;
  - Үнэт цаасны газар;
  - Үнэт цаасны зах зээлд тавигдах хяналтын арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх газар;
  - Хуулийн хэлтэс;
  - Бичиг хэрэг, архивыг хариуцах алба;
  - Эдийн засаг, санхүү болон нягтлан бодох бүртгэлийн хэлтэс;
  - Захиргаа-техникийн хангалтын алба;
  - Санхүүгийн зах зээлийн мэдээлэл, мониторингийн алба.
- Мөн бүтцэд нь бие даасан гурван нэгж багтана:
- Төрийн алба, хүний нөөцийн хэлтэс;
  - Нэгдүгээр хэлтэс;
  - Мобилизацийн бэлтгэлийн алба

Санхүүгийн зах зээлийн холбооны алба нь өөрийн үйл ажиллагаагаа шууд болон орон нутгийн байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлднэ. Холбооны улсын хэмжээнд 14 орон нутгийн салбартай.

#### БНТУ:

Хөрөнгийн зах зээлийн хороо 1981 онд 2499 дугаар Хөрөнгийн зах зээлийн хуулиар байгуулагдсан. Бүрэн эрхээ өөрийн хариуцлагаар, хараат бусаар хэрэгжүүлэх, захиргаа болон санхүүгийн бие даасан зохицуулагч нийтийн байгууллага юм. Харьяалдаг сайд нь Ерөнхий сайдын үүрэг болгосон Төрийн сайд (Шадар сайд) юм. Төв нь Анкарад байх бөгөөд Станбулд төлөөлөгчийн газартай байна. Хорооны үндсэн чиг үүрэг:

- Хөрөнгийн зах зээлийн итгэл нээлттэй, шийдвэртэй ажиллахыг;
  - Хадгаламж эзэмшигчдийн өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах явдлыг хангах юм;
- Хороо Засгийн газраас томилсон долоон гишүүнээс бүрдэнэ. Тэдний:
- Хоёрыг нь холбогдох сайдын нэр дэвшүүлсэн 4 хүнээс;
  - Нэгийг нь Сангийн сайдын нэр дэвшүүлсэн 2 хүнээс;
  - Нэгийг нь Үйлдвэр, Худалдааны сайдын нэр дэвшүүлсэн 2 хүнээс;
  - Нэгийг нь Банкны зохицуулах болон хянах байгууллагын нэр дэвшүүлсэн 2 хүнээс;
  - Нэгийг нь Туркийн Хөрөнгийн зах зээлийн зуучлагч байгууллагуудын нийгэмлэгээс нэр дэвшүүлсэн 2 хүнээс;
  - Нэгийг нь Туркийн Танхимууд болон Биржийн нийгэмлэгийн нэр дэвшүүлсэн 2 хүнээс томилно.
- Засгийн газар нэр дэвшигчдийн нэгийг даргаар томилно. Хорооны даргын саналаар гишүүдийн дундаас нэгийг нь дэд даргаар сонгоно. Хорооны дарга, гишүүд төрийн болон хувийн өөр ямар нэг үүрэгт ажил хавсарч болохгүй бөгөөд үүрэгт хугацаа 6 жил байна. Хугацаа нь дууссан гишүүн дахин томилогдох боломжтой Даргаа

бусад гишүүдийн гуравны нэгийг хоёр жилд нэг шинэчилнэ.

Хөрөнгийн зах зээлийн хороо, хорооны дарга, гишүүд болон хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц бүхий хорооны удирдлага дахь бүтээс бүрдэнэ. Хорооны ажиллагаа даргын харьяан дахь даргын туслахын харьяанд ажиллах албадууд гүйцэтгэнэ. Албадууд:

- Хянан шалгах газар;
- Компанийн санхүүгийн газар;
- Зуучлах үйл ажиллагааны газар;
- Компанийн хөрөнгө оруулагчдын газар;
- Судалгааны газар;
- Нягтлан бодох стандартын газар;

- Зах зээлийг хянах болон зохицуулах газар;
- Эрх зүйн газар;
- Мэдлэг, Статистик болон мэдээллийн газар;
- Захиргаа болон санхүүгийн газраас бүрдэнэ.

Албадууд хэлтсийн дарга, даргын туслах, мэргэжилтнүүд, хэлтсийн даргын бүтэц дэх үйлчилгээний нэгж болон албан хаагчдаас бүрдэнэ. Хороо санхүүгийн бие даасан байна. Хорооны бүх зардлыг тусгай сангаас гаргана. Үнэт цаас гаргагчид (компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалтын компани) энэхүү санд гаргасан үнэт цаасны мянганы хоёртой тэнцэх хэмжээний төлбөр төлнө. Сангийн орлого хорооны зардалд хүрэхгүй тохиолдолд нээлттэй, төсвөөс авах тусламжаар үлдэгдлийг хаана.

#### Үнэт цаасны зах зээлд оролцдог зарим арилжааны банкны онцлог:

Арилжааны банк нь өөрийн олон талт чиг үүрэгтэй санхүүгийн байгууллагын хувьд үнэт цаасны зах зээлийн оролцогч байдаг. Гэхдээ улс болгонд арилжааны банкны үнэт цаасны зах зээлд эзлэх байр суурь янз бүр байдаг байна. Өнгөрсөн зууны 50-иад оны дундаас арилжааны банк үнэт цаасны зах зээлд шууд болон шууд бусаар нэвтэрч оролцож эхэлжээ. Зарим улс

(АНУ, Япон, Канад)-ад арилжааны банкны санхүүгийн зах зээл оролцох эрхийг нь хязгаарласан байдаг боловч эдгээр нь трастын үйл ажиллагааны хэлбэрээр болон брокерийн пүүсээр дамжуулан, эсхүл хөрөнгө оруулалтын компани, банкыг санхүүжүүлэх хэлбэрээр шууд бус байдлаар оролцдог байна. Үнэт цаастай холбоотой ариллагаанд идэвхтэй байдлаар германы арилжааны банк оролцдог. Үнэт цаастай холбоотой өргөн хүрээний ажиллагаанд оролцох боломжийг нь хуулиар зохицуулсан байдаг байна. Тухайлбал, эмитентийн чиг үүргийг (облигаци гаргах) хэрэгжүүлж болохоос гадна зуучлагч, хөрөнгө оруулагчаар оролцож болдог байна.

Ихэнхи улсад арилжааны банк нь өөрийн ашгаа үнэт цаастай холбоотой болон хөрөнгө оруулалтын ажиллагаанаас олох орлогоос бүрдүүлэх хандлагатай байна. Арилжааны банкны үнэт цаасны зах зээлд оролцох хандлага нэмэгдсэнээр арилжааны банкаар толгойлуулсан банк, санхүүгийн том том группүүд байгуулагдах нөхцөл болжээ. Эдгээр санхүүгийн групп нь өөртөө хөрөнгө оруулалтын сан, брокерын пүүс, трастын компани, зөвлөх үйлчилгээ үзүүлэх пүүс, компаниудыг төвлөрүүлсэн бүтэцтэй байдаг.

Арилжааны банк өөрийн охин санхүүгийн компани байгуулж, мөн брокерын пүүсийн үйл ажиллагаанд шууд оролцох замаар хөрөнгийн зах зээлд байр сууриа олж байна. Үнэт цаасны зах зээлийн хил дамжаж хөгжиж байгаа нь мөн арилжааны банкинд илүү ашигтай гадаадын хувьцаа, облигацийн эргэлтэнд оролцож (мөн ханшны зөрүү дээр тоглох замаар) үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлж байна. Ийм байгууллагын ихэнхи нь олон улсын түвшинд нэртэй байхаас гадна гадаадын банк, санхүүгийн байгууллагатай нягт холбоотой байдаг. Ихэнхи улсад арилжааны банкны шинэ төрлийн үйл ажиллагааны чиглэл бол санхүүгийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх явдал юм. Энэ үйлчилгээгээ

тодорхой санхүүгийн актив хөрөнгө оруулах үйлчлүүлэгчийн сонирхолд үзүүлдэг. Ийм тусалцааг банкны дотоод мэдээллийн тогтолцоонд тугуурлан актив хөрөнгийн ашиг, эрсдэлийн харилцан хамааралд үнэлгээ хийх, ашгийн динамик үзүүлэлтийг харгалзан үнэт цаасны багц (portfolio) бүрдүүлэх, худалдан авах тооцоо боловсруулах зэргээр хийнэ.

#### Хөрөнгийн биржийн зарим онцлог:

Зарим улсад (Англи, АНУ) хөрөнгийн бирж нь хувьцаат нийгэмлэг хэлбэртэй хувийн компани байдаг. Ийм бирж нь бие даасан байдалтай биржийн арилжааг явуулдаг. Бирж дээрхи бүх хэлцэл хууль тогтоомжийн дагуу явагдахаас гадна тухайн зохицуулалтыг зөрсөнөөр тодорхой эрх зүйн хариуцлагыг үүрдэг.

Зарим улсад (Австри, Швейцар, Швед) бирж нь хувьцаат нийгэмлэг хэлбэртэй боловч холимог байдлаар, тухайлбал, 50% хувьцаа нь улсын мэдэлд байх хэлбэрээр байгуулагддаг. Ийм биржийг сонгуультай байгууллага удирдана. Гэхдээ биржийн комиссар нь биржийн үйл ажиллагааг хянахаас гадна албан ёсоор биржийн ханшийг бүртгэдэг.

Харин улс хэсэг улсад (Казахстан, Киргиз, ОХУ) бирж нь ашгийн бус байгууллага байдаг. Ийм байгууллагын гол зорилго нь үнэт цаасны хэвийн эргэлтэд шаардлагатай нөхцөлийг хангах, зах зээлийн үнийг нь тодорхойлох, зохих мэдээллийг түгээх, мэргэжлийн оролцогчдын мэргэжлийн өндөр түвшинг тогтоож байх үүрэгтэй.

Мэргэжлийн байгууллага нь зохих тусгай зөвшөөрөлд үндэслэн үйл ажиллагаагаа явуулна. Ихэнхи улсад гурван төрлийн тусгай зөвшөөрөл мэргэжлийн байгууллагад олгогддог байна.

- Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл;

- бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл.;

- хөрөнгийн биржийн тусгай зөвшөөрөл.

Ийм байдлаар тусгай зөвшөөрлийг тусгаарлан хуульчилж буй нь аливаа зөрчлийн асуудлаас урьчилан сэргийлэх үүднээс үйл ажиллагааг холин, давхардуулан хэрэгжүүлэхийг хязгаарласан байдаг байна. Өөрөөр хэлбэл бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг бусад мэргэжлийн үйл ажиллагаатай хавсарган явуулж болохгүй.

Хөрөнгийн биржийн гишүүний статус улс болгонд харилцан адилгүй байдаг байна. Тухайлбал, АНУ, Англид хөрөнгийн биржийн гишүүд нь зөвхөн хувь этгээд, Итали, Герман, ОХУ, Казахстанд хувь болон хуулийн этгээд байдаг байна. Хөрөнгийн бирж үнэт цаасны холбоотой бирж дэх ажиллагааг явуулах журмыг тогтохоос гадна үнэт цаасыг арилжаанд гаргах (листинг), арилжаанаас гаргах (делистинг) журмыг, хэлцэлийг бүртгэх, хангах журмыг тогтоодог. Зарим улсад листингд эзлэх байр суурь нь татварын хөнгөлөлтийн үндэслэл болдог байна.<sup>11</sup>

#### Өөрийгөө зохицуулах байгууллага:

Үнэт цаасны зах зээлд өөрөө удирдах байгууллага өндөр ач холбогдолтой. Өөрийгөө зохицуулах байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ашгийн төлөө бус сайн дурын байгууллага юм. Өөрийгөө зохицуулах байгууллагын эрх зүйн зохион байгууллагын хэлбэр нь бүх улсад холбоо, нийгэмлэг хэлбэртэй байдаг. Энэ байгууллага нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах оролцогчдын сайн дурын үндсэн дээр байгуулагддаг ба тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний биелэлтийг хангах, үнэт цаас эзэмшигч болон тухайн холбооны гишүүн этгээдийн бусад үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, өөрийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах. Үнэт цаасны зах

зээлийн зохицуулах байгууллагаас үүрэг болгосны дагуу үнэт цаастай холбоотой ажиллагааг явуулах мэргэжлийн журам, стандартыг тогтоох, түүнийхээ хэрэгжилтийг хянах чиг үүрэгтэй. Энэ байгууллага нь гол төлөв Үнэт цаасны зах зээлийн зохицуулах байгууллагаас олгох зөвшөөрлөөр байгуулагдаж энэ байгууллагадаа тайлагнах үүрэгтэй байдаг байна. Олсон орлогоо гишүүддээ хуваарилахгүйгээр зөвхөн өөрийн дүрмийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа зарцуулна. Өөрийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс зарим улсад эдгээр холбоо нь хөндлөнгийн арбитрын үүрэг гүйцэтгэх нэгжтэй байдаг байна. Харин ийм байгууллагын гишүүдийн гэрээнд арбитрийн тухай зохицуулалт байхгүй бол арбитрын байгууллагад эрхээ хамгаалуулахаар хандаж болдог байна. Өөрийгөө зохицуулах байгууллага нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчийн итгэлийг татах хүчин зүйлсийн нэг болдог. Өөрийгөө зохицуулах байгууллага хөгжсөн улсад (АНУ, Англи, Герман, Франц) аливаа асуудлын гарц, шийдлийг мэргэжлийн зүгээс гаргадаг. Харин үнэт цаасны зах зээлийг зөвхөн төр хянадаг улсад ихэнх тохиолдолд асуудлыг шийдэхдээ үр дүн, өгөөж багатай, эсхүл хожимдуулж шийдвэр гаргадаг. Өөрийгөө зохицуулах байгууллага нь зөвшилцөлд үндэслэн шийдвэрээ гаргадаг. Мөн хариуцлагын хувьд төрийн санцгаас Өөрийгөө зохицуулах байгууллагын авах арга хэмжээ нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, бойкот үзүүлэх замаар (харьцаагаа хязгаарлах замаар) зөрчил гаргагчийг дампууралд хүргэж болно.

#### Хариуцлагын тогтолцоо:

АНУ-ын хувьд Үнэт цаасны болон биржийн комисс нь хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд захиргааны арга хэмжээ авдаг ба мэргэжлийн байгууллагын эрх бүхий

албан тушаалтан, эсхүл тухайн хуулийн этгээдэд, мөн үнэт цаас гаргагчдад торгууль тавих эрхтэй. АНУ-ын хууль тогтоомжоор Комисс нь 500 мянган долларын торгууль тавих эрхтэй. Үүнээс гадна үнийг хууль бусаар өсгөж, бууруулсан бол хувь этгээдэд 1 сая доллар, эсхүл 10 хүртэл жил хорих ял, хуулийн этгээдэд 2,5 сая долларын тогтох ялаар шийтгэгдэж байна. Харин дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих тохиолдолд хувь этгээдэд 5-100 мянган доллар, хуулийн этгээдэд 50-500 мянган долларын торгууль тавьдаг байна. Мөн мэргэжлийн байгууллага дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих тохиолдолд Комисс нь тухайн мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдлын хэмжээг гурав нугалсан хэмжээний торгууль тавих эрхтэй. Энэ тохиолдолд хяналт тавьж байсан этгээдийг торгож бас болно. Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих хэргийн хөөн эхлэлцэх хугацаа иргэний хэргээс их буюу 5 жил байдаг байна. Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журам зөрчсөнийг илрүүлэхэд мэдээллээр тусалсан этгээдэд Комисс нь торгуулийн 10% хүртэл хэмжээний шагнал, урамшуулал олгох эрх хэмжээтэй. Торгуулийн санцгаас гадна Комисс нь холбогдох этгээдийн бусад үйл ажиллагааг нь хязгаарлах арга хэмжээ авах боломжтой. Мөн Комисс нь тухайн байгууллагыг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах тухай шүүхэд хүсэлт гарган шийдвэрлүүлэх боломжтой.

Европын зохицуулалт нь мөн хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг шийтгэх үр дүнтэй зохицуулалттай. Захиргааны хариуцлагаас торгууль нь өргөн хэрэглэгддэг. Тухайлбал, Англид дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих

<sup>11</sup> Т.О. Редеева. Правовое регулирование рынка ценных бумаг. Уч.п. Волгоград. 2001. С.41

тохиолдолд 7 хүртэл жилээр хорих, эсхүл торгох шийтгэлийг ногдуулж болдог байна. Мөн энэ хоёрыг нэгтгэсэн байдлаар ч хариуцлага хүлээлгэж болдог байна. Дотоод мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдал болох хэмжээг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч болно.

Франц улсад энэ төрлийн хэрэгт 2 сараас 2 жил хүртэл, эсхүл (болон) 6000 – 10 сая франк буюу дотоод мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдлын хэмжээг арав нугалсан хэмжээний торгууль тавина.<sup>12</sup>

#### Дүгнэлт

Өөрийгөө зохицуулах байгууллагын үнэт цаасны зах зээлд үзүүлэх эерэг нөлөөнөөс гадна сөрөг нөлөөг харгалзан үзэх ёстой. Тухайлбал, тодорхой хүрээ (холбоо)-гээр хязгаарласан монополи тогтоох боломжтой ба эрх мэдэл, нөлөөлөл хуваах нөхцөл бүрддэг. Хэдий мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах журам, стандарт гаргах боловч түүнийгээ хэрэгжүүлэх эрх зүйн хязгааргүй байдаг. Мөн ийм байгууллагад гишүүнээр сайн дурын үндсэн дээр нэгддэг боловч хэн хэзээч нэг ийм байгууллагаас гарч өөр байгууллагад орох эрхтэй байдаг. Энэ тохиолдолд хяналт, зохицуулалтаас дүрвэж сул, ёс зүйн хувьд чөлөөтэйд орох магадлалтай. Эдгээр байгууллага нь хиндаархаж, чиглэл зааж хаалттай клуб болох боломжтой. Иймд манай улсын хувьд дэвшилтэй улсын практикийг даган Өөрийгөө зохицуулах байгууллагыг хөгжүүлэх шаарлагатай боловч дээрхи сул талыг нь тооцон хандах (тоон хязгаар тавих, г.м.) нь зохимжтой.

Үнэт цаасны зах зээл хөгжсөн зарим улсын практикт шинжилгээ хийж листингд эзлэх байр сууриар нь татварын хөнгөлөлтийн үндэслэл

болдог тогтолцоог нэвтрүүлэх боломжтой гудлах шаардлагатай байна. Энэ нь үнэт цаасны зах зээлийн үр нөлөөгөөр эдийн засгийг хөгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг болох листингд баталгаатай байр суурь эзлэх, хөрөнгө оруулагчийн итгэл, сонирхолыг нэмэгдүүлж буй компанид үзүүлэх урамшууллын тогтолцоо болно.

Гадаад улсын практик, олон улсын стандартыг баримтлан Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход баримтлах үндсэн чиглэл:

- Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг иргэний эрх зүйд үндэслэн боловсронгуй болгох;

- Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолыг хамгаалах, зах зээлд дээрхи хууль бус үйл ажиллагааг хориглох, үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогч байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, захиргааны болон эрүүгийн эрх зүйн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;

- Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх үүднээс нөхөн олговрын олон хувилбар, хэлбэрийг нэмэгдүүлэх;

- Мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох;

- Удирдлагын зохистой хэлбэрийг хөгжүүлэх;

- Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн шаардлагыг шалгах улсын хяналтыг боловсронгуй болгох, мэргэжлийн үйл ажиллагаанд өндөр мэргэшил, хөрөнгийн баталгаа, шударга, нээлттэй байх стандартын асуудлаар тусгай зөвшөөрлийн шаардлагыг нэмэгдүүлэх;

- Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах тэгш нөхцөл, чөлөөт өрсөлдөөнийг хөгжүүлэх;

- Бие даасан олон нийтийн хяналтыг тогтолцоог хөгжүүлэх;

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлд оролцуулах нөхцөл, орчныг бүрдүүлэх;

- Монголын үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах нөхцөл, орчныг бүрдүүлэх;

- Компанийн удирдлага (манайд “Компанийн засаглал” гэж томъёолсон байгаа)-ын олон улсын стандартыг үнэт цаасны зах зээлд оролцох компаниудад нэвтрүүлэх.

#### **ТАВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУРТАЛЧИЛГАА БА ИРГЭДИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙН БАЙДАЛ**

##### **5.1. Судалгаа явуулсан байдал**

Иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдал, энэ талаар тэдэнд хүрч буй хууль тогтоомжийн сурталчилгааны төлөв, үр өгөөжийг судлан тогтоохын тулд нийслэл, орон нутгийн хэмжээнд ихээхэн өргөн хүрээг хамруулан судаллаа.

Иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдал, хууль тогтоомжийн сурталчилгаа явуулж буй байдал, үр өгөөжийн талаар иргэдээс авах санал асуулгад зориулан 13 асуулт бүхий санал асуулгын хуудас боловсруулж, уг асуулгын хуудсаар 1100 иргэнээс санал асуулга авч, саналыг төрөлжүүлэн авч үзсэн болно.

Иргэдийн үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл ямар түвшинд байгаа, түүнчлэн үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл олж авахад учирч буй бэрхшээл нь иргэдийн нас, боловсрол болон нийслэл, хөдөө орон нутагт амьдарч буй байдлаас хамаарч буй эсэхэд дүгнэлт хийх зорилгоор санал асуулгын судалгааг нийслэл, хөдөө орон нутгаас адил тоогоор авсан болно.

Санал асуулгын судалгааны үр дүнгийн магадлалыг тандах, судалгааны бодитой байдлыг хангах зорилгоор Дархан-Уул, Орхон, Булган аймгуудад биечлэн очиж, зохих иргэд, албан тушаалтнаас ярилцлагын аргаар судалгаа авлаа.

Санал асуулгын болон ярилцлагын аргаар хийсэн

<sup>12</sup> <http://agitis.ru/strategiya/page14.html>

судалгаанд иргэн, төр захиргааны байгууллагын албан хаагч, шүүгч, өмгөөлөгч гэх мэтчилэн давхардсан тоогоор 1208 хүн оролцож санал өгчээ.

Мөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг уншиж судалж байх явцад иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдлыг судалж үзсэн болно.

## 5.2. Иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдал

### 5.2.1. Хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбарыг хэрхэн зарцуулсан

Санал асуулгын судалгаанд оролцогчдын "хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбарыг хэрхэн зарцуулсан" байдлыг судалж үзэхэд судалгаанд хариулт өгсөн 1012 иргэний 13.1% нь тухайн үед ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулсан, 43.7% нь өөрөө зарцуулаагүй буюу эцэг, эх нь зарцуулсан, 18.1% нь бусад бэлэн мөнгөөр худалдсан, 24.9% нь тасалбарыг хэрхэн зарцуулснаа мэдэхгүй байна гэж хариулжээ. Харин асуулгад хариулсан оролцогчдыг насны ангиллаар нь авч үзвэл 35-аас доош насны иргэдийн 83.3% нь цэнхэр болон ягаан тасалбарыг өөрөө зарцуулаагүй, эсвэл хэрхэн зарцуулснаа мэдэхгүй гэх хариултыг өгчээ. Харин 36-аас дээш насны иргэдийн 21.7% нь цэнхэр болон ягаан тасалбараа ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулж, 27.7% нь бусад бэлэн мөнгөөр худалджээ.

Харин судалгаанд оролцогчдын амьдарч буй нутаг дэвсгэрийн харьяаллаар авч үзэхэд нийслэл, орон нутаг гэх үзүүлэлтийн хувьд төдийлөн ялгаа байгаагүй боловч хөдөө орон нутгийн иргэд хувьчлалын тасалбараа ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулах замаар зарцуулсан нь нийслэлд амьдарч буй иргэдтэй харьцуулахад 46.1%-аар илүү, тухайн үед бэлэн мөнгөөр худалдсан

нь 44.8%-аар илүү байлаа. Энэхүү дүн нь хөдөө орон нутгийн иргэд хувьчлалын тасалбарыг хэрхэн зарцуулах аргаа мэдэхгүй байснаас гадна тэднийг ажиллуулж байсан байгууллагын удирдлага болоод бусад этгээдүүд энэ байдлыг туйлын овжин ашиглаж, иргэдийн үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцох эрхийг зөрчиж байсан гэх дүгнэлтэд хүргэж байна.

Үүнээс харахад иргэд үнэт цаасыг хэрхэн зарцуулах арга замаа мэдэхгүй, энэ талаархи мэдээ, мэдээлэл хомс байснаас хувьцааг хөрөнгө оруулалт хэлбэрээр бусдад өгсөн бөгөөд үүнээс ногдол ашиг аваагүй, мөн хувьцааг хэрхэн зарцуулснаа буюу яаснаа мэдэхгүй байсан юм. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны талаархи мэдээ мэдээлэл хомс байсан нь хувьчлалын тасалбарын зарцуулалтад сөргөөр нөлөөлжээ.

Хувьчлалын цэнхэр, ягаан тасалбарын зарцуулалтын талаархи санал асуулгын дүнг магадлах зорилгоор иргэдтэй биечлэн уулзаж ярилцахад:

- цэнхэр, ягаан тасалбар гар дээр нь байхгүй, брокерийн компанид л байдаг байх, яасныг мэдэхгүй байна;
- хэзээ ч ямар нэг ногдол ашиг авч байгаагүй, үүнийг мэдэж хөөцөлдөө ч үгүй, аль нэг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд сууж үзээгүй, хурал болох тухай хэн нэгэн мэдэгдэж байгаагүй;
- цэнхэр, ягаан тасалбар байгаа, тэр одоо хэрэггүй болсон биз дээ, хувьчлалын тасалбарыг иргэд бидэнд хуваарилж байх тэр үеэр л зарж борлуулах ёстой байсан тэгж чадаагүй;

- зарим хувьцаагаа үнэтэй борлуулж, үнэд хүрэх магадлалтай гэж үзэж хэдэн ширхэг хувьцаа авсан байсан юм. Түүнийгээ зарах санаатай очтол орон нутгийн брокерийн компани надаас асуулгүйгээр борлуулчихсан байсан, тэгээд та зөвшөөрч, гарын үсэг зурсан учраас манайх аяла л хийсэн гэж мэлээд өнгөрсөн.

Түүнээс хойш хувьцаагүй болсон гэж бодоод тэр тухай сонирхохоо болсон;

- Үнэт цаасны арилжаа явагддаг эсэх талаар мэдэхгүй, арилжааны зар хүргэгддэггүй, арилжаа хаана явагддаг нь ч тодорхойгүй гэх мэтчилэн ярьж байлаа.

Мөн санал асуулгын судалгаанд оролцсон иргэдийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараар өөртөө ашигтай хөрөнгө оруулсан эсэхийг судлахад 23.7% нь хариулаагүй буюу мэдэхгүй гэсэн бол 17.8% нь тухайн үедээ ашигтай байсан гэж, 3.9% нь одоо хүртэл ногдол ашиг авч байгаа тул ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэж хариулжээ. Гэтэл асуулгад хариулагчдийн 54.5% нь ашигтай хөрөнгө оруулалт хийгээгүй гэж хариулснаас<sup>13</sup> үзэхэд иргэд хувьчлалын тасалбараа ашигтайгаар зарцуулж чадаагүй байна гэх дүгнэлтэд хүрлээ.

Иргэдийн хувьчлалын тасалбараар өөртөө ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэх үнэлгээ тэдний нас, боловсрол, амьдарч буй нутаг дэвсгэрийн харьяаллаар төдийлөн ялгаатай бус байсан боловч орон нутгийн иргэдийн хувьчлалын тасалбараар өөртөө ашигтай хөрөнгө оруулсан гэх үнэлгээ нийслэлийн иргэдийн үнэлгээнээс 59.2%-аар, тухай үедээ ашигтай байсан гэх үнэлгээ 70.4%-аар илүү байлаа. Энэ нь орон нутгийн иргэд хувьчлалын тасалбараараа нийслэлийн иргэдээс ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэх дүгнэлтэд хүргэсэн юм.

### 5.2.2. Үнэт цаас гэж юу вэ?

Иргэдийн үнэт цаасны талаархи ойлголт ямар түвшинд байгааг санал асуулгын аргаар судалж үзэхэд судалгаанд оролцогчдын 44.2% нь энэхүү асуулгад хариулаагүй, харин 55.8% нь дор дурдсанаар хариулжээ. Судалгаанд оролцогчдын:

- 40% нь буюу 0.3% нь үнэт цаасыг арилжааны зүйл буюу ашигтай зүйл гэж;

<sup>13</sup> Хавсралт зураг 3-ийг харна уу

• 114 нь буюу 10.3% нь буюу мөнгө, өмч хөрөнгө буюу өмч хөрөнгийн нэг хэлбэр гэж;

• 22 нь буюу 2% нь энгийн л цаас буюу залилан мэхлэх арга гэж;

• 112 нь буюу 10.1% нь хөрөнгийн баталгаа гэж;

• 38 нь буюу 3.4% нь Засгийн газар, аж ахуйн нэгж болон эрх бүхий байгууллагаас гаргадаг бичиг гэж;

• 82 нь буюу 7.4% нь хувьцаа эзэмшигчийн эрхийн гэрчилгээ, хувьцаа гэж;

• 56 нь буюу 5.09% нь ноогдол ашиг авах бизнесийн нэг төрөл гэж;

• 11 нь буюу 1% нь биет бус хөрөнгө гэж ойлгодог бол 138 нь буюу 12.5% нь мэдээлэл байхгүйгээс мэдэхгүй гэж хариулжээ.<sup>14</sup>

Судалгааны энэхүү дүнгээс дүгнэж үзэхэд судалгаанд оролцсон иргэдийн 56.7% нь үнэт цаасны талаар тодорхой ойлголтгүй буюу мэдлэггүй /асуулгад хариулаагүй оролцогчийг үнэт цаасны талаар тодорхой ойлголтгүй байна гэж үзэхэд/, 12.1% нь үнэт цаасны талаар буруу ойлголттой байлаа.

### 5.2.3. Одоо эзэмшиж буй үнэт цаас

Иргэдээс одоо ямар үнэт цаас эзэмшиж байгааг нь санал асуулгын аргаар асууж судлахад судалгаанд оролцогчдын 35% нь хариулаагүй, 21.8% нь ямар нэг үнэт цаас эзэмшдэггүй гэж хариулсан бол үнэт цаас эзэмшдэг хэмээн хариулсан оролцогчид дараах нэр төрлийн үнэт цаасыг дор дурдсан хувиар эзэмшдэг гэж хариулсан юм. Судалгаанд оролцогчид (давхардсан тоогоор)-ын:

• 14.8% нь хувьцаа;

• 5.7% нь эрх бүхий байгууллагаас олгодог гэрчилгээ;

• 1.3% нь Засгийн газрын бонд;

• 2.4% нь өрийн бичиг;

• 0.4% нь вексель;

• 3.7% нь чек;

• 0.2% нь опцион;

• 3% нь банкны сертификатыг;

• 13.7% нь бусад төрлийн үнэт цаас эзэмшдэг гэж хариулжээ.

Үнэт цаас эзэмшиж буй оролцогчдыг насны байдлаар харьцуулж үзэхэд үнэт цаасны төрлөөс шалтгаалан харилцан адилгүй байлаа.

### 5.2.4. Иргэдийн хамгийн сайн мэдэх үнэт цаас

Судалгаанд оролцсон иргэдээс ямар үнэт цаасыг хамгийн сайн мэдэхийг асуулгын аргаар судлахад давхардсан тоогоор 53.1% нь хувьцаат компанийн хувьцааг, 25.6% нь Засгийн газрын бондыг, 9.5% нь өрийн бичгийг, 6% нь векселийг, 26.1% нь чекийг, 4.2% нь опционыг, 12.2% нь банкны сертификатыг, 6.3% нь бусад үнэт цаасыг сайн мэднэ гэжээ.

Судалгаанд оролцогчдыг насны байдлаар харьцуулж үзэхэд 18-45 насныхан илүү олон төрлийн үнэт цаасыг мэддэг ажээ.

Үнэт цаасны талаар иргэд хэрхэн ойлгодог талаар ярилцаж үзэхэд үнэт цаасыг цэнхэр, ягаан тасалбар, хувьцаа гэхээс өөрөөр нэрлэж мэдэхгүй байлаа.

### 5.3. Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа

#### 5.3.1. Үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг хаанаас олж авдаг болох

Санал асуулгын судалгаанд оролцсон иргэдээс үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг ямар эх сурвалжаас олж мэддэгийг асуухад судалгаанд оролцогчид давхардсан тоогоор, дараах байдлаар хариулт өгсөн юм. Үүнд:

• Үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг телевизээр олж авдаг гэж 53.2% нь;

• Сонин хэвлэлээс олж авдаг гэж 23.9% нь;

• Хөрөнгийн биржээс гаргадаг сэтгүүлээс олж авдаг гэж 5.8% нь;

• Хувь хүнээс мэдээлэл олж авдаг гэж 8.7% нь;

• Интернетээс мэдээлэл авдаг гэж 13.9% нь хариулсан байна.

Харин судалгаанд оролцогчдын 24.6% нь үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл олж авч чаддаггүй

гэж хариулсан бол 3.4% нь асуулгад огт хариулаагүй байна.

### 5.3.2. Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа

Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа орон нутагт ямар түвшинд байгаа талаар санал асуулгын судалгаанд оролцсон иргэдээс асуухад 2.4% нь хариулаагүй бол 80.3% нь үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа орон нутагт хангалтгүй, 14.8% нь дунд зэрэг, 2.4% нь хангалттай сайн гэж дүгнэсэн байна.

Судалгаанд оролцогчдын дүгнэсэнээс харахад орон нутагт үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа маш хангалтгүй байдаг нь харагдаж байлаа.

Судалгаанд оролцогчид үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа хангалтгүй байгаа шалтгааныг тогтоох зорилго бүхий асуулт тавихад судалгаанд оролцогчдын:

• 45% нь мэдээлэл байхгүй, сурталчилгаа хангалтгүй гэж;

• 5.7% нь төрийн бодлого хангалтгүй гэж;

• 2.5% нь үнэт цаас ач холбогдолгүй тул хэрэглээ бага, зах зээл байхгүй гэж;

• 6% нь мэргэжлийн байгууллага байхгүй, Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа хангалтгүй гэж;

• 1.6% нь үнэт цаасны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчний нөөц байхгүй гэж;

• 0.8% нь хариуцлага байхгүйгээс гэж;

• 0.09% нь орон нутгийн хөгжил, иргэдийн ухамсар хангалтгүйгээс гэж;

• 8.7% нь хууль тогтоомжийн сурталчилгаа хангалтгүй байгаа шалтгааныг мэдэхгүй гэж хариулсан бол судалгаанд оролцогчдын 36.2% нь ямар нэг хариулт өгөөгүй байна.

Иргэдээс ярилцлагын аргаар судалгаа авахад иргэд төдийгүй төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид ч үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэлгүй, үнэт цаасны эрх зүйн харилцаанд

<sup>14</sup> Хавсралт зураг 5-ыг харна уу.

оролцдоггүй болох нь тогтоогдож байлаа.

Мөн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд хууль тогтоомж сурталчлах ажил хийдэг ч ихэвчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон нийгмийн халамжийн чиглэлийн хууль тогтоомжийн сурталчилгаа кийдэг, үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажил хийдэггүй байна.

Хөдөө орон нутагт буюу Дархан-Уул, Орхон аймаг дахь Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгчид үнэт цаасны талаар мэдээлэл өгөх, үнэт цаасны тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд орон нутгийн телевизээр ярилцлага нэвтрүүлэг хийхээс гадна нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, иргэдэд мэдээлэл хүргэжээ. Гэвч тус аймагын иргэдийн үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэл мөн л хомс байлаа.

Санал асуулгын аргаар судалгааг авахдаа судалгаанд оролцогчийн нас, боловсролын байдлыг үзүүлэлт болгон дүгнэхэд хувьчлалын тасалбарыг зарцуулсан байдал, үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэл, түүнийг олж авч буй байдал насны ангилал болоод боловсролын түвшингээр төдийлөн ялгаатай байсангүй. Өөрөөр хэлбэл, иргэд массаараа үнэт цаасны талаар мэдлэг, мэдээлэл муутай, үнэт цаасны талаархи мэдээлэл хомс сурталчилгаа муу гэх дүгнэлтэд судлаачдыг хүргэсэн юм.

#### 5.4. Дүгнэлт

Социологийн судалгаанд хамрагдагсдын 68.6% нь хувьчлалын тасалбараа хэрхэн зарцуулснаа мэдэхгүй, эсвэл зөв зарцуулаагүй, 56.7% нь үнэт цаасны талаар тодорхой ойлголцоггүй буюу мэдлэггүй, 12.1% нь үнэт цаасны талаар буруу ойлголцотой, 45.2% нь л үнэт цаас эзэмшиж байгаа, давхардсан тоогоор 53.1% нь хувьцаат компанийн хувьцааг үлдэх 46.9% нь үнэт цаасны бусад төрлийг маш бага хувиар мэдлэг, 80.3% нь үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа орон нутагт хангалтгүй

гэж дүгнэснээс харахад иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн түвшин маш муу, үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа маш хангалтгүй байна.

Иргэд нас, боловсролоос хамаарахгүйгээр буюу нийт массаараа үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэлгүйгээс хувьцаа эзэмшигчийн хөрөнгө үхмэл байгаа, үүний улмаас иргэд хөрөнгийн зах зээлд итгэх итгэлгүй, Монгол Улсад хөрөнгийн зах зээл зогсонги байдалтай байна.

Судалгааны явцад иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг зэрэгээр үнэлэн сайшаах зүйл ажиглагдсангүй. Ийнхүү иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэг хомс, муу байгаа нь үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаатай шууд холбоотой тул үнэт цаасны хууль тогтоомжийг иргэдэд таниулан сурталчлах ажлыг сайжруулж, улмаар иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчлах ажлыг сайжруулж, иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай Үүнд:

1. Үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг нийтэд хүртээлтэй бөгөөд үр өгөөжтэй хэлбэрээр түгээх шаардлагатай. Судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 53.2% нь үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг телевизээс олж авдаг байх тул телевизээр цуврал нэвтрүүлэг явуулах болон өөр бусад хэлбэрээр үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл нэвтрүүлж, хууль тогтоомжийг сурталчлах;

2. Хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчилахад чиглүүлэх, уялдуулах;

3. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын биржгалтын төлөвлөгөөнд үнэт цаасны хууль тогтоомжийн талаар сэдэв оруулж, үнэт цаасны талаархи мэдлэг олгож, мэдээлэл өгөх;

4. Бүх төрлийн хэвлэл, мэдээлэлд үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчилах, иргэдэд эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох зорилго бүхий булан, нэвтрүүлэг бий болгох;

5. Хөрөнгийн биржээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4-т заасны дагуу явуулах үйл ажиллагааны хүрээнд иргэд, харилцагчдыг мэдээллээр хангахаас гадна үнэт цаасны талаархи мэдлэг олгох чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааж, Хөрөнгийн бирж энэхүү чиг үүргийн хүрээнд тодорхой ажлыг төлөвлөн ажилладаг тогтолцоог бий болгох, Хөрөнгийн биржийн энэхүү үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооноос хяналт тавих чиг үүргийг хүлээлгэх;

6. Хөрөнгийн биржээс үнэт цаасны арилжаа явуулах журам, арилжаа явагдах цаг хугацаа, бирж дээр арилжихаар зөвшөөрөгдсөн үнэт цаасны жагсаалт, арилжааны үр дүн гэх мэдээллийг хэвлэл мэдээллийн бүх хэргэсээр шуурхай мэдээлж байх тогтолцоог боловсронгуй болгох;

7. Ерөнхий боловсролын болон Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэт цаасны талаар мэдлэг олгох хичээлийг зохих төлөвлөгөөний дагуу оруулахаар тусгах;

8. Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг илүү нээлттэй болгож, иргэдэд чиглүүлэх;

9. Санхүүгийн зохицуулах хороонд Хувьцаат компаниас хувь нийлүүлэгчдийн хурал хийж буй байдал, ногдол ашиг тарааж буй байдал, хувь нийлүүлэгчдийн эрх ашиг зөрчигдөж буй эсэхэд хяналт гавьж, зохих арга хэмжээ авах бүрэн эрх олгох.



## Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүндийг хамгаалах иргэний эрх зүйн зохицуулалт



Докторант Ш.Сүхбаатар

Иргэний эрх зүйн субъект тус бүр иргэний эрх зүйн арга хэрэгслээр өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ хамгаалуулах эрхтэй. Харин энэхүү эрхийг зөрчсөн этгээд өөрийн буруутай үйлдлийн улмаас учирсан үр дагаварыг хариуцаж Иргэний хуульд зааснаар учирсан хохирлыг нөхөн төлөх зарчим өнөө манай улсад үйлчилж байна.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах эрх нь хувиин эд хөрөнгийн бус эрхэд хамаарна. Хувиин эд хөрөнгийн биш харилцааны өвөрмөц онцлог нь материаллаг бус баялгийн уг чанар, юуны өмнө тэдгээрийн жам ёсны гарал үүсэлд оршдог. Үнэхээр нэр төр, алдар хүнд, нэр хүнд, алдар нэр, ажил хэргийн нэр хүнд гэсэн ойролцоо олон ухагдахуун нь хүнтэй ямагт салшгүй хамт байж ирсэн бөгөөд тэдгээрийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжгүй юм. Ямар нэг үйлдэл хийх замаар гэдгээрийг өөрчлөх эсвэл таслан зогсоох аргагүй. Иймээс тэдгээрийг

зохицуулах нь утгагүй хэрэг гэж үзэх ч явдал бий. Гэвч өнөөг хүртэл иргэний эрх зүйн шинжлэх ухаанд иргэний эрх зүй хувиин эд хөрөнгийн биш харилцааг зохицуулах уу, эсвэл хамгаалах уу гэдэг талаар маргаан хэлэлцүүлэг явсаар ирсэн. Нэг хэсэг эрдэмтэд материаллаг бус үнэт зүйлсээс үүссэн хувиин эд хөрөнгийн биш харилцааг иргэний эрх зохицуулдаггүй, зөвхөн хамгаалдаг гэж үздэг. Нөгөө хэсэг нь хамгаалаад зогсохгүй зохицуулдаг хэмээн маргадаг. Оросын эрдэмтэн судлаач К.Б.Ярошенко

зохицуулалтыг “Гол төлөв эрхийн хамгаалалт нь үйлдлийг үйлдэхийг (үйлдлээс түдгэлзэх) албадах байдлаар илэрхийлэгддэг учраас хүний зан үйлд нөлөөлөх явдал, үүгээрээ тэр нь зохицуулалтын хувилбаруудын нэг мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй” гэж<sup>1</sup> “Гражданско-правовая защита чести и достоинства” номдоо бичсэн байна.

Судалгаанаас үзэхэд нэр төр, алдар хүнд нь зөрчигдөөгүй байдлаараа бол иргэний эрх зүйн нөлөөллийн объект болохгүй. Гэхдээ тэдгээрийг иргэний хууль тогтоомжоор хамгаалах харилцааг зохицуулахгүйгээр эдгээр материаллаг бус үнэт зүйлсийг хамгаалахад иргэний эрх зүйн арга хэрэгслийг хэрэглэх боломжгүй юм.

Түүний хамт ийм харилцааг хамгаалах нь зарим талаар уламжлалт бус шинжтэй байдаг. Нэр төр, алдар хүнд хөндөгдөх хүртэл иргэний эрх эдгээр материалаг бус үнэт зүйлсийг “тэдгээрийг зөрчихгүй байхыг бүх нийтийн үүрэг болгох замаар”<sup>2</sup> хамгаалдаг гэж “Честь, достоинство и деловая репутация Гражданско-правовая защита” бүтээлдээ судлаач эрдэмтэн А.Л.Анисимов бичсэн байна.

Ийнхүү эдгээр материалаг бус үнэт зүйлсэд халдсан тэр цагаас иргэний эрхийн хэм хэмжээнүүд тодорхой хэм хэмжээнүүдийг тогтоох замаар зохицуулалтыг хийдэг.

Материаллаг бус үнэт зүйлсийн хамгаалалтын ийм өвөрмөц шинж нь хувиин эд хөрөнгийн биш эрхүүдийг хэрэгжүүлэх онцлогтой холбоотой нь илэрхий байна. Энэ онцлог нь “хууль тогтоогч эрх мэдэлтэн материаллаг бус үнэт зүйлсийг хэрэгжүүлэх хэр хэмжээг тодорхойлдоггүйг, харин үүрэг хүлээсэн этгээд иргэний хувиин хэрэгт оролцох хил хязгаарыг тогтоодог...хэрэв хил хязгаар зөрчигдөөл иргэний эрхийн хариуцлага хүлээлгэхэд оршино” гэсэн дээрхи А.Л.Анисимовын саналтай нэг байна.

Мөн “Нэр төр, алдар хүнд мэтийн материаллаг бус үнэт зүйлсийн субъектив эрх гэж байхгүйг санах хэрэгтэй. Тэдгээрийг оршин байхад эрхийн хэм хэмжээ мөн үү, түүний ямар салбарт хамаарагдах вэ гэдэг нь нөлөөлөхгүй”<sup>3</sup> гэж судлаач эрдэмтэн В.А.Тархов “Ответственность по советскому гражданскому праву” бүтээлдээ тэмдэглэжээ.

Үүний хамт олон судлаач нэр төр, алдар хүндийн эрхийг субъектив эрхэд хамааруулж байна. Судлаач эрдэмтэн А.Б.Белявский, П.А.Привворов нар зарим үл зохицлыг илрүүлсэн ч “Хэдийгээр объектив талаас нь тодорхойлж болохгүй ч нэр төр, алдар хүндийн эрх нь субъектив эрхүүдийн нэг төрөл”<sup>4</sup> гэж “Охрана чести и достоинства личности в СССР” бүтээлдээ тэмдэглэсэн байна.

Нэр төр, алдар хүндийн субъектив эрхийг үгүйсгэх нь “нэр төр, алдар хүндийн ямар нэг гүгээмэл эрх” байдаггүй гэсэн үг биш. Энэ эрх нь бүх нийтийн эрх, бүр

<sup>1</sup> К.Б.Ярошенко “Гражданско-правовая защита чести и достоинства” М.1989, стр.73.

<sup>2</sup> А.Л.Анисимов: “Честь, достоинство и деловая репутация Гражданско-правовая защита” М., 1994 г. стр.34.

<sup>3</sup> В.А.Тархов: “Ответственность по советскому гражданскому праву. Саратов 1973 г. стр.382.

<sup>4</sup> А.Б.Белявский, П.А.Привворов: “Охрана чести и достоинства личности в СССР” М., 1971 г. стр.32.



тодруулбал, юуны өмнө хүний алдар хүндэд халдахгүй байх нь бүх нийтийн үүрэг. мөн хүний бодит үнэлгээ нэр төрийг хамгаалах үндэс нь болж байдаг нийгмийн ашиг сонирхлыг өргөн утгаар нь хэлж байна.

Г.В.Мальцев хүний нэр төр, алдар хүндийг иргэний эрх зүйгээр хамгаалах асуудалд дүн шинжилгээ хийгээд "тухайн үнэт зүйлсийг шүүхээр хамгаалах нь ямар нэг онцгой субектив эрхийг бус хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл болно. Нэр төр, алдар хүндийг хамгаалах субектив эрхийн онцлог зөвхөн ганц хувь хүний ашиг сонирхлыг илэрхийлж буй аливаа бусад субектив эрхээс ялгаатай нь түүнд хувь хүний амьдралын амин чухал ашиг сонирхлуудын нарийн нийлмэл систем тусгалаа олсон байдагт оршино"<sup>5</sup> хэмээн "Социальная справедливость и право" бүтээлдээ бичжээ.

Ийнхүү нэр төр, алдар хүндийг хамгаалах субектив эрхийн гол онцлог нь эрх зүйн хамгаалалтыг онцолсон байх бөгөөд түүнийг хэрэглэх бололцоо материаллаг бус үнэт зүйлсэд халдсан үеэс гарч ирдэг байна. Шууд халдаж хөндөх хүртэл төрөөс бие хүнийг бүх талаар хамгаалах элемент болсон дээр дурдсан ерөнхий эрхийн зарчим үйлчилнэ.

Иймээс иргэний эрх зүйн чиг үүрэг нь тухайн харилцааг зохицуулж, тодорхой объектыг хамгаалахаар хязгаарлалагдсан байдаг.

Эрх зүйн хамгаалалт гэдэгт эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан нийгмийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг болон эдгээр эрхийг зөрчих тохиолдолд хүлээх хариуцлагын санхүүг тогтоохыг ойлгоно. Эрх зүйн хамгаалалтын нэг онцлог нь зөрчигдсэн эрх зүйн харилцааг төрийн, зарим тохиолдолд нийтийн нөлөөллийн арга хэмжээгээр эрх зөрчигдөхийн өмнөх байдалд буцаан тогтоох зорилгоор шууд хэрэглэх явдал юм.

"Эрх зүйн хамгаалалт", "эрх зүйг хамгаалах" гэсэн ойлголтууд

харилцан холбоо бүхий боловч бие даасан, адил биш эрх зүйн шалгавар ба эрх зүйн зохицуулалтын ойлголтын нийлбэрт багтана.

Ямар ч мэдээлэл, хэрэв тэр нь тархмал бол нэр төр гутаасан, бодит байдалд нийцэхгүй мэдээлэл болдог. Субъектын ямар нэг тодорхой сөрөг тал юуу шинжийг заасан агуулгатай зөвхөн тийм тархсан мэдээнүүд нь сөрөг муу үр дүнд хүргэдэг.

Энэ бүх нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах иргэний эрх зүйн элементүүд нь Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийг хэрэглэх онол, практикийн нэн чухал ач холбогдолтой хамгаалалтын нөхцөлүүд гэж үзэж болох юм.

Манай Улсын иргэний хууль тогтоомжид энэ талын зохицуулалт хэрхэн туссаныг судалж үзвэл 1994 оны Иргэний хуульд "Иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг няцаахгай, ийнхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг, арилгуулахыг шаардах эрхтэй" гэж заажээ. Эл заалтын ач холбогдлыг Академич С.Нарангэрэл "Тус угсад анх удаа нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг мөнгөн хэлбэрээр арилгах болсон юм"<sup>6</sup> хэмээн Монголын төр, эрх зүй сэтгүүлд 1997 онд бичсэн өгүүлэлдээ онцлон тэмдэглэсэн байна.

"Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлож чадахгүй бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй"-г Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заажээ. Тиймээс юуны өмнө нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэдгийг нотлох шаардлагатай болсон байна.

"Мэдээ тараасан гэдэгт уг мэдээг хэвлэлд хэвлүүлэх, радио-телевизийн нэвтрүүлгээр дамжуулах, ажил хэргийн годорхойлолтод тусгах, олон нийтийн өмнө хандаж үг хэлэхдээ

мэдэгдэх, хуулийн этгээдэд хандаж гаргасан мэдэгдэлд тусгах, эсхүл ямар нэгэн өөр хэлбэр, түүнчлэн амаар нэг буюу хэд хэдэн этгээдэд мэдээлснийг ойлгохоор заажээ. Тодорхой этгээдэд холбогдолтой мэдээг уг этгээдэд буюу хүмүүсийн оролцоогүйгээр зөвхөн өөрт нь хэлж ярьсныг мэдээлэл тараасан гэсэн ойлголтод хамруулж үзэхгүй юм. Тараасан мэдээг нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг "гутааж" буй мэдээ гэж нотлон тодорхойлох нь зайлшгүй чухал, энэ зорилгоор объектив шалгуурыг удирдлага болгох нь зүйтэй байна.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэдэгт тухайн иргэнийг дагаж мөрдөж буй хууль тогтоомж буюу ёс суртахууны хэм хэмжээг зөрчсөн гэж баталсныг, бодит байдалд нийцээгүй мэдээ нь түүний нэр төр, алдар хүндийг унагасныг ойлгоно.

Нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад эдгэрийг гутаасан мэдээ нь бодит байдалд нийцээгүй байх гэсэн гэм бурууг тогтоох үндэслэлийг баримталдаг. Энэ нь уг мэдээг тараасан этгээд мэдээ нь үнэн зөв (бодит байдалд нийцж) гэдгийг нотлох ёстой гэсэн үг юм. Хэрэв энэ байдлыг нотолсон тохиолдолд шүүхэд хөрөнгийн бүс гэм хорыг арилгах эрх зүйн үндэслэлгүй болно.

Монгол Улсын 1994 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулгаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасныг няцаах болон албан ёсны баримт бичигт тусгагдсан мэдээг няцаахад баримтлах тусгай журмыг хуулиар тогтоогоогүй орхигдуулжээ. Энэ байдлыг 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Иргэний хуульд оруулсан нэмэлтээр засаж мөн зүйлийн гуравдугаар хэсэгт "Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу

<sup>5</sup> Г.В.Мальцев "Социальная справедливость и право" М., 1977 г. стр.167

<sup>6</sup> Академич С.Нарангэрэл "Монголын төр, эрх зүй сэтгүүл" УБ, 1997 он №4.1 дэх тал.

шүүх тодорхойлоно" хэмээн хуульчилсан байна.

Мөн 1994 оны Монгол Улсын Иргэний хуулийн 392 дугаар зүйлд "Эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах" арга замыг дараах байдлаар хуульчилжээ. "Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасны үл харгалзан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээлгэхээр заасан байна.

Иргэний нэр төр, алдар хүндийг гутаагаагүй боловч иргэний эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг тодорхой хэмжээгээр хөндсөн буюу ажил хэргийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлсэн мэдээ тараах тохиолдол амьдрал дээр цөөнгүй гарч байна. Энэ нь ихэвчлэн ажил хэргийн шүүмжлэлтэй холбогдсон байдаг. Ийм тохиолдолд уг иргэн хариу тайлбарыг мэдээг тараасан мэдээллийн арга хэрэгслээр гаргуулах эрх болно. Энд зарим санааг онцолж үзэх нь зүйтэй байна Тухайлбал:

1. Иргэний нэрийг хууль бусаар ашиглах нь тухайн иргэний өөрийн нэрээр олж авсан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд сөрөг үр дагаврыг бий болгодог төдийгүй тухайн иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж буй эрх зүйн эсрэг үйлдэл юм. Иргэний нэрийг хууль бусаар ашиглаж буй үйлдэл нь янз бүрийн хэлбэрээр илэрч болдог. Тухайлбал, бусдын нэрийг ашиглан иргэний эрх олж авах, бусдын нэрээр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл хийх, ингэснээрээ нэрийг ашигласан төдийгүй гуравдагч этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаах, бусдын нэрийг ашиглан ашиг хонжоо олох, олон нийтийг төөрөгдөлд оруулах гэх мэтийг ойлгоно.

Иймээс иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хуулиар хориглосон байна. Харин тухайн этгээдийн зөвшөөрлөөр буюу хуульд заасан үндэслэл журмын дагуу иргэний нэрийг ашиглаж болно.

2. Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан

гэдэгт бодит байдалд нийцэхгүй, өөр хэн нэгэн этгээдэд мэдээлсэн байхыг ойлгоно Харин тийм мэдээ, мэдээллийг иргэнд өөрт нь мэдээлснийг гутаасан мэдээ тараасан гэж үзэхгүй. Уг мэдээ, мэдээлэл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, электрон шуудангаар, хурал цуглаан дээр төдийгүй тухайн иргэний ажил байдлын тодорхойлолт, өргөдөл, албан тоотоор буюу амаар өөр этгээдэд хүргэгдсэн байхыг ойлгоно.

Өөр нэг л этгээдэд уг мэдээ мэдээлэл хүргэгдсэн байхад нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзэх үндэстэй. Жишээ: Иргэн Дорж Сүхбаатар дүүргийн нэгэн албан газарт ажилд орохоор болжээ. Гэтэл тухайн албан газрын дарга Доржийн өмнө ажиллаж байсан газраас түүний ажил байдлын тодорхойлолтыг ирүүлэхийг хүсчээ. Доржийн ажиллаж байсан газрын хүний нөөцийн менежер нь Цэцгээ Доржийг өөр газар ажиллах хүсэлт гаргасанд дургүйцэж түүний ажил байдлын тодорхойлолтод удаа дараа ажлаас хочордог, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэгийг гэхчилэн бичжээ. Үүнээс болоод Доржийг тухайн албан газар ажилд авахаас татгалзсан байна. Доржийн ажил байдлын тодорхойлолтод дурьдсан мэдээлэл нь бодит байдалд нийцээгүй худал мэдээлэл байсан байна. Энэ тохиолдолд Дорж өөрийн нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзэж шүүхэд хандах эрхтэй юм.

Дээрх жишээ нь Доржийн талаарх худал мэдээллийг зөвхөн нэг этгээдэд шууд хүргэх замаар гараагдсан гэж үзнэ. Харин ийм мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (радио, телевиз, тогтмол хэвлэл гэх мэт) гараасан байж болно. Ийм мэдээ мэдээллийг мөн нэг удаагийн мэдээллийн хэрэгслээр, эсхүл ам дамжин тараасан байж болно. Ийм тохиолдолд уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгслийг ашиглан няцаалт хийх боломжгүй юм.

Иймээс нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд нь гутаагдсан иргэний хүсэлтээр шүүх, мэдээ гарсан хүрээ, хэлбэр зэргийг

харгалзан үзэж өөр хэлбэр хэрэгслээр няцаалт хийх үүргийг эрх зөрчигчид хүлээлгэнэ.

3. Зарим мэдээ, мэдээлэл нь бодит байдалд нийцсэн, үнэн мэдээ байж болох боловч хувь хүний нууцад хамаарах мэдээ байж болно. Хувь хүний нууцыг хуулиар хамгаалдаг. Ийнхүү хуулиар хамгаалсан нууцад хамаарах мэдээг тухайн иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэд тараасан бол иргэн өөрт учирсан гэм хороо арилгуулахаар шаардах эрх эдэлнэ.

4. Иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ямарваа нэгэн хэлбэрээр дүрслэн түүнийгээ нийтэд тарааснаас тухайн иргэнд гэм хор учирч болно. Ийнхүү дүрслэхдээ дүрслэгч нь тухайн иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах зорилго агуулаагүй ч гэсэн уг хүний хувьд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаагдсан гэж үзэх үндэстэй.

5. Иргэний нэр төр, алдар хүнд нь тухайн хүнээс салшгүй амин хувийн эрх хэдий ч уг хүнийг насан эцэслэсний дараа ч нэр төр, алдар хүнд нь түүний төрөл төрсгдийн хувьд үнэт баялаг нь байдаг. Бас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тарааснаар өвлөгчид нь сэтгэл санааны дарамтад оруулах, оюун санааны гэм хор учирч болно. Хувь хүн өөрийнхөө нэр, нэр төр, алдар хүндийг хамгаалуулах эрхтэй төдийгүй нас барсны дараа түүний хууль ёсны өвлөгчид нь дээрх эрхийг хэрэгжүүлж болохоор Иргэний хуульд зохицуулсан нь шинэлэг заалт юм. Нас барагчийн нэр, нэр төр, алдар хүндийг гутааснаас эдийн бус гэм хор учирсан хэмээн дурын субьект шүүхэд хандах бус хууль ёсны өвлөгчид нь энэ эрхийг хэрэгжүүлэхээр хязгаарлалт тогтоосон байна.

Түүнчлэн иргэний шинэ хуульд эдийн бус гэм хор учирсан гэж үзвэл өвлөгчид уг гэм хорыг гагцхүү эдийн бус хэлбэрээр буюу уг мэдээг няцаалгах эрхийг л хуульчилж өгчээ.



## Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир

Өгүүллэйн хүрээнд эдийн бус хохирлыг манай улсын хэмжээнд хэрхэн зохицуулсан болоод шийдвэрлэж байгаа талаар, ОХУ-ын зарим зохицуулалттай харьцуулсан байдлаар авч үзэхийг зорилго.

Эрх зүйт төрийн зорилтын нэг нь иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээх, нөхөн төлөх эрх зүйн орчин, тогтолцоо, механизмыг бүрдүүлэх явдал билээ. Монгол Улсын хувьд ардчилсан тогтоононд шилжээд 20 жил болж байгаа ба энэ хугацаанд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд иргэний болон эрүүгийн эрх зүйн суурь эх сурвалжуудыг 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн батлан дагаж мөрдөж байна.

Юуны өмнө эдийн бус хохирол гэж юуг ойлгож байгаа талаар цухас авч үзье. Иргэний эрх зүйн ном зохиолд хохирол, гэм хор гэсэн нэр томъёонууд өргөнөөр хэрэглэгддэг. Эдгээр нэр томъёог эдийн болон эдийн бус гэм хор (эд хөрөнгийн

болон эд хөрөнгийн бус ч гэж томъёолдог), материаллаг болон материаллаг бус хохирол гэж ангилан хэрэглэсэн байдаг. Эдийн бус гэм хор, эдийн бус хохирол нь агуулгын хувьд адил мэт боловч зарим талаар ялгаатай байж болно. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуульд гэм хор, хохирол гэсэн ойлголтуудыг нэр томъёоны хувьд тайлбарлаагүй боловч иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эдийн болон эд хөрөнгийн бус амины эрхийг зөрсөнөөс үүсч буй сөрөг үр дагавар гэсэн ерөнхий хүрээнд ойлгож хэрэглэсээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байхаар хуульчилж өгсөн байна. Гэвч эрх зүйн онол ёсоор Үндсэн хуулийг хувийн эрх зүйн хэрэг маргааныг шийдвэрлэхэд бус бусад салбар хуулийг батлахдаа үндсэн зарчим болгож хэрэглэдэг. Тийм ч учраас Монгол Улсын Иргэний хуульд (2002 он) Үндсэн хуулийн дээрх суурь зохицуулалт нь 8,9 дүгээр зүйл, 18, 52 дугаар бүлэгт тусгалаа олон хуульчлагдажээ. Гэвч нэр томъёоны хувьд зарим зөрүүтэй томъёолол байсаар байна. Үндсэн хуульд хэдийгээр хохирол гэж тодорхойлсон боловч иргэний хуульд гэм хор гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Эдгээр нэр томъёоны аль нь өргөн хүрээтэй ойлголт вэ?, Ялгамжтай байдлаар авч үзэх нь ямар ач холбогдол, үр дагавартай вэ? гэсэн асуудлууд гарч ирэх нь ойлгомжтой юм. Зарим судлаач гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй

ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ<sup>1</sup> гэж үздэг. Хүмүүнлэгийн эрх зүйн үүднээс авч үзвэл хохирол гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт гэж үзэж болох талтай. Өөрөөр хэлбэл, гэм хор учрахгүйгээр хохирол учирч болно. Жишээ нь, байгалийн давагдашгүй хүчин зүйл болох ган, зуд, үер усны аюулаас болж хохирол хүлээх зэргийг дурдаж болно.

Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас харахад хохирол бол гэрээний үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан материаллаг зардал, олох байсан орлого<sup>2</sup> гэж тодорхойлсныг шууд хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Учир нь уг хуулийн 510 дугаар зүйлийг авч үзвэл гэрээний бус үүрэгтэй холбоотой эд хөрөнгөд учруулсан гэм хорыг мөнгөөр нөхөн төлж байгааг хохирол гэж тодорхойлж болно гэсэн гаргалгааг хийж болно. Гэвч ингэж тодорхойлох нь хэт явцуу бөгөөд зарим талаар учир дутагдалтай юм.

Монгол Улсын Дээд Шүүхийн 1997 оны "Гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаарх Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 473 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт гэм хорыг хохирол гэж авч үзсэн байдаг. Түүнчлэн "...эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол" гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхгүйгээр учруулсан гэм хорыг ойлгоно"<sup>3</sup> хэмээн тайлбарласнаас үзвэл гэм хор, хохирлыг ойлголтын

<sup>1</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 2007 он. УБ хот, 138 дахь тал.

<sup>2</sup> Ш.Уянзартөгс. Сэтгэгдэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт "Хууль д... х эс" сэтгүүл УБ, 2007 он, 47 дахь тал.

<sup>3</sup> Гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим

хувьд ижил хэмжээнд авч үзжээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд “Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” гэж зааснаас үзвэл хохирол нь өргөн хүрээтэй гэж ойлгож болохоор байна.

Тэгвэл энэ талаар манай хойд хөрш ОХУ хэрхэн тодорхойлсон байдаг талаар авч үзье. Учир нь эрх зүйн тогтолцооны хувьд ижил тул харьцуулахад хялбар байх болно. Сэтгэл санааны хохирлыг “Иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө (эдийн хохирол), иргэний жам ёсны болон хуулиар олгогдсон материаллаг бус баялагт (амьдрал, эрүүл мэнд, хувийн үнэлэмж, ажил хэргийн нэр хүнд, хувийн халдашгүй байдал, хувийн болон эмчилгээний нууц) гэм хор учруулсны үр дагавар эсвэл, тэдгээрийн хувийн эдийн бус эрхийг (нэр төрөө ашиглах эрх, зохиогчийн эрх болон оюуны өмчийн үйл ажиллагааны үр дүнг хамгаалах), хуульд заасан бусад эдийн бус эрхийг зөрчсөн гэм хор (сэтгэл санааны хохирол)”<sup>4</sup> гэж тайлбарласан байна. Хохирол (ущерб) нь гэм хортой адил утгатай, хохирлын мөнгөн илэрхийллийг гарз, алдагдал (убыток) гэдэг.<sup>5</sup> Өөрөөр хэлбэл, гэм хор учруулсны улмаас үүссэн хохирлын мөнгөн илэрхийлэл юм. (Судлаац)

Дээрх тодорхойлолтуудаас харахад иргэний эрх зүйд гэм хор гэх ойлголт нь хохирол гэсэн ойлголтоос агуулгын хувьд ялгаатай. Гэм хор гэдэг нь бусдын эрхийг зөрчсөн үйлдлийг хэлж байгаа ойлголт бөгөөд тухайн үйлдлийн улмаас зөрчигдсөн эдийн болон эдийн бус

эрхэд учирсан сөрөг үр дагавар нь хохирол гэсэн ойлголтод хамаарна. Өөрөөр хэлбэл, гэм хор нь эрх зүйг зөрчсөн үйлдэл бөгөөд хохирол учрах урьдач нөхцөл юм. Харин эдийн бус хохирол гэдгийг нийгмийн харилцааг ангилж байгаа талаас нь тайлбарлаж болно. Эрх зүйн харилцааг зохицуулж буй хүрээгээр нь улс төрийн, эдийн засгийн, нийгэм соёлын, оюун санааны гэж ангилдаг. Тэгвэл эдийн бус хохирол нь оюун санааны харилцаанд үүсч байдаг ба нүдэнд үл үзэгдэж, гарт эс баригдах хийсвэр харилцаанд үүсэж буй сөрөг үр дагавар юм. Энэ нь дараах байдлаар илэрдэг. Төрөл саднаа алдах, нийгмийн идэвхтэй амьдралаа үргэлжлүүлэх боломжгүй болох, ажлаа алдах, гэр бүлийн болон эмчилгээний нууц задрах, нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тараасан, тодорхой хугацаагаар ямар нэг эрхийг хассан, хязгаарласантай холбоотой сэтгэл санааны хямрал, сэтгэл санааны зовлон шаналлын үр дүнд бий болсон эрүүл мэндийн сарнил, бэртэл гэмтэл байж болно.<sup>6</sup>

Монгол Улсын хувьд Эрүүгийн, Иргэний хуульд эдийн бус хохирлын төрлүүдийг бүрэн бус ч тодорхой хэмжээгээр тусгасан байдаг ба үүнийг дараах байдлаар авч үзэж болно.

- Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан сэтгэл санааны хохирол;

- Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол;

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын хууль бус үйлдлийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол (эрүүдэн шүүгдсэн,

хилсээр ял эдэлсэн, үндэслэлгүйгээр хоригдсон);

Бие махбодийн болон эдийн хөрөнгийн хохирлыг Иргэний болон Эрүүгийн хуулийн хүрээнд хангалттай зохицуулж байна. Харин орчин үеийн оросын хууль тогтоомжид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх нь шинэ бөгөөд судлагдаагүй төвөгтэй асуудал байгаа юм” гэж оросын эрдэмтэн үзэж байгаатай Монгол Улсын нөхцөл байдлыг харьцуулбал санал нийлж байна. Өнөөгийн байдлаар эдийн бус хохирлыг нөхөн төлж байгаа дэлхийн ерөнхий чиг хандлага мөнгөн хэлбэртэй байна. Гэхдээ үүнийг зөвхөн мөнгөн хэлбэртэй гэж шууд ойлговол өрөөсгөл болно. Үүний зэрэгцээ эдийн бус гэм хор учруулсан үйлдлийн шинжээс хамаарч түүнийг нөхөн төлөх бусад арга байгааг ч үгүйсгэх аргагүй юм. Жишээлбэл, Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан хүлцэл өгчих, залруулга хийх, үнэнд нийцэхгүй мэдээлэл тараасныхаа төлөө олон нийтийн өмнө няцаалт хийхийг гэм буруутай этгээдэд даалгах<sup>7</sup> зэрэг арга байж болдог. Үүнийг ч манай улсад зарим тохиолдолд хэрэглэдэг. Гэвч үүнийг хэрэглэх боломжгүй тохиолдолд мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхөөс өөр оновчтой хэлбэр одоогоор байхгүй. Нөгөө талаас аливаа зүйлийг үнэлэхгүйгээр түүнийг хамгаалах, нөхөн сэргээх боломжгүй юм. Тийм ч учраас эдийн бус хохирлыг үнэлэх, түүний эдийн засгийн утгыг иргэний эрх зүйн хүрээнд тодорхойлох нь өнөөгийн түвшинд тулгамдсан асуудал болж байна.

Энэ талаар судалгаа хийдэг Оросын эрдэмтэн А.М.Эрделевский

<sup>4</sup> зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай. Монгол Улсын дээд шүүхийн тогтоол 2009.5.22. №15.

<sup>5</sup> Э/С.М. Синеельников и др. -СПб., 1994г.

<sup>6</sup> Б / Под ред. А.Я. Сухарева, В.Е. Крутских -М., 2002г.

<sup>7</sup> “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай хууль тогтоомжийн хэрэглээний зарим асуудал”, ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоол 1994.12.20, №10.

<sup>8</sup> ОХУ-ын хувьд хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас эдийн бус хохирол (моральный вред) учирч болно гэж үздэг. Жишээ нь Ажлаас үндэслэлгүй халагдах, ажилд авахаас үндэслэлгүйгээр татгалзах гэх мэт Үүнийг “Хөдөлмөрийн тухай” хуульдаа тусгасан байдаг.

<sup>9</sup> Завидов Б.Д. Моральный вред. Из-во Экзамен.2001., стр 3.

<sup>10</sup> www.yurpractika.ru

гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох талаар хүснэгт, томъёо<sup>9</sup> зохиосон байдаг ба үүнийг мөн л хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээтэй уялдуулан мөнгөн хэлбэрээр илэрхийлсэн байдаг.

Манай орны хувьд эдийн бус хохирлын төрлүүдээс эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэлийн эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагыг шийдвэрлэх нь аль ч талаасаа үнэхээр хангалтгүй байгаа билээ. Эдийн бус хохирлыг нөхөн төлөх асуудлыг эрх зүйн зөрчлийн шинжээс үл хамааран үндсэндээ Иргэний хуулиар<sup>10</sup> зохицуулж байна. Түүхэн талаас нь цухас авч үзвэл 1992 оноос өмнөх Иргэний хуулиудад энэ талаарх зохицуулалт үндсэндээ байхгүй байсан гэж болно. Хэдийгээр эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцааг (хуульд заасан бол эд хөрөнгийн бус амины бусад харилцааг) зохицуулахаар тусгасан хэдий ч энэ нь социалист системийн аж ахуй, социалист өмчийг бэхжүүлэн хөгжүүлэх, социализм байгуулж цаашид коммунизмын байгуулалтад шилжих зорилгод тулгуулаж байсантай холбоотой юм. Өнөөгийн байдлаар эдийн бус хохиролтой холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулж байна.

Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой эдийн бус хохирлыг Иргэний хуулийн 21, 230, 510 дугаар зүйлээр тус тус зохицуулж өгсөн байдаг. Ийнхүү зохицуулахдаа эдийн бус хохирол нь Иргэний эрх зүйн хамгаалалт болох, өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болохоос эхлэн, түүнийг мөнгөн хэлбэрээр болон бусад аргаар хэрхэн арилгах талаар тусгаж өгсөн.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын хууль бус

үйлдлийн улмаас учирсан эдийн бус хохирлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388, 389, 391 дүгээр зүйл, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасны дагуу тус тус зохицуулж байна. Гэвч эдгээр хуулийн заалт нь тухайн харилцаанд хийдлийг гаргаж байдаг. Жишээ нь: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.2-т "Эд хөрөнгийн бус хохирлыг хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно" гэж заасан боловч дараах сөрөг үр дагавар үүснэ.

- Иргэний хуульд эдийн бус хохирлыг арилгах арга замыг зааж өгснөөс бус хохирлын хэмжээг тодорхойлох талаар нарийвчлан тусгаагүй;

- Ингэж заахдаа эдийн бус хохирлыг явцуу хүрээнд буюу зөвхөн Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд хохирол учирсан тохиолдолд мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхөөр хязгаарлаж (императив байдлаар) заасан.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах замаар шийдвэрлэдэг. Мэдээж иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл гэм хорын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулна. Дээр дурдсанчилан эдийн бус хохирлыг зөвхөн хуульд заасан тохиолдолд л мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхөөр заасан нь гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх хууль зүйн боломжгүй байгаа юм. Учир нь эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх харилцааг зөвхөн Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарласан байдаг. Нөгөө талаас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд "хохирогч гэж гэмт хэргийн

улмаас ... санаа сэтгэл, ... эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ", "иргэний нэхэмжлэгч гэж гэмт хэргийн улмаас учирсан... эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ"<sup>11</sup>. Мөн уг хуулийн 120 дугаар зүйлд хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэл, нөхцөлийг тогтоосон журмыг хэрэглэхдээ Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хуулиар тодорхойлохоор алгасуулан заасан боловч эдгээр хуульд нарийвчлан зохицуулан журам байхгүй байгаа юм.

Шүүхийн практикаас харахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль бус үйлдлийн улмаас учирсан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нь бусад эрх зүйн зөрчлийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээс хууль зүйн болон шийдвэрлэж байгаа байдлын хувьд "арай илүү" байна. Гэвч практикт энэ төрлийн тохиолдол тийм ч элбэг биш байдаг бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хийсэн судалгаагаар<sup>12</sup> 2006-2009 оны хооронд энэ төрлийн хэрэг маргаан зургааг шийдвэрлэжээ. Харин гэмт хэрэг нь бусад тохиолдлуудтай харьцуулбал гаралтын тоо өндөр байдаг. Гэмт хэрэг дотроо хүчирхийллийн (хувь хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг) гэмт хэргийн улмаас тэр бүр эдийн хохирол учраад байдаггүй (эмчилгээний зардал, олох ёстой байсан орлогыг эс тооцвол). Хохирогчид учирч буй үндсэн хохирол нь сэтгэл санааны сөрөг үр дагавар (эрх нь зөрчигдсөний улмаас учирч буй сэтгэлийн зовлон шаналал) буюу эдийн бус хохирол байдаг.

ОХУ-д гэмт хэрэг болон бусад эрх зүйн зөрчлийн улмаас учрах эдийн бус хохирлыг тодорхойлох, нөхөн төлөх талаар холбогдох хууль болон

<sup>9</sup> А.М. Эрделевский. Компенсация морального вреда. Москва. Из-во. 2000.-256с.

<sup>10</sup> Төрийн мэдээлэл, 2002, №7.

<sup>11</sup> Төрийн мэдээлэл, 2002 он, №5, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 43 дугаар зүйл, 43.1.

<sup>12</sup> "Хуулийн харьцангуй үндэслэлгүй татагдсан, цагаан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн

хохирлыг нөхөн төлөх зөвлөлийн хэмжээг тогтоомж", Судалгааны тайлан, ХЗҮХ, 2010 он.

эрх зүйн бусад актад тодорхой хэмжээгээр тусгасан байдаг. Уг харилцааг зохицуулдаг гол эх сурвалж нь:

- Иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан хохирол;

- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол;

- Хуульд заасан бусад тохиолдол.

ОХУ-ын Иргэний хуулийн 1101 дүгээр зүйл.

1. Сэтгэл санааны гэм хорыг нь мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.

2. Сэтгэл санааны гэм хорыг хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар, хэрэв гэм буруу нь гэм хорыг нөхөн төлөх үндэслэл болж байгаа тохиолдолд гэм буруутай этгээдийн гэм буруугийн зэргийг үл харгалзан шүүх тогтооно. Гэм хорын хэмжээг тодорхойлохдоо ухаалаг байдал ба шударга ёсны шаардлагыг тооцон үзэх ёстой.

Биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар нь сэтгэл санааны гэм хор учруулсан тухайн нөхцөл байдлын үйл баримт, хохирогчийн хувийн онцлогийг харгалзан шүүх үнэлнэ.

Үүнээс гадна ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлаар 1994 оны 12 дугаар сарын 20-ны өдөр 10 тоот “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай хууль тогтоомжийн хэрэглэний зарим асуудал” нэртэй тогтоол гаргасан бөгөөд шүүх сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх хэмжээг хэрхэн тогтооно талаар гаргасан зөвлөмж юм. Гэхдээ ОХУ-ын хууль тогтоомжид биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын зэрэглэл, шинж чанарын тухай ойлголтыг тодорхой заагаагүй байдаг.<sup>13</sup>

**Дүгнэлт**

Эдийн бус хохирлыг нөхөн төлөх, тэр дундаа мөнгөн хэлбэрээр барагдуулахад Иргэний эрх зүй чухал байр суурийг эзлэх нь ойлгомжтой юм. Өөрөөр хэлбэл, Иргэний эрх зүйн хөгжлөөс шууд хамрааралтай гэсэн үг. Нөгөө талаас дэлхий нийтийн чиг хандлага гэмт хэргийг зөвхөн шүүгдэгчид зохих хариуцлагыг оногдуулах бус хохирогчийн зөрчигдсөн эрхийг бүрэн дүүрэн сэргээж цогц байдлаар нь шийдвэрлэхийг зорих болжээ. Энэ нь бусад эрх зүйн хүрээнд ч иргэний эрх зүйн эзлэх байр суурь өргөжиж байгааг харуулж байгаа юм.

Манай орны хувьд эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх тогтолцоо, эрх зүйн орчин тийм ч хангалттай биш гэж судлаачийн хувьд үзэж байна. Хэдийгээр практикт энэ харилцааг зохицуулж байгаа боловч түүнийг шийдвэрлэж байгаа байдал нь өөр өөр байгаа юм. Түүнчлэн эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх харилцааны объект туйлын хязгаарлагдмал байна. Шүүх практикт энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 497, 510 дугаар зүйлийг баримталж байгаа нь тийм ч бүрэн дүүрэн зохицуулалт биш юм. Учир нь уг харилцаа нь нотлоход хэцүү материаллаг нотлох баримтгүй учир шүүх зарим талаар үнэлэх боломжгүй байдаг. Үүнд дараах шалтгаан нөлөөлж байж болох юм.

- Иргэний хууль болон бусад хуульд сэтгэл санааны хохирлыг тодорхойлсон тодорхойлолт байдаггүй. Энэ нь хуульчдын дунд нэгдсэн ойлголтгүй байх шалтгаан болдог;

- Тухайн харилцааг зохицуулах хэм хэмжээний хийдэл (хуулиудын хоорондын уялдаа болмогүй байдлаас болж зохицуулалтгүй орхисон);

- Эдийн бус хохирлын мөнгөн хэлбэрээр барагдуулах хүрээг (объект) хязгаарласан;

- Энэ талаар хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил ховор.

Уг асуудлын талаарх өөрийн орны эрх зүйн зохицуулалтыг ОХУ-ын эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдлаас харахад эдийн бус хохирлыг нөхөн төлөхийн тулд дараах зүйлсийг зайлшгүй хийх хэрэгтэй байна.

- Эдийн бус хохирлийн тухай Иргэний хуульд тодорхой болгох;

- Түүнийг нөхөн төлөх боломжийг нээлттэй болгох;

- Эдийн бус хохирлыг нөхөн төлөх талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох. Энэ нь дараах үндсэн хоёр асуудалд хуваагдана.

- Нөхөн төлөх хэлбэр;

- Нөхөн төлөх хэмжээ;

- Эдийн бус хохирлын хэмжээ болон мөнгөн үнэлэмжийг тодорхойлоход зайлшгүй харгалзах шалгуурууд (гэм буруугийн хэлбэр, хохирол учруулах үеийн нөхцөл байдал, хохирогийн өвчин шаналлын зэрэг, гэм буруутай этгээдийн эд хөрөнгийн байдал г.м).

Энд нэг зүйлийг дурдах нь зүйтэй болов уу. Эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх нь түүний нотлогдож байгаа байдлаас ихээхэн хамаардаг. Үүнийг тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хоёр талаас нь авч үзэх боломжтой юм.

1. Нэхэмжлэгч эдийн бус хохирлоо мөнгөн хэлбэрээр илэрхийлэхдээ түүнийг нотлох ёстой;

2. Эдийн бус хохиролд нэхэмжилж байгаа мөнгөн дүн нь бодит байдалд нийцэхгүй гэдгийг гэм буруутай этгээд нотлох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, хохирогчид нэхэмжилж буй хэмжээний хохирол учраагүй гэдгийг нотлох ёстой.



<sup>13</sup> Варпаховская Е. М. Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве. Иркутск-2004, стр. 143.

## Орчин тойрондоо аюултай зүйлс, аюултай үйл ажиллагаанаас учруулсан гэм хорыг арилгах, түүний эрх зүйн зохицуулалтын асуудал



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Наранцацрал

Арванесдүгээр дүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заасан нь иргэн өөрт учирсан гэм хорыг арилгуулах Үндсэн хуулийн баталгаа билээ.

Дэлхий нийтийн хэмжээнд үйлдвэржилтийн эрчимтэй хөгжил, техник технологийн дэвшил нь шинэ төрлийн энерги, хими, биологийн хорт бодис, элементүүд, олон төрлийн өөрөө явагч машин механизм, техник хэрэгслийн ашиглалтын явцад орчин тойронд аюул бүхий урд өмнө нь байгаагүй шинэ зүйлсийг үүсгэж улмаар бусдад

тохиолдолд хохирогчийн эрхийг хууль зүйн үүднээс хэрхэн хамгаалах, зөрчигдсөн эрхийг ямар аргаар сэргээн тогтоох зэрэг асуудлаар төрөөс эрх зүйн зохицуулалтыг хийдэг ч тэрхүү зохицуулалт нь гэм хорыг арилгах ерөнхий зохицуулалтаар зохицуулагддаг байна. Энэхүү асуудлыг судлахын тулд эн тэргүүнд "гэм хор, хохирол" гэсэн ойлголтуудыг авч үзэх нь зүйтэй юм.

Өнөөдөр манай улсын практик учруулсан хохирол ийм зүйл, гэм хорд ийм зүйл орно гэсэн тайлбар хараахан гараагүй байна. Иймд дээрх ойлголтыг үг зүйн болон эрх зүйн үүднээс тайлбарлан ялгаатай ойлголт уу, нэг ойлголт уу гэдгийг нэг мөр ойлгон хэрэглэх шаардлагатай байна. (Хүснэгт-1)

Хүснэгт-1

№	Монгол хэлэнд	Орос хэлэнд	Англи хэлэнд
1.	Гэм Ёс зүйгээс ангид хийсэн үйл явдал, түүний үр нөлөө	Вред хор, хөнөөл, хохирол;	Delict эрх зүйн зөрчил, зөрчил, гэм буруу
2.	Хор гэм, хөнөөл, аюул, зовлон	Ущерб хохирол, гэрз	Tort иргэний эрх зүйн зөрчил, гэм буруу
3.	Хохирол алдагд, алдагдал, хөнөөл, сүйтгэл <sup>1</sup>	Убытки эдийн буюу мөнгөн үнэслээг нэрлэнэ <sup>2</sup>	Damage гэм хор, гэмтэл, гэрз, хохирол, алданги, алдагдал, алдагдлын нөхөн олговор <sup>3</sup>

гэм хор учруулах эрсдэл нэмэгдэх хандлагатай байгаа юм.

Орчин тойрондоо аюултай зүйлээс гэм хор учруулсан

Монгол хэлэнд гэм хор, хохирол гэсэн нэр томъёог ихэнх хууль болон ном зохиол, шүүхийн практикт хамтад нь хэрэглэдэг. Tort гэдэг нь

<sup>1</sup> Шинжлэх Ухааны Академ. Хэл зохиолын хүрээлэн. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. УБ. 2008 он. 580 дахь тал

<sup>2</sup> А.Л.Сухарева. В.Е.Сухомин. Большой Юридический словарь. 2002г., под ред.

<sup>3</sup> S. Narangerel. English-Mongolian Jurisprudence dictionary. 2005-он

Англи гаралтай үг бөгөөд практикт дийлэнхдээ deficit гэж ярьдаг. Энэ нь бусдын амь нас, бие махбодид, эд хөрөнгөд гэм хор учруулахад хариуцлага хүлээлгэх зарчмыг хэрэгжүүлэхэд түгээмэл хэрэглэгддэг байна.

Оросын Холбооны Улсын хувьд хууль зүйн үг хэллэг болон шүүх, арбитрын практикт вред, ущерб, убытки гэсэн ойлголтууд зэрэг хэрэглэгдэж байна. Вред, ущерб гэсэн үгнүүдийг ижил утгаар авч үзэж болно. Харин вред, убытки гэсэн үгнүүд ижил бус утгатай байдаг.<sup>4</sup>

Вред-илүү өргөн утгаар хэрэглэгддэг бөгөөд эдийн (эдийн засгийн) шинжтэй яригддаг.

Гэм хорыг хууль, албан ёсны баримт бичгүүд, ном зохиолуудад янз бүрээр тодорхойлсон байдаг. Тухайлбал:

1. Доктор С.Нарангэрэл “Гэм хор” гэж иргэний эрх зүйд субъектив эрх буюу баялгийг багасгах, устгахыг хэлнэ. Хууль зүйн ном зохиол шүүхийн практикт хохирол гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Гэм хор буюу хохирол гэсэн 2 үг нь хоорондоо яг нийцдэггүй. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хор гэдэгт үнэлгээний хэлбэр бүхий эрх зүйн зөрчлийн материаллаг (эдийн засгийн) үр дагаврыг ойлгоно. Эд хөрөнгийн гэм хорын материаллаг үнэлгээг хохирол гэж нэрлэнэ. Эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны гэм хор гэж бусад этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан зан суртахууны ба бие махбодийн зүдгүүр шаналал<sup>5</sup> гэж тодорхойлсон байдаг;

2. Эд хөрөнгө, устгасан, гэмтээсэн, иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан цалин дутуу авсан,

нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал зэргийг гэм хор<sup>6</sup> гэнэ гэж тодорхойлсон.

3. Гэм хорыг материаллаг болон материаллаг бус гэж ангилан авч үздэг бөгөөд материаллаг гэдэгт алдагдал, олох ёстой байсан орлого, зардлыг харин материаллаг бус гэдэгт амь нас, эрүүл мэндийг хохироосон, нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг үнэ өртгөөр илэрхийлэгддэггүй, хохирогчийг санаа сэтгэлийн дарамтанд оруулсан үр дагаврыг ойлгоно. Энэ хохирогчийн амин хувийн болон эд хөрөнгийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчсөн явдлаар илэрдэг<sup>7</sup> гэж авч үзжээ.

Үүнээс үзвэл гэм хор нь агуулгын хувьд илүү өргөн утга, агуулгатай байна. Өөрөөр хэлбэл, гэм хор нь иргэний эрх зүйн чадамжтай холбоотой ойлголт бөгөөд харин “хохирол” гэдэг нь иргэний хуулиар олгосон эрхийг хязгаарласныг ойлгоно. “Аж үйлдвэрийн хөгжилт нь шинэ төрлийн энерги ашиглах (электрон, атомын г.м), аж үйлдвэрийн “хортой” салбаруудын (химийн, металлургийн г.м) эрчимтэй өсөлт, бүх төрлийн тээврийн хэрэгслийн (ялангуяа автомашин болон агаарын хөлөг) хөгжил, өргөн хүрээний механикжуулалт зэрэг урд өмнө байгаагүй хор уршиг бүхий хүчин зүйлсийг үүсгэж, дэлгэрүүлсний улмаас орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон аюултай зүйлсээс гэм хор учруулах явдал элбэг болсон. Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа, аюултай зүйл гэдэг нь хоёр өөр харилцааг илэрхийлж байгаа бөгөөд харин дээрхээс үүдэлтэй гэм хорын хариуцлагын асуудал нь ижил юм.

Орчин тойрондоо аюултай зүйл гэдэг нь: төрөл бүрийн авто механикжсан тээврийн хэрэгсэл, шатахуун түгээх газар, өндөр хүчдэлийн цахилгаан шугам, тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх болон түргэн шатамхай, идэмхий буюу хорт бодис, орсон буур, зуудаг нохой зэрэг орчин тойрондоо аюул учруулж болох бөгөөд хүний бүрэн хяналтанд байх боломжгүй объект, амьтныг ойлгоно гэж Улсын Дээд шүүхийн 1997 оны 473 дугаар тогтоолд тайлбарлажээ. Энэхүү тогтоол нь өнөөдрийн байдлаар нэлээд хоцрогдсон бөгөөд орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон аюултай зүйлийг нэг бүрчлэн тоочих бус ерөнхийд тайлбарлалав зохилтой байна.

ОХУ-ын эрдэмтэн О.А.Красавчик орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа, аюултай зүйлийг өргөн хүрээнд нэгдмэл шалгуураар ангилал хийж нийтэд ил тод тавьсан байна.<sup>8</sup> Үүнд :

1. Физикийн–бүх төрлийн механикжсан тээврийн хэрэгсэл, цахилгаан, дулааны станц, шатахуун түгээх газар, өндөр хүчдэлийн цахилгаан шугам;

2. Химийн-хүчтэй үйлчлэх түргэн шатамхай идэмхий буюу хорт бодис;

3. Фикс химийн–төрөл бүрийн цацраг идэвхит бодис;

4. Биологийн–бүх төрлийн амьтан, микробиологийн эд, эс.

Зарим эрдэмтэн орчин тойрондоо аюултай зүйлд орчин тойрондоо аюултай үйл ажиллагааг оруулах нь зүйтэй гэж үздэг байна.

Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай зүйлээс учруулсан гэм хорын хариуцлагын талаар иргэний болон эрүүгийн эрх зүйн харилцааны хүрээнд дэх харьцуулалт (Хүснэгт-2)

Иргэний эрх зүй бол зөвхөн хохирсон эрхийг сэргээх, учирсан

<sup>4</sup> А. Л. Сухарева, В.Е. Критских Большой Юридический словарь. 2002г., под ред 771

<sup>5</sup> С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007 он. 138 дах тал

<sup>6</sup> Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй /тусгай англи/. УБ хот., 1997 он. 48 дахь тал.

<sup>7</sup> Д.Наранчимэг. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. УБ., 1999 он. 89 дэх тал.

<sup>8</sup> А.П.Сергеева, Ю.К.Толстого. “Гражданское право”. Том 3., 2004. Под ред 40



## Хүснэгт-2

д/д	Иргэний хуулийн заалт	Эрүүгийн хуулийн заалт
1.	<p>499 дүгээр зүйл. "Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах"</p> <p>499.1.Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй.</p> <p>499.2.Агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс гэм хор учирсан бол энэ хуулийн 499.1-д заасан үүрэг үүсэхгүй.</p> <p>499.3.Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.</p> <p>499.4.Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.</p>	<p>215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих</p> <p>215.1.Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын бие махбодид хүндэтвэр гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасгах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>215.2.Энэ хэргийг согтуугаар үйлдсэн, бусдын бие махбодид хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>215.3.Энэ хэргийн улмаас бусдын амь нас хохирсон, эсхүл онц их хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг дөрвөн жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>215.4 Энэ хэргийн улмаас хоёр ба түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

	<p>Дээрхи зохицуулалтаас харахад аль аль нь тээврийн хэрэгсэл ашиглалтын явцад бусдад учирсан гэм хорыг арилгах талаар ерөнхий зохицуулалт бөгөөд оногдуулах хариуцлага буюу санцаараа ялгаатай. Иргэний эрх зүйд гэм хорын хариуцлага нь материаллаг бүрэлдэхүүнтэй, хувь хүний хариуцлагатай холбоотой үүсдэг бол эрүүгийн эрх зүйд тогтоосон актыг зөрсөний улмаас үүссэн гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй үйлдэгддэг байна. Харин гэм буруутай этгээд болон тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигч буюу өмчлөгч нь аль ч тохиолдолд заавал хариуцлага хүлээнэ.</p>
<p>2. 500 дугаар зүйл. Барилга байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хорыг хариуцах</p> <p>500.1.Зохих ёсоор арчилж хамгаалаагүй, гэмтэл согогтой байснаас бусад тохиолдолд байшин барилга бүтэн буюу хэсэгчлэн нурсны улмаас учирсан гэм хорыг тухайн барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна</p> <p>500.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөлцөл байдлын улмаас, эсхүл хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас байшингаас ямар нэг зүйл унасан, хаягдсан буюу асгарсны улмаас гэм хор учирсан бол тухайн байшин барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцлага хүлээгүй.</p>	<p>183 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааны журам зөрчих</p> <p>183.1.Уул, уурхай, барилга, түүнчлэн тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй үйлдвэр бусад аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны журам зөрсөний улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол төдөрхөн албан тушаал эрлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
	<p>Иргэний хуульд барилга байгууламж барих, ашиглах явцад үүссэн гэм хорыг арилгах талаар заасан бол Эрүүгийн хуульд түүнийг уул уурхай, барилга, тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй үйлдвэр бусад аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй ажиллагааны журам зөрсөнөөс бусдад гэм хор учруулсан бол хохирлыг арилгах талаар заасан байна.</p>
<p>3. 502 дугаар зүйл. Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хорыг хариуцах</p> <p>502.1.Барилга байгууламжийн хийц, зохион байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн, эсхүл гүүнд байрлуулсан буюу дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учирсан бол уг гэм хорыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, эсхүл аюултай зүйлийг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.</p> <p>502.2.Онцгой аюул учруулж болох барилга</p>	<p>Эрүүгийн хуулийн 183 дугаар зүйл, 185 дугаар зүйл, Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх, 189 дүгээр зүйл, Галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих, 190 дүгээр зүйл, Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээж журам зөрчих, 200 дугаар зүйл, Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, 206 дугаар зүйл, Химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих гэмт хэргүүд.</p>

<p>байгууламж эд хөрөнгийг өмчлөгч буюу эзэмшигч нь гэм буруутай байсан эсэхээс үл хамгаалан энэ хуулийн 502.1-д заасан гэм хорыг хариуцна.</p> <p>502.3.Өмчлөгчийн эзэмшилд байгаа барилга байгууламж дотор буюу түүний эдлэн газрын хил хязгаарын дотор бусдад гэм хор учирсан боловч түүнд өмчлөгч буруугүй бол тэрээр хариуцлага хүлээхгүй.</p>	
<p>Иргэний хуульд барилга байгууламжийн дүр мэдэн өөрчилсөн, эсхүл түүнд байрлуулсан буюу дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учирсан бол гэж заасныг Эрүүгийн хуульд нэлээд тодорхой нэг бүрчлэн задаргаа хийж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.</p>	
<p>4. 501 дүгээр зүйл. Амьтны учруулсан гэм хорыг хариуцах</p> <p>501.1.Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.</p> <p>501.2.Гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учирсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй.</p>	<p>201 дүгээр зүйл. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах</p> <p>201.1.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний бие махбодийг хөнгөн буюу хүндэтгэр гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>201.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>Хүний хараа хяналтанд байдаг болон гэрийн тэжээвэр амьтдаас бусдад учруулсан гэм хорыг түүний эзэмшигч болон өмчлөгч хариуцана гэсэн ерөнхий заалт аль аль хуульд заагдсан байна. Харин хүний хараа хяналтанд байдаггүй золбин нолонд хазуулсан иргэн хаана хандах хэнээс гэм хорыг нэхэмийлэх нь тодорхой бус байна.</p>	

хохирлыг арилгуулах зорилготой байдаг бол эрүүгийн эрх зүй нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг шийтгэх зорилготой байдгаараа ялгаатай. Орчин ойрондоо аюултай үйл ажиллагаа болон

орчин тойрондоо аюултай бусад зүйлийн талаар Эрүүгийн хуульд нэлээд нарийн зохицуулалтуудыг хуульчилж ялыг ялгамжтай оногдуулахад хэрэглэдэг байна. Монгол Улсын Үндсэн хуулийн

Арванзургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй, 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын

гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх" эрхийг хуульчилсан. Гэтэл өнөөдөр Үндсэн хуульд заасан эдгээр эрхээ баталгаатай эдэлж чадаж байна уу? гэвэл маш их эргэлзээтэй байсаар байна. Мөн Иргэний хуулийн 502 дугаар зүйлийн 502.1 дэх хэсэг: Барилга байгууламжийн хийц, зохион байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн, эсхүл түүнд байрлуулсан буюу дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учирсан бол уг гэм хорыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, эсхүл аюултай зүйлийг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй гэсэн зохицуулалт бараг хэрэгжихгүй байна. Учир нь орон сууцны барилгын нэгдүгээр давхарыг дур мэдэн өөрчилж зориулалтын бусаар ашиглаж эхэлснээс эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдэлж чадахгүй хүрч байгаа нөхцөл байдлууд нэлээдгүй байна. Нийслэлийн Засаг даргын 1997 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 241 дүгээр захирамжтай холбоотой. Энэхүү захирамжаар "Орон сууцны барилга байгууламжийн хийц зориулалтыг өөрчилж, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход мөрдөх журам"-ыг баталсан юм. Үүний үр дүнд гэхэд 1-40 мянгат, 50 мянгат гэх мэт хотын төвийн орон сууцны нэг давхрууд тэр чигээрээ үйлчилгээний газар болж хувирсан. Уг нь Монгол Улсын Нийслэлийн Засаг даргын (2001 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн дугаар 333 тоот захирамж) 1950, 1960-аад оны үед баригдсан орон сууцны барилгуудыг зориулалтын бусаар ашиглахгүй байх тухай шийдвэр байдаг. Харин дээрх оноос хойш баригдсан барилгуудыг үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг

үндэслэн ашиглуулах эрх олгож байхыг Хотын ерөнхий менежерт даалгасан байдаг ч захирамж гарсны дараа байдлыг шалгахад зөвшөөрлүүд нь 1950-1960 оны үед баригдсан барилгуудын нэгдүгээр давхарыг дур мэдэн өөрчлөх шийдвэр болон хувирсан байжээ.<sup>3</sup> Ингэж барилгыг дур мэдэн өөрчилж даацын хана тааз нэвт цөмлөн үйл ажиллагаа явуулж байгаагаас болж барилга нурахад хүрвэл түүний дээд давхрын оршин суугчид, ойр орчмын зам бусад барилга байгууламжид нөлөөлж орчин тойрондоо аюултай нөхцөл байдал бий болгосноос бусдад ихээхэн хэмжээний хохирол учрах нь тодорхой. Энэ мэт зөрчлүүд олон байгаа нь нэг талаас иргэд энэ талаарх хуулийн зохицуулалтыг мэддэггүй, нөгөө талаас уг хуулийн зохицуулалт хэрэгжиж чадахгүй байна гэж үзэж болохоор байна. Энэхүү асуудалтай холбоотой дурьдвал: Иргэд дур мэдэн орон сууцныхаа ханыг нураан үсчин, хоолны газар, эмийн сан, худалдааны цэг болгон хувиргаж байгаа нь өөрсдийнхөө амь насанд аюул учруулж буй хэрэг юм. БЗД-ийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 60 айлын орон сууц буюу ХАА-н яамны ажилчдын байрны нэг давхрын даацын ханыг нураан 16 үйлчилгээний газар ажиллаж байна. Орон сууц руугаа дотогшоо ордог 12 хаалга шинээр гаргасан нь даацын ханын бат бөх чанарыг алдагдуулсан гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарчээ. Энэ нь Иргэний хуулийн 500, 502 дугаар зүйлүүдийг зөрчиж орчин тойрондоо аюултай нөхцөл байдлыг бий болгож байна. Энэ мэт асуудал их гардаг ч орчин тойрондоо аюултай зүйлс, аюултай үйл ажиллагаанаас бусдад гэм хор учруулсан тохиолдолд түүнийг шүүхээр шийдвэрлүүлсэн практик чөөн байна. Шүүхийн статистикийг 2006-2008 оны хоорондох 6 дүргийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг судлахад Иргэний хуулийн 499 дүгээр зүйл (Тээврийн

хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах) асуудлаар 2006 онд 9 удаа буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 0.18%, 2007 онд 5 удаа буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 0.15%, 2008 онд 6 удаа буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 0.10%-ийг эзэлж байна.

Иргэний хуулийн 500 дугаар зүйл буюу (Барилга байгууламж барих, ашиглах явцад үүссэн гэм хорыг арилгах) асуудлаар шүүхээр шийдвэрлэгдсэн практик дэвсгэр онд байхгүй. Иргэний хуулийн 501 дүгээр зүйл буюу Амьтны учруулсан гэм хорын асуудлаар 2006 онд Хан-Уул дүүргийн шүүхээр шийдвэрлэгдсэн нэг удаагийн хэрэг байна. Дээрхи бүх байдалд дүгнэлт хийхэд орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай зүйлээс учруулсан гэм хорын асуудал нь практикт олон тохиолддог гэдгийг хүн бүр мэдэх боловч хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учирсан бол тэрхүү асуудлыг иргэд хуулийн этгээдүүд хоорондоо зохиож учруулсан гэм хорыг арилгадаг практик тогтсон байгааг харуулж байна. Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай зүйлээс бусдад учруулсан гэм хорын хариуцлагын хариуцагч байж болох субъект нь зарим тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллагын албан тушаалтан байдаг. Учир нь зөвшөөрөл олгох ёсгүй газар барилга байгууламж барьсан, үйл ажиллагаа явуулснаас үүдэлтэй гэм хор учраа явдал их байна. Мөн орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай зүйлээс бусдад гэм хор хамгийн их учруулж байгаа нь аж ахуйн нэгжүүд байдаг. Гэтэл өнөөдрийн байдлаар тэдгээрийн үйл ажиллагааг зогсоох, торгууль хүлээлгэхээс хэтрэхгүй байгаа нь хуулийн зохицуулалт бодит байдалд нийцэхгүй учир дутагдалтай байгааг харуулж байна.

<sup>3</sup> www.irgen.mn/index.php?option=com

## ХБНГУ-ын захиргааны шүүхийн Үндсэн хуулийн болон энгийн хуулийн эрх зүйн үндсүүд (II хэсэг)

**МУИС-ийн ХЗС-ийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор Г.Банзрагч**

Уг сэтгүүлийн [№3(22) 2008]-д гарсан эхний хэсгээр Германы захиргааны шүүх эрх мэдлийн хөгжлийн асуудлыг тоймлон өгүүлсэн бол энэхүү хэсгээр ХБНГУ-ын Үндсэн хууль болон Захиргааны шүүхийн тухай хуулиар (ЗШТХ) зохицуулагдсан захиргааны эрх зүйн хамгаалалтын зорилго, үндсэн зарчмуудыг тайлбарлан, тэдгээрийг өөрийн улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан, хоорондын төсөөтэй болон ялгаатай талуудыг гаргахыг зорилоо. Тодруулбал, захиргааны шүүх эрх мэдлийн зорилго, чиг үүрэг, эрх зүйн хамгаалалтын хэлбэрүүд, захиргааны шүүхийн тогтолцоо зэргийг авч үзлээ.

1945 оноос хойш Германы эрх зүйн шинжлэх ухаан нь эрх зүйн позитивизмын хүрээнд гарсан алдааг засах зорилгоор төрөлхийн эрх, хүний үндсэн эрхэд тулгуурласан материаллаг эрх зүйт төрийн тухай ойлголтыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж эхэлсэн. Учир нь "төрийн үйл ажиллагаа хуулиар зохицуулагдсан байх ёстой" гэсэн зарчим нь эрх зүйн баталгааг тодорхой хэмжээгээр хангаж буй боловч энэ нь ёс суртахуунгүй үйлдэл, үйл ажиллагаа хуулийн хэлбэрээр хэрэгжихгүй гэсэн баталгаа болж чадахгүй юм байна гэдгийг үндэстний социалистуудын хуулиар дамжуулан үндэстэн астанг үй олноор нь устгасан аймшигт үйл явдал харуулсан билээ. Иймээс энэ үеэс Үндсэн хуульд ёс, эрх зүйт төрийн тухай ойлголт зэрэг нь

(өөрөөр хэлбэл нийтийн эрх зүй нь) шинэ чиг хандлагаар хөгжиж эхэлжээ.

Орчин үеийн захиргааны шүүхийн ач холбогдлыг тодорхойлохын тулд Үндсэн хуулиас эхлэх шаардлагатай. Учир нь Үндсэн хуульд тунхагласан хүний үндсэн эрхүүд болон үндсэн хуулийн зарчмууд нь захиргааны шүүхийн үйл ажиллагааны дээд хэмжүүр буюу хязгаар нь болдог юм. Түүнээс гадна захиргааны шүүх эрх мэдлийн байгуулалт нь Үндсэн хуулиар тодорхойлогдох бөгөөд уг хуулийн бодит хүчин чадал нь захиргааны шүүх эрх мэдэл үр нөлөөтэй байхад олон талаар нөлөөлдөг байна. Үндсэн хууль дахь үндсэн эрхүүд болон түүнтэй төсөөтэй эрхүүдээс (ҮХ §1.3) гадна эрх зүйт төрийн зарчим (ҮХ §§20, 28, 19.4), захиргааны шүүхийн байгуулал (ҮХ §§92, 96.1), шүүгчийн хараат бус байдал (§§ 97, 101.1 өг.2), процессын нийтлэг зарчмуудыг (§§97, 101.1, 103.1) зохицуулсан зүйл заалтууд нь захиргааны шүүх эрх мэдлийг тодорхойлох үндсэн аспектиуд юм.

1. Үндсэн эрхүүд болон түүнтэй адилтгах эрхүүд

а. Формаль үндсэн эрх

Үндсэн хуулийн 19 зүйлийн 4 дэх хэсэгт "Хэрэв хэн нэгний эрх нь нийтийн засаглалын үйл ажиллагааны улмаас зөрчигдвөл, түүнд шүүхийн зам нээлттэй" хэмээн заасан байдаг. Уг заалтаар нийтийн засаглалын эсрэг хүний эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжийг үндсэн хуулийн түвшинд нээж, баталгаажуулж өгч буйгаараа онцгой ач холбогдолтой бөгөөд энэ

нь захиргааны шүүх эрх мэдлийн хувьд хамгийн чухал эрх зүйн үндэс нь юм. Энд заасан "нийтийн засаглал" хэмээх ойлголтдог гагцхүү гүйцэтгэх эрх мэдлийг ойлгоно.<sup>1</sup> Үндсэн хуулийн 19 зүйлийн 4 дэх хэсэг нь иргэнд зөвхөн эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжийг нээгээд зогсохгүй уг хамгаалалт нь (өөрөөр хэлбэл захиргааны шүүхийн үйл ажиллагаа нь) үр дүнтэй байх утгыг давхар агуулдаг.<sup>2</sup> Эрх зүйн хамгаалалт үр дүнтэй байх гэдэг нь захиргааны шүүхээс захиргааны үйл ажиллагааны эрх зүйн болон бодит байдлыг бүрэн дүүрэн, хугацаа алдалгүй хянахыг хэлнэ хэмээн Үндсэн хуулийн шүүхээс тайлбарласан байдаг.

б. Материллаг үндсэн эрхүүд

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Дараах үндсэн эрхүүд нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хувьд шууд хэрэглэгдэх эрх юм" хэмээн заасан байдаг. Эндээс хүний үндсэн эрхүүд нь гагцхүү Үндсэн хуулийн шүүхээр бус харин захиргааны шүүхээр давхар хамгаалагддаг болох нь харагдаж байна. Учир нь эдгээр эрхүүд нь захиргааны өдөр тутмын үйл ажиллагаанд тайнга өртөгдөж байдаг бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн процессоор хянагдаж, хамгаалагдаж байдаг. Иймд Үндсэн хуулийн эхний бүлэгт заасан хүний үндсэн эрхүүд нь захиргааны шүүхийн хувьд (мөн бусад шүүхийн хувьд ч ялгаагүй) шууд хэрэглэгдэх эрх буюу хэм хэмжээ болох бөгөөд энэ утгаараа захиргааны шүүх нь хүний үндсэн эрхийг баталгаажуулах чухал үе шат юм.<sup>3</sup>

<sup>1</sup>Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр 24, 33, 49 хойш 45, 297, 334.

<sup>2</sup>Stern, Klaus, Verwaltungsverfahrensprobleme in der öffentlich-rechtlichen Arbeit, 8. Aufl., мөп 16; Sommermann, Karl-Peter,

Die Deutsche Verwaltung: Gerichtsbarkeit, x 11; Wüstenberger, Thomas, Verwaltungsprozessrecht, мөп 86 рм.

<sup>3</sup>Stern, мөп 20, 21; Wüstenberger, мөп 22; Hufen/Friedhelm, Verwaltungsprozessrecht, 6. Aufl., 1 зүйн, мөп 22 рм.

Үндсэн хуулийн шүүхээс "үндсэн эрхээс өөрөөс нь түүний хэрэгжилтийг шаардах боломж буюу шаардах эрх (субъектив эрх) урган гарч байдаг" гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл үндсэн эрх нь өөрөө субъектив эрх болдог. Иймд иргэн үндсэн эрхээ шүүхээр хамгаалуулахын тулд Үндсэн хуульд заасан материаллаг эрхүүдийг шууд иш үндэслэл болгох уу, эсхүл 19 дүгээр зүйлийн 4-т заасан формал эрхээр дамжуулан шаардах уу гэсэн асуудал үүсдэг. Үндсэн хуулийн шүүх үүнд хариулахдаа: "энэхүү хоёр боломжийн аль алиныг нь ашиглаж болно" гэсэн байна. Гэхдээ сүүлийн үед Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 4-ийг дангаар нь хэрэглэх байдал түүгэмэл байна.

#### в. Процессын эрхүүд

Үндсэн хуулийн 101 дүгээр зүйл буюу хууль ёсны шүүгч, 103 дугаар зүйлийн 1 дэх хэсэг буюу шүүхэд сонсох зарчмууд нь үндсэн эрхтэй төстэй эрхэд хамаарах бөгөөд энэ захиргааны шүүхэд ч мөн хамааралтай юм. Үндсэн хуулийн 101 дүгээр зүйлд хүн бүр хууль ёсны шүүгчээр шүүлүүлэх тухай болон хуулиас гадуур шүүх байгуулж болохгүй тухай заасан байдаг. Өөрөөр хэлбэл шүүх болон шүүгчийг хуулиар аль болох тодорхой заасан байх ёстой гэсэн зарчим юм. Уг зарчим нь шүүх бүрэлдэхүүнийг хуульд зааснаас бусад үндэслэлээр солих, өөрчлөхгүй байх, үүгээрээ шүүхийн шийдвэр дэх төрийн нөлөөллийг хязгаарлах, улмаар шүүх эрх мэдэл дэх олон нийтийн итгэлийг хамгаалах, шүүхийн төвний сахисан, бодитой, шударга шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэж буй юм.<sup>4</sup>

Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 1-ийн дагуу "хүн бүр шүүхэд өөрийгөө мэдүүлэх эрхтэй" байдаг. Энэхүү эрх нь шүүхийн процессын

бүхий л үе шатанд хамааралтай юм. §103.1-т заасан эрх нь хүний эрхэмсэг оршихуйг хамгаалах үүднээс хүн бүрт шүүхийн өмнө хэрэгний бодит болон эрх зүйн байдлын талаар нотолгоо гаргах боломжийг олгодог. Нөгөө талаас шүүх энэ зарчмын дагуу өөрийн шийдвэрийн үндэслэлээ хэргийн оролцогчдод танилцуулах үүрэг хүлээх бөгөөд ингэснээр гэнэтийн шийдвэр гаргах нөхцөлийг хаадаг байна.<sup>5</sup>

Хэрэв дээрх хоёр эрх нь зөрчигдвөл иргэн бусад (материаллаг) үндсэн эрхийнхээ нэгэн адил зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхтэй байдаг.<sup>6</sup>

#### 2. Эрх зүйт төрийн үндсүүд

Otto Baehr<sup>7</sup> -н эрх зүйт төрийн талаарх үзэл баримтлал нь Үндсэн хуулийн §20.2, 3, §28.1-т илэрлээ олсон байдаг. §20.2-т "Төрийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй. Энэхүү эрх мэдэл нь ард түмний санал хураалга, сонгуулийн үндсэн дээр байгуулагдсан хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдлээр хэрэгжинэ" хэмээн заасан байдаг. Ийнхүү шүүх эрх мэдэл нь эрх зүйт төрийн нэг урьдчилсан нөхцөл болон хүлээн зөвшөөрөгдсөн байна. §20.3-ийн дагуу "Хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хуульд ёсыг, гүйцэтгэх засаглал болон шүүх эрх мэдэл нь хууль, эрх зүйг баримтална" гэж заажээ. Үүгээр "хууль дээдлэх" болон "хуульд үндэслэх" гэсэн эрх зүйт төрийн зарчим баталгаажсан байна.

Үндсэн хуулийн 92, 95 дугаар зүйлийн дагуу "Шүүх эрх мэдэл нь Үндсэн хуулийн шүүхээс гадна ердийн, захиргааны, санхүүгийн, хөдөлмөрийн, нийгмийн гэсэн таван төрлийн төрөлжсөн шүүхээс бүрдэнэ". Ийнхүү захиргааны шүүх

нь шүүх эрх мэдлийн нэг бие даасан салаа мөчир нь болох бөгөөд түүнд бусад шүүхэд хамааралтай үндсэн хуулийн зарчмууд мөн адил хамаарна.

Шүүхийн болон шүүгчийн хараат бус байдлын баталгаа нь шүүх эрх мэдэл, түүний дотор захиргааны шүүхийн хувьд Үндсэн хуулийн нэгэн чухал үндэс юм. Хараат бус шүүхгүйгээр, өөрөөр хэлбэл хараат бус захиргааны шүүхийн хяналтгүйгээр эрх зүйт төрийн үндсэн зарчмууд нь хэрэгжих боломжгүй юм. Иймээс Үндсэн хуулийн 92, 97 дугаар зүйлээр шүүх эрх мэдэл нь зөвхөн шүүгчдээр дамжин хэрэгжих бөгөөд тэд зөвхөн хуульд захирагдах тухай заасан байдаг. Шүүгчдийн албаны болон хувийн хараат бус байдлыг Үндсэн хуулийн 97 дугаар зүйлээр, тэдний онцгой статусыг 98 дугаар зүйлээр хамгаалсан байдаг.

#### 3. Ардчилсан, социал холбооны улсын зарчим

Үндсэн хуулийн §20.1-ийн дагуу "ХБНГУ нь ардчилсан, социал, холбооны улс" юм. §20.2-т ардчилалын зарчмыг тодорхой заасан. Захиргааны шүүх нь захиргаанаас ардчилсан хуулиудыг дагаж мөрдөхийг шаарддаг, түүнчлэн ардчилалын нэг зарчим болох цөөнхийн эрхийг баталгаажуулж байдгаараа ардчилсан ёсны зарчмыг зохих хэмжээнд хэрэгжүүлдэг гэж үздэг.<sup>8</sup>

Социал төр гэдэг нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд нийгмийн шударга ёсыг аль болох өргөн хүрээнд хэрэгжүүлдэг төрийг хэлнэ. Ингэхдээ хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлэх, тэдний хоорондын эрс ялгааг арилгахад үйл ажиллагаагаа чиглүүлэх юм.<sup>9</sup> Захиргааны шүүх нь нийтийн захиргааны зөвхөн хүний эрхэд халдсан үйл ажиллагааг

<sup>4</sup>Sommermann, x.24, Stern, мөр.24, Wuertenberger, мөр.87, 88

<sup>5</sup>Stern, мөр.25; Wuertenberger, мөр.89;

<sup>6</sup>Stern, мөр.23, 24.

<sup>7</sup>Baehr, Otto, Der Rechtsstaat, x.192-оос харна уу.

<sup>8</sup>Jarass/Pieroth, GG-Kommentar, 20 зүйл, мөр. 1-ээс хойш

<sup>9</sup>Creifelds, x.1209, Jarass/Pieroth, GG-Kommentar, 20 зүйл, мөр. 112-оос хойш

хянаад зогсохгүй, тэдэнд үзүүлэх ёстой үйлчилгээ хууль ёсны дагуу явагдсан эсэхийг мөн хянадагаараа боломж, эрсдэл, эд баялаг, ачааллын шударга хуваарилалтыг баталгаажуулдаг гэж болно. Үүгээр хувь хүний нийгмийн наад захын хэрэгцээ шаардлага хангагдах, түүнчлэн хувийн эрх чөлөөний хүрээ баталгаажих юм. Учир нь хувь хүний эрх чөлөөний хүрээ нь төрөөс үзүүлэх үйлчилгээнээс их хэмжээгээр шалтгаалдаг.

Герман улс нь холбооны улс тул (захиргааны) шүүхийн тогтолцоо нь түүнд зохицсон байдаг. Энэ нь Үндсэн хуулийн 92 дугаар зүйлээр зохицуулагдсан байна.

#### 4. Захиргааны шүүхийн зорилго, чиг үүрэг

а. Субъектив эрхийн хамгаалалт  
Үндсэн хуулийн § 4 дүгээр зүйл нь захиргааны шүүхийн зорилгыг тодорхойлдог. Уг зүйлийн дагуу нийтийн засаглалын үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн хэн бүр шүүхэд хандан эрхээ хамгаалуулах эрхтэй байдаг. Энд заасан "эрх" хэмээх ойлголт нь нэг талаас бодит хэм хэмжээ буюу объектив эрх, нөгөө талаас тэрхүү объектив хэм хэмжээнээс шууд, эсхүл шууд бусаар үүсэх хувь хүний субъектив эрхийг давхар агуулна. Субъектив эрх гэдэг нь эрх бүхий этгээд нь үүрэг бүхий этгээдээс тодорхой зүйл хийхийг, эсхүл тэдвэхийг шаардах боломж буюу бүрэн эрх юм.<sup>10</sup> Иймд тодорхой маргааныг захиргааны шүүхээр шийдвэрлүүлэх урьдчилсан нөхцөл нь нэхэмжлэгчийн субъектив эрх нь зөрчигдсөн болохыг батлах явдал юм. Энэ утгаараа өнөөгийн захиргааны шүүхийн тэргүүн зорилго нь объектив эрхийн хэрэгжилтийг хамгаалахад бус харин нийтийн засаглалын үйл ажиллагаанаас иргэний субъектив

эрхийг нь хамгаалахад чиглэгдэнэ. Иймээс иргэн бусдын эрхэд хамааралтай, өөрөөр хэлбэл өөрөөс нь өөр хэн нэгний эрх зөрчигдсөн тухай нэхэмжлэлийг (Popularklage) захиргааны шүүхэд гаргах боломжгүй юм.<sup>11</sup> Хэдийгээр үүнийг зарим хуульч судлаачид (Werner Wiese, Axel Goerlitz) шүүмжилдэг боловч уг зарчим нь нэгэнт тогтсон байна.

Германы хуульч Niese-ийн үзсэнээр "хэрэв захиргааны шүүхийн зорилго нь захиргааны үйл ажиллагааны объектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэх юм бол захиргааны байгууллагаас хууль зөрчин гаргасан акт, шийдвэрүүд нь зөвхөн шүүхийн шийдвэрээр л засагдах боломжтой болно. Энэ байдал нь захиргаа, шүүх хоёрын харилцаа үндсээр нь өөрчлөгдөхөд хүргэнэ, өөрөөр хэлбэл захиргааны шүүх нь дээд шатны захиргааны байгууллага болж хувирах юм. Ийнгэснээр захиргааны шүүхийн зорилго нь хувь этгээдийн субъектив эрхийг хамгаалахад бус, харин захиргааг хууль ёсыг сахиулахад чиглэгдэх болно" гэжээ.

Дээр дурьдсан субъектив эрхийн ойлголтоос "нийтийн эрх зүйн субъектив эрх"-ийн тухай ойлголтыг тодорхойлж болно. Энэ нь төр юмуу нийтийн эрх зүйн бусад этгээдээс нийтийн эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг, эсхүл зогсоохыг шаардах хувь этгээдийн бүрэн эрх буюу түүнд олгогдсон шаардах боломж юм.<sup>12</sup> Иймээс уг эрхэд зөвхөн Үндсэн хуульд заасан үндсэн эрхүүд хамаараад зогсохгүй бусад бүхий л нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн буюу олгогдсон субъектив эрхүүд хамаарах юм. Түүнээс гадна нийтийн эрх зүйн субъектив эрхэд хуулиар хамгаалагдан хүлээн

зөвшөөрөгдсөн хувийн ашиг сонирхлууд хамаарч болно. Нийтийн эрх зүйн хэм хэмжээ нь ихэнхдээ гагцхүү нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдагч зарим тохиолдолд хувийн ашиг сонирхлыг (субъектив эрхийг) давхар хамгаалж болно. Энэ тохиолдолд хууль тогтоогчийн хүсэл зориг нь тухайн хэм хэмжээгээр нийтлэг ашиг сонирхлоос гадна хувь этгээдийн хувийн ашиг сонирхлыг хамгаалахыг зорьсон болох нь илэрхий байх ёстой. Гэхдээ зөвхөн нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн хэм хэмжээнээс нийтийн эрх зүйн субъектив эрх үүсэхгүй.<sup>13</sup>

б. Объектив эрхийн хамгаалалт  
Хэдийгээр Үндсэн хуулийн § 19.4 нь зөвхөн субъектив эрхийн хамгаалалтын тухай боловч уг заалт болон мөн хуулийн § 20.3-т заасан хууль, эрх зүйг дагаж мөрдөх тухай эрх зүйт төрийн зарчмын хоорондын уялдаа холбоо нь субъектив болон объектив эрхийн хоорондын холбоогч харуулж буй юм.<sup>14</sup> Түүнчлэн Үндсэн хуулийн § 19.4-дх зарчим нь зөвхөн захиргаа өөрөө өөрийгөө хянах зарчмыг бус харин шүүх захиргааг хянаж байхаар заасан нь захиргааны шүүхийн үйл ажиллагааны дараагийн зорилго нь объектив эрхийн хамгаалалт болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны шүүх нь захиргаанаас хуулийг дагаж мөрдөхийг шаардсанаар буюу албасанаар захиргааны үйл ажиллагаа хууль ёсны байх зарчмын хэрэгжилтийг хангах юм<sup>15</sup> (ҮХ-ийн § 20.3). Гэхдээ уг хяналт нь ихэнхдээ хувь этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр үүснэ. Тодруулбал, захиргаа нь акт гаргах, бусад үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд хуулийг үндэслэсэн, бусад хуулийг дээдэлсэн эсэхийг шүүхээс шалгаснаар захиргааны

<sup>10</sup>Bachof, Otto, Die VerwaltungsgerichtlicheKlage auf VornahmeinerAmthandlung, x 62-63

<sup>11</sup>Sommermann, x 14-16.

<sup>12</sup>Creifelds, x 1288

<sup>13</sup>Schenke, in: FS Haeberling Hyon Seok, x 115-116, Sommermann, x 15-16.

<sup>14</sup>Hufen, 1 зүйл мөр.

<sup>15</sup>Steikens, Verwaltungsgerichtsbarkeit in der Krise, in: DVBl, 1995, x 1105, 1110.

хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хангуулна. Өөрөөр хэлбэл, субъектив эрхийн хамгаалалтаар дамжуулан объектив эрхийн хэрэгжилтийг хангана гэсэн үг юм. Түүнээс гадна захиргааны шүүх нь энэхүү нэхэмжлэлээр үүсэх "дамжмал" хяналтаас гадна цэвэр хэм хэмжээний хяналтыг мөн хэрэгжүүлдэг. Захиргааны шүүхийн тухай хуулийн (ЗШТХ-ийн) § 47.2-ийн дагуу иргэн, хуулийн этгээд нь эрх зүйн хэм хэмжээ эсвэл түүний хэрэгжилтийн улмаас эрх нь зөрчигдсөн эсвэл зөрчигдох болох тухайгаа нотолж чадвал, мөн түүнчлэн төрийн байгууллага нь эрх зүйн хэм хэмжээ гарснаас хойш хоёр жилийн дотор тухайн хэм хэмжээг хянуулахаар өргөдөл гаргаж болохоор заасан байна. Үүнээс үзэхэд субъектив эрх заавал зөрчигдсөн байхыг батлах шаардлагагүйгээр (гэхдээ зөвхөн төрийн байгууллага бусад нийтийн эрх зүйн этгээдийн хувд) хэм хэмжээний хяналт хэрэгжүүлэх боломжтой байгаа нь энэхүү зорилтыг улам тодотгож байгаа юм.<sup>16</sup>

Энэ утгаараа захиргааны шүүх нь иргэний эрхээ хангуулах итгэлийг хамгаалахаас гадна захиргааны итгэлийг мөн хамгаалдаг гэж үзэх үндэслэлтэй. Иймээс захиргааны шүүх нэг талаас өөрийн субъектив эрхийн баталгааг хангуулахыг хүссэн нэхэмжлэгчийн буюу иргэний, нөгөө талаас объектив эрх нь хүчинтэй болохыг тогтоолгохыг эрмэлзэж буй хариуцагчийн буюу захиргааны итгэл, хууль ёсны эрх ашгийг адил хамгаалах ёстой.

5. Захиргааны шүүхийн зохион байгуулалт, тогтолцоо

ЗШТХ-ийн 2 дугаар зүйлээр захиргааны шүүх нь гурван шаттай.

Муг улсуудын түвшинд анхан болон давж заалдах шатны шүүхүүд, холбооны түвшинд дээд шатны буюу хяналтын шатны шүүх байна. Захиргааны ердийн шүүхээс гадна санхүүгийн болон нийгмийн гэсэн захиргааны төрөлжсөн шүүхүүд мөн өөр өөрийн тогтолцоотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

6. Захиргааны шүүхээс хэрэгжүүлэх эрхийн хамгаалалтын хэлбэрүүд (процессын хэлбэрүүд)

Захиргааны шүүх нь гурван төрлийн эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг. Үүнд: нэхэмжлэлийн хэлбэр, урьдчилсан эрхийн хамгаалалт, хэм хэмжээний хяналт хамаарна. Сүүлийн хоёр ажиллагаа нь өргөдлийн үндсэн дээр явагддаг.

а. Нэхэмжлэлийн хэлбэр

Нэхэмжлэлийн үндсэн дээр үүсэх эрхийн хамгаалалтын хэлбэр нь захиргааны шүүхийн үндсэн үйл ажиллагаа юм. Энэ нь захиргааны шүүхээс иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр захиргааны үйл ажиллагааг хянахад чиглэгддэг. Нэхэмжлэлийн төрлүүдэд дарамт учруулсан захиргааны актыг хүчингүй болгуулахад чиглэгдсэн "хүчингүй болгох нэхэмжлэл" (Anfechtungsklage), татгалзсан, эсхүл гаргаагүй захиргааны актыг гаргуулахад чиглэгдсэн "даалгах нэхэмжлэл" (Verpflichtungsklage), захиргааны актаас бусад үйл ажиллагаанд чиглэгдсэн "болиулах нэхэмжлэл" (Unterlassungsklage) нэхэмжлэл, мөн тогтоох нэхэмжлэл (Feststellungsklage)<sup>17</sup> болон бусад "тодорхойлох нэхэмжлэл" (Gestaltungsklage)-ийн төрлүүд хамаарна.

б. Урьдчилсан хамгаалалт

Үндсэн хуулийн 19.4 зүйл нь шүүхээс хэрэг маргааныг дуусахаас

өмнө, хохирол учрахаас урьдаж эрхийн хамгаалалтыг аль болох үр дүнтэй үзүүлэхийг шаарддаг. Тиймээс ч Германы ЗШТХ нь нэхэмжлэлийн хэлбэрээс гадна өргөдлийн үндсэн дээр үүсэх урьдчилсан хамгаалалтын хэлбэрийг хуульчилсан байдаг. Тодорхой нэг маргааны талаар нэхэмжлэл гаргаснаас хойш түүнийг шүүхээр шийдвэрлэх хүртэлх хугацаанд захиргааны актыг гүйцэтгэснээр юмуу тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байснаар нэхэмжлэгч этгээдэд их хэмжээний хохирол учрах боломжтой. Тэгвэл энэхүү цаг хугацааны алдагдлыг нөхөх зорилгоор үндсэн ажиллагааны өмнө, өөрөөр хэлбэл нэхэмжлэл гаргахаас өмнө холбогдох этгээдэд буюу нэхэмжлэгчид урьдчилсан байдлаар эрхийн хамгаалалт үзүүлэх боломж байдаг. Тодруулбал эрхийн урьдчилсан хамгаалалт дарамт учруулсан захиргааны актыг шууд хэрэгжүүлэхийн эсрэг, эсвэл даалгах болон тогтоолгох нэхэмжлэлийн төрөлтэй холбогдон үүсэн бусад маргааныг урьдчилан зохицуулахад чиглэгддэг. Гэхдээ энэхүү урьдчилсан хамгаалалт нь эцсийн шийдвэр болохгүй, гагцхүү тухайн маргааныг үндсэн ажиллагаагаар шийдвэрлэгдэх хүртэл түүний status quo-г хадгалах арга юм.<sup>18</sup>

в. Хэм хэмжээний актын хяналт

Захиргааны шүүхээс хэрэгжүүлэх дараагийн эрхийн хамгаалалтын хэлбэр нь хэм хэмжээний актын хяналт юм. Тодруулбал захиргааны шүүхээс гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас тогтоосон хэм хэмжээний акт нь<sup>19</sup> дээд хүчин чадал бүхий хэм хэмжээ буюу хуультай нийцэж буй эсэхийг шалгах ажиллагаа юм. Гэхдээ үг

<sup>16</sup>Ule, Verwaltung und Verwaltungsgerichtsbarkeit, x. 49-өөс хойш харна уу.

<sup>17</sup>Тогтоох нэхэмжлэл нь дотроо олон төрөлтэй. Үүнд нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг (allgemeine Feststellungsklage), захиргааны акт илтхуульбуслохыг (Klage auf Feststellung der Nichtigkeit eines Verwaltungsaktes), гүйцэтгэгдсэн буюу хэрэгжээд дууссан захиргааны акт хууль бус байсныг (Fortsetzungsfeststellungsklage), ирээдүйд бий болох эрх зүйн харилцааны хууль бус болохыг урьдчилан тогтоох (vorbeugende Feststellungsklage), түүнчлэн нэхэмжлэлийг шийдвэрлэх явцад эрх зүйн харилцаа нь маргаантай бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрт нөлөөлөхгүй бол явцад нь тогтоох нэхэмжлэл (Zwischenfeststellungsklage) гэсэн төрлүүдтэй.

<sup>18</sup>Schenke, in FS. fuer Hyun Seok, x. 137-140; Sommermann, x. 60.

<sup>19</sup>Хэм хэмжээний акт гэдэгт гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хууль тогтоогчийн хуулиар шилжүүлсэн тусгай эрхийн



## Ауснэгт-1

ХБНГУ	Монгол Улс
<p>Үндсэн хуулийн түвшинд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн хуулийн 19 дугаар зүйлийн 4 дэх хэсэг-нийтийн засаглалын улмаас зөрчигдсөн эрхийн хамгаалах эрх зүйн баталгаа-захиргааны шүүхийн тусгай зохицуулалт;</li> <li>2. Үндсэн хуулийн 1 зүгээр зүйлийн 3 дахь хэсэг-төрийн гурван эрх мэдлийн хувьд үндсэн эрх нь шууд эрхийн хүчинтэй байх-иймээс үндсэн эрхүүд нь захиргааны шүүхийн хувьд нэг бол шууд хэрэглэгдэх эрх эсвэл шаардах эрх болно;</li> <li>3. Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгүүд нь эрх зүйт төрийн талаарх шууд зохицуулалт;</li> <li>4. Захиргааны шүүхийн тогтолцоо нь холбооны улсын хэлбэрт тохирсон, бие даасан (ҮХ-ийн 95 дугаар зүйл).</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 хэсэг-эрхийн хамгаалалтын талаарх ерөнхий зохицуулалт-захиргааны шүүхийн хувьд шууд бус зохицуулалт.</li> <li>2. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрхүүд нь төрийн гурван эрх мэдлийн хувьд буюу захиргааны шүүхийн хувьд шууд хэрэглэгдэх эрх болох тухай заалт байхгүй.</li> <li>3. Эрх зүйт төрийн үндэслэлүүд нь олон зүйлд шууд бус байдлаар зохицуулагдсан. Тухайлбал ҮХ-ийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг г.м.</li> <li>4. Захиргааны шүүх Улсын Дээд Шүүхийн тогтолцоонд хамаарах, төрөлжсөн шинжтэй (ҮХ-ийн 48 дугаар зүйл).</li> </ol>
<p>Захиргааны Шүүхийн тухай хуульд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Захиргааны шүүхийн зорилго нь: <ul style="list-style-type: none"> <li>- Субъектив эрхийн хамгаалалт (ЗШТХ-ийн 40 дүгээр зүйл);</li> <li>- Объектив эрхийн хамгаалалт (ЗШТХ-ийн 47 дугаар зүйл);</li> </ul> </li> <li>2. Процессын төрөл: <ul style="list-style-type: none"> <li>- нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа;</li> <li>- өргөдлөөр үүсэх урьдчилсан эрхийн хамгаалалт (ЗШТХ-ийн 80.5 дугаар зүйл);</li> <li>- өргөдлөөр үүсэх хэм хэмжээний актын хяналт (ЗШТХ-ийн 47 дугаар зүйл).</li> </ul> </li> <li>3. Нэхэмжлэлийн төрлүүдийг тодорхой системчлэлтэй зохицуулсан: <ul style="list-style-type: none"> <li>- хүчингүй болгох нэхэмжлэл (ЗШТХ-ийн 42 дугаар зүйл);</li> <li>- даалгах нэхэмжлэл (ЗШТХ-ийн 42 дугаар зүйл);</li> <li>- тогтоох нэхэмжлэл (ЗШТХ-ийн 43.1 дүгээр зүйл);</li> <li>- болиулах нэхэмжлэл (ЗШТХ-ийн 43.2 дугаар зүйл);</li> <li>- тодорхойлох нэхэмжлэл (ЗШТХ-ийн 43.2 зүйл дугаар).</li> </ul> </li> </ol>	<p>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Захиргааны шүүхийн зорилго нь: <ul style="list-style-type: none"> <li>- Субъектив эрхийн хамгаалалт (ЗХХШТХ-ийн 1 дүгээр зүйл);</li> </ul> </li> <li>2. Процессын төрөл: <ul style="list-style-type: none"> <li>- нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа (захиргааны акт, хэм хэмжээний актын хяналт, ЗХХШТХ-ийн 3.1.4);</li> <li>- захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх (ЗХХШТХ-ийн 45, 46 дугаар зүйл);</li> </ul> </li> <li>3. Нэхэмжлэлийн төрлүүд нь нэхэмжлэлийн шаардлага болон шүүхийн шийдвэрийн агуулгаар тодоонолодоно: <ul style="list-style-type: none"> <li>- хүчингүй болгох нэхэмжлэл (ЗХХШТХ-ын 32.5.1 дүгээр зүйл);</li> <li>- даалгах нэхэмжлэл (ЗХХШТХ-ийн 32.5.4 дүгээр зүйл);</li> <li>- илт шууд бус актыг тогтоох нэхэмжлэл;</li> <li>- хохирлыг тогтоох нэхэмжлэл (ЗХХШТХ-ийн 32.5.3 дугаар зүйл).</li> </ul> </li> </ol>

ажиллагааг зөвхөн муж улсын шүүх л хэрэгжүүлдэг. ЗШТХ-ийн 47 дугаар зүйлд хэм хэмжээний актын ерөнхий болон тусгай хяналтын төрлийг хамтад нь зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, тухайн хэм хэмжээ хүчин төгөлдөр эсэхийг зөвхөн тодорхой нэг тохиолдлын хувьд хамгаатай байхаар, эсвэл тодорхой нэг тохиолдлоос салган ерөнхийд нь нийтлэг байдлаар хянахыг хэлнэ. Иймээс хэм хэмжээний актын тусгай хяналтын

үед тухайн хэм хэмжээ нь өргөдөл гаргагч этгээдийн субъектив эрхийг зөрчсөн эсэхийг, харин ерөнхий хяналтын үед холбогдох хэм хэмжээ нь дээд хүчин чадалтай хуулийн хэм хэмжээтэй нийцэж буй эсэхийг шалгах юм.<sup>20</sup> (Хүснэгт-1)

Дээрх ялгааг үндэслэн манай улсын захиргааны процессын эрх зүйн хувьд цаашид анхаарах асуудлуудыг хөндөө.

1. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 19 зүйлийн 4 нь хэдийгээр захиргааны

шүүхийн талаар шууд дурьдаагүй боловч "нийтийн засаглал"-ын (хууль бус) үйл ажиллагаанаас хүний эрхийг шүүхийн журмаар хамгаалах замыг нээж буйгаараа захиргааны шүүхийн хувьд чухал ач холбогдолтой, эрх зүйт төрийг баталгаажуулсан зохицуулалт юм. Учир нь "нийтийн засаглал"-д гүйцэтгэх эрх мэдэл буюу захиргааг ойлгох бөгөөд захиргааны үйл ажиллагаанаас хүний эрхийг хамгаалах нь захиргааны шүүхийн

үндсэн дээр гаргасан, нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн нийтлэг тохиолдлыг зохицуулсан, төсөөтэй тохиолдолд дахин давтан хэрэглэгдэх, г м чиглэсэн шийдвэрийг (дүрэм, журам г.м.) хэлнэ

<sup>20</sup>Redeker/U. Gertzen, 47 зүйл, мөр 1; Eyermann, 47 зүйл, мөр 5; Kopp/Schenke, 47 зүйл, мөр 1-ээс 10-ийг

үндсэн зорилго билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т үүнтэй төсөөтэй ерөнхий заалт байдаг. Уг зүйлийн дагуу "Монгол Улсын иргэн... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... эрхтэй." гэж заажээ. Уг заалтыг зарим эрдэмтэн зөвхөн эрүү, иргэний процессын эрхэд хамааралтай гэж үздэг боловч<sup>21</sup> энэ нь захиргааны процессын эрхэд (захиргааны шүүхэд) ч мөн хамааралтай гэж үзэх үндэслэлтэй. Учир нь: нэгдүгээрт, "эрх" хэмээх ойлголтод хувийн болоод нийтийн эрх зүйн субъектив болоод объектив эрх аль аль хамаарах боломжтой; хоёрдугаарт, шүүх эрх мэдэлд захиргааны шүүх хамаарах нь ойлгомжтой юм. Иймд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-ийг дэлгэрүүлбэл: "Монгол Улсын иргэн... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан (нийтийн эрх зүйн субъектив) эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар (захиргааны) шүүхэд гомдол гаргах эрхтэй" хэмээн тайлбарлаж болох юм. Ийнхүү тайлбарлахын учир холбогдол нь нийтийн засаглалалаас хүний эрхийг хамгаалахад онцгой ач холбогдол өгөхөд оршино.

2. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт төрийн гурван эрх мэдлийн хувьд үндсэн эрх нь шууд хэрэглэгдэх хэм хэмжээ байхаар заасан байдаг. Иймээс Үндсэн хуульд тунхагласан үндсэн эрхүүд нь захиргааны шүүхийн хувьд нэг бол шууд хэрэглэгдэх эрх, эсвэл шаардах эрх (нийтийн эрх зүйн субъектив эрх) болно. Энэ утгаараа Үндсэн хуулийн 1.3 дугаар зүйл нь үндсэн эрхийг "амьдруулдаг" зохицуулалт гэж хэлж болно. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрхүүд нь төрийн гурван эрх мэдлийн хувьд шууд хэрэглэгдэх эрх болох тухай зохицуулалт байхгүй, тунхагалын

шинжтэй гэж хэлж болно. Иймд Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний үндсэн эрх, эрх чөлөө нь төрийн гурван эрх мэдлийн хувьд заавал мөрдөх хэм хэмжээ, иргэний хувьд шүүхэд нэхэмжлэл гаргах шаардах эрх (нийтийн эрх зүйн субъектив эрх)-ийн хэмжээнд ойлгох талаар Үндсэн хуулийн цэцээс тайлбарлах нь зүйтэй болов уу.

3. Германы захиргааны шүүхийн тэргүүн зорилго нь субъектив эрхийн хамгаалалт, удаах зорилго нь объектив эрхийн хамгаалалт байдаг. Харин Монгол Улсын захиргааны шүүхийн хувьд үндсэн зорилго нь субъектив эрхийн хамгаалалт гэж хэлж болно.

4. Германы шүүхэд бие даасан гурван төрлийн процессын үйл ажиллагаа явагддаг бол Монгол Улсын шүүхийн хувьд үндсэн нэг (нэхэмжлэлээр үүсэх ажиллагаа), туслах шинжтэй нэг (захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх) төрлийн процессын ажиллагаа явагддаг гэж болно. Хэм хэмжээний актын хяналтын хувьд хоёр улсын зохицуулалт хоорондоо ялгаатай байна. Германы хуулиар хэм хэмжээний актын хяналт нь өргөдлөөр үүсэх процессын бие даасан төрөл, субъектив болон объектив эрхийн хамгаалалтыг аль алиныг нь багтаадаг. Харин манай улсын хувьд ЗХХШТХ-ийн 3.1.4 дүгээр зүйлээр захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр (тогтоол, дүрэм, журам)-ийг захиргааны актад хамруулдаг. Иймээс захиргааны шүүх нь хэм хэмжээний актад нэхэмжлэлийн үндсэн дээр хяналт тавих эрхтэй юм. Захиргааны шүүхээс тавих энэхүү хяналт нь нэг талаас нэхэмжлэлээр үүсэх бөгөөд нэхэмжлэгч этгээдийн нийтийн эрх зүйн субъектив эрх нь заавал зөрчигдсөн буюу хөндөгдсөн байхыг шаарддаг (нэхэмжлэгч эрх нь зөрчигдөж буйгаа нотлох ёстой) эрэг шинжээрээ инцидент хяналтын шинжийг агуулдаг, нөгөө талаас хэм хэмжээний акт нь

шүүхийн хяналтын шууд объект нь болдог (өөрөөр хэлбэл шүүх ямар нэгэн маргааны шийдвэрлэхийн тулд, тухайлбал захиргааны акт хууль бус эсэхийг тогтоохын тулд эхлээд хэм хэмжээний актыг хянадаггүй), шүүхээс гарах шийдвэрийн үр нөлөө нь нийтэд хамааралтай (өөрөөр хэлбэл оролцогчдоор хязгаарлагддаггүй) байдгаараа принципиаль хяналтын шинжийг давхар агуулж байдаг өөрмөц онцлогтой. Цаашид манай улсын захиргааны шүүх нь зорилгодоо бүрэн хүрэхийн тулд процессын хэлбэрээ нэмэх талаар судлах нь зүйтэй болов уу.

5. Нэхэмжлэлийн төрлийн хувьд Германы хуулиар илүү дэлгэрэнгүй буюу тус бүрт нь зохицуулсан бол манай хуулиар нэхэмжлэлийн шаардлагын төрөл байдлаар явцуу хүрээнд зохицуулсан байна. Тухайлбал манайд захиргааны бусад үйл ажиллагаанд чиглэгдсэн (захиргааны актаас бусад) "биюулах нэхэмжлэл", "тодорхойлох нэхэмжлэл" болон "тогтоох нэхэмжлэл"-ийн зарим төрлүүд зохицуулагдаагүй. Цаашид эдгээр төрлийн нэхэмжлэлийг нэмэх талаар судлах нь зүйтэй болов уу. Учир нь захиргааны шүүхийн хяналт нь зөвхөн захиргааны актаар хязгаарлагдах нь учир дутагдалтай юм. Түүнээс гадна захиргааны гэрээнд тохирсон нэхэмжлэлийн төрлийг бий болгох нь зүйтэй. Учир нь захиргааны гэрээ нь захиргааны акт ч биш, эрх зүйн хэм хэмжээ ч биш, бодит акт ч биш учраас хуульд заасан нэхэмжлэлийн төрлүүд нь тохиромжгүй юм. Гэхдээ захиргааны гэрээний хамтын тохиролцооны шинжийг харгалзан захиргааны шүүхээр шалгагдах боломжтой болон боломжгүй нөхцөлүүдийг нарийвчлан зохицуулах шаардлагатай. Үүнд таарч болох нэхэмжлэл нь захиргааны гэрээ хууль ёсны эсэхийг "тогтоох нэхэмжлэл"-ийн нэг төрөл байж болох юм.

<sup>21</sup>Ред. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он. 114 дэх тал.

## Хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан иргэнд учирсан хохирлыг арилгуулах талаарх Польшийн эрх зүйн зохицуулалт



**Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Баттуяа**

Хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг Төрөөс арилгах тухай асуудлыг Польшийн хууль тогтоогчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШХ). Иргэний эрх зүйн хууль (ИЭЗХ) болон бусад хуулиар зохицуулахаар зааж өгсөн билээ.

Польш улсын 1928 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хууль бусаар ял

шийтгүүлсэн тохиолдолд төрийн сан хариуцлага хүлээнэ гэж заасан бол 1956 онд тус улсад улс төрийн үймээн, хөдөлгөөн гарсантай холбогдуулан 1958 оны 11 дүгээр сарын 15-нд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна<sup>1</sup>. Уг нэмэлт, өөрчлөлтөөр "Хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон иргэнд Төрийн сангаас хохирлыг нөхөн олгох тухай" нэмж тусгасан байна. 1989 онд тус улсын улс төрийн тогтолцоо өөрчлөгдөж, реформ бий болсноор 1969 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд<sup>2</sup> нэмэлт, өөрчлөлт оруулсан ч "Хууль бусаар баривчлагдсаны улмаас иргэнд учирсан хохирлыг Төрийн сангаас нөхөн төлнө" гэх зохицуулалт өөрчлөгдөөгүй байна.

Хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн тухай асуудлыг зохицуулахдаа 1991 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн "Улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль"<sup>3</sup>-ийг үндэслэл болгож байсан ба энэхүү хуульд улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийн бие махбодь болон сэтгэл санааны хохирлыг Төрийн сангаас нөхөн олгох тухай тодорхой зааж өгсөн.

Польш Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар бүлэгт "Иргэнийг хууль

бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай" зохицуулсан бөгөөд мөн хуулийн 552 дугаар зүйлд "... улмаас өөрт учирсан эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлоо Төрийн сангаас нөхөн төлүүлнэ" гэж, мөн "Зайлшгүй хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон бол эдийн болон эдийн бус хохирлоо нөхөн төлүүлнэ" хэмээн заасан боловч хохирлын хэмжээ болон хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох талаар тодорхой зохицуулаагүй байна.

Польш Улсын Дээд шүүхээс "Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ (хилсээр хоригдсон хоног тутамд ногдох)-г тогтооход дараах шалгуур үзүүлэлтүүдийг баримтална" гэж тайлбарлажээ<sup>4</sup>. Үүнд:

1. Хохирол нь нөхөн төлүүлэх бэлгэдлийн шинжтэй бус эдийн засгийн хувьд мэдрэгдэхүйц байх;
2. Нөхөн төлбөр нь нийгмийн тухайн цаг үеийн өмчийн харилцаанд нийцсэн бодит хэмжээнд тугуурласан байх;
3. Нөхөн төлбөрийн хэмжээ нь хэт их, хэт бага байж болохгүй;
4. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтооходоо тухайн нөхцөл байдлыг

<sup>1</sup> Ustawa o odpowiedzialności państwa za szkody wyrządzone przez funkcjonariuszy państwowych (Dz U nr 54, poz. 243) Төрийн албан хаагчдын хууль бус ажилгааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцах тухай хууль ("Хууль тогтоомжийн мэдээлэл" сэтгүүлийн дугаар 54)

<sup>2</sup> Ustawa z 29 maja 1969r. o zmianie niektórych przepisów prawa karnego, prawa o wykroczeniach oraz innych ustaw (Dz U nr 34, poz. 180)

Эрүүгийн хууль, захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай 1969 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хууль

<sup>3</sup> Dz U nr.34, poz.149. W Daszkiewicz, Problem rehabilitacji i odszkodowania za bezprawne represje karne. PiP, 1990, nr.2, s.16

<sup>4</sup> В. Дашкевич. Эрүүгийг байцаан шийтгэх ажиллагаан дахь хууль бус ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирол арилгах болон нөхөн сэргээх ажиллагааны хэмжээний тухай асуудал. "Прокурор болон хууль ес" сэтгүүлийн 1990/2, 2 дахь тал.

<sup>5</sup> <http://www.lublin.sa.gov.pl/26/213/>

цогцоор нь авч үзэх шаардлагатай. Тухайлбал, сэтгэл санааны зовиур, шаналалын хэмжээ, шаналалын үргэлжилсэн хугацаа, хэвийн байдлаа алдсан шинж төлөв гэх зэрэг.

Ийнхүү хуулийн зохицуулалтын дагуу Иргэний шүүх тухайн асуудлыг хянан шийдвэрлэдэг байна. Гэвч хууль зүйн үндэслэлээ хангалттай зааж өгдөггүйгээс шалтгаалан сэтгэл санааны хохиролын нөхөн төлбөрийн шийдвэрлэлт хангалтгүй байна.

Сүүлийн үед Польш Улсад энэ төрлийн иргэний нэхэмжлэлийн асуудал эрчимтэй өсч байгаатай холбогдуулан сэтгэл санааны хохирол нөхөн арилгуулах нэхэмжлэл ихээхэн ач холбогдол өгч байна.

Польш Улсын хуульд дараахь үндэслэлээр өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр зааж өгсөн байна. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийдвэрээр ял ногдуулсан бөгөөд тухайн ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан, мөн ялыг хөнгөн ялаар сольсон бөгөөд тийнхүү эдлэх ёсгүй байсан ялыг бүхэлд нь буюу хэсэгчлэн эдлэсний улмаас өөрт учирсан эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлыг Төрийн сангаас нөхөн төлүүлэх эрхтэй. (ЭХХШХ-ийн 552.1);

2. Тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү хорих ял шийтгүүлсэн этгээд хохирлоо нөхөн төлүүлэхээр тусгасан. (ЭХХШХ 552.2)

3. Албадлагын арга хэмжээ оногдуулсан тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлнэ. (ЭХХШХ-ийн 552.3);

Тус улсын ЭХХШХ-ийн зохицуулалтаас харахад, тухайн хохирогч эдлэх ёсгүй байсан ялыг бүхэлд нь буюу хэсэгчлэн эдлэсэн

тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй. Ингэхдээ "материаллаг" болон "материаллаг бус" хохирол нөхөн төлүүлэхээр заасан байна. Материаллаг хохирлыг дараахь хэлбэрээр ойлгоно, Үүнд: *Damnum emergens* буюу хохирлын улмаас үүссэн гарз хохирол, *lucrum cessans* буюу хохирол амсаагүй тохиолдолд олж болох байсан ашиг орлого. Түүнчлэн бие, эрүүл мэндэд учруулсан гэмтлээс үүссэн бие махбодийн хохирол байж болно. Энэ тохиолдолд, хохирлын нөхөн төлбөрт гэмтлийн улмаас үүссэн бүх төрлийн зардал багтана. Тухайлбал, эмчилгээний зардал, мөн эмчилгээ хийлгэх хугацаанд алдагдсан ажлын хөлс зэрэг багтана. Харин "материаллаг бус хохирол"-д юуны түрүүнд хууль бусаар баривчлагдсан болон цагдан хоригдсоны улмаас учирсан (*психические страдания*) сэтгэл санааны хохирол орно. Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон болон ял эдлэх явцад хувь хүнийхээ хувьд дордсон мэт мэдрэмж төрөх, нэр төрөө алдах, мөн бие махбодийн хувьд шаналах (физические страдания) зэрэг хэлбэрээр илэрч болно.

Хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэл гаргах үйл явц нь хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон болон ял эдэлсэн ажиллагааны үргэлжилсэн процесс мэтээр тайлбарлаж болохгүй. Учир нь энэхүү процедур нь *иргэний журмаар* хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар нэхэмжлэл гарган шийдвэрлүүлнэ.

Ихээхэн чухал бөгөөд маргаантай асуудлын нэг бол яах аргагүй хууль бусаар цагдан хорих, баривчлах зэрэг үйл явцыг дүнгэх асуудал билээ. Польш улсын Дээд шүүхийн тайлбарт, "... шүүхээс хууль бусаар, үндэслэлгүйгээр баривчилах, цагдан хорих тухай

дүгнэлтийг хийхдээ тухайн хууль бус байцаан шийтгэх арга хэмжээг авах тухай шийдвэр гаргах мөчөөс эхлэн энэ арга хэмжээг хэрэгсэхгүй болгосон тухай шийдвэр гаргах хүртэл асуудлыг цогцоор нь, бодитой авч үзэх шаардлагатай" гэсэн байна.<sup>5</sup> Илт хууль бус байцаан шийтгэх арга хэмжээ гэдэг нь энэхүү ажиллагааг явуулж буй эрх бүхий байгууллагаас тухайн хэргийг явуулахад хангалттай хууль зүйн үндэслэл байхгүйг мэдсэн хэрнээ тус албадлагын арга хэмжээг авах тухай шийдвэрээ хэвээр үлдээсэн тохиолдлыг хэлнэ хэмээн Дээд шүүх тайлбарлажээ.<sup>6</sup> Польш улсын судлаачдын дунд энэхүү асуудал маргаантай байдаг бөгөөд хууль тогтоомжид ч бүрэн дүүрэн зохицуулагдаагүй үлдсэн байна.

Хохирол нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдийн хувьд тус улсын ЭХХШХ-ийн дагуу хууль бусаар ял шийтгүүлсэн, цагдан хоригдсон, баривчлагдсан иргэнийг хэлнэ. (ЭХХШХ-ийн 552). Энэ нь шүүхийн эцсийн шийдвэрээр ял шийтгүүлсэн этгээд буюу "яллагдагч"-ийг хэлнэ. Тухайн ял шийтгүүлсэн хохирогч нас барсан тохиолдолд зөвхөн материаллаг хохирол нь өв залгамжлагчид олгогдоно.

Хохирол нөхөн арилгуулах тухай өргөдлөө гаргах хугацааны хувьд хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон нь нотлогдож хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай шүүхийн тогтоол гарсанаас хойш 1 жилийн дотор гаргах эрхтэй бөгөөд ингэхдээ, цагдан хоригдсон тохиолдолд, шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож эхлэнэ. Баривчлагдсан тохиолдолд суллагдсан өдрөөс эхлэн эрхээ сэргээлгэх хөөн хэлэлцэх хугацаа тоологдож эхлэхээр зааж өгдөг. (ЭХХШХ-ийн 555)

Иргэний эрх зүйн хуулийн 445.2-т мөн хууль бусаар эрх чөлөөг нь

<sup>5</sup> Postanowienie skladu siedmiu sędziów SN (V KRN 411/86), OSPIKA, nr 4 z czesciowo krytyczna glosa M.Mozgawy I.L. Nowikowskiego. 7 шүүгчдийн бүрэлдэхүүнтэй шүүх хурлаас гарсан шийдвэр дээд М.Мозгав болон Л.Новиковскийн хэлсэн шүүмж.

<sup>6</sup> Uchwała SN z 15 czerwca 1985 r. (KZP 14/85) OSPIKA 1986, nr 2, poz.32. 1985 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Дээд шүүхийн тогтоол.

хязгаарлах хууль бус ажиллагааны улмаас үүсэх хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан. Польш улсын Дээд шүүхээс хууль бусаар хорих гэдэгт тухайн иргэний хүсэл зоригийг үл харгалзан сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх нь хууль бус ажиллагаа мөн бөгөөд түүний улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй<sup>7</sup> гэж зааж өгсөн<sup>8</sup>. Мөн түүнчлэн сэтгэцийн эмнэлэгт хэвтэж байгаа өвчний биеийн байдал сайжраагүй байхад эмнэлгээс гаргах явдлыг мөн адил авч үзнэ гэжээ. Хохирлын хэмжээг тогтооходоо, ямар хугацаанд, ямар шалтгааны улмаас хоригдоо болсон зэргийг авч үзэх шаардлагатай.

**Жишээ:** Польш Улсын нэгэн иргэн хууль бусаар эрүүлжүүлэх газар 6 цагийн турш цагдан хоригдсон байна. Тус иргэн Польш Улсын шүүхэд хандсан боловч өргөдлийг нь буцаасан. Харин Штрасбургийн Хүний эрхийн Шүүхэд 600.000 ам. долларын хэмжээний нэхэмжлэл гаргахад тус шүүхээс 2.000 ам. долларын хохирол гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Өөр нэгэн жишээнд, Ромын Пап Жон Пол II Польш улсад айлчлах үеэр, тус улсын иргэн баярын жагсаалд оролцож байхад нь цагдаагийнхан ямар ч учир шалтгаангүйгээр 2 цагийн турш баривчилж саатуулсан байна. Энэ нь тус улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан халдашгүй, чөлөөтэй байх эрхийг нь ноцтой зөрчсөн гэж үзээд шүүхэд хандсан байх жишээтэй.

#### Дүгнэлт

Польш Улсад бусдын хууль бус ажиллагааны улмаас иргэнд учирсан материаллаг болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх асуудлыг шүүхийн харьяалалд шилжүүлсэн бөгөөд сэтгэл санааны хохирлыг арилгуулах тухай нөхөн төлбөрийн хэмжээ тогтоох нарийвчилсан аргачлал байхгүй боловч, түүний шалгуур үзүүлэлтүүдийг Улсын Дээд шүүхээс нарийвчлан авч үздэг байна.

Тухайлбал, бие махбодийн болон сэтгэл санааны шаналалын түвшин болон түүний үргэлжлэх хугацаа (Үүнд, эмчлүүлсэн байдал, нөхөн сэргээх эмчилгээ, мэс засал хийлгэсэн эсэх зэрэг эмчилгээний явц), эрүүдэн шүүлтийн хэлбэрийн нөхцөл байдлын улмаас үүссэн урт хугацааны шаналал, зовиур (аливаа бие махбодь, сэтгэл санааны чадвар, чадамжаа алдах, бие махбодид өөрчлөлт гарах, цөхрөх, гансрах, гутралд орох) аах гадна шууд бусаар нөлөөлөх хүчин зүйлс болох ирээдүйд гаргах амжилт, бүтээл буурах, мөн насны онцлог, сэтгэл санааны таашаал өгөх ажил, спорт, хүсэл сонирхлын дагуу бүтээл туурвих, гэр бүл, үр хүүхэдтэй болох зэрэг чадвар, чадамжаа алдах, аялал жуулчлалд явах, спорт болон урлагийн арга хэмжээнд оролцох, найз нөхөдтэйгээ зугаацах зэрэг нийгмийн идэвхи, оролцоо, амьдралын хэмнэл алдагдах г.м.<sup>9</sup> тухайн хохирогчийн хохирлод нөлөөлж болохуйц амьдралын бүх хүрээг хамруулан авч үздэг байна.

Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, ял шийтгүүлсэний улмаас иргэнд учирсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг дээрх шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд авч үзэхдээ, хэргийг тус бүрт нь авч шийдвэрлэдэг байна. Учир нь хүн бүрийн сэтгэл санааны байдал, аливаа бэрхшээл саадыг даван туулах чадвар нь тухайн хүний онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байдагтай холбоотойгоор хэрэг тус бүр дээр өөр өөр өнцгөөс харахыг шаарддаг байна.

Эдгээр онцлогоос гадна тухайн хохиролын хэмжээг тогтооходоо энэ хэмжээ нь бэлгэ тэмдгийн чанартай бус, гэхдээ хохирлын хэмжээтэй харьцуулахад хэт өндөр биш, үндэслэлийг тодорхой гаргаж өгсөн, нийгмийн амьдралын баталгаажих дундаж түвшинд нийцэхүйц байвал зохиистой<sup>10</sup> гэсэн Польш Улсын Дээд шүүхийн шийдвэр оновчтой байна. Түүнээс гадна тухайн нэхэмжлэгч

болон хариуцагч хоёрын амьжиргааны баталгаат түвшин, цалин хөлсний орлого зэргийг харьцуулан авч үздэг нь тухайн асуудлыг бодитой шийдвэрлэх үндэслэл болж байна.

Польш Улс нь иргэний, ардчилсан нээлттэй нийгмийг цогцлон байгуулсныхаа хувьд өөрийн улсын иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг төрийн зүгээс ихээхэн дээгүүр авч үздэг байна. Энэ нь нэг талаасаа тухайн хохирогчийн сэтгэл зүй, сэтгэцэд нөлөөлсөн хүчин зүйлийг нарийн шалгуураар авч үзэхдээ нийгмийн шударга ёсны зарчим, амьжиргааны баталгаат түвшин болон эдийн засгийн нөхцөл байдалтай нь уялдуулан бодитой хэмжээг тогтоож өгөхийг эрмэлздэг. Нөгөө талаасаа тухайн улсын төрийн төсвийн бодит байдал мөн тулгуурлагдаж хэмээн дүгнэлт хийж болохоор байна.

Иймээс Польш Улсын хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ тогтоох аргачлалын дээрхи хувилбарыг цаашид илүү гүнзгийрүүлэн судлан үзэж, үндэсний хууль тогтоомжид тусгах боломжит хувилбарыг боловсруулах хэрэгтэй юм.

Польш Улс 2005 онд Европын холбоонд гишүүн улс болон нэгдэхээс өмнө манай улстай адил пост-коммунист улсын тогтолцоонд тулгуурлан социалит эрх зүйн чиг баримжаатайгаар хууль тогтоомжоо боловсруулан гаргадаг байв. Тус улс нь Европын холбоонд элсэн орсон цагаас эхлэн Европын хууль тогтоомжийн стандартыг дотоодын хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байгаа улсуудын нэг билээ. Иймээс цаашид Европын Холбоонд нэгдэн орсон пост-коммунист улсуудын хууль тогтоомжийн хөгжилт болон сайн туршлагыг судлах хэрэгтэй.

<sup>7</sup> Judgment of 15 11 1976, /1981/ OSpIKA, 26

<sup>8</sup> European tort law, Helmut Koziol, Barbara C. Steininger /eds./, p. 176

<sup>9</sup> SN of 24.6.1965, /1966/ OSpIKA, 92

## Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин



**Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд**

Монгол Улсад гарч буй насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийн сэдэлт, арга нь улам бүр харгис хэрцгий болж, хүүхэд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртөж, гэмт хэргийн улмаас сэтгэл санаа, бие махбодь, эд материалын хохирол хүлээсээр байна. Практикт гэмт хэргийн улмаас тэр тусмаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн улмаас хохирсон хүүхдийн эрх ашгийг хамгаалах хууль зүйн боломж байсаар атал түүнийг анзаарахгүй орхигдуулж, гэмт этгээдүүдэд ял завших боломж олгон, хуулиар хориглоогүй бусад арга хэмжээг авахгүй байна. Энэхүү өгүүллээрээ бид гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн эх сурвалжуудад дүн шинжилгээ хийн, тэдгээрийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг гарган ирж, тодорхой шийдлүүдийг санал болгох юм.

*Бэлгийн мөлжлөгийн тодорхойлолт, ойлголт*  
Олон Улсын хэм хэмжээ

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенци<sup>1</sup> нь түүнийг соёрхон баталж буй гишүүн орнуудаас хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл үүнийг санал болгохыг (Заалт 3 (б)) хориглох болон арилгах үр дүнтэй арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлэхийг шаарджээ.

ОУХБ-ын 182-р конвенцийн 3 дугаар зүйл:

- Боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглахын тулд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаанууд;

- Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самуун сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл үүнийг санал болгох;

- Мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэхүйц ажил.

Мөлжлөгийн эдгээр тухайлсан тодорхойлолтууд нь уг конвенцийг хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих хамгийн хүчирхэг хэрэгсэл болж байгаа юм.

### Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц

Энэхүү олон талт арга хэрэгсэл нь оролцогч улсуудаас хүүхэд нь эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах болон түүний эрүүл мэндэд хохирол учруулах буюу боловсрол олоход нь саад болох,

эсвэл түүний эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны болон нийгмийн хөгжилд нь хор уршиг учруулж болзошгүй ямарваа нэгэн ажил эрхлэхээс сэргийлүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрөх (1) мөн хүүхдийг бэлэгсийн хууль бус аливаа ажиллагаанд ятгаж юмуу албадаж татан оролцуулах явдал болон хүүхдийг мөлжлөгийн зорилгоор биеэ худалдах, садар самууны зүйл, садар самуун явдлыг дүрсэлсэн материал болон бэлэгсийн хууль бус бусад хэрэгт ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талын, олон талын бүхий л тохирох арга хэмжээг авахыг (2) шаарддаг байна.

### Хүүхэд худалдах, биеийг нь үнэлэх болон хүүхдийг садар самуунд ашиглах тухай Хүүхдийн эрхийн конвенцид оруулсан нэмэлт протокол

Энэхүү протокол нь оролцогч улсуудыг арилжааны бэлгийн мөлжлөгт өртөх магадлал ихтэй хүүхдүүдийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, хохирогч-аврагдагсад зохих ёсны бүх тусламж, үүний дотор тэднийг нийгэмд бүрэн татан оруулах болон бие махбодийн хийгээд сэтгэл зүйн хувьд бүрэн нөхөн сэргээснийг баталгаажуулах бүх боломжит арга хэмжээг авахыг шаарддаг.

Үндэстэн дамнанас зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенц-ын нэмэлт болох "хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба ял шийтгэх тухай" 2000 оны Протоколын 3 дугаар зүйлийн "а" хэсэгт хүн худалдаалах гэж "бусдыг мөлжих зорилгоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, загилах, хууран

<sup>1</sup> ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенц, 1999 он (№182)

мэглэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр этгээдийг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх, ашиг олгон хахуульдах замаар хүнийг элсүүлэх, зөөх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээн авах"-ыг ойлгоно гэжээ.

"Sexual exploitation" буюу "бэлгийн мөлжлөг" хэмээх ойлголт нь наад зах нь бусдын биеийг үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрийг хэлнэ" гэснээс үзвэл хүчирхийллийн шинжтэй аливаа үйлдэл хамаарахааргүй байна. Харин үүнийг "rape" буюу "хүчиндэх" гэсэн утгаар тусад нь ойлгож хэрэглэж байна. Үүнээс гадна "abuse" хэмээх ойлголтыг нь "доромжлон харьцах" хэмээн ойлгож болохоор байгаа бөгөөд ихэвчлэн насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэгддэг гэмт хэрэгт хэрэглэгддэг нэр төмөө юм.

ОУХБ-аас арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгийг хүүхэд болон өсвөр насныхны эрхийг ноцтой зөрчиж байгаа явдал бөгөөд боолын болон албадан хөдөлмөртэй адил эдийн засгийн мөлжлөгийн хэлбэр ба энэ нь охид, хөвгүүд болон өсвөр насныхныг сексийн арилжаанд ашигладаг хүмүүсийн зүгээс үйлдэж буй гэмт хэрэг хэмээн үздэг.

Арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөг:

- Гудамжинд болон янхны газар, диско клуб, массаж, баар, зочид буудал, зоогийн газар гэх мэт газар охид хөвгүүдийг бэлгийн үйл ажиллагаанд (тогтсон хэллэгээр бол хүүхдийг биеэ үнэлэх явдалд) мөнгөн болон мөнгөн бус урамшуулал хэлбэрээр ашиглах, уруу татах;

- Бэлгийн арилжааны зорилгоор охид, хөвгүүд болон өсвөр насныхныг худалдаалах;

- Секс жуулчлалд хүүхдийг татан оролцуулах;

- Хүүхдийг порнографд татан оролцуулах;

- Хүүхдийг секс үзүүлбэрт ашиглах (олон нийтийн болон хувийн) зэргийг багтаадаг (Child sexual abuse).

Үүний нэг адилаар Стокгольмын тунхаг<sup>2</sup> арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгийг "албадан хөдөлмөр болон боолчлолын орчин үеийн хэлбэр болж өргөжсөн хүүхдийн эсрэг албадлага, хүчирхийллийн хэлбэр юм" гэж тодорхойлжээ.

#### Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ:

Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүүхдийн биеийг бусдад төлбөртэй үнэлүүлж мөлжих нь "хөнгөн" гэмт хэрэгт тооцогдож байна.

Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд судлан үзвэл хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй арилжааны шинжтэй бэлгийн мөлжлөгийг үндсэндээ Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1. "Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулах" гэсэн зүйл, заалтаар зохицуулж байна. Эндээс үзвэл хүүхдийн биеийг үнэлүүлсэн этгээд насанд хүрсэн хүний биеийг үнэлүүлснээс хөнгөн ял шийтгэгдэхээр хуульчилсан ба хүүхдийн биеийг бусдад төлбөртэй үнэлүүлж мөлжих нь "хөнгөн" гэмт хэрэгт тооцогдож байгаа нь тод харагдана. Энэ нь хүүхдийн эрхийг хэт дорд үзсэнээс гадна Эрүүгийн хуулийн "гэм буруутай этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон хариуцлага хүлээлгэх" зарчимтай нийцэхгүй байна.

Монгол Улсын Дээд шүүхээс: "124 дүгээр зүйлийн 124.1-д заасан "биеэ үнэлэхэд татан оролцуулсан" гэж шунахай болон хувийн бусад сэдэлтээр хохирогчийг бусдадтай

бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ". гээд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан "биеэ үнэлэхэд татан оруулсан" гэдгийг дээрхтэй нэгэн адилаар ойлгож, хэрэглэнэ" гэж тайлбарлажээ.

"Насанд хүрээгүй биеэ үнэлэгч" гэсэн ойлголт байхгүй бөгөөд насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулсан тохиолдол бүрийн цаана хүүхэд хэн нэгэн этгээдийн эрхшээлд байдаг шинжийг хууль тогтоогч орхиуулуулснаас гэмт этгээдүүдэд ял завших, энэ төрлийн гэмт хэргийг өвгүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Хууль тогтоогч ямар шаардлагын улмаас насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулж мөлжих үйлдлийг "биеэ үнэлэхэд татан оролцуулах" гэж үзэх болсон, яагаад хөнгөн гэмт хэрэгт тооцсон, ямар шалтгааны улмаас Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон авч үзсэн нь тодорхойгүй байна. Харин Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу "Хүн худалдаалах" гэмт хэргийн бүрэлдэхүүний хүндүүлэх бүрэлдэхүүнд шууд хамаарч байна. Иймд хуулийн дээрх хэм хэмжээг өөрчилж Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн хүндүүлэх бүрэлдэхүүн болгон зүйлчлэх нь зохимжтой гэж үзэв.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах зохицуулалт байхгүй байна: Насанд хүрээгүй хохирогчийн хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 269 дүгээр зүйлийн 2-т "насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсохдоо түүний эцэг эх, хууль ёсны төлөөлөгч, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж болох, тэдгээр нь шүүх хуралдаанд даргаллагчийн зөвшөөрөлтэйгээр гэрчид асуулт

<sup>2</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг хуулийн байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага". Палермогийн конвенцийн нэмэлт протокол 3 дугаар зүйл /a/

<sup>3</sup> Стокгольмын тунхаг ба үйл ажиллагааны хөтөлбөр (1996): Энэхүү баримт бичгийг Арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг Дэлхийн чуулга уулзалт дээр баталсан бөгөөд энэ нь оролцогч бүх орнуудыг дээрх асуудал анхаарал хандуулахын тулд Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулахыг үүрэг болгосон байна. Мөн үндэсний хөтөлбөрүүдийн дэвшил, хэрэгжилтийг янхаж механизм байна гэжээ

гавьж болно", мөн зүйлийн 3-т "хэргийн бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой бол шүүхийн тогтоол, шүүхийн захирамжаар шүүгдэгчийг хуралдааны танхимаас гаргасны дараа насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсож, улмаар түүнийг танхимд орж ирсний дараа гэрч, хохирогчийн мэдүүлгийг танилцуулж, түүнд гэрч, хохирогчид асуулт тавих боломж олгоно", мөн зүйлийн 4-т "насанд хүрээгүй гэрч, хохирогчийг цаашид байлгах шаардлагагүй бол түүний мэдүүлгийг сонссоны дараа шүүх хуралдааны танхимаас гаргана" гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн "Насанд хүрээгүй хохирогчийг байцаах" 148 дугаар зүйлийн 1-д насанд хүрээгүй хохирогчийг энэ хуулийн 145 дугаар зүйлд заасан журмын дагуу буюу насанд хүрээгүй гэрчийг байцаахдаа түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгаж байхаар заасан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд "хохирогч" гэдгийг тодорхойлохдоо "гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ" гэсэн боловч "хохирогч хүүхэд" гэж тусгайлан заагаагүй байна.

Мөн хохирогчийн эрхийг өмгөөлөгч авах, нотлох баримтыг шалгуулах хүсэлт гаргах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, 42.3.10-д цагаатгах болон шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын шатны журмаар голмол гаргах эрхтэй болохыг заасан байна.

Харин хохирогч хүүхэд бие махбодь, сэтгэл санааны хувьд бүрмөсөн эдгэрэх, нийгэмшихэд хэрэгцээтэй зохих тусламжийг авах тухай болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах талаар тусгайлсан заалт байхгүй байна.

**Монгол Улсын хэмжээнд хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нөхцөл байдал**

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг хамгаалах хууль, эрх зүйн орчинд зарим дэвшил үзэгдэж байгаа боловч энэ төрлийн гэмт хэрэг нугдамал байдгаас шалтгаалж хуулийн байгууллагуудаар шийдвэрлэгдэж байгаа нь цөөн байна. Судалгааны дүнгээс үзэхэд Улаанбаатар хот болон хилийн боомтын хот, суурингуудад хүүхдийн бэлгийн мөлжлөг нэмэгдэж, орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг илрэхгүй байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын нэлээд нь гэр бүл дэх хүчирхийлэл, зөрчилдөөний улмаас орон гэрээсээ дайжсан хүүхдүүд байдаг. 2008 оны ХЭҮК-ийн тайлангаас үзэхэд олон жил тэнэмэл амьдарлаар айл, халамжийн төв дамжин амьдардаг, хөдөө орон нутгаас нийслэлд нүүж суурьшсан, ядуу өрхийн сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй гэр бүлийн охидууд бэлгийн мөлжлөгт илүү ихээр өртөж байна.<sup>4</sup>

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглагчдын ихэнх нь зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гудамжинд амьдрагчид, үе тэнгийн хөвгүүд, архинд донтогчид байгаа нь сэтгэл түгшээж байна.<sup>5</sup> Өсвөр насны охидын дунд бусдыгаа бэлгийн мөлжлөгт зуучлах, уруу татах явдал цөөнгүй байгаа төдийгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, таслан

зогсоох, урьдчилан сэргийлэх талаар явуулж буй төрийн бодлого, үйл ажиллагаа хангалтгүй байна.<sup>6</sup>

Энэ төрлийн гэмт хэргийн үйлдэгдэж буй хэлбэрийг үзэхэд:

- Бэлгийн мөлжлөгт өртүүлэх;
- Хүчиндэх;
- Садар самуунд уруу татах;
- Бэлгийн дур хүслээ ёс буусаар хангах;

• 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх;

• Хүн худалдаалах зэрэг хэлбэртэй байна.

ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний төвөөс гаргасан сүүлийн 4 жилийн статистик үзүүлэлтийг үзвэл:<sup>7</sup>

2006 онд Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 2005 оноос 10 хувиар буурсан байна.

2007 онд Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг өмнөх оныхоос 12.0 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 19931 иргэн хохирсоны 5.8 хувь нь насанд хүрээгүй хүн байна.

2008 онд Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2.1 хувийг эзэлж байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр авч үзвэл: хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 10.9 хувиар өсчээ.

• 2009 онд Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 375 гэрч бүртгэгдсэн, урд оныхоос 12 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 19545 хүн хохирсны 5.3 хувь нь хүүхэд байна.

Үүнээс үзэхэд хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг тогтмол гарч бүртгэгддэг боловч энэ төрлийн гэмт хэрэг буурах хандлагатай байгаа зэрэг үзүүлэлт байна. Гол нь илэрсэн нэг хэргийн цаана илрээгүй хэдэн хэрэг байгаа нь тодорхойгүй байдаг.

<sup>4</sup> ХЭҮК-ийн тайлан. 2008 он 46 дахь тал.

<sup>5</sup> ХЭҮК-ийн тайлан. 2008 он 46 дахь тал.

<sup>6</sup> Хүн амын сургалт, судалгааны төв. 2005он. ОУХБ/АИПЕК-ийн санхүүжилтээр хийгдсэн.

<sup>7</sup> ЦЕГ-аас жил бүр гаргадаг гэмт хэргийн мэдэээнэс.



Ялангуяа насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлддэг гэмт хэргийн илрүүлэлт бага байдаг гэдгийг мартаж болохгүй юм. Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн хэрэгжилт тааруу байна. Мөрдөн байцаагчидтай хийсэн бүлгийн ярилцлагын судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг цөөн тоотой гарч бүртгэгддэг, ихэвчлэн нууцдалд байдалд байдаг байна.<sup>8</sup>

Хуулийн хэрэгжилт дутмаг шалтгааныг судлан үзэхэд хуулийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл ирдэггүй, ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүсийн өмнөөс өргөдөл гомдол гаргах субъект байдаггүй аж.<sup>9</sup> Иймээс гагцхүү гэмт хэргийн тоон үзүүлэлт бус бусад эх сурвалжид дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулж хохирогчид ээлтэй өмгөөллийн хувилбар, тактикийг боловсруулах нь зайлшгүй хэрэгцээтэй байна гэж үзэв.

Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал: Монгол Улсад 2002-2009 онд шүүхээр шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болгосон ЭХ-ийн 113 дугаар зүйл, 124 зүйлд заасан эрүүгийн хавтаст хэргийн судалгаанаас үзэхэд ЭХ-ийн 113 дугаар зүйл, ЭХ-ийн 124 дүгээр зүйлийг нэг мөр ойлгон хэрэглэх талаар онол-арга зүйн зөвлөмж гаргах, урьд шийдэгдсэн эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн байгууллагын ажилтнуудад сургалт явуулах шаардлагатай байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн "...Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар бус үнэлэхэд татан оролцуулсан..." гэдэг хэсгийн

агуулгыг өөрчлөх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл энэ нь ЭХ-ийн тухайн заалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд томъёоллын хувьд эргэлзээ, маргаан үүсгэх нэг хүчин зүйл болж байгаа юм.<sup>10</sup>

2002-2008 онд хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах талаар хийсэн судалгаанаас үзэхэд энэ таван жилд эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 4 хэрэгт 4 хүн ял шийтгүүлсэн бол 124 дүгээр зүйлээр 32 хэрэгт 53 хүн ял шийтгүүлсэн байна. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 2006 онд-1 хэрэгт 1 хүн, 2007 онд-1 хэрэгт 1 хүн, харин 2008 онд-2 хэрэгт 2 хүн, 2009 онд гарсаар 4 хэрэгт 7 хүн, 2009 оны 12 сарын байдлаар 1 хэрэг (5 холбогдогчтой) шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр 2005 онд-2 хэрэгт 5 хүн, 2006 онд-2 хэрэгт 1 хүн, 2007 онд-8 хэрэг 8 хүн ял шийтгүүлсэн бол 2008 онд 20 хэрэгт-39 хүн ял шийтгүүлжээ.<sup>11</sup>

Гэтэл ЦЕГ-ын МДШТ-ийн мэдээгээр 2007 онд хүн худалдаалах гэмт хэрэг огт бүртгэгдээгүй бол 2008 онд 9 хэрэг бүртгэгджээ. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2007 онд огт бүртгэгдээгүй бол 2008 онд 27 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Статистик үзүүлэлт:

Судалгаанаас харахад 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг ял шийтгүүлэгчдийн 65 хувь нь эмэгтэчүүд, нийт ял шийтгүүлсэн 37 ялтны насны байдлыг судлахад 19-30 насны 9, 31-35 насны 18, 36-аас дээш настай хүн 18 байна. Боловсролын хувьд дээд мэргэжилтэй 8, тусгай дунд 4, бүрэн дунд 16, суурь боловсролтой 7, бага боловсролтой 2 байна. Нийт ажил

сургуульгүй хүн 19, гадаадын иргэн 3 хүн байна.

Нийслэлийн цагдаагийн газрын олон нийттэй харилцах хэлтсээс гаргасан мэдээгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд буюу нэгдсэн арга хэмжээгээр биеэ үнэлдэг нь тогтоогдсон, хүүхдийн байцаагчийн хяналтанд байдаг насанд хүрээгүй охидын тоо 2005 онд 93, 2006 онд 156, 2007 оны эхний 9 сарын байдлаар 127 гэж гарсан байна. Эрүүгийн цагдаагийн газраас гаргасан мэдээгээр улсын хэмжээнд биеэ үнэлсэн гэсэн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүүхдүүд 2005 онд 380, 2006 онд 412, 2007 онд 426 (давхардсан тоогоор) болж өссөн байна.

Шүүхийн практикт: Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үндсэн нь зөв зүйлчилж байгаа боловч насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэн авч явж, зодож хүчээр биеийг нь үнэлүүлсэн үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгээр зүйлчлэхгүй, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл "Биеэ үнэлэхэд татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэсэн хөнгөн зүйлээр зүйлчилж, ноцтой гэмт хэрэгтнийг ял завшуулж байгаа буруу хандлага байгааг таслан зогсоох шаардлагатай юм. Үүнд биеэ үнэлж байгаа этгээдийн хүсэл зориг, үйлдэлдээ хандах харьцааг буруу илэрхийлсэн мэт санагддаг. Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх арга хэлбэр нь өөрөө хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэх нэг хэлбэр гэж үзвэл зохино.

2009 онд Улсын дээд шүүхээс Хүн худалдаалах гэмт хэргийн талаар албан ёсны тайлбар гарч, төрийн болон төрийн бус байгууллагуудаас тодорхой

<sup>8</sup> Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны тайлангаас. ХЗХУ. ЭЗЗКС. 2009 он.

<sup>9</sup> Төслийн хүрээнд УИМБГ-тай хамтран зохион байгуулсан 15 мөрдөн байцаагчтай хийсэн ярилцлагын судалгаанаас. ХЗХУ. 2009 оны 11дугаар сарын 12-ны өдөр.

<sup>10</sup> "Хүн худалдах гэмт хэргийн шийдвэрлэлт" судалгааны тайлангаас, ХТЭТ, 2009 он.

<sup>11</sup> УДШ-ийн Судалгааны төвөөс хийсэн судалгаанаас. 2009 он.

давтамжтай сургалт, сурталчилгаа явуулснаар дээрх гэмт хэргийн шийдвэрлэлт харьцангуй сайжирчээ. Хэдий тийм ч зарим гэмт этгээдэд захиргааны арга хэмжээ авах, торгох төдийгөөр ял завшуулж, өөгшүүлж байгаа нь хууль тогтоомжийн давхардалтай холбоотойгоос гадна хуулийн байгууллагын санаачлага бүхий үйл ажиллагаа дутсантай холбоотой байна.

Ялангуяа "Хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг" үйлдэгдсэн шалтгаан, нөхцөлийг тогтооходоо "байнга дурдагддаг" нийтлэг нөхцөл байдал болох ажилгүйдэл, ядуурал, нийгмийн байдал гэх мэт "тодорхой бус" хүчин зүйлийг дурдахаас татгалзсан бодлого барьж ажиллах хэрэгтэйг судалгааны олон дүгнэлт, санал харуулж байна.

### БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХОЛБООТой КЕЙСТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн 20 хэргийг<sup>12</sup> сонгон авч, тэдгээрийг шийдвэрлэх явцад гарч байгаа бэрхшээл, хуулийн байгууллагуудын практикт анализ хийж үзэхэд дараахь нөхцөл байдал тогтоогдох байна.

Тогтмол бэлгийн мөлжлөгт өртүүлсэн үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байсан ч хүчирхийлсэн этгээдийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгосон байна.

Сонгогдсон кейсүүдийн нэг нь тогтмол бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байсан ч хохирогчийг худлаа ярьж байна хэмээн буруутган "биеэ үнэлэгч", "өөрөө буруутай" гэсэн нүдээр харж, хүчирхийлсэн этгээдийг торгоод өнгөрөөжээ.

Кейс шийдэгдээгүй явдалд цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж, хороонд ажиллаж байгаа хэсгийн байцаагч нарт энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх, шалгах эрмэлзэл бага, алба хаагчаас тодорхой үр чадвар шаарддаг учир шалгах аас зайлсхийж, ажлаа хялбарчлахын тулд Захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэсэн нь нөлөөлжээ.

Хохирогчийн болон түүний эргэрийн зүгээс сэжигтэн этгээдүүдийн нөлөөнд орж хувиараа тохиролцон, цагдаагийн байгууллагад шалгуулахгүй, "гомдолгүй" хэмээн тухайн асуудлыг өөрсдөө дур мэдэн шийдвэрлэдэг явдал байсаар байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд тулгарч байгаа асуудлууд: Ураг төрлийн хүчингийн гэмт хэрэг хожуу илэрдгээс шалтгаалж, мөрдөн байцаалтын шатанд нотлоход хүндрэл бэрхшээл үүсдэг, мөрдөн байцаагчаас тодорхой үр чадвар шаардагддаг нь ажиглагдав. Өөрөөр хэлбэл, зөвхөн мэдүүлсэн нотлох баримт буюу хохирогч, гэрчийн мэдүүлэгт тулгуурлан хэргийг шийдвэрлэдэгтэй холбоотойгоор хохирогчид хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого их гардаг, үүнээс шалтгаалж насанд хүрээгүй хохирогч айж залхах, улмаар мэдүүлгээсээ буцах, мөрдөн байцаалтын шатанд хэргийн шийдвэрлэлт удаашрах зэрэг байдал гарч байлаа.

Тухайлсан кейсээс үзэхэд холбогдогчийн талын эгч, дүү нар нь мэдүүлгээ өөрчилж өгөхийг шаардах, шан харамж амлах, заналхийлэх, хуурч мэхлэх үйлдлийг байнга гаргаж байсан ноцтой баримтууд илэрсэн. Үүний гол шалтгаан нь хүчирхийлэгч нь хохирогчтой ойрын хамаатан, садан төрөл, танил талын холбоотой, хохирогч ямар нэг байдлаар хүчирхийлэгчийн эрхшээлд байдагас шууд шалтгаалж байна.

Болзооны хүчингийн гэмт хэргийн хувьд хохирогчийг буруутгах хандлага, хохирогч болзоонд очсоноороо бэлгийн харьцаанд орохыг "зөвшөөрсөн" гэсэн ойлголт цагдаагийн байгууллагын ажилтнуудын дунд байсаар байна.

"Ураг төрлийн хүчин", "болзооны хүчин", "тохиолдлын буюу гудамжны хүчин" хэмээн төрөлжүүлэн сонгон авсан кейсүүдийн талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч шүүгч, прокурор нар үзэхдээ: "Хүчингийн гэмт хэрэг бол хүчингийн гэмт хэрэг. Дээр дурдсанаар хүчиндэх гэмт хэргийг ангилж байгаа нь хууль зүйн ямарваа нэгэн үр дагавар үүсгэхгүй юм. Насанд хүрээгүй хүмүүсийг хүчиндсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульд тусгайлан зааж өгсөн учир "бэлгийн мөлжлөг" гэсэн ойлголтонд хамаарахгүй, харин удаан хугацааны туршид хүчиндэж, бэлгийн хүчирхийлэлд өртүүлж байсан тохиолдолд эрүүгийн эрх зүйн онолын ойлголтоор "үргэлжилсэн үйлдэлтэй хүчиндэх гэмт хэрэг" гэж үздэг. Хууль тогтоогчос гэмт хэрэг гэж тусгайлан тогтоосон ойлголтыг хуулиас гадуур томъёолж, илэрхийлж болохгүй" гэж байлаа.

PS: Гадаадын Улс орнуудын эрүүгийн эрх зүй болон, криминологийн салбарын чиг хандлагыг судлан үзэхэд<sup>13</sup> дээрх ойлголтыг төрөлжүүлэн авч үзсэн байна. Үүнийг тодорхой дурьдвал "marital rape" буюу "гэрлэлтэн дэх хүчин" хэмээн ойлголтод гэр бүл, хамаатан садны хүрээнд гардаг хүчингийн гэмт хэргийг ялган нэрлэдэг бөгөөд түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага хүртэл ялгамжтай байна. Харин "date rape" хэмээх ойлголтыг мөн тусгайлан ялган төрөлжүүлсэн байх бөгөөд үүнийг "болзооны хүчин" хэмээн дийцүүлэн ойлгож болох юм. Дээр дурдсан "хүчиндэх" гэмт хэргийг ерөнхийд нь "statutory rape" гэж нэршиж заншжээ.

<sup>12</sup> Сонгон авсан кейс тус бүр өөр өөрийн онцлог шалтгаан, нөхцөлд үйлдэгдсэн байна. Иймд байцаан шийтгэх ажиллагааны 2 шатыг сонгон авч, тулгарч байсан асуудлуудыг тоймлон бэлтгэлээ.

<sup>13</sup> Sue Titus Reid, J.D., Ph.D. "Crime and Criminology", 194-196" p. 2000

Хүчингийн гэмт хэрэгт өртсөн хохирогчид, тэр тусмаа насанд хүрээгүй хохирогч нь сэтгэл зүйн хувьд айдас, цочрол, стресс тэжээлтэй ордгоос шалтгаалан хүчиндүүлснээ бусдаас нуусан нь хэргийн шийдвэрлэлтэнд нөлөөлж нотлоход хүндрэл, бэрхшээл учруулж байсан. Хэргийг шалгах явцад хохирогч жирэмсэн болсон болон бэлгийн замын халдварт өвчин туссан асуудлыг нотлоход хугацаа алдаж, энэ нь хохирогчийн амь насанд аюултай нөхцөл байдал бий болгох, бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд дахин хохироход хүргэж байлаа.

Зарим хохирогчийн анхны мэдүүлэг, тайлбарт "гомдолтой, хохирол нэхэмжилнэ" гэсэн байдаг боловч яваандаа "хохиролгүй, нэхэмжлэх зүйлгүй, гомдолгүй, шүүх хуралд суухгүй" гэхчлэн мэдүүлэг өөрчлөгдсөн нь анхаарал татаж байлаа. Энэ бүхний ард хохирогчид бодит аюул занал, далайланг сүрдүүлж байх магадлал өндөр учир хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид нь насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон түүнтэй адил төстэй гэмт хэргийг шалган шийдвэрлэхдээ дээрх нөхцөл байдлыг анхаарч "хэвшмэл арга барил"-аас ангижирч, шинэ туршлагыг нэвтрүүлэх хэлбэрээр ажиллах шаардлагатай байна.

Мөрдөн байцаалтын шатанд хохирогчдоос мэдүүлэг авах тусгай өрөө байхгүйгээс хохирогчийн анхаарал сарних явдал их гарч байсан төдийгүй зарим дүүргэд хохирогчийг байцаах зориулалтаар тусгайлан тохижуулсан өрөө нь хүүхдийн байцаагч эсвэл өөр албан хаагчийн тасалгаа болон ашиглагдаж байлаа.

Мөрдөн байцаалтын шатанд хэргүүдийг шалган шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 5 сар байгаа нь хохирогчийн хувьд урт хугацаа юм.

Эрэгтэй хүүхдийг "эмэлсэн" буюу хүчирхийлсэн кейсийг тухайлан судлахад асуудлыг шалгах явцад баримтуулж чадаагүйгээс гэмт этгээдэд ял завшуулжээ. Энэ хэргийг "бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах"-аар зүйлчлэн эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан боловч хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Хохирогч бие махбодийн гэмтэл авснаас гадна хэт олон хүн энэ тухай мэдсэнээс шалтгаалан сэтгэл санааны давхар хохирол амчээ.

"Males as Rape"- "эрийг эмлэх" буюу "эр хүнийг хүчиндэх" гэмт хэрэг гэсэн ойлголт нь гадаадын зарим оронд "хүчиндэх" гэмт хэрэг гэсэн ойлголтод багтдаг. Гэтэл манай улсад "бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах" гэмт хэрэг хэмээн тодорхойлж гагцхүү эрэгтэй хүн эмэгтэй хүнд хүч хэрэглэн хурьцал үйлдсэн тохиолдолд хүчиндэх гэмт хэрэг хэмээн үзэж байгаа нь хоцрогдсон хандлага юм.

#### Шүүхийн шат

Шүүх хурлын тэмдэглэл, мөрдөн байцаалтын явцад бэхжүүлэн авсан мэдүүлгүүдтэй танилцахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын зүгээс хохирогчийг "хөнгөн явдалтай" хэмээн буруутгах хандлагыг гаргасан ба "Чи өөрөө дуртайдаа очиж хүчиндүүлээд байсан юм биш үү?" гэж асуусан байдаг. Энэ нь хохирогчийн хуулийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулахад хүргэжээ.

Шүүх хуралдааны үед хохирогч сэтгэл санааны хямралтай байсаар атал хохирогчийг тусгаарлах арга хэмжээ аваагүй, хүчирхийлэгчээс шууд хамааралтай байдлыг анхаарч үзээгүйгээс хохирогч айдаст автаж, байж суух газраа олохгүй гэх зэргээр сандарч сэтгэл зүйн сөрөг байдлууд гарч байжээ.

Мөн тодорхой кейст бэлгийн мөлжлөгт өртөж сэтгэл санаа, бие махбодийн хувьд хохирол хүлээсэн ямар нэг дарамт шахалт, өөрийгөө

хамгаалах чадваргүй байдлын улмаас өөрөө гэмт хэрэг үйлдсэн байж болохыг<sup>14</sup> анхаарч үзээгүй ял ногдуулсан нь гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, энэхүү нөхцөл байдлыг харгалзаж шийдвэрлэж байх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэв.

Сайн туршлага нь эрүүгийн шүүхээс хохирогчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргуулж чадсан явдал байлаа. Бага насны хоёр хохирогчид сэтгэл санааны хохирол хүлээсэн гэж үзэж болох нотлох баримтыг бүрдүүлэн, шүүхэд итгүүлж чадсанаар тус бүр 2 сая төгрөг<sup>15</sup> гаргуулж олгохоор шүүхийн шийтгэх тогтоолоор шийдвэрлүүлжээ.

Тулгарч байсан бэрхшээл, анхаарах асуудлууд:

Нэг. Хуулийг хэрэглэх явцад гарч буй бэрхшээл

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашигласан үйлдэлд хариуцлага оногдуулах зарим хэм хэмжээ Эрүүгийн хууль, бусад хуульд давхардан зохицуулагдсан нь гэмт этгээдэд ял завших гэмт үйлдлээ дахин давтах боломжийг олгож байна. Үүнд:

1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль

"Садар самуун явдалтай тэмцэх тухай" хуулийн 3 дугаар зүйл 3.1.2-т "садар самуун явдал" гэж биеэ үнэлж явалдах, түүнд бусдыг уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг" гэж тодорхойлсон нь Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл дэх Садар самууныг сурталчлах, 124 дүгээр зүйл дэх Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шинжийг агуулсан боловч эрүүгийн бус захиргааны хариуцлага ногдуулж болохоор байна. Тухайлбал Насанд хүрээгүй хүний биеийг

<sup>14</sup> Судлагдсан кейст хохирогч өөрөө эмзэг байдлынхаа улмаас хулгайн гэмт хэрэгт холбогдож улмаар шүүхээс хорих ялаар шийтгүүлж, эмзэг хүнийг хорих ангид ял эдлэж байгаа жишээ байна.

<sup>15</sup> 2010 оны 2 сарын 5-ны өдрийн СХД-ийн шүүхийн №67 дугаар шийтгэх тогтоол.

хүчээр үнэлүүлж, бэлгийн мөлжлөг өртүүлсэн үйлдлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, нийгэмд аюулгүй үйлдэл биш.<sup>16</sup> Гэтэл цагдаагийн ажилтнууд Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дээрх давхардлыг ашиглан “Садар самуунд уруу татах”, “Садар самууныг сурталчлах” гэсэн зүйлээр гэмт этгээдүүдэд захиргааны шийтгэл хүлээлгэн ял завшуулж байна. Мөн насанд хүрээгүй хохирогчдыг “бие үнэлсэн” хэмээн буруутгаж торгох шийтгэл хүлээлгэсэн байна.

2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1) хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтныг 40000-50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах;

5) хүүхдээр гуйлга гуйлгасан иргэн, эрүүл мэндэд нь харшлах ажил хөдөлмөр хийлгэсэн албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр торгох;

6) өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах тоглоом, наадамд оролцуулах үйл ажиллагаа явуулсан иргэн, албан тушаалтны олсон ашиг, орлогыг хурааж, 30000-60000 төгрөгөөр торгох;

Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох үйлдэлд энэ хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой байгаа нь хуулийн

давхардал гэж үзэж болохоор байна.<sup>17</sup>

Эдгээр заалт хариуцлагын үр нөлөөг багасгах, зарим тохиолдолд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших боломжийг олгож байгаа юм. Нэгэнт Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлагын талаар дурдаж байгаа учраас захиргааны хариуцлагын тухай давхардуулан авч үзэх нь илүүц юм.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг зөрчсөн этгээдэд захиргааны арга хэмжээ авсан сум, дүүргийн Засаг дарга байхгүй байна.

3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Уг хуулийн 6 дугаар зүйл заасан бэлгийн хүчирхийлэл нь энэ хуулиар бус тухайн үйлдлийнхээ объектив шинжээс хамаарч Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бие даасан гэмт хэрэг болно. Жишээ нь, Хүүхдийг бэлгийн мөлжлөгт оруулж түүнээс ашиг орлого олсон бол 113 дугаар зүйл буюу “Хүн худалдаалах” болон “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурцал үйлдэх”, “Бэлгийн дүр хүслээ ёс бусаар хангах”, “Хүчиндэх” гэмт хэргүүдийн аль тохирох зүйл, хэсгээр хариуцлага хүлээлгэх үйлдэл юм.

Сүүлийн үед үйлдэгдэж байгаа “хүчиндэх” гэмт хэргийн шинжийг аваад үзэхэд гэр бүл, ураг төрлийн хүрээнд нуугдмал, ужирсан шинжтэй байна.

Харин бэлгийн эрх чөлөөтэй нь холбоогүй боловч хүүхдийг ямар нэг байдлаар ашиг олох хэрэгсэл болгосон, хүнд нөхцөлд байлгасан, албадан хөдөлмөр эрхлүүлж ашиг олсон, давуу байдал бий болгосон, өр төлбөрт түр хугацаагаар шилжүүлсэн зэрэг үйлдэл хийсэн, түүний улмаас ямар нэг гэм хор үүссэн бол мөн Эрүүгийн хуулийн “Асран хамгаалах үүргээ урвуулах”, “Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийн шинжийг агуулж байдаг.

Дээрх хэлбэр нь гэмт хэргийн шинжийг шууд агуулж байдаг учир

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар бус Эрүүгийн хуулиар тайлбарлаж хариуцлага хүлээлгэдэг байх нь зохимжтой юм.

Эрх зүйн аливаа зөрчлийн хариуцлага туйлын тодорхой байх ёстой. Гэтэл уг хуулийн 19.1.-т “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэсэн нь иш татсан, хариуцлага тооцсон, алгасуулан иш татсан хэм хэмжээний аль нь болох нь мэдэгдэхгүй хэт “бөөрөнхий” байгаа юм.

Хэдийгээр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн зарим зүйл заалтыг тайлбарласан УДШ-ийн 2006 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн 47 дугаар тогтоол байдаг боловч хариуцлагын талаар тайлбарлаагүй юм. Гэтэл ГБХТХ-ийн 5.1.6-д “эрх хязгаарлах арга хэмжээ” гэж хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлага хэмээн заажээ. Практикт энэ арга хэмжээг буруу арга замаар авч байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага энэ эрхийг бие дааж хэрэгжүүлдэггүй, зөвхөн шүүхэд хүсэлт гаргах эрхтэй байдаг. Энэ нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхийлэгчээс яаралтай тусгаарлах хойшуулшгүй арга хэмжээ авах боломжгүй байдалд хүргэж байна. Шүүхэд энэ эрх хязгаарлах хүсэлт гаргаж шийдвэрлүүлтэл ихээхэн хугацаа шаардагддаг, үүнээс болж хохирогч дахин бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд орж болох юм.

**Хоёр. Практикт тулгарч буй бэрхшээл**

Хуулийн байгууллагын ажилтнуудын хохирогчийг буруутган үзэх хандлага: Хохирогчдын зарим

<sup>16</sup> Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 45 дугаар тогтоолоос.

<sup>17</sup> ХЗХУ-ийн ЭЗЗК-оос хийсэн “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” судалгааны тайлангаас.

хэсэг нь биеэ үнэлдэг боловч энэ нь гэмт хэрэгт өртөх хамгийн гол эрсдэлт хүчин зүйл болж байсан гэдгийг дурдах нь зүйтэй. Тухайн тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүчээр биеийг нь үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт ашиглаж байсныг судлаачийн зүгээс олж харахыг хичээлээ. "Хөнгөн явдалтай" хэмээн дурьдагдсан, хэрэгсэхгүй болгон шийдвэрлэгдсэн хэргийн хохирогч нарын мэдүүлэг нь судлаачийг "энэ өнцгөөс" харахад хүргэлээ.

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, хэмжих аргачлал байхгүй байна: Бэлгийн мөлжлөгт өртсөн хүхүдэд эдийн гэхээсээ илүү эдийн бус гэм хор учирдаг. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хүчтэй цочролд орох, амиа хорлох, хорлохыг оролдох зэрэг сэтгэл санааны хохирлыг хүлээж байдаг. Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх практик аргачлал, шүүхийн хэвшүүлэлт байхгүй зэрэг нь хохирогчийг хамгаалахад тулгарч буй хамгийн "хүндрэлтэй" асуудал юм. Үүгээрээ энэ гэмт хэргийн нийгмийн хор уршиг тодорхойлогдож байдаг. Гэтэл сэтгэл санааны хохирлыг тодорхойлох, хэмжих, үнэлэх аргачлал байхгүй байна.

Хохирогч хамгааллын зохицуулалт дутмаг. Төслийн багийн ажилласан хэргүүд дотор хохирогчийн эрсдэл бүхий байдалтай холбоотойгоор үйлдэгдсэн хэргүүд нэлээдгүй байлаа. Хохирогчийн "эрсдэл бүхий байдал" гэдэгт хамаатан садны дэмжлэг, туслалцаа байхгүй, танил нөхдийн холбоо найдваргүй, хэт итгэмтгий (найздаа итгэснээс гэмт хэргийн хохирогч болох), түүнчлэн эцэг эхийн хайр, халамж дутагдах, гэр бүлийн хүчирхийллийн улмаас орон гэрээсээ дайжсан, хараа хяналтгүй, гудамжны тэнэмэл амьдрал зэрэг хохирогчдын "эрсдэл" бүхий шинжийг орууллаа.

Жишээ нь, 2 кейст хохирогч охины биеэ хамгаалах чадваргүй, ар гэрийнх нь эмзэг байдлыг дэлгэмдүүлэн хүчиндэж, улмаар хүчээр биеийг нь үнэлүүлсэн байна.

#### ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Үйл ажиллагааны хүрээнд өгөх дүгнэлт

- Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан ноцтой үйлдэлд хохирогчийг өөрийг нь "биеэ үнэлэгч" гэж буруутган, гэм буруутай этгээдийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгоод өнгөрөөх явдал гарсаар байна.

- Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулах гэмт хэрэг гэсэн халхавчийн цаана хүүхдийг бусдад худалдах, дамжуулан худалдах гэмт хэрэг нуугдаж байдгийг анхаарах шаардлагатай байна.

- Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдын хувьд өөрсдийнх нь аюулгүй байдал алдагдах, нэр төр гутаагдах, буруутгагдах эрсдэлтэй гэж үздэг (хуулийн байгууллагад үл итгэх байдал) нь тэднийг хуулийн байгууллагад хандахаас татгалзахад хүргэж байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шат дамжлага удаан, хохирогч гомдолтой гэсэн тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлж чадах эсэх нь эргэлзээтэй учраас хохирогч хохирлын мөнгө гэж хэдэн төгрөг аваад гомдлоосоо буцахад хүрдэг байна.

- ЭБШХ-ийн 25 дугаар зүйлд зөвхөн хөнгөн гэмт хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог бөгөөд бусад төрлийн гэмт хэргийн хувьд хэрэгсэхгүй болгох боломжгүй юм. Гэтэл бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад "хохирогчийн ар гэрийнхэнтэй нь эвлэрсэн" гэсэн үндэслэлээр хэргийг

хэрэгсэхгүй болгосон нь хууль зөрчсөн үйлдэл гарчээ.

- Олон Улсын эрх зүйн хэм хэмжээнд 18 насанд хүрээгүй хүнийг "хүүхэд" гэж үздэг<sup>18</sup> бөгөөд хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох нь хүч хэрэглэсэн, хэрэглээгүй, хүүхэд зөвшөөрсөн эсэхээс хамаарахгүйгээр гэмт хэрэг мөн. Гэтэл манай Эрүүгийн хуулиар 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь 16-18 насны хүнтэй хүч хэрэглээгүй... л бол бэлгийн харьцаанд орж болохыг зөвшөөрсөн зохицуулалт болжээ.

- Захиргааны зөрчлийг гэмт хэрэгтэй ижил байдлаар хуульчилж, хэм хэмжээний давхардал үүсгэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэрхшээл учруулж байна. Улсын дээд шүүхийн тайлбараас үзэхэд "эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол" гэсэн ойлголтын тайлбар бүрхэг байгаа нь хууль хэрэглэж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.<sup>19</sup>

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах" талаар тусгайлан бүлэг одоогоор байхгүй, зөвхөн насанд хүрээгүй гэрч хохирогчийн мэдүүлгийг шүүх ажиллагааны үед сонсох талаар л заажээ.<sup>20</sup> Харин 145 дугаар зүйлд заасан Насанд хүрээгүй гэрчийг байцаах зохицуулалт нь "хохирогч хамгаалал"-ын үйл ажиллагаатай төдийлэн хамааралтай биш байна.

- Мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хохирогчийг хөндлөгийн нөлөөллөөс хамгаалах хуулийн арга хэрэгсэл байхгүй, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын ажил дүгнэх үзүүлэлтэд нь ордоггүй учир тэд ийм асуудалд "хуулиар хүлээсэн үүрэгт ажил биш" гэж хүнийрхсэн байдлаар хандаж байна.

Санал, зөвлөмж

<sup>18</sup> Монгол Улсын нэгдсэн орсон Хүүхдийн эрхийн конвенцнд.

<sup>19</sup> ХЗУХ "Эрүүгийн орон Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилт" судалгааны тайлан. 2007 он.

<sup>20</sup> ЭБШ хуулийн 269 дүгээр зүйл.

• Насанд хүрээгүй хүний хувьд "биеэ үнэлэлт" гэсэн ойлголт байх боломжгүй. Энэ нь бэлгийн хүчирхийллийн үр дагавар учир ийм тохиолдол бүрийг нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр шалтгаан, нөхцөлийг тогтоож, цаана нь байгаа гэмт этгээдүүдэд эрүүгийн хариуцлага заавал тооцож байхын тулд хуульчдын дунд тогтсон насанд хүрээгүй хүний биеэ үнэлэлтийг "хүлээн зөвшөөрөх" хандлагыг өөрчлөх сургалтуудыг явуулах;

• Цаашид "хүчиндэх" гэмт хэргийн ойлголтыг өргөжүүлж, төрөлжүүлэх;

• Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг хэмжих, тооцох, нөхөн төлүүлэх аргачлал боловсруулж, мөрдүүлэх;

• Эрүүгийн хууль, Садар самуун явдлыг хориглох тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын давхардлыг арилгах;

• Монгол Улсын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл (16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх)-ийг нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн "Насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх" болгон өөрчлөх;

• Тодорхой судалгаа, шинжилгээний үндсэн дээр насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах тухай тусгайлсан бүлэг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмж оруулах;

• Хохирогч, гэрчийн аюулгүй байдлын хамгааллын асуудлыг ЭБШ хуульд тусгаж өгөх. Хохирогч, гэрчийг хамгаалах нь ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгч (хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч)-дийн үүрэг байхаар хуульчилж өгөх;

• Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан "уулзахыг түр хугацаагаар хязгаарлах" арга хэмжээг цагдаагийн байгууллага Эрүүгийн байцаан шийтгэх

ажиллагааны явцад бие даан хэрэгжүүлдэг байх зохицуулалт бий болгох.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийн зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах талаарх хуулийн зүйл, заалтуудыг хэрэглэх боломж

Энэхүү зөвлөмжийн хүрээнд бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдийн эрхийг Монгол Улсын Эрүүгийн хуулиас бусад хуулиар хамгаалах хууль зүйн боломжийн талаар авч үзсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-т "улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайндурьн харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална." гэж заасан нь хүүхдийн эрхийг хамгаалах суурь зохицуулалт юм. Тийм ч учраас хүүхдийн асуудлыг аливаа салбар эрх зүйд тусгайлан авч үзсэн байдаг.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа аливаа хуульд "бэлгийн мөлжлөг" гэж шууд заасан, тайлбарласан нэр томъёо байдаггүй бөгөөд одоогоор энэ ойлголтыг " хүнд нөхцөлд байгаа хүүхэд" гэсэн хууль зүйн ойлголттой адилтган хэрэглэж байна.

Бэлгийн мөлжлөгт өртөж хохирсон хүүхдийн "эрх, хууль ёсны ашиг сонирхол"<sup>21</sup>-ыг хамгаалахдаа дараах хүчин зүйлийг зайлшгүй авч үзэх шаардлагатай:

1. эрүүл мэнд (бие махбодь, сэтгэл санаа);

2. боловсрол (суурь боловсрол эзэмших харилцаагаар дамжуулж хэрэгцээтэй ерөнхий мэдлэгийг олж авдаг);

3. гэр бүлийн болон амьдрах орчин (гэрийн бүл нь нийгмийн хамгийн анхдагч нэгж, хүний хамгийн чөлөөтэй байх орчин);

4. бусад (эдийн болон эдийн бус хохирлыг тооцон гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, "нийгэмшүүлэх" гэх мэт).

Эдгээр хүчин зүйлийг үндэслэл болгон дараах хуулийг сонгон авсан.<sup>22</sup>

1. Эрүүл мэндийн тухай хууль (1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр)

35 дугаар зүйл. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах баталгаа 35.1. Монгол Улсад эх, хүүхдийн эрүүл мэнд төрийн байнгын анхаарал, ивээлд байна.

35.2. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцна."

26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт "гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюул учирсан иргэн, амаржих гэж байгаа эхэд энэ хуулийн 25.1.3-т зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн тусламжийг ямар ч нөхцөлд үзүүлэх;"

Хэдийгээр практикт зарим нэг хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байдаг ч хохирогч хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд холбохдоо хуулийн энэ зохицуулалтыг аль болох ашиглаж оролдлого хийх нь зүйтэй.

2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль (1996 оны 5 дугаар сарын 7-ны өдөр)

15 дугаар зүйл. Онцгой ба хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, тусламж

2. Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хүнд нөхцөлд байгаа хүүхдэд

<sup>21</sup> Эрх, хууль ёсны ашиг сонирхол гэдэгт хүүхдийн баталгаатай эдлэх эрх, бусад хуулиар олгогдсон субъектив боломж юм. (Судлаач)

<sup>22</sup> Холбогдох бусад хуулиуд байгаа боловч өмнө нь энэ сэдвээр хийгдсэн судалгаа, шинжилгээний эжилд хангалттай дурдагдсан учир эдгээр хуулиудаар хязгаарласан болно. (Судлаач)

дараахь халамж, хөнгөлөлт, тусламж үзүүлнэ:

1) боловсрол, мэргэжил эзэмшихэд тусалцаа үзүүлэх;

2) эрүүл мэндийн нь нөхөн сэргээх, сувилах, тахир дутуу хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад хэрэгслийг үнэ төлбөргүй олгох;

3) хүнд нөхцөлд байгаа хүүхдийг үрчилсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олго;

4) хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах;

5) хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг үзүүлэх.

Гэр орноосоо дайсан хүүхдэд сургуулийн орчин нийгэмшиж, зөв мэдээлэл олж авах анхдагч нөхцөл болдог учир хохирогч хүүхдэд боловсролын үйлчилгээг заавал үзүүлдэг байх нь чухал. "Боловсролын тухай" хуулийн 32 дугаар зүйлд зааснаар баг, хорооны Засаг даргын бүрэн эрхэд "суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах" үйл ажиллагаа хамаардаг учир энэ зохицуулалттай уялдуулан, хамтран ажиллах зарчимд суурилсан үйлчилгээ үзүүлэх нь үр дүнтэй байх юм.

Нийгмийн халамжийн тухай хууль (2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр)

19 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн төрөл

19.1. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж дараахь төрөлтэй байна:

19.1.6. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээж, хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж;

191 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрх

191.1.2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие

махбодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

Уг хуульд заасан нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар тогтоодог бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмыг 2008 оны 162 дугаар тогтоолоор (2 дугаар хавсралт) баталсан байна. Ингэхдээ хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ асарч байгаа гэр бүлийн тэтгэмж авах эрх нь "Асран хүмүүжүүлэх гэрээ"-г үндэслэн бий болдог ба иргэний гаргасан хүсэлтийг "Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл" шийдвэрлэдэг байна.

26 дугаар зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээ

26.1. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ дараахь төрөлтэй байна:

26.1.3. сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

26.1.4. түр байрлуулан асрамжлах;

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан үйлчилгээнд дор дурдсан иргэн, өрхийг хамруулна:

26.2.3. хүнд нөхцөлд байгаа хүүхэд;

26.2.4. хүчирхийлэлд өртсөн иргэн;

Энэ зүйл, заалтаар хүчирхийлэлд өртсөн иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, үйлчилгээг авах эрхтэй юм.

Гэр бүлийн тухай хууль (1999 оны 5 дугаар сарын 11-ний өдөр)

25.5. Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх,

ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.

Энэхүү зохицуулалтаас харахад хүүхдийн эрх ашгийг хамгаалах субъект нь анхан шатны нэгжийн Засаг дарга байна. Энэ субъект нь суурь боловсрол олгох, мэргэжлийн сургалтад хамруулах, бичиг баримтжуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах аргаар хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг.

Иргэний хууль (2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр)

497 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

497.1. Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхгүй)-гээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг кариуцан арилгах үүрэгтэй.

Хохирогчийг хамгаалах, түүнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжийн нэг нь иргэний эрх зүйн хамгаалалт юм. Эрүүгийн хэргэд дэх иргэний нэхэмжлэлээс гадна хохирогч иргэний журмаар бие даасан нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй байдаг уг боломжийн гол ач холбогдол оршдог. Тухайн гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах, өөрөөр хэлбэл сэтгэл санааны хувьд гэмт хэргэ үйлдэгдэхээс өмнөх байдалд оруулахад шаардлагатай сэтгэцийн эмгэг заслын үйлчилгээний төлбөр, хөдөлмөр эрхэлдэг байсан бол ажилгүй байсан хугацааны төлбөр, боловсрол эзэмшихэд шаардагдах зардал гэх мэт зүйлийг энд дурдаж болно. Эдгээр хохирлыг үнэлэн тогтооход зарим талаар хэцүү, маргаантай боловч хуульчдын хувьд ингэж хэвших нь бэлгийн мөхлөгт өртсөн хүүхдийн эрх ашгийг хамгаалахад томоохон дэвшил гарах "эхлэл" болох юм.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нь хувь хүний нууц болох нэр төр, бэлгийн амьдралтай холбоотой мэдээллийг агуулсан

нэхэмжлэл гаргахад сэтгэл зүйн хүнд дарамт амсдаг. Ийм учраас энэ төрлийн гэмт хэрэгт эдийн болон эдийн бус гэм хорыг үнэлэх, нөхөн төлүүлэхээр төлөөлөн нэхэмжлэл гаргах, түүнийг хангасан шийдвэр гаргуулж хэвшүүлэх шаардлагатай.

Иргэний хууль (2002 он)

Уг хуулийн Гуравдугаар дэд бүлгээр гэр бүлийн хөрөнгийн харилцааг зохицуулдаг бөгөөд хүүхэд гэр бүлийн гишүүнд тооцогддог. Энэ үүднээс хохирогч хүүхэд гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийн хувьд шаардах эрх эдэлнэ. Иргэний эрх зүйд иргэний бүрэн чадамж 18 наснаас эхэлнэ. Мөн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний асран хамгаалагч нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Эдгээрийг тооцон үзж хохирогчид ногдох хэсгийг нэхэмжлэх нь хохирогч хамгааллын бас нэг хувилбар байж болох юм. Хохирогч хүүхэд 18 нас хүрч бие даан амьдрах шаардлагатай болдог. Энэ үед үүссэн санхүүгийн зарим нэг асуудлыг шийдвэрлэх бас нэг хууль зүйн боломж юм.

PS: Иргэний эрх зүйн эдгээр боломж нь хохирогчийг хамгаалах арга хэрэглүүр болохоос эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл болохгүй гэдгийг дурдах нь зүйтэй болов уу.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр)

6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

6.1. Энэ хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно.

Хуулийн энэхүү заалтанд гэр бүлд үйлдэгддэг хүчирхийллийн

хэлбэрийг тоочих замаар тодорхойлжээ. Хэрэв хохирогч хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн улмаас орон гэрээсээ дайжсан, цэг, эхтэйгээ хамт амьдрах нь түүний амь нас, эрүүл мэндэд хохиролтой бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу түүнийг эсрэг хүчирхийлэл үйлдсэн гэр бүлийн гишүүдэд "эрх хязгаарлах арга хэмжээ" авахуулах боломжтой юм.

**Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн гэмт хэргийн нотлогдвол зохих байдлууд, түүний хэмжээ хязгаар**

Гэмт хэрэг бүрийн онцлогоос шалтгаалан хэрэг тус бүрийн нотлогдвол зохих байдлуудын бүрэн жагсаалтыг хуульчлах боломжгүй, өөрөөр хэлбэл нотолгооны зүйлийг хуульд тодорхойлж болдог бол хэмжээ хязгаарыг тогтоож болдоггүй.

Гэмт хэргийн нотолгооны хязгаар гэдэг нь гэмт хэргийн нотолгоо явагдах цар хүрээг илэрхийлдэг бол нотолгооны хэмжээ гэдэг нь тухайн асуудлыг хангалттай нотлохын тулд хэдий хэрийн баримт сэлт, мэдээлэл цуглуулбал зохих ёстойг илэрхийлж байгаа үзүүлэлт юм.

Өмгөөлөгч нь эрүүгийн хэрэгт оролцох явцдаа нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд идэвхтэй хэлбэрээр оролцож болох хэд хэдэн арга байдаг. Энэ нь "хуулиар хориглоогүй бусад арга" гэсэн ойлголтонд ордог бөгөөд хүний нэр төр, алдар хүндэд харшилсан хууль бусаар олж авсан шинжгүй байх ёстой гэдгийг онцгой анхаарвал зохино. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагад хандахаас өмнө хохирогч өөрөө үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүргэгдэж ирсэн үед анхны мэдээлэл, бодит нөхцөл байдлыг

нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын оролцоотойгоор бэхжүүлж авах. Ингэхдээ дүрс бичлэгийн болон гэрэл зургийн аппарат ашиглаж болно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гол алдаа бол "анхны үйлчилгээ үзүүлсэн баримт нотлох баримт болохгүй байх" гэсэн хандлагаар баримтжуулалтыг дутуу хийдэг явдал юм.

Өмгөөлөгчөөс хэргийн талаар өргөдөл гомдол гарган шийдвэрлүүлэх явцдаа дээрх баримтыг нотлох баримын хэмжээнд цуглуулах, бэхжүүлэх тухай хүсэлт гарган шийдвэрлүүлж хэвших хэрэгтэй.<sup>23</sup> Энэ нь байцаан шийтгэх ажиллагааны журамд харшлаггүй бөгөөд бэхжүүлж авахдаа өөрсдөө тэмдэглэл үйлдэх, эсвэл хураан авах замаар нотлох баримтын хэмжээнд бэхжүүлж болно.<sup>24</sup>

2. Тодорхойлолт авах: Өмгөөллийн тухай хуульд<sup>25</sup> зааснаар өмгөөлөгч бусад байгууллагаас тодорхойлолт гаргуулан авах эрхтэй байдаг. Энэхүү гаргасан тодорхойлолт хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзэж байвал хэрэгт хавсаргах, бэхжүүлж авах тухай хүсэлтийг мөн л бичгээр гаргаж хэвших хэрэгтэй бөгөөд энэ нь нотлох баримтын ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Тухайлбал, хохирогч мэс засал хийлгэсэн, сэтгэл заслын үйлчилгээ авсан эсвэл хүчиндүүлсэнээс шалтгаалан жирэмсэлж, ураг хөндүүлэх г.м амь насанд аюултай эмчилгээ хийлгэсэн үед өвчтөний түүхийн хуулбарыг гаргуулан авах, эмнэлгээс нь өвчний шинж тэмдэг, бусад байдлын талаар тодорхойлолтыг гаргуулан авч мөрдөн байцаагчаар тэмдэглэл үйлдүүлэн хэрэгт хавсаргах гэх мэт хэлбэртэй байж болно;

3. Гэрч, мэргэжилтний хувиар сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг

<sup>23</sup> Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4-т "өмгөөлөгч нь "нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих эрхтэй" гэжээ.

<sup>24</sup> Мөрдөн байцаагч нартай хийсэн арилцлагын дүн, 2010 он

<sup>25</sup> Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, мэдээ сэлтийг гаргуулан авахын тулд шүүх, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, бусад байгууллага, түүний холбогдох албан тушаалтанд хүсэлт гаргах эрхтэй.



байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах: Хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь мөрдөн байцаагчид хүүхдэд учирсан тодорхой бэрхшээлийг тодруулах, хэрэгт ач холбогдол бүхий баримтыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх нь хэргийн шийдвэрлэлтэд шууд нөлөөлдөг. Нэн ялангуяа кейс шийдвэрлэлтийн явцад ийм байдлаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа явдал нь ихээхэн үр дүнтэй нь мэдрэгдэж байсан юм.

Нотлох баримтыг цуглуулах үед анхаарах асуудлууд:

Өмгөөлөгч нь ЭБШХ-д зааснаар нотлох баримтыг цуглуулах эрх бүхий этгээд биш тул үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээлэл, баримт сэлтээ цагдаагийн байгууллагад гарган өгч байгаа тэр хэлбэрээр хандах нь үр дүнтэй. Доорхи зүйлсийг анхаарах шаардлагатай:

- Болсон үйл баримт, фактыг үнэн зөв, бүрэн тодорхой тусгах;
- Нотлох баримт болохуйц зүйлсийг үргэдэх, гэмтэх, солигдох, урагдах гэмтэх зэрэг байдлаар гаргуулахгүйн тулд гэрэл зургаар бэхжүүлэх, лацдах, шинж тэмдэг, онцлог зүйлийг тэмдэглэж авах, хувилж авч болохоор бол хувилж авах гэх мэт дараа нь гомдол, хүсэлт гарган шийдвэрлүүлэх баримттай байх;

- Хэрэгт цаашид ач холбогдолтой баримт сэлт, мэдээллийг шалгах бололцоог бий болгох шаардлагуудыг баримталвал зохино. Ингэхдээ нотлох чадвараа алдаж болзошгүй нөхцөл байдлын талаар анхаарах хэрэгтэй;

- Хувийн нууцлалыг хамгаалах. Төслийн багийн гишүүдээс хэргийг шийдвэрлэх явцад гарч байсан хүндрэл бэрхшээлтэй асуудал тухайн хохирогчийн хувийн нууцлал бүхий баримтыг задруулах явдал байлаа.

Нэн ялангуяа байцаан шийтгэх ажиллагаанд гэрч, сэжигтний хувиар байцаагдаж байгаа этгээд хохирогчийн "хувийн нууцлалыг задруулна" хэмээн айлгаж сүрдүүлсэн баримт нэг бус удаа гарч байсан бөгөөд эдгээр тохиолдол тухай бүрт нь үр дүнтэй арга хэмжээ авч хэвшүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал, гэмт хэргийн хохирогчийн хувийн нууцлалтай холбоотой асуудал нь мөрдөн байцаалтын нэг хэсэгт хамаардаг учир "байцаан шийтгэх ажиллагааны журам зэрчсөн" хэмээн тухайн мөрдөн байцаах албаны дарга болон шүүгчид хүсэлт гарган шийдвэрлүүлж болно.<sup>26</sup>

Эдгээр зүйл нь хууль тогтоомжийн хүрээнд авч асуудал нь мөрдөн байцаагатай арга хэмжээнүүд юм

Хэдийгээр Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг зааж өгсөн боловч үндэс зүйн тусламж, үйлчилгээг мөн оруулах нь зүйтэй болов үү.

Практик зөвлөмжүүд:

Судлагдсан кейсүүдээс үзэхэд энэ төрлийн гэмт хэргийг өмгөөлөх ажиллагааны явцад анхаарах шаардлагатай зүйлс нэлээдгүй ажиглагдаж байсан ба энэхүү үйл ажиллагааны оновчтой загварыг гаргах шаардлагатай байгаа нь тулгамдсан асуудал гэж үзэв.

Хүсэлт гаргах: Өмгөөллийн тухай хууль болон ЭБШХ-иар өмгөөлөгчид олгосон ашиглаж болох үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр, боломж нь хүсэлт гаргах эрх юм. Хүсэлт гаргах эрх нь өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, шалтгаан, түүний улмаас учирсан хохирлыг бодитой тогтоох талаар байж болно.

Гэмт этгээдээс сэтгэл санааны хохирол нэхэмжлэн гаргуулах:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад өмгөөлөгчийн гаргаж болох эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг нь "хүсэлт" юм. Мөн эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэл байж болно. ЭБШХ-ийн 41 дүгээр зүйлд өмгөөлөгчийн эрх үүргийг заасан бөгөөд шаардлагатай нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт гаргаж болдог.

Сэтгэцийн гэм судлаач-шинжээчээр хохирогчийн сэтгэл санааны хохирлын зэргийг тогтоолгож,<sup>27</sup> түүнийг эмчлэх хугацаанд гарах зардлыг тооцон нотлох баримтын хэмжээнд бүрдүүлж иргэний нэхэмжлэлд хавсаргах боломжтой юм.

Нөгөө талаас гэм буруутай этгээдээс иргэний журмаар гаргуулах мөнгөний хамгийн доод хэмжээг амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээтэй холбоотой авч үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэгдсэнээс эхлэн эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацааг тухайн орон нутагт тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингийн мөнгөн хэлбэрт дүйцүүлэн (шилжүүлэн) нэхэмжилнэ гэсэн үг юм. Учир нь амьжиргааны баталгаажих түвшин нь тухайн хүн ажил эрхэлдэггүй, орлогогүй байсан ч амьдрахын тулд зайлшгүй шаардагдах зүйлийн мөнгөн илэрхийлэл юм.

Насанд хүрээгүй хохирогчийг байцаах, эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд оролцуулахад бичлэг хийлгэх, гүнчлэн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорыг байлцуулах нь ихээхэн үр дүнтэй юм. Ингэснээр хэргийн шийдвэрлэлтэд шууд нөлөөлдөг сайн талтай.

Хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэргүүдийн гаралт, шийдвэрлэлтийн байдлаас

<sup>26</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 77, 78 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааны журам зэрчсөн тохиолдолд торгууль ногдуулж болох эрх зүйн үндэслэлийг дурдсан бөгөөд энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгохоор заасан.

<sup>27</sup> Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч шинжилгээ хийлгэх тогтоолдоо энэ тухай асуулт оруулбал тодорхой хэмжээнд сэтгэл санааны хохирлыг зэргийг тогтоох боломжтой байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хуулийн тасгийн эрхлэгч Д. Янхуатай хийсэн ярилцлага. ХЗҮХ, 2009 он

шалтгаалан ТББ-ууд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргаж цагдаагийн байгууллагад хүргүүлбэл гэмт хэрэг илрүүлэх, хойшлуулшгүй ажиллагааг хамтран явуулах боломжтой.

ТТБ-д ажиллаж буй, хуульч өмгөөлөгчид нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйчидтэй хамтран ажиллах: Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн шөнийн цагаар үйлдэгддэг учраас цагдаагийн байгууллага дээр сурган хүмүүжүүлэгч олддоггүй байна. Энэ нь ЭБША-ны явцад хохирогчийн анхны мэдүүлгийн үр нөлөөг бууруулах, улмаар нотолгооны шинж чанараа алдахад хүрдэг.

Мөн төрийн бус байгууллагууд нь эрх ашгийг хамгаалж буй хохирогчдоо байцан шийтгэх ажиллагааны явцад мэдүүлэг өгүүлэхдээ цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах үндсэн дээр мөрдөн байцаагчийг хохирогч байгаа газар (боломжтой тохиолдолд энгийн хувцастай) хүрэлцэн ирүүлж ажиллагаа явуулах, өөрсдөө байлцах тал дээр санаачлагатай ажиллах хэрэгтэй байна. Энэ нь нотлох баримтыг шүүх үнэлэхэд өндөр ач холбогдолтой байхыг үгүйсгэхгүй.

#### Дүгнэлт

Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэхээс бусад тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд нь сайн дурын санхүүжилтээр, ашгийн төлөө бус байдлаар үйл ажиллагаа явуулдаг учир эдийн засгийн хувьд тэр бүр сайнгүй байх нь бий. Нийгмийн халамжийн хуульд заасан нөхцөлт мөнгөн тэтгэмжийг хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлж

байгаа төрийн бус байгууллага авах эрхтэй байхаар хуулийн зохицуулалт бий болгох нь санхүүгийн хувьд бүрэн биш ч тодорхой хэмжээгээр дэмжлэг болох юм.

Нөгөө талаас бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг аль нэг гэр бүлд шууд өгөх боломж бага, өөрөөр хэлбэл, хохирогч хүүхдийг аль нэг гэр бүлд шилжүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, үрчлүүлэх асуудал нь эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гаргах зэрэг тодорхой ажиллагаа хийгдсэний үндсэн дээр шийдвэрлэгддэг тул цаг хугацааны хувьд хүндрэл бэрхшээлийг үүсгэж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан "хүнд нөхцөлд байгаа хүүхэд" гэдгийг ямар субъект тодорхойлохыг зааж өгөөгүй, хуулийг сурталчлах ажил муу байгаа зэргээс тухайн хүүхдэд зайлшгүй үзүүлэх ёстой тусламж үйлчилгээг авахад хүндрэлтэй байна.<sup>28</sup>

Эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй, хаягийн шилжилт хөдөлгөөн хийлгээгүй "хүнд" нөхцөлд байгаа хүүхэд эмнэлгийн үйлчилгээ авах ямар ч боломжгүй байна.<sup>29</sup>

#### Санал, зөвлөмж

• Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн өнөөгийн нөхцөл байдалд тохируулан хүүхдийн эрхийг хамгаалж буй төрийн бус байгууллага мөн адил авах эрхтэй байхаар өөрчлөн найруулах;

• Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөлд эрх зүйн

туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг оруулах.

• Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүчингийн гэмт хэргийг олон нийтэд жишүүлэх ажиллагаа хийлгэж, тэдний ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг тасралтгүй хийх.

• Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;

• Монгол Улсын Дээд шүүхээс хүчингийн гэмт хэргийн талаар шинэ тайлбар гаргуулахад нөлөөлөл хийж ажиллах;

• Хүүхдийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хуулийн механизм бий болгох;

• ХЗДХ яаманд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр ажиллах байгаа ажлын хэсгийнхэнтэй уулзалт зохион байгуулж, хохирогч хамгааллын асуудал болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа томъёолж өгөх;

• Мэргэжилтнүүд, хуульчдад системтэй сургалт зохион байгуулж, тэдний хандлага, мэдлэгийг сайжруулах тал дээр нөлөөлөн ажиллах;

• Холбогдох бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулахад оролцох;

• Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хэрэгт мөрдөн байцаагчдыг мэргэшүүлэх, мэргэшсэн мөрдөн байцаагч ажиллуулах;

• ЭБШХуульд хохирогчийг хамгаалахад онцгой анхаарах, уулзах.



<sup>28</sup> ХЗҮХ-ийн ЭЗЗКС-оос 2009 онд хийсэн "Хүүхдийн гэмт хэргийн асуудал хариуцах хорооны дүрмийг боловсронгуй болгох" судалгааны тайлангаас.

<sup>29</sup> 2009 онд ХЗҮХ-ийн ЭЗЗКС-оос явуулсан "Иргэний бүртгэлийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах" судалгааны тайлангаас.

## Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын асуудал



Цагдаагийн академийн төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч С.Гантулга

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй хийх Эрүүгийн эрх зүйн тэмцэл нь үндсэндээ 1996 оноос эхэлсэн гэж үзэж болно. 1996 оны 4 дүгээр сарын 1-нд батлагдсан Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд Эрүүгийн хуулийн 111-р зүйлийн 1-д *"Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлсэн буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол 3- 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"* гэсэн заалтыг шинээр оруулсан байна

2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг: *"Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг"* гэсэн бүлгийн 113-р зүйлд *"Хүн худалдах, худалдан авах"* гэмт хэргийг хуульчилсан нь энэ

төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн чухал алхам болсон хэдий ч олон улсын эрх зүйн хэм хэмжээнд бүрэн нийцээгүй байна.

Иймээс 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдөр Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас батлан гаргасан.

*Үндсэн бүрэлдэхүүн* 113.1. Ашиг олох буюу *мөлжих* зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тэвээрлэсэн, дамжуулсан, оргнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51- 260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*Хүндрүүлэх бүрэлдэхүүн*

113.2. Энэ хэргийг:

113.2.1. Насанд хүрээгүй хүнийг;

113.2.2. Хоёр ба түүнээс олон хүнийг;

113.2.3. Хулгайлах,

113.2.4. Эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг;

113.2.5. Давтан;

113.2.6. Бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн

бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*Онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүн* (113.3. Хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ) гэж хуульчлан

ангилжээ.

*Тайлбарт:*

1. Энэ хуулийн 113.1-д заасан "мөлжих" гэдгийг худалдагдсан хүний биеийг нь үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.

2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

*Хүн худалдаалах гэмт*

*хэргийн бүрэлдэхүүний объект:*

Гэмт хэргийн объектыг:

- Ерөнхий;
- Төрлийн;
- Шууд гэж ангилах ба халдлагын зүйлийг мөн авч үздэг.

Хүн худалдаалах гэмт хэргийн ерөнхий объект нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1 дүгээр зүйлд зааснаар "Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдал" юм.

Төрлийн объект нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгээр хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төр юм.

Хүн худалдаалах гэмт хэргийн шууд объект нь худалдагдаж буй тухайн хүний амь нас, эрүүл мэнд, хуулиар хамгаалагдсан халдашгүй байдал юм.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын тухай асуудлын хүрээнд гэмт хэргийн халдлагын зүйлийн тухай асуудлыг хамааруулан авч үздэг.

Хүн худалдаалах гэмт хэргийн халдлагын зүйлд нэгдүгээрт, гэмт хэргийн улмаас халдагдаж, өртөж байгаа материаллаг юмс, эд зүйл,

хоёрдугаарт, гэмт халдлагад өртөж байгаа этгээд буюу халдлагын зүйл буюу халдлагад өртөгч нь худалдагдаж буй хүн байхаар хуульчилжээ.

**Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал:**

Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолоор "Хүн худалдаалах" гэдэгт тодорхой төлбөртэйгээр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх гэх мэт) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно гэж албан ёсоор тайлбарласан.

Хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуульд хуульчлахдаа түүний үндсэн бүрэлдэхүүнд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхаар хуульчилсан. Тиймээс шалтгаант холбооны тухай асуудал энд яригдахгүй. Өөрөөр хэлбэл тус гэмт хэрэг нь хүн худалдаалах үйлдэл, эс үйлдэхүй хийгдсэнээр төгс үйлдэгдсэнд тооцно.

Хүнийг худалдаалахдаа тэвэрлэх, дамжуулах, орогнуулах, нугдуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

Хүн худалдаалах үйлдэл нь дараах аргуудаар объектив талын шинжүүдийг үүсгэнэ.

1. Ашиг олох, мөлжих зорилгоор хүч хэрэглэх;
2. Хүч хэрэглэхээр заналхийлэх;
3. Хулгайлах;
4. Хууран мэхлэх;
5. Эрх мэдлээ урвуулан ашиглах болон эмзэг байдлыг далимдуулж бусдыг элсүүлэх;
6. Тэвэрлэх;
7. Дамжуулах;
8. Орогнуулах;
9. Хүлээн авах аргуудаар илэрнэ.

Онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүний тухайд хүнийг хил дамуулан худалдаалсан үйлдэл объектив талын шинж болно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд давтан үйлдлийн шинжийг зааж өгсөн байна. Уг гэмт хэргийг давтан үйлдсэн бол 5-10 жил хүртэл хорих ял шийтгэхээр хууль тогтоогч зааж өгчээ.

Палермогийн протоколын 3 дугаар зүйлд: "Хүн худалдаалах" гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгох зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тэвэрлэх, дамжуулах, нугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ."

Өмнөд Азийн бүсийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн конвенцийн 1.3 дугаар зүйлд "Хүн худалдах гэмт хэрэг гэдэг нь эмзэгтэйчүүд, хүүхдийг тэдний зөвшөөрөлтэйгээр буюу зөвшөөрөлгүйгээр буюу биеийг нь үнэлүүлэх зорилгоор тухайн орны нутаг дэвсгэр дээр буюу гадаад оронд шилжүүлэн мөнгөөр буюу бусад зүйлээр худалдах буюу худалдан авах үйлдлийг хэлнэ" гэсэн байдаг.

Гэмт этгээдийн зүгээс хүнийг худалдаалахын тулд худалдагдаж буй хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах хууран мэхлэх, эрх мэдлээ ашиглах болон эмзэг байдлыг нь далимдуулах зэрэг аргыг ашиглан бусдыг элсүүлэх, тэвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах үйлдлээр илэрнэ.

Хууран мэхлэх гэдэгт: үзэж буюу

үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ.<sup>2</sup>

Эмзэг байдлыг нь далимдуулсан гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.<sup>3</sup>

Элсүүлсэн гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтонд нэгэн адил хамаарна.<sup>4</sup>

Тэвэрлэсэн гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно. Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тэвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.<sup>5</sup>

Дамжуулсан хүн худалдаалж байгаа мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно.<sup>6</sup>

Орогнуулсан гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүн худалдаалж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын

<sup>1</sup> Палермогийн протокол, 2000 он, 3 дугаар зүйл.

<sup>2</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

<sup>3</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

<sup>4</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

<sup>5</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

<sup>6</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.<sup>7</sup>

Хүлээн авсан гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.<sup>8</sup>

Судлаачийн зүгээс дүгнэвэл: Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээс үзэхэд Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжид зуучилсан (санхүүжүүлдэг, бичиг баримт гаргаж өгдөг) үйлдлийг орхиуулсан. 2008 оны Эрүүгийн хуулиар зуучилсан этгээд хамжигч, хатгагчаар "хүн худалдах" гэмт хэрэг оролцсон гэж ял оногдуулдаг байсан болодоо зуучилсан этгээдэд ял завших боломжийг Эрүүгийн хуулиар олгогчлоод байна. Үүнийг эргэж харах нь зүйтэй болов уу?

Улсын Дээд Шүүхээс 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолдоо Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн тайлбарын 1 дэх хэсгийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

Биеийг нь үнэлүүлэх гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ. 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс өмнө биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдах үйлдлийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилж өгсөн байна. Гэтэл нэмэлт өөрчлөлтөөр үндсэн бүрэлдэхүүнд хуульчилж өгсөн нь гэмт этгээдүүдэд ял завшуулж, хүн худалдаалах гэмт хэрэг гэмт хэргийн бүтцэд зэлэх хувийн жин огцом нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд гэмт этгээдүүдтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцэлд ухралт хийсэн алхам болжээ гэж судлаачийн зүгээс дүгнэж байна. Учир нь үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнд тодорхойлсон ялын санки ялгаатай болохыг бид бүхэн сайн мэднэ.

Бэлгийн хүчирхийлэлд оруулах гэдэгт биеийг үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчилахад татан оруулсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно. өрийн дарамтанд оруулах зэргээр биеийг үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.

Албадан хөдөлмөр хийлгэх гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.

Боолчлох гэдэгт эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.

Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах гэж хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй хөлбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.

Эд эрхтнийг авч ашиглах гэдэгт хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.

#### **Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект:**

Гэмт хэргийн субъект гэж: Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн тодорхой хүн байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалсан этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан

Субъект нь: Ердийн буюу 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол улсын иргэн, харьяалалгүй буюу гадаад улсын иргэн байна.

#### **Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал:**

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь гэмт этгээдийн өөрийн үйлдэж буй нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас хэрхэн хандаж байгаа сэтгэхүйн үйл ажиллагааг тодорхойлох гэм буруу, гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал зэрэг шинжүүдийг багтаасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бие даасан элемент юм.<sup>9</sup>

Хүн худалдаалахыг болохгүй гэдгийг мэдсээр байж буюу мэдэх бололцоотой байсаар байж хүн худалдаалж буй шууд санаатайгаар үйлдэгдэх гэмт хэрэг бөгөөд худалдан авагчийн удирдлага болгосон сэдэлт зорилгыг тус тусад нь тогтоох ёстой юм. Хүн худалдаалах гэмт хэргийн сэдэлт нь шунахайн сэдэлттэй байна. Мөн ес хонзонгийн болон хувийн бусад сэдэлттэй байж болно.

Гэмт этгээдүүд хүн худалдаалж байна гэдгийг мэдсэн байх шууд ба шууд бус санаатай байна.

Энэ гэмт хэргийн заавал байх шинж нь зорилго юм. 2 төрлийн зорилгыг тухайлан зааж өгсөн. Үүнд:

1. Ашиг олох;
2. Мөлжих.

Дээрх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын зайлшгүй байх шинж болох ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахаас гадна бусад зорилгоор худалдаалах гэдгийг нэмж хуульчлах Тухайлбал: (хүүхэдтэй болох, гэрлэх зорилгоор) хүн худалдан авч болох юм. Монголоос нэг сайхан хүүхэн аваад ир би гэрлэмээр байна гээд авчруулж худалдан авсан гохиолдолд түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байдлаар хуульчилсан байна.

<sup>7</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол

<sup>8</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол

<sup>9</sup> Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2003 он. 178 дугаар тал.

Хүүхэд тогтдоггүй айл хүүхэд худалдан авсан тохиолдол өмнө гарч байсан энэ тохиолдолд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулиар түүнд хариуцлага хүлээлгэх мөн л боломжгүй байна. Эрх зүйн орчин нь бүрдээгүй. Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинж үгүйсгэгдэнэ.

**Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн:**

Хүн худалдаалах гэмт хэргийг 113.2.1.Насанд хүрээгүй хүнийг; 113.2.2.Хоёр ба түүнээс олон хүнийг; 113.2.3.Хулгайлах, 113.2.4.Эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг;

113.2.5.Давтан;

113.2.6.Бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хүндрүүлэн хуульчилсан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 2-т зааснаар давтан үйлдсэн, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, мөн 113.3-т Хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, үр хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол гэж онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилжээ.

Насанд хүрээгүй хүнийг худалдаалсан гэдэгт: 18 нас хүрээгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнийг худалдаалсныг ойлгоно. Гэмт этгээд насанд хүрээгүй хүнийг худалдаалж байна гэдгийг мэдсэн байх шаардлагатай.

Хоёр буюу түүнээс олон хүнийг худалдаалсан гэдгийг хуульд зааснаар шууд ойлгож хэрэглэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийг давтан үйлдсэн гэдэгт. Хүнийг хоёр ба түүнээс дээш удаа хүн худалдаалсан баяхыг ойлгоно.

Давтан үйлдэх гэдэг нь ял шийтгэлтэй ба ял шийтгэлгүй давтан гэсэн хоёр ойлголтоос бүрддэг.

Бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэдэгт: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйл, 36.3-т зааснаар хүн худалдаалах гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдэн үйлдсэн бол бүлэглэж үйлдсэн гэнэ.

Тус гэмт хэргийг хамтран үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон хоёр буюу түүнээс дээш этгээд үйлдсэн бол урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн гэнэ.

Гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдүүлэхээр бусдыг хөлсөлсөн захиалагч, гэмт хэрэг үйлдэхийг гардан зохион байгуулсан буюу удирдсан зохион байгуулагч, ятгах, заналхийлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан хатгагч, гэмт хэргийг гардан үйлдсэн гүйцэтгэгч болон гэмт хэрэг хэрхэн яаж үйлдэхийг зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэх олон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан хамжигчид байдаг.

Бүлэглэж буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээдүүд нь хүн худалдаалах гэмт хэрэгт захиалагч, зохион байгуулагч, хатгагч, гүйцэтгэгч, хамжигчаар оролцож байна гэдгээ мэдсэн байна. өөрөөр хэлбэл гэмт этгээдүүд худалдаалах хүнийг элсүүлэн авч тээвэрлэх, дамжуулах, орогнуулах, хүлээн авах

зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно.

**Хүн худалдаалах гэмт хэргийн онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүн**

Хүн худалдаалах гэмт хэргийг хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, үр хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчилжээ.

Хил давуулан худалдаалсан гэдэгт хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар эсхүл хууль ёсооролж авсан баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна.<sup>10</sup>

Хүнийг хил давуулан худалдаалахдаа хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 89 дугаар зүйлээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн гэдэгт: Хүн худалдаалахын тулд урьдчилан нэгдсэн, тогтвортой бүлгийг ойлгоно.

Хүн худалдаалах гэмт хэргийг гэмт бүлэглэл үйлдсэн гэдэгт: Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, бүтэц, зохион байгуулалт бүхий этгээдүүдийн нэгдлийг ойлгоно.

Хүнд хор уршиг учирсан гэдэгт хүнийг худалдаалахтай шууд холбоотойгоор амь нас нь хохирсон, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.<sup>11</sup>

**Судалгааны үр дүндээ үндэслэн дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж байна. Үүнд:**

1. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн

<sup>10</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

<sup>11</sup> Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол.

шинжид зуучилсан гэх шинжийг нэмэх;

2. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжид **бусад зорилгоор** гэдгийн нэмж хуульчлах (хүүхэдтэй болох, гэрлэх зорилгоор) хүн худалдан авч болох юм;

3. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолийн 4.4-т тайлбарласнаар "Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд хохирогчийн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай, боолчлогдох шинжтэй бол Эрүүгийн хуулийн 124 дугаар зүйлд заасан гэмт хэргийн тухайд **биеэ үнэлж байгаа этгээд нь гэмт этгээдээс ямар нэгэн байдлаар хараат байх боловч эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна**" гэсэн нь хууль хяналтын байгууллагууд үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж байна. Учир нь биеэ үнэлж байгаа этгээд нь гэмт этгээдээс ямар нэгэн байдлаар хараат байх боловч эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна гэдэг нь ойлгомжгүй байна. Иймд үүнийг албан ёсоор тайлбарлах нь зүйтэй;

4. Мөн тайлбарын 4.3-т "Хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болдог бол Эрүүгийн хуулийн 124

дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд ашиг, орлогын тодорхой хэсэг нь гэмт этгээдийн мэдэлд шилжинэ" гэсэн нь мөн ойлгомжгүй байдал үүсгэж байна. Практикт үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргүүдээс үзэхэд гэмт этгээд хохирогчийг хүчээр биеийг нь үнэлүүлээд түүнд зөвхөн амь зогоох төдий өчүүхэн бага хэмжээний мөнгө өгдөг байсан бөгөөд энэ тохиолдолд гэмт этгээд орлогын тодорхой хувийг хохирогчид өгсөн гэдгээр Эрүүгийн хуулийн 124 дугаар зүйлээр зүйлчлэгдэж, ял завшиж байна. Зүй нь 113 дугаар зүйлчлэх нь зүйтэй. Иймд дээрх тайлбарыг эргэн харах шаардлага зайлшгүй тулгарч байна;

5. Мөн тайлбарын 4.5-д "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч биеийг нь үнэлүүлэхийг урьдчилан мэдээгүй байдаг бол Эрүүгийн хуулийн 124-р зүйлд заасан гэмт хэргийн тухайд биеэ үнэлж байгаа этгээд үүнийг урьдчилан мэдсэн байдгаараа ялгагдана" гэж тайлбарласан нь Монгол Улсын нэгдэн орсон Палермогийн Протоколын 3 дугаар зүйлд заасан "...хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь өөрийг нь мөлжих (мөлжих гэдэгт: хүчээр биеийг нь үнэлүүлэх, бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд хамаарна) гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэргэсэхгүй"... гэсэн Олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдөж байна. Монгол Улсын энэхүү протоколд нэгдэн орсноор энэхүү протоколын

хэм хэмжээнд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжуудаа өөрчилөн найруулах үүрэг хүлээдэг;

6. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бие даасан хуультай болох нь зүйтэй. Учир нь Эрүүгийн хууль нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хамаарал бүхий хэм хэмжээ түлхүү байдаг бөгөөд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдэнд тусламж дамжлаг үзүүлэх талаар тусгагдаагүй байдаг учраас юун түрүүнд бие даасан хуулийг батлах. Практикаас үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж чаддаггүйгээс гэрч, хохирогчдыг гэмт этгээдүүд дарамтлах, сүрдүүлэх, ятгаснаар тэд мэдүүлгээсээ буцах, улмаар эрүүгийн хэрэг хэргэсэхгүй болох тохиолдол их байна;

7. Хүн худалдаалах гэмт хэргийн импортлогч улсууд болох Япон, БНСУ, БНХАУ-ын Эрэн, Бээжин, Макао, Тайланд, Малайз зэрэг улсад Цагдаагийн байгууллагын бүрэн эрхт төлөөлөгчийг байнга ажиллуулах;

8. Дээрх улс орнуудтай "Эрх зүйн харилцан тусалцах гэрээ", "Ялтанг шилжүүлэн өгөх тухай гэрээ"-г яаралтай байгуулах шаардлагатай байна. Монгол Улсын гадаад улс орнуудтай байгуулсан "Эрх зүйн харилцан тусалцах гэрээ"-үүдийн дийлэнх хувь нь хуучин социалист системийн улс орнууд байна.



## Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны сайд Намсрай

Үндэсний тов архивын эрдэм шинжилгээний ажилтан Т.Билгсайхан



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны сайд Намсрай

Эрдэнэ ван Намсрайн дээдчүүд хошуу захирах, хил хамгаалах төрийн ажлыг 1694 оноос 200 гаруй жил тасралтгүй үе залгамжлан гүйцэтгэсэн бөгөөд тэрбээр долдугаар үе залгамжилсан засаг юм. Намсрай нь 1876 оны улаан хулгана жилд Мижиддоржийн ууган хөвгүүн болон төрсөн. 1892 оноос Засгийн тэргүүн зэрэг тайж залгамжилж, 1894 онд насанд хүрч засгийн тамгыг хүлээн авч, хэрэг шийтгэн харьяат хошууны олон тайж, ардыг захирах болсон. Намсрайд Бадаргуулт төрөөс / 1875-1908 хаан ор суусан. / 1894 онд нэгэн нэмсэн зэрэг олгосон ба 1895 оны 3 дугаар сараас харьяат чуулганы даргын газраас тус аймгийн Орос зүгийн харуулыг түр, зун нь Хүрээний сайдын газраас бүр захируулан суулгасан байна.

1896 онд Живзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэн засах зэрэг зүйлд мөнгө тусалсан учир

нэг тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1897 онд Бат тэмдэгт бичгийн зүйлд мөнгө тусалсан учир тогосын отго хадуулан, хоёр нэмсэн, дөрөв тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. Хойт хилийг таван жил захиран суусаны дараагаар 1900 оны 4 дүгээр сараас хошууны хэргээ эрхлэн шийтгэхийн хамт, зун нь Түшээт хан аймгийн С э р г и й л э н боловсруулах цэргийг түр захирч байв. Мөн оны өвөл нь Хүрээний сайдын газраас Намсрай Зүүн хоёр аймгийн (Түшээт, Сэцэн) харуулыг бүгд захиран, мөн хошууны хэргийг хавсран шийтгэж таван

жил болсон. Зах этгээдийг үнэн сэтгэлээр цагдан сахиж хүчин гаргасан зэрэг учир 1900 онд улсад туслагч гүнгийн зэрэг олгуулжээ. Бас харуулыг эндэгдэлгүй захирсан учир удаа дараа хоёр нэмсэн, хоёр тэмдэглэсэн зэрэг олгуулжээ 1906 оноос Живзундамба хутагтын Сангийн хэргийг 3 жил захиран суусан байна. 1910 онд Гадаад Монголын төрийг засах авдлын яамнаас урьд цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир Намсрайд хүрээтэр өнгийн жолоо шагнан олгосон.

Олноо өргөгдсөний тэргүүн оны (1911 оны 12 дугаар сарын 29 нд) өвлийн дундад сарын шинийн есөнд Богд Живзундамба хутагт Монгол улсын хаан ширээнээ суугаад гаргасан хишиг тараах зарлигтаа :

"... Түшээт хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг, засаг тэргүүн зэрэг тайж Намсрайд үе улиран Эрдэнэ цол, төрийн жүн

ван, улбар шар жолоо шагнаж, Шадар сайд, Бүгд захирах сайд, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд тохоон талбигтун ... Их баяр бүрдсэн Шинийн есний сайн өдөр" (МУУТА Х-А6, Д-1, ХН-511) хэмээжээ.

Түүний үндэсний эрх чөлөөний хувьсгалын их үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг түүхийн шинжлэх ухааны доктор О. Батсайхан дүгнэхдээ : *Манжаас анх түрүүн зогсийн эрх авсан зургаан хүний нэг, тулгар төрийг байгуулахад үнэн санаагаар чармайн зүтээсэн учир Эрдэнэ засгийн хошууны засаг ноён Мижиддоржийн Намсрайд их албыг даалгаж, гурван нүдний тогосын отго, саран цацаг бүхий ногоон тэрэг олгожээ* / О. Батсайхан.2009.73-74/ хэмээсэн нь түүний тусгаар тогтнолын үйл хэрэгт эхнээсээ ихээхэн үүрэгтэй оролцсоныг нотлож буй аж.

1913 онд улсын санд мөнгө хариулан өргөсөн учир түүнд гурван нэмсэн зэрэг, хоёр тэмдэглэсэн зэрэг олгуулж, 1914 онд дээд зарлигаар ногоон тууз шагнан олгожээ.

Тухайн үеийн Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны үндсэн үүрэг нь : Тусгаар тогтнолоо дахин сэргээж, тулгар байгуулагдсан төрийн эрх зүйн үндсийг боловсруулах, нийгмийн олон талт харилцааг зохицуулах талавр хууль, дүрэм, зарлиг санаачлан боловсруулах ажиллагаа байв. Олноо өргөгдсөн Монгол улсад Чин гүрний хууль цаазыг халах, өөрийн шинэ төрийг бэхжүүлэхтэй нийцүүлэн эрхзүйн шинэтгэл хийх ажиллагаа амжилттай эхэлсэн юм. Үүнд Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамыг тэргүүлж байсан Намсрайн гүйцэтгэсэн үүрэг их байсан.



Түүний тэргүүлж байсан Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны албан хаагчдын тогтоосон тоо нь : "... Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны айлтгаж тавих тэргүүн сайд нэгэн ор , дэд сайд хоёр ор, эрхэлсэн түшмэл нэгэн ор, дэс түшмэл хоёр ор, харьяат яамнаас эрхэлж тохоох эх бичиг зохиогч түшмэл дөрвөн ор, жинхэнэ бичээч зургаан ор, яамны сав хэрэглэлийг эрхэлж сахих нярав нэгэн ор, хэлмэрч нэгэн ор, галч гурван ор, гяндангийн дарга хоёр ор, гяндан сахич хорин ор, ташуурч хүн хоёр ор, тус тус байна .

Эдгээр түшмэдийн эрхлэх ажлын чиглэл нь : "...Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны айлтгаж тавих тэргүүн сайд нэгэн хүн , дэд сайд хоёр хүн цааз хуулийг барьж шүүх таслах хэргийг эрхлэн захирч шийтгэнэ. Шүүх, ариутгах хоёр хэлтэс буй. Эрхэлсэн

түшмэл нэгэн хүн , дэс түшмэл хоёр хүн , харьяат хоёр хэлтсийн аливаа хэрэг зүйлийг хянан үзэж шийтгэнэ. Шүүх хэлтэст эх бичиг зохиогч түшмэл хоёр хүн, жинхэнэ бичээч гурван хүн аливаа хүний амь, хулгай худал , явалдах, занчилдах зэрэг зарга заалхайн хэргийг эрхлэн шүүж, үнэн өчиг учрыг цөм нийлэлцсэний хойно өчгийг бичүүлэн авч ариутгах хэлтэст шилжүүлэн өгч ял хэлэлцүүлнэ. Тэр ариутгах хэлтэст эх бичиг зохиогч хүн хоёр хүн, жинхэнэ бичээч гурван хүн, олон харьяат газраас өргөн заалдсан бичгийн хэргийг эрхэлж шийтгэх бөгөөд шүүн тогтоосон элдэв хэргийн өчиг учрыг магадлан хянаж өршөөлтэй сэжиглэлтэйг ялган салгаж хэлтрүүлэх, оноох ялын нэрийг тогтоож , таслах ба айлтгаж явуулах, бичгийн эх зохиогч гүйцэтгэн шийтгүүлнэ.

Үүнээс дээш таван яамны олон хэлтсийн түшмэд өөр өөрийн яамны

элдэв хэргийг хавсран тусалж шийтгэнэ" хэмээн тус тус Монгол улсын хууль зүйлийн бичигт тэмдэглэгдсэн буй.

1915 онд Намсрайн бие өвдсөн учир тушаалаас шилжүүлэхийг гуйж айлтгасанд зарлигаар Шадар сайдыг хэвээр зүтгүүлж бусдыг гуйсан ёсоор болгожээ. Мөн онд Шүүх таслах яамны албан хэрэгт сайнаар зүтгэсэн учир айлтгаад зарлигаар чин вангийн зэрэг шагнаан хүртээжээ. Тус яамнаа таван жил эндэлгүй зүтгэсэн , улсын санд мөнгө хариулан өргөсөн учир шадар сайд Эрдэнэ чин ван Намсрайд 1919 оны 7 дугаар сарын 30 ны өдөр зарлигаар үе улиран хошой чин вангийн хэргэм шагнаан олгожээ. Түүний хэргэмийг батлан тэмдэглэсэн ахмад хөвгүүн Цэдэндорж залгамжлан авсан билээ.



## НЭР ТОМЪЁО

## (UN) REASONABLE + NESS

*Энэ дугаарын нэр томъёоны буланд хууль зүйн Англи хэлний нэгэн чухал нэр томъёог Монгол хэлнээ оновчтой, ойлгомжтой үгээр оноож орчуулах талаар уншигч Та бүхэнтэй саналаа хуваалцахыг хүслээ.*

Монгол Улсын Иргэний хуулийн зарим зүйл, заалтад “ердийн боломжит хугацаа” гэсэн хэллэг нэлээд олон удаа хэрэглэгдсэн байх ба “ердийнхөөс хэтэрсэн хэмжээгээр” гэсэн хэллэг нэг удаа орсон байна. Эдгээрийг Англи хэлнээ *reasonable time, in unreasonably large quantities* гэх зэргээр дүйлгэн орчуулж болох юм. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйлийн нэгэн чухал стандартыг *reasonableness standard* гэж хэлдэг. Аливаа этгээдийн үйлдлийг энэхүү стандартад нийцэж буй эсэхээс хамааруулан амьдралд тохиолдож болох олон маргааныг шийдвэрлэдэг байна. Иргэний хуульд гэрээ байгуулсанд тооцох нэг тохиолдлыг заахдаа “гэрээний саналыг хариу ирүүлэх хугацаа заалгүй бичгээр илгээсэн бөгөөд түүнийг зөвшөөрсөн тухай хариуг ердийн боломжит хугацаанд хүлээн авсан” (196.1.4.) гэжээ. Жишээ нь, хэрэв саналын хариуг албан тоотоор өгсөн бол түүнийг хүргэхэд зарцуулах ердийн боломжит хугацааг тухайн нөхцөлд хэдэн хоног байхыг шүүх тогтооно гэсэн үг. Англи хэлэнд *reasonable force, reasonable suspicion, reasonable risk* гэх мэт *reasonable* гэсэн тодотгол бүхий үг, хэллэг түгээмэл байдаг. Эсрэг утгаар нь (*unreasonable*) ч энэ үгийг мөн өргөн хэрэглэдэг.

Үүнийг бичигч *reasonableness standard* гэх ойлголт манай улсын иргэний эрх зүйд нэгэнт нэвтэрч эхэлж

байгаа бөгөөд цаашид бусад салбарт хэрэглэдэг болно гэдэгт эргэлзэхгүй байна. Иймд эл ойлголтыг Монгол хэлнээ дүйлгэн орчуулсан байдалд дүн шинжилгээ хийж, илүү оновчтой хувилбар санал болгохыг зорив.

Хугацааг “ердийн боломжит” гэж тодотгон хэрэглэхэд болж байгаа мэт боловч зарим тохиолдолд тэр бүр оновчтой биш болох нь харагдаж байна. Тухайлбал, дээр дурьдсан ойлголтуудыг “ердийн боломжит хүч”, “ердийн боломжит сэжиг”, “ердийн боломжит эрсдэл” гэх мэтээр орчуулж таарна. Эдгээр нь тийм ч тааруу орчуулга биш. Харин эсрэг утгыг хэрхэн илэрхийлэх вэ гэсэн асуудал гарна. “Ердийн боломжит бус” гэх үү? Жишээ нь, *unreasonable search* гэдгийг “ердийн боломжит бус нэгжлэг” гэвэл хэлэхэд ч, сонсоход ч бэрх болно. Ер нь *reasonable* гэдэг үг *reason* буюу оюун ухаан гэсэн үгнээс *able* гэж тэмдэг нэр үүсгэж дагавараар бүтээсэн үг бөгөөд шууд утга нь “хүний оюун ухаан хүлээж авахуйц” гэсэн санааг илэрхийлдэг. Оросоор “разумный” гэж төвөггүй буудаг. Монголоор “ухаалаг” “оюунлаг” гэхээс өөрөөр тэмдэг нэр үүсгэх аргагүй. Гэтэл “ухаалаг хугацаа” гэж яавч байж таарахгүй. Эндээс дүгнэхэд, нэгд, оюун ухаан гэдэг үгнээс тэмдэг нэр үүсгэж *reasonable* гэдэг үгийн шууд утгыг гаргах боломжгүй бөгөөд Монгол сэтгэхүйд буухгүй байна. Хоёрт, “ердийн боломжит” гэдгээс өөр бүх тохиолдолд хэрэглэж болохуйц нэр томъёо шаардлагатай байна.

Иймд өмнө дурьдсан “ердийн хэмжээнээс хэтэрсэн” гэх хэллэгээс санаа авч “хэмээс хэтэрсэн” гэсэн энгийн бөгөөд ойлгомжтой хэллэгийг сонгож авбал болмоор санагдана. Энэ бол *unreasonable* гэдэг үгийн оноолт болох юм. *Reasonable* гэдгийг “хэм тааруу” гэж орчуулж болох юм. Эрхэм уншигч Та саналаа сонины редакцид ирүүлж болно.





Энэхүү Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлд 2009 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд орсон хуулийн бүх нэмэлт, өөрчлөлтийг эмхтгэтгэж гаргалаа.

Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлийг хэрэглэхэд хялбар, цаашид нэмэлт, өөрчлөлтийг оруулан сольж болохуйц сугалбар хуудас, төмөр цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн.

Дээрх 4 ботид цаашид орох өөрчлөлтийг жилд хоёр удаа нэг багц болгон хэвлэж захиалгын дагуу түгээх юм.

Монгол Улсын хууль 4 боть эмхтгэлийн 2009 оны өөрчлөлтийн багцыг бэлтгэн хэвлэж Та бүхэнд хүргэхэд бэлэн болоод байгаа тул тус 4 боть эмхтгэлээс худалдан авсан, байгууллага, иргэд манайд хандан өөрчлөлтийн багцыг худалдан авна уу.

Үнэ: 15 000 төгрөг, Дансны дугаар: Төрийн сан-900012009


Та бүхэн дээрх 4 боть эмхтгэл болон, эдгээр ботиудын өөрчлөлтийн багцыг захиалан авахыг хүсвэл доорхи хаяг, утсаар хандана уу.

**Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Сүхбаатарын талбай 7, Хууль зүйн үндэсний хүрээлэн**  
**Утас: 315736, 315735, 1982, 8800-7557**  
**Факс: 315735**

---




Монгол Улсын хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж болох Үндсэн хуулийг (1992 он) уйгаржин монгол бичиг-кирилл үсгээр бичиж сууар хэлбэрээр хэвлүүлэн, баринтаглан бүтээжээ. Эртний Энэтхэг, Төвдөөс дамжин Монголд орж ирсэн гэх судрын загварыг ашиглан эх нутгийнхаа хөх тэнгэрийг бэлэгдэн баринтагны гадрыг хөх торгоор, газар нутгаа дүрслэн дотрыг ногоон торгоор хийн, баринтагны оосорт шинээр зоос үйлдэн бүтээжээ.



Хууль зүйн үндэсний хүрээлэн  
www.nli.gov.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухааны академиас эрхлэн хэвлүүлсэн Монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичгээр бүтээсэн Монгол Улсын Үндсэн хуулийг танд толилуулаж байна. "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн эхийг Монголчуудын хэрэглэж ирсэн зургаан гол зүйл бичиг үсэг, арван зүйл тиг хэлбэрээр бүтээжээ. Энэхүү номд хэрэглэж ирсэн бичиг үсгийн дараахь дарааллаар оруулсан байна.

- Их Монгол Улсын үеийн монгол бичгийн тиг;
- Монгол бичгийн модон барын тиг;
- Монгол бичгийн бийрийн тиг;
- Монгол бичгийн зөхмөл тиг;
- Монгол бичгийн төмөр барын тиг;
- Монгол дөрвөрэлжин бичиг;
- Тод бичиг;
- Соёмбо бичиг;
- Латин бичиг;
- Монгол кирилл бичиг.



1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хууль тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг эмхтгэн Англи хэлээр орчуулан хэвлүүлжээ. Уг бүтээлд 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулийн жинхэнэ анхдагч эхийг хуулбар хуви, тухайн цаг үед хэвлэгдэн гарч байсан анхны хэвлэмийн хуулбарыг багтаасан байна.